



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

СНАГ-2025/002/-НА-СТА-НТГ

2025 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/57

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-г Нэгдүгээр хавсралтаар, тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлагыг Хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Ц.Наранчимэг), Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (Д.Энхболд) нарт тус тус даалгасугай.

3.Аудитаар тогтоосон төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгч (Л.Оюун-Эрдэнэ), Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч (Б.Жавхлан), Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын үүрэг гүйцэтгэгч (Э.Одбаяр) нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурал болон холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангах, аудитын үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч (Я.Самбууням)-д үүрэг болгосугай.



С.МАГНАЙСҮРЭН

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	7
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	10
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ХЭДИЙ Ч ТАЙЛАНТ ЖИЛИЙН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БАТЛАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БҮРД ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ ӨӨРЧИЛСНӨӨС ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗАРЧИМ АЛДАГДАЖ БАЙНА.....	11
1.1Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангасан боловч тайлант жилийн төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах бүрд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж байгаа нь төсвийн тогтвортой байдлын зарчимд нийцэхгүй байна.....	11
1.2Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн бодлого, чиглэлийг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэн төлөвлөсөн боловч бодлого чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэн дүгнээгүй, үр нөлөөг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулаагүй байна.....	15
БҮЛЭГ 2. УУЛ УУРХАЙН ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ, НИЙТ ИМПОРТ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО БҮРЭН БҮРДЭЭГҮЙГЭЭС НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО 534.5 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР ТАСАРСАН БАЙНА.....	20
2.1Төсвийн орлогод баримталж буй татварын бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн бүс нутгийн хөрөнгө оруулалтыг онилсон, татварын бааз суурийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.....	20
2.2Уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай орлогод суурилсан төсвийн тэлэлт эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлсээр байгаа тул Үндэсний баялгийн сангийн эх үүсвэрийг тогтвортой хуримтлуулж, үр ашигтай удирдах шаардлагатай байна.....	21
2.3Уул уурхайн экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, нийт импортын урсгал өмнөх оноос нэмэгдсэн зэргээс шалтгаалан татварын орлого 115.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна ..	24
БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН БОДЛОГО НЬ УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛД НИЙЦҮҮЛЭН ЗОРИМОГ ШИЙДВЭРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭЭГҮЙ, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД УЛС ТӨРИЙН НӨЛӨӨ ӨНДӨР БАЙГААГААС УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ АЛДАГДАЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ БУУРСАН БАЙНА.....	29
3.1Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын бодлого нь улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд нийцүүлэн зоримог шийдвэрүүдийг төлөвлөсөн боловч гүйцэтгэлийн үр дүнг үнэлээгүй байна.....	29
3.2Монгол улсын төсвийн төлөвлөлтөд улс төрийн бодлогын нөлөө их байгаа нь урт хугацааны хөгжлийн бодлогыг дэмжсэн дунд хугацааны бодлогын баримт бичгийг өөрчлөхөд хүргэж, төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах, төсөв захирагчдын төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах, урсгал зардлын төсөвт үзүүлэх дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.....	29
3.3Тухайн төсвийн жилийн бодлогын хүрээнд улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшний үзүүлэлттэй уялдуулахгүйгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг өөрчилж, хэрэгжүүлэх арга хэмжээний урсгал шинжтэй зардлын хязгаарыг хуулиар нэмэгдүүлэн тогтоож байгаа нь дараагийн жилүүдийн суурь зарлага, төсөвт үзүүлэх ачааллыг нэмэгдүүлэх үр дагавартай байна.....	35
БҮЛЭГ 4. УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ БУУРСАН БОЛОВЧ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ ӨССӨН НЬ ТӨСВИЙН ОРЛОГОД НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖ, ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ ТӨЛӨВЛӨСНӨӨС 2,450.9 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР САЙЖИРЧ, 920.3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ ГАРСАН БАЙНА.....	46
4.1Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл төлөвлөснөөс 2,450.9 тэрбум төгрөгөөр сайжирч, 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.....	46
4.2Улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 2,504.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,283.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1,288.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.....	47

БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ЗАРЛАГА ӨМНӨХ ОНООС 67.4 ХУВИАР, ОРЛОГЫН ӨСӨЛТӨӨС 21.8 ПУНКТААР НЭМЭГДСЭН, ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТЭЛЭЛТИЙГ БУУРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	48
5.1 Орон нутгийн нийт орлого ба тусламжийн дүн 7,121.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 45.6 хувиар өссөн боловч 95.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 362.1 тэрбум төгрөгөөр тасарсан байна	48
5.2 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7,258.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч батлагдсан төлөвлөгөөнөөс 1,981.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх оноос 67.4 хувь буюу 2,922.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна	49
5.3 Орон нутгийн нийт орлого өмнөх оноос 45.6 хувиар өссөн боловч нийт зарлага 67.4 хувиар өссөнөөс шалтгаалж, төсвийн тэнцэл 136.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.	52
БҮЛЭГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАСАН БОЛОВЧ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НАРИЙВЧИЛСАН ЗОХИЦУУЛАЛТГҮЙ БАЙНА	53
6.1 Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэхээр салбарын хуульд тусгасан боловч хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалтгүй байна	53
6.2 Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоолыг салбарын шинэчилсэн хуультай нийцүүлж шинэчлэн батлаагүй байна	54
БҮЛЭГ 7. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТЭНЦВЭР АЛДАГДАЖ, ӨРИЙН ДАРАМТАД ОРСНООС ҮЙЛ АЖИЛЛАГАА ДОГОЛДОХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА	57
7.1 ЭМДС-ийн орлого 1,921.7 тэрбум төгрөгт хүрч 97.8 хувийн гүйцэтгэлтэй байгаагийн 55.7 хувь буюу 1,070.9 тэрбум төгрөгийг төр хариуцах иргэдийн шимтгэл болон тусламж үйлчилгээний орлогоос бүрдүүлсэн байна	57
7.2 ЭМДС-ийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар бодлогын арга хэмжээ аваагүйгээс эх үүсвэр дутагдаж 316.8 тэрбум төгрөгийн өр үүссэн, ЭМДЕГ-аас эмийн сан, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлд тавих хяналт хангалтгүй байна	57
БҮЛЭГ 8. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН НЭМЭЛТ ТӨСВӨӨР 1,160.1 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЖ, ГҮЙЦЭТГЭЛЭЭР 1,160.5 ТЭРБУМ ТӨГРӨГ ЗАРЦУУЛЖ, 81.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ АВЛАГА ҮҮСГЭН ТАЙЛАГНАСАН БАЙНА	59
8.1 Зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын давсан орлогын зарцуулалт жил бүр нэмэгдэж байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна	59
8.2 Нэмэлт санхүүжилтийн төсвөөс 1,160.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 81.2 тэрбум төгрөгийг дараа ондоо авч зарцуулахаар авлагаар бүртгэж, тайлагнасан байна	59
БҮЛЭГ 9. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЦИЙН 95.9 ХУВИЙГ ГАДААД ӨР ЭЗЭЛЖ БАЙГААГ ХЯНАЖ, ҮР ӨГӨӨЖИЙГ САЙЖРУУЛАХАД ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГЫГ ЧИГЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	61
9.1 Өрийн бүтцийн 95.9 хувийг гадаад өр эзэлж байгаа нь санхүүгийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлөхүйц гадаад хамаарал өндөр байгааг харуулж байна	61
9.2 Өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд зөвхөн эдийн засгийн өсөлтөд найдах бус, гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжих төсөл арга хэмжээний мөнгөн урсгалыг бодитой төлөвлөж, үр өгөөжийг сайжруулах, хүүгийн дарамтыг бууруулах зорилгоор дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна	63
БҮЛЭГ 10. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСЫГ БУСАД САНХҮҮГИЙН СИСТЕМД ХОЛБОЖ ХӨГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ХЭРЭГЛЭГЧ, ИРГЭН ОЛОН НИЙТЭД ЭНГИЙН ОЙЛГОМЖТОЙ, ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР БУС, МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ НЬ ХУУЛИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА	69
10.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын төрөл, нэршлийн хувьд уялдуулах шаардлагатай байна	69
10.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийн 97.1 хувийг бүрэн байршуулж, 2.9 хувийг байршуулаагүй, нийт мэдээллийн 89.5 хувийг хуулийн хугацаанд, 10.5 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна	71
БҮЛЭГ 11. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ 54.3 ХУВЬТАЙ БАЙНА	72
ХАВСРАЛТ ТАЙЛАН 1: “УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН	74
ХАВСРАЛТ ТАЙЛАН 2: “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН	113
ДҮГНЭЛТ	131
ЗӨВЛӨМЖ	135
ХАВСРАЛТУУД	139

Товчилсон үгийн жагсаалт

1	ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
2	ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
3	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
4	АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
5	Ам.доллар	Америк доллар
6	АХБ	Азийн хөгжлийн банк
7	БГБАУТХЗ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
8	БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
9	БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
10	БС	Боловсролын сайд
11	БҮБЗ	Бараа үйлчилгээний бусад зардал
12	БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
13	БХС	Батлан хамгаалахын сайд
14	ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
15	ГЕГ	Гаалийн ерөнхий газар
16	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
17	ЗГ	Засгийн газар
18	ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
19	ЖДҮДС	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан
20	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
21	МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
22	МУНТГ	Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл
23	МУШС	Монгол Улсын Шадар сайд
24	НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
25	НДС	Нийгмийн даатгалын сан
26	НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
27	НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
28	НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
29	ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
30	ОУВС	Олон улсын валютын сан
31	ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
32	ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
33	СЯ	Сангийн яам
34	ТАХ	Төсөл, арга хэмжээ
35	ТЕГ	Татварын ерөнхий газар
36	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
37	ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
38	ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
39	ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
40	ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
41	ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
42	ТҮ	Төрийн үйлчилгээ
43	ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
44	УИХ	Улсын Их Хурал
45	УТЕЗ	Улсын төсвийн ерөнхийлөн захирагч
46	УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
47	УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
48	ҮАГ	Үндэсний аудитын газар
49	ҮБС	Үндэсний баялгийн сан
50	ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
51	ХАА	Хөдөө аж ахуй
52	ХББОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
53	ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
54	ХК	Хувьцаат компани
55	ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд

56	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
57	ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
58	ЦХИХХС	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
59	ШДНЦХ	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
60	ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
61	ШУ	Шинжлэх ухаан
62	ЭЗХАХБ	Эдийн засаг, хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллага
63	ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
64	ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
65	ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
66	ЭМС	Эрүүл мэндийн сайд
67	ЭМЯ	Эрүүл мэндийн яам
68	ЭХС	Эрчим хүчний сайд

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт	13
Хүснэгт 2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж, /тэрбум төгрөг/	21
Хүснэгт 3. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого бүрдүүлэлт, /тэрбум төгрөг/	22
Хүснэгт 4. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ, /тэрбум төгрөг/	23
Хүснэгт 5. Төсвийн тогтворжуулалт, Үндэсний баялгийн сангийн орлого, /тэрбум төгрөг/	23
Хүснэгт 6. Монгол Улсын 2024 оны улсын төсвийн татварын орлого, /тэрбум төгрөг/	24
Хүснэгт 7. Монгол Улсын 2024 оны улсын төсвийн татварын бус орлого, /тэрбум төгрөг/	25
Хүснэгт 8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн судалгаа, /тэрбум төгрөг/	27
Хүснэгт 9. Татварын өрийн мэдээлэл /1990-2023 оноор/	27
Хүснэгт 10. ESA /Event Study Analysis/ шинжилгээний үр дүн	30
Хүснэгт 11. Монгол Улсын 1996-2024 оны зардал өссөн шалтгаан	31
Хүснэгт 12. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөлт, /тэрбум төгрөг/	32
Хүснэгт 13. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл, /тэрбум төгрөг/	32
Хүснэгт 14. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл хөтөлбөрөөр, /тэрбум төгрөг/	33
Хүснэгт 15. Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл, /тэрбум төгрөг/	34
Хүснэгт 16. Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээл, /тэрбум төгрөг/	35
Хүснэгт 17. Улсын төсвийн цалин, НДШ-ээс бараа, үйлчилгээний бусад зардал, /тэрбум төгрөг/	38
Хүснэгт 18. Улсын төсвийн хүүгийн зардлын эдийн засгийн ангилал, /тэрбум төгрөг/	39
Хүснэгт 19. Улсын төсвийн татаас ба урсгал шилжүүлэг, /тэрбум төгрөг/	40
Хүснэгт 20. Улсын төсвийн 2024 төсвийн хөрөнгө оруулалтын зардал, /тэрбум төгрөг/	41
Хүснэгт 21. Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл /тэрбум төгрөгөөр/	42
Хүснэгт 22. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүдийн ДНБ-д эзлэх хувь болон өсөлтийн хувь	46
Хүснэгт 23. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, /тэрбум төгрөг/	46
Хүснэгт 24. Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, /тэрбум төгрөг/	47
Хүснэгт 25. Орон нутгийн орлогын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар, /тэрбум төгрөг/	48
Хүснэгт 26. Орон нутгийн орлогын гүйцэтгэл төсөв захирагчаар, /тэрбум төгрөг/	49
Хүснэгт 27. Орон нутгийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн эдийн засгийн ангиллаар, /тэрбум төгрөг/	50
Хүснэгт 28. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл төсвийн захирагчаар, /тэрбум төгрөг/	50
Хүснэгт 29. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн төсвийн захирагчаар, /тэрбум төгрөг/	51
Хүснэгт 30. Нийгмийн даатгалын сангийн орлого, /тэрбум төгрөг/	54
Хүснэгт 31. Нийгмийн даатгалын сангийн зарлага, /тэрбум төгрөг/	55
Хүснэгт 32. Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр, /тэрбум төгрөг/	59
Хүснэгт 33. Засгийн газрын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/	61
Хүснэгт 34. Засгийн газрын 2024 оны өрийн үйлчилгээний үзүүлэлт, /тэрбум төгрөг/	62
Хүснэгт 35. Засгийн газрын 2024 оны өрийн үзүүлэлт, /тэрбум төгрөг/	63
Хүснэгт 36. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/	64
Хүснэгт 37. Орон нутгийн дотоод үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/	65
Хүснэгт 38. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/	66
Хүснэгт 39. Орон нутгийн гадаад үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/	66
Хүснэгт 40. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/	67
Хүснэгт 41. Шилэн дансны тухай хуульд заасан байгууллагын төрөл	69
Хүснэгт 42. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь байгууллагын төрөл	69

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн байгууллагын тоо	7
Дүрслэл 2. Нэгдсэн төсвийн үзүүлэлт 2020-2024 он, тэрбум төгрөг.....	15
Дүрслэл 3. Нэгдсэн төсвийн нийт орлого	21
Дүрслэл 4. Татварын орлогын дүн, төрлөөр /тэрбум төгрөг/	25
Дүрслэл 5. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 1995-2025 он, /тэрбум төгрөг/	30
Дүрслэл 6. Нийт зарлага ба цэвэр зээлийн бүтэц, /тэрбум төгрөг/	31
Дүрслэл 7. Нийт зарлага өсөлт, ДНБ-д эзлэх хувь, /тэрбум төгрөг/	31
Дүрслэл 8. Шинэчлэн баталсан цалингийн доод хэмжээ	36
Дүрслэл 9. Улсын төсвийн 210801, 210901 зардлууд арга хэмжээний хуваарилалт	39
Дүрслэл 10. Хүүгийн зардал /тэрбум төгрөг/	40
Дүрслэл 11. Улсын төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүн ба хөрөнгийн зардал, /тэрбум төгрөгөөр/	42
Дүрслэл 12. ЭМДС-ийн 2020-2025 оны орлого, зарлага, өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/	57
Дүрслэл 13. Тогтвортой байдлын хязгаар	62
Дүрслэл 14. Ханшийн алдагдлын статистик, /тэрбум төгрөг/	63
Дүрслэл 15. Засгийн газрын дотоод үнэт цаасны статистик, /тэрбум төгрөг/	64
Дүрслэл 16. Хяналтын багц дахь 17 байгууллага 2024 онд мэдээлсэн мэдээллийн тоо	70
Дүрслэл 17. Шилэн дансны нэгдсэн цахим систем болон Үнэлгээний тайлангийн харьцуулалт	71
Дүрслэл 18. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн тоо, хувиар.....	72
Дүрслэл 19. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудитаар өгсөн зөвлөмжийн тоо, хувиар	73

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2² дахь заалтыг үндэслэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын зорилт

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн бодлогын зорилт үр нөлөөтэй хэрэгжсэн, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Аудитын хамарсан хүрээ

Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7³-д заасны дагуу Сангийн яамны бэлтгэсэн Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгад үндэслэн нийт 3718 төсөвт байгууллага, сангуудын төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл;
- Улсын төсвийн 2024 оны гүйцэтгэл;
- Орон нутгийн 2024 оны төсвийн гүйцэтгэл;
- ЭМДС-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэл;
- НДС-ийн 2024 оны төсвийн гүйцэтгэл;
- Ирээдүйн өв сан;
- Үндэсний баялгийн сан;
- Төсвийн тогтворжуулалтын сан;
- Нэмэлт төсвийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан;
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр;
- Татварын зарлагын тайлан;
- Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэл;
- Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт;
- ТЕЗ нарын 2024 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтүүд;
- Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт;
- Өмнөх оны зөвлөмжийн биелэлт.

Дүрслэл 1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн байгууллагын тоо



Тайлбар:

* Төсвийн ерөнхийлөн захирагч

** Төсвийн байгууллага, төсвийн гүйцэтгэлийн тайлан

*** Гүйцэтгэлээр санхүүжих байгууллага - 2560

¹ Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

² Төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх

³ Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудит”, Монгол Улсын Ерөнхий аудиторын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэлээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, аудитын горим сорилыг хэрэгжүүлэв. Үүнд, Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа, тоон мэдээлэл авах, түүвэрлэлт, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын тайланд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн гүйцэтгэл, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнг нэгтгэсэн болно. Аудитын холбогдох мэдээлэл, ажлын баримтыг хавсаргав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон уг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль болон уг хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын багц хуулиуд;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Үндэсний баялгийн сангийн тухай хууль;
- Ирээдүйн өв сангийн тухай хууль;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Татварын багц хуулиуд;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль;
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хууль;
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас хөнгөлөх, чөлөөлөх тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Тухайн жилийн төсвийн бодлого, чиглэл, зарчим;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.

Улсын Их Хурлын болон Засгийн газрын дараах тогтоол, шийдвэрүүдийг 2024 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоол;
- Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 24 дүгээр тогтоол;
- Улсын Их Хурлын 2024 оны "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 21 дүгээр тогтоол;
- Улсын Их Хурлын 2024 оны "Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай" 64 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2016 оны "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам" 29 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоол.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн орлогч Я.Самбууням, Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор Д.Энхболд, аудитын менежер Б.Долгорсүрэн, П.Чанцалдулам, Э.Энхбаатар, Ю.Энхтуяа, В.Эрдэнэцогт, И.Эрдэнэцэцэг нар үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор, аудиторууд төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитад хөндлөнгийн мэргэжлийн шинжээчийг оролцуулж, зарим төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт гаргуулан, үр дүнг аудитын тайланд тусгасан болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитын танилцуулгад дурдсан эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдийг Монголбанкнаас гаргасан 2024 оны жилийн тайлан, Үндэсний Статистикийн хорооны "Монгол Улсын Статистикийн эмхэтгэл-2024", мөн Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас тоймлон авч ашигласан болно.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 27.4 хувиар өсөж 29,670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 35.9 хувиар өсөж 30,591.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

Эдийн засгийн суурийг тэлэх, төрөлжүүлэх хүрээнд уул уурхайн болон уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлснээр нэрлэсэн ДНБ-ий хэмжээ өмнөх оноос 9,514.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 79,956.3 тэрбум төгрөгт хүрч, эдийн засаг 4.9 хувиар өссөн байна.

Эдийн засгийн өсөлтөд 4.8 нэгж хувийг үйлчилгээний салбар, 1.4 нэгж хувийг уул уурхай, олборлолтын салбар, 0.3 нэгж хувийг аж үйлдвэр, барилгын салбар бүрдүүлж, хөдөө аж ахуйн салбар 3.6 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд үйлчилгээний салбар 22.2 хувь, уул уурхай, олборлолтын салбар 10.0 хувь, аж үйлдвэр, барилгын салбар 7.5 хувиар өссөн бол жил дараалсан зудын хүндрэл, малын зүй бус хорогдлоор тоо толгой буурснаар хөдөө аж ахуйн салбар 15.5 хувиар агшсан байна.

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляц өмнөх оноос 1.1 нэгж хувиар өсөж оны эцэст 9.0 хувьд хүрч, Монголбанкны зорилтот түвшний дээд хязгаарыг давсан байна. Жилийн дундаж инфляц 6.8 хувь болж, өмнөх оноос 3.6 нэгж хувиар буурсан байна.

Инфляц өсөхөд цахилгааны үнийн өсөлт голлон нөлөөлсний зэрэгцээ дотоод эдийн засгийн сэргэлт, цалингийн өсөлттэй холбоотойгоор үйлчилгээ, түрээс, импортын барааны үнэ хүлээлтээс өндрөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Мөнгөний нийлүүлэлт (M2) 43,334.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 5,709.9 тэрбум төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Мөнгөний нийлүүлэлт (M2) өсөхөд төгрөгийн хадгаламж 28.8 хувиар, төгрөгийн харилцах 19.7 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2,352.8 мянга болж, өмнөх оноос 2.4 хувиар нэмэгдсэн байна. 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 61.3 хувь буюу 1,441.1 мянга нь ажиллах хүч, 38.7 хувь буюу 911.7 мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 61.3 хувь болж өмнөх оноос 1.8 нэгж хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 57.6 хувь болж, өмнөх оноос 1.3 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 5.9 хувь болж, өмнөх оноос 0.6 нэгж хувиар тус тус өссөн байна.

Монгол Улс 2024 онд 160 улстай худалдаа хийж, нийт бараа эргэлт 27,395.0 сая ам.долларт хүрсэн байна. Экспортын хэмжээ өмнөх оноос 3.9 хувиар өсөж 15,783.4 сая ам.доллар, импортын хэмжээ 25.5 хувиар нэмэгдэж 11,614.7 сая ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 4,168.7 сая ам.долларын ашигтай байна.

Импортын өсөлтөөс шалтгаалан урсгал данс 2,372.6 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 3,338.8 сая ам.долларын ашигтай, төлбөрийн тэнцэл өмнөх оноос 834.7 сая ам.доллараар буурч 622.3 сая ам.долларын ашигтай, гадаад валютын улсын нөөц оны эцэст 5,509.8 сая ам.долларт хүрсэн байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 2,862.6 сая ам.доллар, багцын хөрөнгө оруулалтын Улаанбаатар хотын нийслэл бондын 500.0 сая ам.доллар, Голомт банкны 400.0 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд амжилттай арилжсан 1,144.1 сая ам.доллар нь санхүүгийн дансны 3,338.8 сая ам.долларын ашигт нөлөөлжээ.

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл өмнөх оноос 7.7 хувиар өсөж 37,237.4 сая ам.долларт хүрсэн бол, Засгийн газрын гадаад өр нэрлэсэн үнээр 8,397.1 сая ам.доллар байна.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ НЬ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТУСГАЙ ШААРДЛАГЫГ ХАНГАСАН, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН ХЭДИЙ Ч ТАЙЛАНТ ЖИЛИЙН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ БАТЛАХ, НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БҮРД ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙГ ӨӨРЧИЛСНӨӨС ДУНД ХУГАЦААНЫ ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ, ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗАРЧИМ АЛДАГДАЖ БАЙНА

1.1 Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангасан боловч тайлант жилийн төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах бүрд төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилж байгаа нь төсвийн тогтвортой байдлын зарчимд нийцэхгүй байна

1.1.1 Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцлийн зорилтыг тодорхойлж тусгах, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүнд нийцүүлсэн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах, УИХ-д өргөн мэдүүлэх, батлах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах, нэгдсэн гүйцэтгэлийг батлах, хяналт тавих, санхүүгийн хуримтлалын удирдлагыг хэрэгжүүлэх харилцааг тус тус зохицуулж байна.

1.1.2 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг анх баталснаас хойш 18 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байгаа нь тус хуулийн үндсэн зорилт, үзэл баримтлалтай нийцэхгүй байна.

1.1.3 Засгийн газраас 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй хамт нийт 15 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар УИХ-д өргөн мэдүүлсний дагуу, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

1.1.4 УИХ-аас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталж, Ирээдүй өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэсэн төрөлжсөн сангаас бүрдэх тогтолцоо бий болсон байна.

1.1.5 Тус хуулийн зорилтыг “газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор Үндэсний баялгийн санг байгуулах, түүний төрөл, зориулалт, эх үүсвэрийг тодорхойлох, сангийн хөрөнгийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааг тайлагнах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах” гэж заасан байна. УИХ-ын 2024 оны “Хууль баталсантай холбоотой авах арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоолын хүрээнд Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, Үндэсний баялгийн төрөлжсөн сангийн дансыг Монголбанк дахь Төрийн сангийн дансанд байршуулах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

1.1.6 Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх журам”-ыг баталж, хуримтлалын сангаас иргэн бүрд нэрийн данс үүсгэн 138,993.00 төгрөгийг хуваарилжээ.

1.1.7 Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцааны ногдол ашгаас 499.5 тэрбум төгрөг, АМНАТ-аас Төсвийн тогтворжуулалтын болон орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгээс 20.0 хувь буюу 789.0 тэрбум төгрөг, нийт 1,288.5 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталж, Ирээдүй өв санд 841.3 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 500.6 тэрбум төгрөг, нийт 1,341.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

1.1.8 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилготой Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор “2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих” болгон зарласан.

1.1.9 УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг баталж, Монгол Улсыг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн бүсчлэлийн тогтолцоогоор хөгжүүлэхээр тусгасан байна.

1.1.10 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг УИХ-аас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталсныг Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль батлахтай холбоотойгоор 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан, мөн 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт тухай хуулийг батлахдаа дахин нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

1.1.11 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг УИХ-аас 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр баталж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 21,163.2 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 22,996.1 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,832.9 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

1.1.12 Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг УИХ-аас 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр өөрчлөлт оруулж, тэнцвэржүүлсэн орлогыг 4,691.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 4,364.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 327.5 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

1.1.13 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 28,872.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 36.4 хувь, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 30,487.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 38.5 хувь, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,615.4 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцүү байхаар баталсан байна.

1.1.14 Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээг 27,269.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 34.4 хувь, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,603.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувийн ашигтай, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн хэмжээг 47,529.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 60.0 хувьтай тэнцэхээр тооцсон байна.

1.1.15 Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 3,017.4 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 3,127.4 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 110.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

1.1.16 Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт орсон өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг холимог тогтолцоогоор явуулж, Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэйгээр 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан байна.

1.1.17 Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр Монгол Ардын нам, Ардчилсан нам, ХҮН намын төлөөллөөс бүрдсэн хамтарсан Засгийн газар байгуулж, улс төрийн гурван намын мөрийн хөтөлбөр, нийтлэг зорилтот суурилсан “ХУРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” гэрээг байгуулжээ.

1.1.18 УИХ-ын 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, бусад холбогдох тогтоолын төслүүд батлагдсантай холбоотой, төрийн зарим чиг үүрэг төсвийн ерөнхийлөн захирагч хооронд шилжиж, шинээр төсвийн ерөнхийлөн захирагч бий болж, зарим агентлагийн нэр өөрчлөгдсөн байна.

1.1.19 Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд орсон өөрчлөлтөөр Засгийн газрын бүрэлдэхүүнийг 22 сайд, 16 яамтай байхаар баталж, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан байна.

1.1.20 Засгийн газраас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор төсвийн ерөнхийлөн захирагч нарын хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөл үүссэнээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бүсчилсэн хөгжил, Шинэ сэргэлтийн бодлогод хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг үндэслэлээр Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсний дагуу УИХ-аар хэлэлцэж 2024 оны 8 дугаар сарын 30-ний өдөр эцэслэн баталсан байна.

1.1.21 Төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан Монгол Улсын 2024 оны анх баталсан болон тодотгосон төсвийн эдийн засгийн үзүүлэлтүүд нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байна.

Хүснэгт 1. Монгол Улсын 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл			Өөрчлөлт /өмнөх түвшнээс/	
		Анх баталсан	Өөрчлөн баталсан	Тодотгол	Анх баталснаас	Өөрчлөн баталснаас
		/2023.05.31/	/2023.11.10/	/2024.08.30/		
А		1	2	3	4=3-1	5=3-2
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.5	7.0	5.6	(0.9)	(1.4)
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.0	8.5	6.5	(1.5)	(2.0)
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	21,163.2	25,855.1	28,872.5	7,709.3	3,017.4
	ДНБ-д эзлэх хувь	32.3	34.9	36.4	4.1	1.5
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	22,996.1	27,360.5	30,487.9	7,491.8	3,127.4
	ДНБ-д эзлэх хувь	35.1	37.0	38.5	3.4	1.5
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	(1,832.9)	(1,505.4)	(1,615.4)	217.5	(110.0)
	ДНБ-д эзлэх хувь	(2.8)	(2.0)	(2.0)	0.8	-
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	Энэ үзүүлэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн		27,269.0	27,269.0	27,269.0
	ДНБ-д эзлэх хувь			34.4	34.4	34.4
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/			1,603.5	1,603.5	1,603.5
	ДНБ-д эзлэх хувь			2.0	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, нэрлэсэн дүнгээр /тэрбум төгрөг/			47,529.4	47,529.4	47,529.4
	ДНБ-д эзлэх хувь			60.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,153.8	2,351.9	2,351.9	198.1	-
	ДНБ-д эзлэх хувь	3.3	3.2	3.0	(0.3)	(0.2)
A	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, ӨҮЦ-ээр /тэрбум төгрөг/	39,276.0	44,400.0	Энэ үзүүлэлтийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хассан		
	ДНБ-д эзлэх хувь	60.0	60.0			
B	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	2,520.8	4,989.2			
	ДНБ-д эзлэх хувь	3.9	6.7			
B	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	5,850.4	6,273.3			
	ДНБ-д эзлэх хувь	8.9	8.5			

Эх сурвалж: Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль

1.1.22 Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл болон батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэхийн оронд, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар дунд хугацааны төсвийн хүрээний үндсэн үзүүлэлтүүдийг өөрчилдөг зөрчил давтагдан гарсаар байна.

1.1.23 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг УИХ-аас 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр баталж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 25,855.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 27,360.5 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,505.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тус тус баталжээ.

1.1.24 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 28,872.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30,487.9 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1,615.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан байна.

1.1.25 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 29,670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30,591.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай, мөн нэгдсэн төсвийн суурь зарлага 28,029.6 тэрбум төгрөг, суурь тэнцэл 1,641.2 тэрбум төгрөгийн ашигтай байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁴, 19 дүгээр зүйлийн 19.9-д заасан тусгай шаардлагыг хангасан байна.

1.1.26 Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл өмнөх оноос 27.4 хувь буюу 6,375.8 тэрбум төгрөгөөр өсөж, төлөвлөснөөс 1.8 хувь буюу 553.2 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн байна. Уул уурхайн салбарын идэвхжил өмнөх түвшинд хадгалагдаж, нүүрс, зэсийн баяжмалын биет хэмжээ нэмэгдсэн нь төсвийн орлого өмнөх оноос өсөхөд голлох нөлөө үзүүлсэн байна.

1.1.27 Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл өмнөх оноос 35.9 хувь буюу 8,082.0 тэрбум төгрөгөөр өсөж, төлөвлөснөөс 8.9 хувь буюу 3,004.2 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна.

1.1.28 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл 1,641.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.1 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын 6.1.2⁵-д заасан тусгай шаардлагыг хангасан байна.

1.1.29 Тайлант оны нэгдсэн төсвийн нийт урсгал зарлагын хэмжээ 22,176.6 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 27.7 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3⁶-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.

1.1.30 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 33,399.9 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 41.8 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4⁷-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.

1.1.31 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хоорондын орлого, зарлагын шилжүүлгийг 5,291.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,071.5 тэрбум төгрөгийн гүйлгээг цэвэрлэн тайлагнажээ.

1.1.32 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн орлого 2024 онд өмнөх оноос 29.0 хувиар, нийт зарлага ба цэвэр зээл 35.9 хувиар тус тус өссөн байна. Харин 2020–2024 оны хугацаанд жилийн дундаж өсөлтөөр нь харвал нийт орлого 22.8 хувь, нийт зарлага 23.5 хувиар өссөн байна.


⁴ Төсөвт дараах тусгай шаардлагууд нэгэн зэрэг хангагдсан байна

⁵ нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх;

⁶ нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх;

⁷ Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх;

Дүрслэл 2. Нэгдсэн төсвийн үзүүлэлт 2020-2024 он, тэрбум төгрөг



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

1.1.33 Нэгдсэн төсвийн нийт орлогын өсөлтөөс давсан зарлагын өсөлт нь төсвийн сахилга бат сулрах, улсын өрийн дарамт нэмэгдэх, улмаар макро эдийн засгийн тогтворгүй байдал үүсгэх эрсдэл дагуулах магадлалтай байна.

1.1.34 Нэгдсэн төсвийн алдагдал төлөвлөсөн түвшнээс буурсан хэдий ч төсвийн орлогын бүтэц уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний экспорт, түүний дэлхийн зах зээлийн үнэ ханшаас хэт хамааралтай хэвээр байна.

1.1.35 Үүний зэрэгцээ, нэгдсэн төсвийн нийт зарлагын хэт тэлэлт нь эдийн засгийн дотоод тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж, хувийн хэвшлийн үйл ажиллагааны орчин, хөрөнгө оруулалтын идэвхийг сааруулж болзошгүй байна.

1.1.36 Төсвийн орлогын бүрдүүлэлт уул уурхайн гол нэрийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ ханшаас хэт хамааралтай байгаа тул нэгдсэн төсвийн зарлагыг оновчтой хуваарилах, үр ашиггүй зардлыг бууруулах, өрийн удирдлагын бодлогыг сайжруулах чиглэлд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна.

1.2 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн бодлого, чиглэлийг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэн төлөвлөсөн боловч бодлого чиглэлийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэн дүгнээгүй, үр нөлөөг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулаагүй байна

1.2.1 Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулийн төсөлд Засгийн газраас 2024 онд “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгасан бодлого, арга хэмжээнүүдийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд 6 бодлого чиглэлийг баримтлахаар УИХ-д өргөн барьсан байна.

1.2.2 Эдийн засгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх бодлого, тэргүүлэх чиглэлийн хүрээнд өмнөх онуудад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг хадгалж, макро тогтвортой орчныг дэмжсэн төсөв, мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн, улсын зээлжих зэрэглэлийг ахиулах зорилт тавьж ажилласан байна.

1.2.3 Олон улсын зээлжих зэрэглэлийн Fitch Ratings болон Global Ratings агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “B+”, Moody’s агентлаг “B2, тогтвортой” болгон тус тус нэг шатлалаар нэмэгдүүлэн зарласан байна. Энэ нь Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, олон улсын санхүүгийн зах зээлээс хүү багатай санхүүжилт босгох боломжийг нэмэгдүүлэх, улмаар төсөв, төлбөрийн тэнцэл, валютын ханшид эерэг нөлөө үзүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

1.2.4 Төсвийн бодлогын хүрээнд төсвийн алдагдлыг ДНБ-ий 2.8 хувьд хязгаарлахаар төлөвлөж, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр төсвийн алдагдал 920.3 тэрбум төгрөгт хүрч ДНБ-ий 1.2 хувьтай тэнцсэн байна.

1.2.5 Экспортыг нэмэгдүүлэх бодлого, тэргүүлэх чиглэлийн хүрээнд эдийн засгийн суурийг тэлэх, төрөлжүүлж уул уурхайн болон уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.6 Өмнөх онтой харьцуулахад нийт бараа эргэлтийн хэмжээ 12.1 хувиар, экспорт 3.9 хувиар, импорт 25.5 хувиар тус тус өссөн байна. Экспортын нийт өсөлтөд 54.1 хувийг чулуун нүүрс, 21.0 хувийг зэсийн баяжмал, 5.7 хувийг алт, 3.8 хувийг төмрийн хүдэр, баяжмал, 15.4 хувийг бусад бараа, бүтээгдэхүүний экспорт нөлөө үзүүлсэн байна.

1.2.7 Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр тайлант онд нийт 24.8 сая тонн нүүрс, 3.1 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 5.4 сая тонн зэсийн баяжмал, 17.6 сая тонн хайлуур жоншийг арилжаалсан байна. Монголын Хөрөнгийн бирж ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч 21 компани, гэрээ байгуулсан 471 худалдан авагч бүртгэлтэй байна.

1.2.8 УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-т тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөсний 1 дүгээрт Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина” гэж тусгасан байна.

1.2.9 Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх” арга хэмжээний талаар хэлэлцэж, УИХ-ын 2024 оны “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоолыг баталсан байна.

1.2.10 Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулсан ажлын хэсэг БНХАУ-ын талтай хэлэлцээр хийсний үр дүнд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулж, УИХ-ын 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хэлэлцээрийг соёрхон баталсан байна.

1.2.11 Монгол улс, БНХАУ-ын хилийн боомтууд болох Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүнхатавч хил дамнасан төмөр замын холболтын хэлэлцээр хийгдээгүй байна.

1.2.12 Гаалийн бүрдүүлэлт, хяналтыг хөнгөвчлөх ажлын хүрээнд Гашуунсухайт, Шивээхүрэн, Замын-Үүд зэрэг хилийн боомтуудад ухаалаг гарцыг ашиглалтад оруулж, экспортын үйл ажиллагаанд зарцуулах хугацааг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

1.2.13 Экспортын зах зээлийг өргөжүүлэхээр БНСУ-тай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг шинээр байгуулах бодлогын хүрээнд тус улстай 2023 оноос хойш албан ёсны дөрөв дэх шатны хэлэлцээрийг зохион байгуулсан байна.

1.2.14 Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.11-д “Бүгд Найрамдах Солонгос Улс болон Евро-Азийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулж, худалдааны түнш улс орнуудтай хамтран ажиллах эдийн засгийн чиглэлийг нарийвчлан тодорхойлж, хөрөнгө оруулалт, экспорт, бизнесийг дэмжсэн харилцааг хөгжүүлнэ” гэж тусгасан байна. Энэ хүрээнд Монгол Улс болон Евро-Азийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын Худалдааны түр хэлэлцээрийн албан ёсны яриа хэлэлцээрийг 2023 оноос эхлүүлж, 2024 оны 9 дүгээр сар, 2025 оны 3 дугаар сард хоёр, гурав дахь шатны хэлэлцээрийг хийсэн байна.

1.2.15 **Зохицуулалтыг хялбарчилж, бизнесийг дэмжих бодлого чиглэлийн хүрээнд аливаа** төрлийн бизнес эрхлэхэд тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх чиглэлд төрийн зохицуулалтыг хялбарчилж, хувийн секторын чөлөөт өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилтыг тавьсан байна.

1.2.16 Засгийн газрын 2023 оны 251 дүгээр тогтоолоор “Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх журам”-ыг баталсан байна.

1.2.17 Засгийн газрын 2023 оны 233 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд нэгдсэн сан /license.mn/ системийг хөгжүүлэн хуульд заасан 60 зөвшөөрлийн хүсэлт хүлээн авах, олгох хүртэлх үйл ажиллагааг цахимаар шийдвэрлэж байна.

1.2.18 **Салбаруудыг татааснаас чөлөөлж, цогц шинэчлэл хийх бодлого чиглэлийн** хүрээнд эдийн засгийн салбаруудын өрсөлдөөнийг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог

бууруулах чиглэлд хөдөө, аж ахуйн салбарт бодлогын цогц шинэчлэл хийх, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, нийтийн тээврийн тогтолцоог шинэчлэхэд чиглүүлнэ гэж тодорхойлсон байна.

1.2.19 Монгол Улсын нийт ажиллах хүчний 23.7 хувь буюу 321.3 мянган хүн хөдөө аж ахуйн салбарт ажиллаж, ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 7.4 хувийг эзэлж байна. Хөдөө, аж ахуйн салбарт хүнсний нийлүүлэлтийг дэмжих зорилготой “Хүнсний хувьсгал”, хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих “Цагаан алт” зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

1.2.20 Хөдөө, аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих татаас санхүүжилтийн зардалд 332.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 316.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс 20.8 хувь буюу 65.7 тэрбум төгрөгийг хүнсний улаанбуудай, хүнсний ногоо, сүү, арьс шир, ноосны урамшууллын зардалд, 79.2 хувь буюу 250.7 тэрбум төгрөгийг хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлт болон зээлийн хүүгийн хөнгөлөлтийн татаасны зардалд зарцуулсан байна.

1.2.21 Тайлант онд Хөдөө аж ахуйн биржээр зохион байгуулсан 178 удаагийн цахим арилжааны 936 хэлцлээр 996.8 тэрбум төгрөгийн ноос ноолуур, хүнсний улаанбуудай, тосны ургамал зэргийг арилжиж, арилжааны мөнгөн дүн өмнөх оноос 17.2 хувиар өссөн байна.

1.2.22 Хадлан, тэжээлийн тариалангийн тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны зардлыг бууруулах бодлогын хүрээнд Засгийн газрын 2023 оны 107 дугаар тогтоолын дагуу 2024 онд 569 иргэн, аж ахуй нэгжид 90 төрлийн 1827 тоног төхөөрөмжийн 7.3 тэрбум төгрөгийн гаалийн албан татварын хөнгөлөлт үзүүлсэн байна.

1.2.23 Улаанбаатар хотын агаар дахь хүйтний улирлын PM2.5 тоосонцорын дундаж агууламж 2024 онд 46 мкг/м³ хүрсэн нь 2023 оны үзүүлэлтээс 5 мкг/м³-ээр, төлөвлөсөн зорилтот түвшнээс 15 мкг/м³-ээр их байгаа нь агаарын чанарыг сайжруулах бодлого, арга хэмжээний үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.

1.2.24 **Хөрөнгө оруулалтыг дэмжиж, эдийн засгийг төрөлжүүлэх бодлого, чиглэлийн хүрээнд** бүтээгдэхүүнүүдийн боловсруулалтын түвшнийг шат шатаар ахиулах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, уул уурхайн болон уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийг дэмжинэ гэж тодорхойлсон байна.

1.2.25 Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төлөвлөгөөг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 дугаар тушаалаар баталж, агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг гүйцэтгэхээр тусгаснаас гүйцэтгэл 33.5 хувьтай байна.

1.2.26 Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах металлург-химийн үйлдвэр, (HL-SX/EW) технологиор катодын зэс үйлдвэрлэх төсөл арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэлийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хөрөнгөөс 4.1 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлж, 2019 он, 2022 онд Эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулсан боловч, төлөвлөсөн хугацаанд төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

1.2.27 Эрдэнэставантолгой ХК 485.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий жилд 10.0 сая тонн нүүрс хүлээн авч 2 төрлийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлж, ажлын бодит гүйцэтгэл 95.0 хувьтай байна.

1.2.28 Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани хооронд байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, УИХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн зөвшилцсөний дагуу Засгийн газар, Орано майнинг С.А.С компани хооронд хөрөнгө оруулалтын гэрээг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан байна.

1.2.29 Ховд, Хөвсгөл, Өмнөговь, Чойбалсан аймгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, 4С ангилалтай болгох төслийн ТЭЗҮ-г боловсруулаагүй байна.

1.2.30 Түүх, соёл, байгалийн үзэсгэлэнт газрын нөөц, археологи, палеонтологийн нөөцөд үндэслэсэн аялал жуулчлалын чөлөөт бүсийг байгуулах бодлогын хүрээнд ССАЖЗС-ын

төсвийн багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулах, аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэг байгуулах, Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга барих зэрэг 17.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 2024 онд 14.5 тэрбум төгрөгөөр санхүүжих 8 ТАХ-г баталж, 4 ТАХ-ний 10.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

1.2.31 Засгийн газрын 2023 оны 445 дугаар тогтоолоор “Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн НӨАТ-ын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан байна.

1.2.32 Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагаанд төрөөс дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг УИХ-аас 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан байна. Монгол кино үйлдвэр ТӨҮГ-ын барилга байгууламжийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн төв болгох” төслийн хүрээнд “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн цогцолбор”-ын олон талт арга хэмжээний ажлын зураг төсөл, төсвийг 23.5 тэрбум төгрөгөөр “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-аар хянан баталгаажуулсан ч 2025 оны төсвийн тухай хуулийн хөрөнгө оруулалтын ТАХ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдаагүй байна.

1.2.33 **Амьдралын чанарыг дээшлүүлэх бодлого, чиглэлийн хүрээнд** боловсрол, эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийх, иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.2.34 Япон Улсын Коосэн сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад нэвтрүүлсэн байгууллагын тоог 24-т хүргэхээс 2024-2025 оны хичээлийн жилд шинээр 6 сургалтын байгууллагад тус хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

1.2.35 Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр дэх англи хэлний агуулгыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, (2024-2036)”-ийг баталж, бага боловсрол, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг шинэчлэн боловсруулж, тохирц нийцлийг турших үйл ажиллагааг явуулсан байна.

1.2.36 Цахим системд суурилсан PEARSON англи хэлний хөтөлбөрийг 2023 оноос төрийн өмчийн ерөнхий боловсролын 705 сургуулийн 5-7 дугаар ангид хэрэгжүүлэн 204,563 сурагчдыг хамруулж, 2024-2025 оны хичээлийн жилээс төрийн өмчийн ерөнхий боловсролын 105 сургуулийн 4 дүгээр ангид хэрэгжүүлж, 12,000 сурагчдыг хамруулсан байна.

1.2.37 Улсын Их Хурал 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Үүнтэй уялдуулан Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолоор “Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаадын үйлдвэрлэгч болон олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам”-ыг баталсан байна.

1.2.38 Иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан тодорхой дүрмээр нэмэгдүүлдэг тогтолцоонд шилжих бодлогын хүрээнд Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын цалинг 20.0 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10.0 хувиар, Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр, тэтгэмжийг 100.0 мянган төгрөгөөр, Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа 4 төрлийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийг 10.0 хувиар нэмэгдүүлсэн байна.

1.2.39 Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолоор орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40.0 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн

цалингийн 20.0 хувиар тус тус бодож, сар бүр олгохоор шийдвэрлэсний дагуу 105.2 мянган төрийн албан хаагчдад улсын төсвөөс 308.0 тэрбум төгрөгийн нэмэгдэл хөлс олгосон байна.

1.2.40 Нэгдсэн төсвийн бодлого, чиглэлийг дунд хугацааны хөгжлийн баримт бичиг болон тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тулгуурлан боловсруулсан боловч тухайн жилд хүрэхээр төлөвлөсөн үр дүн, шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус, бодлогын хэрэгжилтийг гүйцэтгэлтэй уялдуулан нэгтгэн дүгнээгүй, үр дүнг тайлагнах үйл явц хангалтгүй байгаагаас төсвийн бодлого, зарцуулалтын үр нөлөөг үнэлэх боломж хязгаарлагдмал байна.

1.2.41 Төсөвт тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй нь хэрэгжилтийн зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. УУЛ УУРХАЙН ЭКСПОРТЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ, НИЙТ ИМПОРТ ТӨЛӨВЛӨСӨН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО БҮРЭН БҮРДЭЭГҮЙГЭЭС НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО 534.5 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР ТАСАРСАН БАЙНА

2.1 Төсвийн орлогод баримталж буй татварын бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн бүс нутгийн хөрөнгө оруулалтыг онилсон, татварын бааз суурийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна

2.1.1 Засгийн газраас 2024 онд төсвийн орлогын чиглэлээр баримтлах татварын бодлогыг 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төсвийн баримт бичгийг боловсруулан, УИХ-д өргөн барьсан байна.

2.1.2 Төсвийн орлогын чиглэлээр баримталсан бодлогын хэрэгжилтийг нэгтгэн тайлагнаж, үр дүнг үнэлж, дүгнээгүй байна.

2.1.3 Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор нүүрс, төмрөөс гадна зэсийн баяжмал, хайлуур жоншийг уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалж эхэлсэн байна.

2.1.4 Уул уурхайн биржээр 2024 онд нийт 571 удаагийн арилжаа амжилттай явагдаж, 24.8 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт 8,894.2 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Үүнээс 312 удаагийн арилжаагаар 22.4 сая тонн нүүрсийг 8,275.9 тэрбум төгрөгөөр, 250 удаагийн арилжаагаар 2.4 сая тонн төмрийн хүдэр, баяжмалыг 567.8 тэрбум төгрөгөөр, 2 удаагийн арилжаагаар 5.4 мянган тонн зэсийн баяжмалыг 40.5 тэрбум төгрөгөөр, 7 удаагийн арилжаагаар 17.6 мянган тонн хайлуур жоншийг 10.0 тэрбум төгрөгөөр арилжаалжээ.

2.1.5 Төрийн өмчит компаниудын нийт арилжааны 59.9 хувь буюу 5,324.9 тэрбум төгрөгийн арилжааг Эрдэнэс тавантолгой ХК, 21.7 хувь буюу 1,928.6 тэрбум төгрөгийн арилжааг Энержи ресурс ХХК, 10.3 хувь буюу 917.2 тэрбум төгрөгийн арилжааг Тавантолгой ХК, 3.3 хувь буюу 296.7 тэрбум төгрөгийн арилжааг Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК, 3.1 хувь буюу 276.5 тэрбум төгрөгийн арилжааг Монголросцветмет ТӨҮГ (хуучин нэрээр) арилжаалсан байна.

2.1.6 Замын-Үүд, Гашуунсухайт боомтын импортын тээврийн хэрэгслийн 9 гарцыг 23, экспортын 5 гарцыг 27, нүүрс тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх экспортын 6 гарцыг 10 болгон өргөтгөж, Шивээ хүрэн боомтын хилийн шалган нэвтрүүлэх 8 хаалгыг шинээр ашиглалтад оруулсан байна.

2.1.7 Засгийн газрын 2024 оны “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 64 дүгээр тогтоолд “Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатар”-ын бүсчилсэн тогтолцоонд чиглэсэн татварын бодлогоор 2024 онд Нийслэлээс алслагдсан аймаг, сумдад үйл ажиллагаа эрхэлж буй 369 хуулийн этгээд 34.3 тэрбум төгрөг, 54 иргэн 0.3 тэрбум төгрөгийн шаталсан хөнгөлөлтөд хамрагдаж, өмнөх оноос хуулийн этгээдийн хамрагдалт 27.7 хувиар нэмэгдсэн байна.

2.1.8 Орон нутагт шинээр барьсан нийтийн зориулалттай орон сууц борлуулсны орлогод ногдох албан татвараас 12 иргэн 0.9 тэрбум төгрөг, орон нутаг дахь түрээсийн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор амьдран суух зориулалтаар орон сууц түрээслүүлсний орлогод ногдох албан татвараас 2 иргэнд хөнгөлөлтийг эдлүүлсэн байна.

2.1.9 Татварын орчин, тайлагналыг хялбаршуулах замаар малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулж, боловсруулах үйлдвэрүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд 71894 малчдын борлуулсан бүтээгдэхүүн /таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр/-ийг 1,964.1 тэрбум төгрөгөөр худалдан авсан 889 татвар төлөгч 1,785.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.

2.1.10 Хөрөнгө оруулалтын орчныг энгийн ойлгомжтой болгох, хялбаршуулах үүднээс кастодиан банк болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК нэгдсэн журмаар татварыг суутган тооцож, татвар төлөгчийн өмнөөс тайлагнах зохицуулалттай болсон байна.

2.2 Уул уурхайн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай орлогод суурилсан төсвийн тэлэлт эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлсээр байгаа тул Үндэсний баялгийн сангийн эх үүсвэрийг тогтвортой хуримтлуулж, үр ашигтай удирдах шаардлагатай байна

2.2.1 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийг 31,991.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 31,456.6 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 98.3 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 29.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж, /тэрбум төгрөг/


Төсвийн орлого	2023 оны гүйц	2024 оны				Өмнөх оноос өөрчлөлт
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
Нийт орлого ба тусламжийн дүн	24,387.0	31,991.1	31,456.6	(534.5)	98.3	7,069.6
Тогтворжуулалтын сан	675.9	478.6	443.9	(34.7)	92.7	(232.0)
Ирээдүйн өв сан	416.2	789.0	841.3	52.3	106.6	425.1
Хуримтлалын сан	-	499.5	500.6	1.1	100.2	500.6
Хөгжлийн сан	-	-	-	-	-	-
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	23,294.9	30,224.0	29,670.8	(553.2)	98.2	6,375.9
Татварын орлого	21,484.2	27,910.6	27,417.3	(493.3)	98.2	5,933.1
Татварын бус орлого	1,810.7	2,313.4	2,253.5	(59.9)	97.4	442.8
Төсвийн бүрэлдэхүүнээр:						
Улсын төсвийн орлого	16,085.2	20,173.7	20,089.1	(84.6)	99.6	4,003.9
Орон нутгийн төсвийн орлого	4,891.3	7,483.9	7,121.8	(362.1)	95.2	2,230.5
НДС-ийн орлого	4,271.6	5,893.3	5,609.7	(283.6)	95.2	1,338.1
ЭМДС-ийн орлого	1,586.8	1,964.8	1,921.7	(43.0)	97.8	334.9

Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тайлан

2.2.2 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн 87.2 хувийг татварын орлого, 7.1 хувийг татварын бус орлого, 1.4 хувийг Тогтворжуулалтын санд, 2.7 хувийг Ирээдүйн өв санд, 1.6 хувийг Хуримтлалын санд төвлөрүүлэх орлого эзэлж байна.

2.2.3 Улсын төсвийн орлого 99.6 хувь, ЭМДС-ийн орлого 97.8 хувь, орон нутгийн төсвийн орлого 95.2 хувь, НДС-ийн сангийн орлого 95.2 хувь, ҮБС-ийн орлого 104.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дүрслэл 3. Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн бүтэц /тэрбум төгрөг/



2.2.4 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн төлөвлөснөөс 1.7 хувь буюу 534.5 тэрбум төгрөгийн орлого тасарсан байна. Үүнд: НӨАТ 353.4 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж 305.5 тэрбум төгрөгөөр, бусад татвар (төлбөр, хураамж) 186.2 тэрбум төгрөгөөр, гадаад үйл ажиллагааны орлого 140.2 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 59.9 тэрбум төгрөгөөр тасарч, орлогын албан татвар 349.9 тэрбум төгрөгөөр, онцгой албан татвар 139.4 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн албан татвар 4.2 тэрбум төгрөгөөр давсан нь голлон нөлөөлсөн байна.

2.2.5 Мөн уул уурхайн экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, импортын урсгал нэмэгдсэнтэй холбоотойгоор орлогын татвар 349.9 тэрбум төгрөгөөр, онцгой албан

татвар 139.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол нийт импорт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, 36.0 мянган аж ахуй нэгж, байгууллагын НДШ-ийн авлага барагдаагүйгээс нийт орлого ба тусламж 534.5 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

2.2.6 Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 30,224.0 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 29,670.8 тэрбум төгрөгт хүрч, 98.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.2.7 Тайлант оны нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн ДНБ-ий 37.1 хувьтай тэнцэж, төлөвлөснөөс 1.8 хувиар дутуу биелж, өмнөх оноос 27.3 хувиар өссөн байна.

2.2.8 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн өмнөх оноос 6,375.9 тэрбум төгрөгөөр өсөхөд татвар төлөгч аж ахуйн нэгж 9.4 хувиар өссөн, эдийн засгийн идэвхжил сэргэж татварын болон татварын бус орлого 27.4 хувь, гадаад худалдааны нийт эргэлт 12.2 хувь, импорт 25.6 хувь, экспорт 3.9 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

2.2.9 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 59.3 хувийг улсын, 19.7 хувийг орон нутгийн, 14.1 хувийг НДС, 2.7 хувийг ЭМДС, 4.3 хувийг ҮБС орлогоос бүрдүүлжээ.

2.2.10 Орон нутгийн ТЕЗ нарын ирүүлсэн төсвийн орлогын саналыг Сангийн яам 2,512.8 тэрбум төгрөгөөр, аймгуудын ИТХ 2,219.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 7,483.9 тэрбум төгрөгөөр баталсан байна.

2.2.11 Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн 43.4 хувийг Улаанбаатар хот, 26.4 хувийг Өмнөговь, 4.4 хувийг Орхон, 2.2 хувийг Дорноговь, 2.0 хувийг Төв, 23.6 хувийг бусад аймгууд бүрдүүлсэн байна.

2.2.12 Бүсчлэлээр орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн 43.4 хувийг Улаанбаатарын бүс, 30.4 хувийг Говийн бүс, 7.3 хувийг Хойд бүс, 6.0 хувийг Баруун бүс, 5.1 хувийг Төвийн бүс, 3.9 хувийг Хангайн бүс эзэлж байна.

2.2.13 ААНОАТ-аас 2024 онд аймаг, нийслэлийн төсөвт 2,111.4 тэрбум төгрөгийг шилжүүлэн хуваарилсан байна. Тухайлбал: Өмнөговь аймаг 1,161.4 тэрбум төгрөг, Улаанбаатар хот 710.0 тэрбум төгрөг, Орхон аймаг 100.0 тэрбум төгрөг байна.

Нүүрс, зэсийн баяжмал, газрын тосны олборлолт, экспортын биет хэмжээ нэмэгдсэнээр орлого төлөвлөснөөс 18.6 хувиар давж, өмнөх оноос 33.1 хувиар нэмэгдсэн байна

2.2.14 Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого төлөвлөснөөс 18.6 хувиар давж, өмнөх оноос 33.1 хувиар өсөж, эдийн засгийн 4.9 хувийн өсөлтийн 1.4 нэгж хувийг эзэлж байгаа нь ашигт малтмалын олборлолт, экспортын биет хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2.15 Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний нийт орлогын 40.8 хувийг АМНАТ, 35.2 хувийг ААНОАТ, 12.2 хувийг бусад татвар, хураамж, 5.6 хувийг ногдол ашиг, 4.2 хувийг гаалийн татвар, хураамж, 2.1 хувийг НӨАТ тус тус эзэлж байна.

2.2.16 Тайлант онд АМНАТ-ийн орлогыг 4,750.6 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 4,674.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, төсвийн тогтворжуулалтын санд 296.7 тэрбум төгрөг, улсын төсөвт 3,536.8 тэрбум төгрөгийг хуваарилсан байна.

Хүснэгт 3. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого бүрдүүлэлт, /тэрбум төгрөг/

Татварын төрөл	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
АМНАТ	1,218.2	1,587.9	2,912.5	4,210.6	4,674.8
ААНОАТ	659.4	1,504.7	1,110.2	2,190.7	4,034.2
НӨАТ	112.4	147.8	167.6	213.7	237.5
Гаалийн татвар, хураамж	259.5	250.7	269.4	349.3	483.4
Ногдол ашиг	159.5	204.8	450.8	564.8	645.9
Бусад	393.1	628.3	605.6	1,087.4	1,394.1
Дүн	2,802.1	4,324.2	5,516.1	8,616.5	11,469.9

Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

2.2.17 Нэгдсэн төсвийн нийт орлогын 36.4 хувийг уул уурхай, газрын тосны салбарын орлого бүрдүүлж байгаагаас гол нэр төрлийн эрдэс баялаг болох нүүрс 23.4 хувийг, зэсийн баяжмал 8.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ, /тэрбум төгрөг/

№	Бүтээгдэхүүн нэр төрөл	Биет хэмжээ				Үнэ, ам доллар/нэгж			Орлого /тэрбум төгрөг/		
		х/н	2023 гүйц	2024		2023 гүйц	2024		2023 гүйц	2024	
				Төл	Гүйц		Төл	Гүйц		Төл	Гүйц
1	Нүүрс	сая.тн	69.6	78.1	83.8	128.0	115.0	103.9	4,723.8	6,019.1	7,373.2
2	Зэсийн баяжмал	сая.тн	1.5	1.6	1.7	8,474.0	9,500.0	9,184.0	2,742.6	2,631.6	2,699.6
3	Алт, тушаасан (цэвэр жингээр)	тн, \$/унц	12.4	18.0	10.9	2,022.0	2,200.0	2,483.4	311.7	272.6	375.4
4	Төмрийн хүдэр	сая.тн	5.7	8.4	7.5	78.0	78.0	79.6	117.5	260.5	200.1
5	Боловсруулаагүй нефть	сая.бар	4.7	4.2	4.1	77.0	80.0	76.5	304.2	284.9	237.8
6	Бусад								416.8	198.4	583.8
Дүн									8,616.6	9,667.1	11,469.9

Эх сурвалж: Сангийн яам, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

2.2.18 Уул уурхайн салбарын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний төлөвлөсөн үнэ буурсан боловч нүүрсний биет хэмжээ 83.8 сая тоннд хүрч 20.4 хувиар, зэсийн баяжмалын биет хэмжээ 1.7 сая тоннд хүрч 16.2 хувиар өсөж, 1,802.8 тэрбум төгрөгөөр орлого давж биелсэн байна.

2.2.19 Уул уурхайн салбарын голлох нэр төрлийн бүтээгдэхүүн болох нүүрсний борлуулалтын биет хэмжээ өмнөх оноос 20.4 хувь буюу 14.2 сая тонн, төлөвлөснөөс 7.3 хувь буюу 5.7 сая тоннд хүрч нэмэгдсэн байна.

2.2.20 Гадаадын шууд хөрөнгө оруулалтад уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт 75.3 хувь, гадаад худалдааны экспортод уул уурхай эрдэс баялгийн бүтээгдэхүүн 86.6 хувийг эзэлж байна.

Төсвийн тогтворжуулалтын санд 443.9 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 841.3 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 500.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн боловч Ирээдүйн өв сангийн хөрөнгийг мандатын дагуу удирдах, хянах тогтолцоо бүрдээгүй байна

2.2.21 Тогтворжуулалтын санд 478.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 92.8 хувь буюу 443.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ. Үүнээс ААНОАТ-аас 144.3 тэрбум төгрөг, АМНАТ-өөс 296.7 тэрбум төгрөг, хүүгийн орлогоос 2.9 тэрбум төгрөгийг бүрдүүлжээ.

2.2.22 Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого төлөвлөснөөс 7.2 хувь буюу 34.6 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь нүүрсний биет хэмжээ 83.8 сая тоннд хүрч 20.3 хувиар, зэсийн баяжмалын биет хэмжээ 1.7 сая тоннд хүрч 16.2 хувиар өссөн боловч нүүрсний тэнцвэржүүлсэн үнэ зах зээлийн дундаж үнээс өндөр байсан нь нөлөөлсөн.

Хүснэгт 5. Төсвийн тогтворжуулалт, Үндэсний баялгийн сангийн орлого, /тэрбум төгрөг/

Он	Нийт орлого ба тусламж	ДНБ	Хуримтлал				Эзлэх хувь	
			Ирээдүйн өв сан	Тогтворжуулалтын сан	Хуримтлалын сан	Дүн	Нийт орлогод	ДНБ-д
2011	4,468.20	13,173.80	-	241.0	-	241.0	5.4	1.8
2012	4,975.80	16,688.40	-	94.7	-	94.7	1.9	0.6
2013	5,986.90	19,174.20	-	46.9	-	46.9	0.8	0.2
2014	6,316.50	22,227.00	-	39.9	-	39.9	0.6	0.2
2015	5,983.40	22,894.80	-	2.3	-	2.3	0.0	0.0
2016	5,835.00	23,931.30	-	-	-	-	-	-
2017	7,958.30	28,010.70	357.7	325.7	-	683.4	8.6	2.4
2018	10,172.80	32,582.60	620.7	207.0	-	827.7	8.1	2.5
2019	12,040.30	37,839.20	1,040.2	94.6	-	1134.8	9.4	3.0

2020	10,450.20	37,453.30	914.1	66.2	-	980.3	9.4	2.6
2021	14,306.40	43,555.50	967.0	627.9	-	1594.9	11.1	3.7
2022	18,521.60	53,851.50	1,626.3	1,394.6	-	3064.9	16.5	5.7
2023	24,387.10	70,441.50	416.2	675.9	-	1092.1	4.5	1.6
2024	31,456.60	79,956.30	841.3	443.9	500.6	1,785.8	5.7	2.2

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.2.23 Засгийн газрын 2025 оны “Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн хөрөнгийн удирдлагын бодлого батлах тухай” 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд даалгаж, Монголбанканд зөвлөсөн байна.

2.2.24 Ирээдүйн өв сангийн болон Хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын бодлогыг баталсан боловч Ирээдүй өв сангийн тухай хуульд заасан тус сангийн хөрөнгийг мандатын дагуу удирдах, хянах тогтолцоо бүрдээгүй байна.

2.2.25 Ирээдүйн өв санд 789.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 841.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, Монголбанканд гадаад валютаар хадгаламж байршуулах гэрээг 2025 оны 3 сард байгуулж, нийт 4,103.2 тэрбум төгрөгийн хөрөнгийг арвижуулахаар хадгаламж хэлбэрээр байршуулсан байна.

2.2.26 Харин хуримтлалын санд 499.5 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 500.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 495.6 тэрбум төгрөгийг Монголбанкт гэрээ байгуулж, орон сууцны зээлээр баталгаажсан үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийсэн байна.

2.2.27 Тогтворжуулалтын санд 2011-2024 онд нийт 4,260.7 тэрбум төгрөг, Ирээдүй өв санд 6,783.6 тэрбум төгрөг, Хуримтлалын санд 500.6 тэрбум төгрөгийн хуримтлал үүсгэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, хүний хөгжил сангийн өглөг барагдуулах, хүүхдийн мөнгөн хуримтлал олгоход 5,483.4 тэрбум төгрөгийг зарцуулж, тайлант оны эцэст 5,750.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.3 Уул уурхайн экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, нийт импортын урсгал өмнөх оноос нэмэгдсэн зэргээс шалтгаалан татварын орлого 115.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна

2.3.1 Монгол Улсын 2024 оны улсын төсөвт нийт 16,917.9 тэрбум төгрөгийн татварын орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 17,033.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, баталсан төлөвлөгөө 115.2 тэрбум төгрөг буюу 0.7 хувиар давж биелсэн байна.


Хүснэгт 6. Монгол Улсын 2024 оны улсын төсвийн татварын орлого, /тэрбум төгрөг/

№	Үзүүлэлт	2023 оны Гүйц	2024 оны				Өмнөх оноос өөрчлөлт
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	Б	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
1	Татварын орлого	13,715.0	16,917.9	17,033.1	115.2	100.7	3,318.2
1.1	Орлогын албан татвар	2,716.7	3,781.3	4,307.6	526.3	113.9	1,590.9
1.4	Нэмэгдсэн өртгийн албан татвар	4,777.0	6,220.2	5,866.8	(353.4)	94.3	1,089.8
1.5	Онцгой албан татвар	790.1	968.0	1,107.4	139.4	114.4	317.3
1.6	Тусгай зориулалтын орлого	21.6	28.0	26.4	(1.6)	94.3	4.8
1.7	Гадаад үйл ажиллагааны орлого	1,465.3	1,932.5	1,792.3	(140.2)	92.7	327.0
1.8	Бусад татвар (Төлбөр, хураамж)	3,944.2	3,987.9	3,932.6	(55.3)	98.6	(11.6)

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.3.2 Улсын төсвийн татварын орлого 100.7 хувийн биелэлтэд онцгой албан татвар 14.4 хувь, орлогын албан татвар 13.9 хувиар давж, гадаад үйл ажиллагааны орлого 7.3 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 5.7 хувь, тусгай зориулалтын орлого 5.7 хувь, бусад татвар төлбөр, хураамж 1.4 хувиар тасарсан нь нөлөөлжээ.

Дүрслэл 4. Татварын орлогын дүн, төрлөөр /тэрбум төгрөг/



2.3.3 Улсын төсвийн татварын орлого гүйцэтгэлээр 115.2 тэрбум төгрөг, өмнөх оноос 24.2 хувь буюу 3,318.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2.3.4 Орлогын албан татварын орлогод 3,781.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 4,307.6 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, баталсан төлөвлөгөө 526.3 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар давж, өмнөх

оноос 1,590.9 тэрбум төгрөг буюу 58.5 хувиар өссөн байна.

2.3.5 ААНОАТ-ын орлого нэмэгдэхэд татвар төлөгч аж ахуйн нэгжийн тоо 9.4 хувь, зах зээл дэх мөнгөний нийлүүлэлт 15.2 хувь, инфляцын түвшин 1.1 нэгж хувиар өсөж, нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд хүрсэн зэргээс шалтгаалжээ.

2.3.6 Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогод 6,220.2 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 5,866.8 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 353.4 тэрбум төгрөгөөр тасарсан нь нийт импорт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, НӨАТ-ын төлбөрийн хугацаа сунгалт, хойшлуулалт нэмэгдсэн, дотоодын барааны "0" хувь ногдуулалтын хэмжээ өссөн, НӨАТ-ын хуримтлагдсан өр 538.7 тэрбум төгрөг болсон зэргээс шалтгаалсан байна.

2.3.7 Онцгой албан татварын орлогод 968.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 1,107.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 114.4 хувийн гүйцэтгэлд нийт импортын хэмжээ өмнөх оноос 25.6 хувиар, импортолсон суудлын автомашины тоо 122,761 буюу 67.8 хувиар өссөн нь нөлөөлжээ.

2.3.8 Тусгай зориулалтын албан татварын орлогод 28.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 26.4 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 1.6 тэрбум төгрөгөөр тасарсан нь А-80 бензиний импорт 26.1 хувиар, ногдуулсан татварын хэмжээ 5.6 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2.3.9 Гадаад үйл ажиллагааны орлогод 1,932.5 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 1,792.3 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 140.2 тэрбум төгрөгөөр тасарсан нь нийт импортын төлөвлөсөн хэмжээ 11.8 тэрбум ам.долларт хүрээгүйгээс шалтгаалсан байна.

2.3.10 Бусад нийтлэг төлбөр хураамжийн орлогод 3,987.9 тэрбум төгрөг төлөвлөснөөс 3,932.6 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 55.3 тэрбум төгрөгөөр тасарсан нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ буурснаас ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дутуу төвлөрсөнтэй холбоотой байна.

Хувьцааны ногдол ашгийг бүрэн төвлөрүүлээгүй, газрын тосны экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, гэрээлэгч компаниуд газрын тосны орлогоо он дамнуулан төвлөрүүлсэн зэргээс татварын бус орлого 199.8 тэрбум төгрөгөөр тасарсан байна

2.3.11 Монгол Улсын 2024 оны төсөвт нийт 3,255.8 тэрбум төгрөгийн татварын бус орлогыг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 3,056.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, баталсан төлөвлөгөө 199.7 тэрбум төгрөг буюу 6.1 хувиар дутуу биелсэн байна.

Хүснэгт 7. Монгол Улсын 2024 оны улсын төсвийн татварын бус орлого, /тэрбум төгрөг/

Д.д	Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 он				Өмнөх оноос өөрчлөлт
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
1А	Б	1	2	3	4=3-2	5=3/2	6=3-1
2	Татварын бус орлого	2,370.2	3,255.8	3,056.0	(199.8)	93.9	685.8
2.1	Нийтлэг татварын бус орлого	1,024.1	1,098.4	1,178.5	80.1	107.3	154.4

2.1.1	Хувьцааны ногдол ашиг	32.1	100.0	40.1	(59.9)	40.1	8.0
2.1.2	Хүү, торгуулийн орлого	166.3	161.2	189.4	28.2	117.6	23.1
2.1.3	Түрээсийн орлого	3.7	1.2	3.9	2.7	325.0	0.2
2.1.4	Газрын тосны орлого	304.2	284.9	237.8	(47.1)	83.5	(66.4)
2.1.5	Навигацийн орлого	5.0	80.0	80.0	-	100.0	75.0
2.1.6	Төсөв байгууллагын өөрийн орлого	404.6	299.4	413.2	113.8	138.0	8.6
2.1.7	Бусад орлого	108.2	171.7	214.1	42.4	124.7	105.9
2.3	Тусламжийн орлого	1,346.1	2,157.4	1,877.5	(279.9)	87.0	531.4

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.3.12 Нийтлэг татварын бус орлогод 1,098.4 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 1,178.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 80.1 тэрбум төгрөгөөр давсан нь төсөвт байгууллагын өөрийн орлого 113.9 тэрбум төгрөг, бусад орлого 42.4 тэрбум төгрөгөөр давснаас шалтгаалсан байна.

2.3.13 **Хувьцааны ногдол ашиг** 59.9 тэрбум төгрөг буюу 18.0 хувиар тасарсан нь ТӨБЗГ-ын 2024 оны 351 дүгээр тогтоолын хэрэгжилт хангалтгүй, тогтоолд өөрчлөлт оруулж, зарим хуулийн этгээдийн төвлөрүүлэх ногдол ашгийг чөлөөлж, дутуу төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

- ТӨБЗГ-ын 2024 оны 351 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөнд 2 удаа өөрчлөлт оруулан Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн 1.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг чөлөөлж, Монголын төмөр зам ТӨХК-ийн ногдол ашгийг 3.2 тэрбум төгрөгөөр бууруулсан;
- Эрдэнэсант АЗЗА ХХК 0.01 тэрбум төгрөг, Эрчис ойл ХХК 2.6 тэрбум төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлээгүй;
- Монголросцветмет ТӨҮГ төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн актын төлбөрийг 23.4 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн, Цемент шохой ТӨХК 5.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийн төлбөрийн актыг биелүүлээгүй;

2.3.14 **Газрын тосны орлого** улсын төсөвт 237.8 тэрбум төгрөгийн газрын тосны орлогыг төвлөрүүлж, баталсан төлөвлөгөө 47.1 тэрбум төгрөгөөр тасарсан нь газрын тосны экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 135.9 мянган баррелиар багассан, гэрээлэгч компаниуд 2024 оны 10, 11 дүгээр сарын 36.6 тэрбум төгрөгийн орлогыг 2025 оны 01 дүгээр сард төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

2.3.15 **Төсөвт байгууллагын өөрийн орлого** 413.3 тэрбум төгрөг буюу 113.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь 334 байгууллагын үйл ажиллагааны орлого 169.7 тэрбум төгрөгөөр давсан, 42 байгууллага төлөвлөөгүй 27.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлснээс шалтгаалсан байна.

2.3.16 **Түрээсийн орлогод** 1.2 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 3.9 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 2.7 тэрбум төгрөг буюу 3.3 дахин давж биелсэн нь үндэслэлтэй төлөвлөөгүйтэй холбоотой байна.

2.3.17 **Тусламжийн орлого** тайлант онд 33 төсөл, арга хэмжээг нийт 560.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 22 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, 461.5 тэрбум төгрөгийн ашиглалт гарсан байна.

2.3.18 **Төсөв хоорондын шилжүүлэг** Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 1,595.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,415.9 тэрбум төгрөгийн орлогыг орон нутгаас төвлөрүүлж, 179.4 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

- Дорноговь аймгийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөө биелээгүйгээс 8.6 тэрбум төгрөг;
- Өмнөговь аймгийн "1000 айл орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд 2015 онд аж ахуй нэгж, иргэдэд олгосон зээлийн санхүүжилтийн авлагын үлдэгдлийг төлөвлөсөн хэмжээнд барагдуулж чадаагүйгээс 170.3 тэрбум төгрөг;
- Сэлэнгэ аймгийн Дархан-Сэлэнгийн авто замаас Түшиг-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг Зэлтэрийн боомт чиглэлийн 120.9 км хатуу хучилттай авто зам төслийн хүрээнд карьерын төлбөрийг Засгийн газраас чөлөөлснөөс шалтгаалан түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн төлөвлөгөө биелээгүйгээс 0.4 тэрбум төгрөг.

2.3.19 **Татварын зарлага** буюу тайлант оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 1,587.2 тэрбум төгрөгт хүрч, татварын нийт орлогын 5.0 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 8. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн судалгаа, /тэрбум төгрөг/

Татварын зарлага 2020-2024	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Нийт орлого	10,444.2	14,255.2	18,521.6	24,387.1	31,456.6
Нийт орлогод эзлэх хувь	8.7	6.8	6.5	4.3	5.0
Татварын байгууллага	807.4	773.5	1,028.2	910.5	1,443.2
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	201.5	289.0	443.3	424.6	946.5
Хувь хүний орлогын албан татвар	386.9	181.6	202.2	204.8	209.1
Нэмэгдсэн өртгийн албан татвар	115.0	173.3	197.5	281.1	287.6
Онцгой албан татвар	104.0	129.6	185.2	-	-
Гаалийн байгууллага	98.9	189.7	171.0	142.9	144.0
Гаалийн албан татвар	30.8	59.9	63.5	38.6	38.4
Нэмэгдсэн өртгийн албан татвар	68.1	129.8	107.5	104.3	105.6
Нийт татварын зарлага	906.3	963.2	1,199.2	1,053.4	1,587.2

Эх сурвалж: ТЕГ, ГЕГ, СЯ

2.3.20 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу чөлөөлсөн 743.2 тэрбум төгрөг, хөнгөлөлт 203.3 тэрбум төгрөг, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар чөлөөлсөн 13.9 тэрбум төгрөг, хөнгөлөлт 195.2 тэрбум төгрөг, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт 287.6 тэрбум төгрөгт тус тус хүрчээ.

2.3.21 Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулиар иргэний агаарын хөлөг, хөдөлгүүр болон газар дээрх дадлагажуур, тэдгээрийн эд анги, бүрэлдэхүүн хэсэг, дэд угсралтын хэсэг, сэлбэг, тоног төхөөрөмж, холбогдох хэрэгсэлд 11.2 тэрбум төгрөг, 24 болон түүнээс дээш суудалтай, 45 болон түүнээс дээш зорчигчийн багтаамжтай, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний зориулалт бүхий шинэ автобусанд 9.0 тэрбум төгрөг, агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах зорилгоор импортоор оруулж байгаа агаар цэвэршүүлэгч, эрчим хүчний хэмнэлттэй халаагч төхөөрөмжид 4.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг үзүүлсэн байна.

2.3.22 Орон нутгийн бүсчилсэн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд 2024 онд шинээр 113 хуулийн этгээд 43.3 тэрбум төгрөг, давхардсан тоогоор үйл ажиллагаа нь үргэлжилж буй 5488 татвар төлөгч 160.0 тэрбум төгрөг, нийт 5601 татвар төлөгч 203.3 тэрбум төгрөгийн ААНОАТ-ын хөнгөлөлт эдлүүлсэн байна.

Татварын системд бүртгэлтэй олон жилийн насжилттай хуримтлагдсан өр, гэмт хэргийн шинжтэй хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зөрчлийн дүн татварын орлогын 26.7 хувьд хүрсэн нь улсын төсвийн орлого бүрдэхгүй байх, татвараас зайлсхийх, далд эдийн засгийг дэмжих, орлогоо нуун дарагдуулах, НӨАТ-ын хий бичилт хийх зэрэг эрсдэлийг үүсгэж байна

2.3.23 Татварын байгууллагаас гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй НӨАТ-ын хий бичилттэй холбоотой 950.0 тэрбум төгрөг, бусад гэрээ, бараа, ажил, үйлчилгээ, мөнгө угаасан байж болзошгүй 6,369.5 тэрбум төгрөг, нийт 7,319.5 тэрбум төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн нь 2024 оны татварын орлогын 26.7 хувьтай тэнцэж байна.

2.3.24 Татварын системд 1990 оноос хойш үүссэн 3,258.6 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэл байгаагаас шалтгаантай буюу төлөгдөхгүй байгаа насжилт өндөртэй 1,050.4 тэрбум төгрөгийн өр бүртгэлтэй байна.

Хүснэгт 9. Татварын өрийн мэдээлэл /1990-2023 оноор/

Он	1990-2018	2019	2020	2021	2022	2023
Татварын нийт орлого		9,813.2	8,511.6	11,299.9	15,459.0	21,484.2
Эзлэх хувь		1.9	2.7	3.2	5.0	5.2
Нийт өр	3,258.5	574.4	184.6	231.1	359.9	1,122.8
ААНОАТ	503.9	46.9	22.2	33.0	80.9	154.5
Агаарын бохирдол	11.6	3.4	1.3	0.7	1.0	4.2
АМНАТ	827.5	47.1	33.4	39.2	56.0	413.3
НӨАТ	1,910.2	473.4	127.4	157.9	221.9	379.3
Онцгой	5.2	3.6	0.3	0.3	0.3	0.4
Ус бохирдуулсны төлбөр	0.1	-	-	-	-	-
Үүнээс өрийг ангилж үзэхэд						

Татварын төрөл	Нийт дүн	1990-2018	2019	2020	2021	2022	2023
Шалтгаантай өр	1,050.4	409.1	41.1	38.5	20.1	285.7	255.9
Барагдах өрийн дүн	2,208.2	165.4	143.6	192.5	339.9	499.9	866.9

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн үзүүлэлт

2.3.25 Насжилт өндөртэй хуримтлагдсан өрийн үлдэгдэл 2021 онд 20.1 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 285.7 тэрбум төгрөг, 2023 онд 255.9 тэрбум төгрөг болсон нь цаашид өсөх эрсдэлтэй байна.

Татварын төрөл түс бүрээр өр төлөгдөхгүй байгаа шалтгаан нь:

- НӨАТ-ын 538.7 тэрбум төгрөгийн өр нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой 276.8 тэрбум төгрөг, шүүхийн маргаантай 39.0 тэрбум төгрөг, санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй улсын бүртгэлээс хасахаар хүлээгдэж буй 88.6 тэрбум төгрөг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 34.2 тэрбум төгрөг, эрэн сурвалжилж байгаа 86.7 тэрбум төгрөг, шүүхийн шийдвэр гарсан НӨАТ-ийн хий бичилт 6.3 тэрбум төгрөг, эзэн холбогдогч нь нас барсан 3.4 тэрбум төгрөг, дампуурсан 3.8 тэрбум төгрөг;
- АМНАТ-ын 380.0 тэрбум төгрөгийн өр нь шүүхийн маргаантай 376.6 тэрбум төгрөг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 1.9 тэрбум төгрөг, санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй улсын бүртгэлээс хасахаар хүлээгдэж буй хуулийн этгээдүүдийн 1.0 тэрбум төгрөг, эрэн сурвалжилж байгаа 0.5 тэрбум төгрөг;
- ААНОАТ-ын 111.7 тэрбум төгрөгийн өр нь дампуурсан 5.5 тэрбум төгрөг, бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой 8.2 тэрбум төгрөг, маргаантай 74.8 тэрбум төгрөг, санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй улсын бүртгэлээс хасахаар хүлээгдэж буй 7.1 тэрбум төгрөг, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 9.4 тэрбум төгрөг, эрэн сурвалжилж байгаа 4.8 тэрбум төгрөг, шүүхийн шийдвэр гарсан хий бичилттэй холбоотой 0.6 тэрбум төгрөг, нас барсан 1.2 тэрбум төгрөг;
- Алтны үнийн өсөлтийн албан татварын 14.8 тэрбум төгрөгийн өр нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 10.9 тэрбум төгрөг, дампуурсан 3.8 тэрбум төгрөг, эрэн сурвалжилж байгаа 0.093 тэрбум төгрөг;
- Онцгой албан татварын 4.5 тэрбум төгрөгийн өр нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа 4.5 тэрбум төгрөг, эзэн холбогдогч нас барсан 0.1 тэрбум төгрөг.

БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН БОДЛОГО НЬ УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛД НИЙЦҮҮЛЭН ЗОРИМОГ ШИЙДВЭРҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨСӨН БОЛОВЧ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭЭГҮЙ, ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД УЛС ТӨРИЙН НӨЛӨӨ ӨНДӨР БАЙГААГААС УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ АЛДАГДАЖ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ БУУРСАН БАЙНА

3.1 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын бодлого нь улс төр, эдийн засгийн шинэ нөхцөл байдалд нийцүүлэн зоримог шийдвэрүүдийг төлөвлөсөн боловч гүйцэтгэлийн үр дүнг үнэлээгүй байна

3.1.1 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд төсвийн зарлагын чиглэлээр 5 бодлогыг хэрэгжүүлэхээр төсвийн баримт бичгийг боловсруулан, УИХ-д өргөн барьж баталжээ.

3.1.2 “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, инфляцтай уялдсан цалин тэтгэврийг нэмэгдүүлэх, шинээр батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг хуваарилах, дэлхийн стандартад нийцсэн үндэсний эмнэлгүүдийг байгуулах, гадаад зээл тусламжийн санхүүжилтээр тэргүүлэх ач холбогдолтой томоохон төслүүдийг санхүүжүүлэх, ашиглалтыг сайжруулах талаарх эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

3.1.3 Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон нь Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх нөхцөлийг бүрдүүлж, улс төрийн гурван намаас “ХҮРДАЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ ЗОРИГ” гэрээ байгуулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулан зарлагын чиглэлээр 2 бодлогыг нэмж төлөвлөн баталжээ.

3.1.4 Тус бодлогод эдийн засгийн суурийг тэлж эрчим хүчний үнэ тарифын реформыг эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж либералчлах, хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх шилжилтийн үеийн зардлыг санхүүжүүлэх, эрчим хүч, дэд бүтэц, аж үйлдвэржилтийн хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр тусгаж, нийт 3,127.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж баталсан байна.

3.1.5 Иргэдийн бодит орлогыг хамгаалах бодлогын хүрээнд Боловсролын ерөнхий хуулиар 96.8 тэрбум төгрөг, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд Нийгмийн даатгалын багц хуулиар 445.4 тэрбум төгрөг, Төрийн албаны тухай хуулиар 81.9 тэрбум төгрөг, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд төрийн захиргаа болон нийтлэг үйлчилгээний бүх албан хаагчид суманд 40.0 хувь, аймгийн төвд 20.0 хувийн нэмэгдэл олгоход 218.3 тэрбум төгрөг, нийт 842.4 тэрбум төгрөгийн зардлын эх үүсвэрийг хуульчлан баталсан нь төсвийн урсгал зардлын тэлэлтийг үүсгэж байна.

3.1.6 Иргэдийн орлогыг хамгаалах бодлогын хүрээнд төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг 20.0 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10.0 хувиар нэмэгдүүлэхэд 584.6 тэрбум төгрөг, НДС-аас олгох өндөр настны, цэргийн, тэжээгчээ алдсаны, тахир дутуугийн тэтгэврийг нэмэхэд 602.6 тэрбум төгрөг /Үүнээс өндөр настны тэтгэврийг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхэд нийт 442.5 тэрбум төгрөг/, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 10.0 хувиар нэмэгдүүлэхэд 52.2 тэрбум төгрөг, нийт 1,239.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь инфляцыг өдөөх шалтгаан болжээ.

3.1.7 Төсвийн зарлагын чиглэлээр баримталсан бодлогыг хэрэгжүүлэхэд 2,102.1 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн зарцуулалтын үр дүнг тайлагнаж, хэрэгжилтийн үр нөлөөг үнэлээгүй байна.

3.2 Монгол улсын төсвийн төлөвлөлтөд улс төрийн бодлогын нөлөө их байгаа нь урт хугацааны хөгжлийн бодлогыг дэмжсэн дунд хугацааны бодлогын баримт бичгийг өөрчлөхөд хүргэж, төсвийн тогтвортой байдлыг алдагдуулах, төсөв захирагчдын төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулах, урсгал зардлын төсөвт үзүүлэх дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна

Улсын Их Хурлаас дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллөөр баталсан нийт зарлага ба цэвэр зээлийн дээд хэмжээг жил бүр өөрчилж, төсвийн

жилийн дундуур улс төрийн нөлөөгөөр зарлага нэмэгдүүлэх бодлогын шийдвэр гаргасан нь 2024 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх урсгал зардлыг нэмэгдүүлсэн байна


3.2.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 2024 оны нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 22,996.1 тэрбум төгрөгөөр баталсныг Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулан 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр 7,491.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 3,127.4 тэрбум төгрөгөөр бууруулж, 27,360.5 тэрбум төгрөгөөр баталсан байна.

3.2.2 Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнд улс төрийн намуудын гэрээнд суурилсан Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн томоохон хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагууд, төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулж нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 3,127.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 30,487.9 тэрбум төгрөгөөр баталсан байна.

3.2.3 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн урсгал зардалд сонгуулийн жилийг дагасан амлалтын шинжтэй зардлуудыг төсвийн жилийн дундуур нэмж төлөвлөн, тодотголоор нэмэгдүүлж баталсан нь Төсвийн тухай хуулийн төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх гэсэн зарчмуудтай нийцэхгүй байна.

3.2.4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ 1996 оноос хойш тогтмол өссөн үзүүлэлттэй буюу 30 жилийн хугацаанд нийт 162.4 тэрбум төгрөгөөс 30,591.1 тэрбум төгрөг болж 183.2 дахин өссөн байна.

Дүрслэл 5. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 1995-2025 он, /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны мэдээлэл

3.2.5 Улсын Их Хурлын ээлжит сонгуультай жилүүдэд төсөв өмнөх 3 жилээс 1.5-3.3 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байгаагаас гадна сонгуулийн дараагийн жилүүдэд төсөв нийт дүнгээрээ нэмэгдсэн ч өсөлтийн хувь огцом буурсан нь Монгол Улсын төсвийн жил 4 жилийн мөчлөгтэй, сонгуулиас шууд хамааралтай байна.

Хүснэгт 10. ESA /Event Study Analysis/ шинжилгээний үр дүн

Хугацааны үечлэл /2000-2024 он/	Өсөлтийн хувь			ДНБ-нд эзлэх хувь			ЭЗ-ийн өсөлт
	Орлого	Зардал	Тэнцэл	Орлого	Зардал	Тэнцэл	
Сонгуулийн жил	11.9%	28.7%	-179.2%	29.7%	36.6%	-6.9%	5.0%
Сонгуулийн өмнөх жил	23.0%	27.5%	-111.2%	31.4%	33.5%	-2.1%	8.3%
Сонгуулийн дараа жил	19.7%	3.2%	80.7%	29.2%	32.7%	4.6%	4.6%
Бусад жил	32.7%	23.5%	19.6%	30.9%	32.0%	-1.1%	6.7%
2024 оны гүйцэтгэл	27.4%	35.9%	-217.1%	37.1%	38.3%	-1.2%	4.9%

Эх сурвалж: Сангийн яам

3.2.6 Дээрх хүснэгтээс харахад тайлант оны гүйцэтгэлийн хувьд төсвийн орлого болон зардлын гүйцэтгэл түүхэн дунджаас өндөр өсөлттэй байсан хэдий ч эдийн засгийн өсөлт 4.9 хувьтай гарчээ.


3.2.7 Сонгуулийн жилүүдэд төсвийн зарлага огцом нэмэгдэж, тэнцэл хэт алдагдалтай гардаг нь улс төр-эдийн засгийн мөчлөгийн онолын таамаглалтай нийцэж байгаа ч эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө нь хязгаарлагдмал байна.

Хүснэгт 11. Монгол Улсын 1996-2024 оны зардал өссөн шалтгаан

Он	Тайлбар
1996–2000 он:	Төсвийн зарлага 2.7 дахин нэмэгдсэн нь зах зээлийн эдийн засагт шилжих үеийн бүтцийн өөрчлөлт, инфляцын өсөлттэй холбоотой
2004–2008 он:	Энэ хугацаанд төсвийн зарлага 3.3 дахин өссөн нь уул уурхайн салбарын өсөлт, түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой;
2012–2016 он:	Төсвийн зарлага 58.0 хувиар нэмэгдсэн нь төрийн үйлчилгээний өргөтгөл, нийгмийн халамжийн зардлын өсөлттэй холбоотой;
2020–2024 он:	Төсвийн зарлага 2.2 дахин өссөн нь COVID-19 цар тахлын үеийн эдийн засгийн дэмжлэг, сонгуулийн жилүүдийн төсвийн тэлэлттэй холбоотой байна.

3.2.8 Монгол Улсын төсвийн бодлогод урт хугацаанд тогтвортой өсөлт авчрахын тулд сонгуулийн мөчлөгөөс үл хамаарах хариуцлагатай төсөвлөлт хэрэгтэй байна.

Дүрслэл 6. Нийт зарлага ба цэвэр зээлийн бүтэц, /тэрбум төгрөг/



3.2.9 Нийт зарлага ба цэвэр зээлийн 72.5 хувийг урсгал зарлага, 26.0 хувийг хөрөнгийн зардал, 1.5 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл тус тус эзэлж байна.


3.2.10 Урсгал зардал нь ДНБ-ий 27.7 хувийг эзэлж, сүүлийн жилүүдэд ДНБ-ий 25.0-29.0 хувьд хүрсэн нь хэрэглээ давамгайлсан төсвийн бүтэцтэй байна.

3.2.11 ЭЗХАХБ, Дэлхийн Банкны

судалгааны тайланд өндөр хөгжилтэй орнуудын төсвийн нийт зарлагын 60.0-80.0 хувийг урсгал зардалд зарцуулдаг бол хөгжиж буй орнуудад хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлж, урсгал зардлыг бага түвшинд барьдаг гэж дүгнэсэн байна.

3.2.12 Монгол Улс нь хөгжиж буй орны хувьд иргэдийн нийгмийн хэрэгцээг хангах, төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад нийт зарлага ба цэвэр зээлийн 72.5-81.9 хувийг урсгал зардалд, ирээдүйд эдийн засгийн болон эдийн засгийн бус үр ашиг өгөх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтад үлдсэн хувийг төсөвлөн зарцуулж байна.

Дүрслэл 7. Нийт зарлага өсөлт, ДНБ-д эзлэх хувь, /тэрбум төгрөг/



3.2.13 Судлаач Колин Кларкийн критик хязгаарт төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь 25.0 хувиас дээш гарсан үед инфляцыг өдөөдгийг судлан тогтоожээ. Монгол улсын хувьд нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өмнөх оноос 35.9 хувиар өссөн, сүүлийн 5 жилд ДНБ-ий 32.7-38.3 хувийг эзэлж байна.

3.2.14 ДНБ-д эзлэх зарлагын хэмжээ жил бүр огцом нэмэгдсэнд ОУВС-ийн зүгээс төсвийн тэлэлтийн бодлого нь эдийн засгийн хэт халалтыг үүсгэж болзошгүй тул төсвийн сахилга батыг сайжруулах шаардлагатайг анхааруулсан байна.

Засгийн газраас баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төсөл боловсруулахдаа мөрдөхгүй, төсвийг хэт өндрөөр үндэслэлгүй төлөвлөж байгаа нь Төсвийн тухай хуулийн санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчимд нийцэхгүй байна

3.2.15 Засгийн газрын 2023 оны “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн хязгаарыг батлах тухай” 245 дугаар тогтоолоор улсын төсвийн хязгаарыг 17,574.6 тэрбум төгрөг, НДС-ийн төсвийн хязгаарыг 4,084.3 тэрбум төгрөг, ЭМДС-ийн төсвийн хязгаарыг 1,518.5 тэрбум төгрөгөөр баталж, Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагыг 3,530.3 тэрбум төгрөгөөр хянасан байна.

3.2.16 Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн төсвийн төслийн саналыг Сангийн яам хянаж улсын төсвийн зарлагыг 7,891.0 тэрбум төгрөг, НДС-ийн төсвийн зарлагыг 367.2 тэрбум төгрөг, ЭМДС-ийн төсвийн зарлагыг 142.9 тэрбум төгрөг, орон нутгийн суурь зарлагыг 708.2 тэрбум төгрөг, нийт 9,109.3 тэрбум төгрөгөөр бууруулж, 27,360.5 тэрбум төгрөгөөр УИХ-д өргөн барьсан байна.

3.2.17 Засгийн газраас УИХ-д өргөн барьсан 2024 оны төсвийн төсөлд ТЕЗ нарын төсвийн зарлагын хязгаараас улсын төсвийн зарлагыг 3,164.4 тэрбум төгрөг, ЭМДС-ийн төсвийг 367.1 тэрбум төгрөг, НДС-ийн төсвийг 994.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 -д заасантай нийцэхгүй байна.

3.2.18 Орон нутгийн ИТХ бүрэн эрхийн хүрээнд Сангийн яамнаас хянасан төсвийн суурь зарлагыг 4,726.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Хүснэгт 12. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөлт, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Төсвийн хязгаар	УИХ-д өргөн барьсан	УИХ-аас баталсан	УИХ-аас тодотгосон	Тодотгосон 2	Зөрүү	Хувь
А	1	2	3	4	5	6=5-3	6=5/3
НЭГДСЭН ТӨСӨВ*	-	27,360.5	27,360.5	30,487.9	33,595.3	6,234.8	122.8
Улсын төсөв	17,574.6	20,736.0	20,753.8	22,677.8	22,677.8	1,924.0	109.3
Орон нутгийн төсөв	3,530.3	4,537.6	4,513.5	6,136.0	9,239.7	4,726.2	204.7
НДС-ийн төсөв	4,084.3	5,078.3	5,121.2	5,121.2	5,121.2	-	100.0
ЭМДС-ийн төсөв	1,518.5	1,885.6	1,848.2	1,848.2	1,848.2	-	100.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл /*цэвэр дүнгээр/

Засгийн газраас Монгол Улсын 2024 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 30,591.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан нь ДНБ-ий 38.3 хувьтай тэнцэж байна

3.2.19 Нийт зарлага ба цэвэр зээлийг нийт 33,595.3 тэрбум төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 49.3 хувиар буюу 11,086.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.2.20 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг 33,595.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 30,591.1 тэрбум төгрөгийг зарцуулж, ДНБ-ий 38.3 хувьтай тэнцэж байна.

3.2.21 Нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл өмнөх оноос 8,082.1 тэрбум төгрөгөөр өссөн нь цалин, хөлс 3,041.0 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 2,782.6 тэрбум төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 1,430.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 13. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 он				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	22,509.0	33,595.3	30,591.1	3,004.2	91.1	8,082.1
Урсгал зарлага	17,091.4	23,106.1	22,176.6	929.5	96.0	5,085.2
Бараа, үйлчилгээний зардал	5,085.4	10,132.1	9,556.9	575.2	94.3	4,471.5
Хүү	1,150.0	1,246.1	1,235.9	10.2	99.2	85.9
Татаас ба урсгал шилжүүлэг	10,856.0	11,727.9	11,383.8	344.1	97.1	527.8
Хөрөнгийн зардал	5,188.2	10,379.3	7,970.8	2,408.5	76.8	2,782.6
Эргэж төлөгдөх цэвэр зээл	229.4	109.9	443.7	(333.8)	403.7	214.3
Төсвийн бүрэлдэхүүнээр*:						
Улсын төсөв	16,079.7	22,677.8	21,372.4	1,305.4	94.2	5,292.7
Орон нутгийн төсөв	4,336.3	9,239.7	7,258.6	1,981.1	78.6	2,922.3
НДС-ийн төсөв	4,034.9	5,121.2	5,104.7	16.5	99.7	1,069.8
ЭМДС-ийн төсөв	1,598.0	1,848.2	1,926.9	(78.7)	104.3	328.9

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/*цэвэр дүнгээр/

3.2.22 Төсвийн бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэлийн 59.9 хувийг улсын, 20.4 хувийг орон нутгийн, 14.3 хувийг НДС-ийн, 5.4 хувийг ЭМДС-ийн төсөв тус тус эзэлж байна.

3.2.23 Нийт зарлага ба цэвэр зээлийн гүйцэтгэл 91.1 хувьтай, төлөвлөснөөс 3,004.2 тэрбум төгрөгөөр дутуу байгаагаас 80.2 хувь буюу 2,408.5 тэрбум төгрөг нь хөрөнгийн зардал байна.

3.2.24 Нэгдсэн төсөвт нийт 134 хөтөлбөрийн 359 арга хэмжээг 33,595.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 134 хөтөлбөрийн 350 арга хэмжээнд 30,591.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

3.2.25 Улсын хэмжээнд хэрэгжиж байгаа гадаад зээл, тусламжаар улс орон нутагт хэрэгжиж байгаа зорилтот хөрөнгө оруулалт, гүйцэтгэх засаглалын удирдлага, шинжлэх ухааны бодлого удирдлага хөтөлбөрүүдийн гүйцэтгэл хангалтгүй байна.

Хүснэгт 14. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл хөтөлбөрөөр, /тэрбум төгрөг/

Хөтөлбөр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1	2	3=1-2	4=2/1
Улсын төсөв	22,677.8	21,372.4	1,305.4	94.2
Гадаад зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	3,024.4	2,749.4	275.1	90.9
ШУ-ны бодлого удирдлага	767.1	588.3	178.8	76.7
Гүйцэтгэх засаглалын удирдлага	221.0	97.1	123.9	43.9
Зам тээврийн бодлого удирдлага	751.1	648.6	102.5	86.4
Эрүүл мэндийн бодлого, удирдлага	399.8	307.0	92.8	76.8
Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага	459.2	374.7	84.5	81.6
Бусад	17,055.2	16,607.3	448.1	97.4
Орон нутаг	9,239.7	7,258.6	1,981.1	78.6
Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	2,621.4	1,588.9	1,032.5	60.6
Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	3,824.3	3,193.9	630.4	83.5
Бусад	2,794.0	2,475.8	318.2	88.6
Нийгмийн даатгалын сан	5,121.5	5,104.7	16.8	99.7
Нийгмийн даатгал	5,188.4	5,107.2	81.2	98.4
Эргэж төлөгдөх зээл	(67.2)	(2.5)	(64.7)	3.7
Бусад	0.3	-	0.3	-
Эрүүл мэндийн даатгалын сан	1,848.2	1,926.9	(78.7)	104.3
Эрүүл мэндийн даатгал	1,933.2	1,931.3	1.9	99.9
Эргэж төлөгдөх зээл	(85.0)	(4.4)	(80.6)	5.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.2.26 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд улсын төсвийн гадаад зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл 90.9 хувь буюу 275.0 тэрбум төгрөг, шинжлэх ухааны бодлого удирдлага хөтөлбөрийн гүйцэтгэл 76.7 хувь буюу 178.8 тэрбум төгрөг, гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн гүйцэтгэл 43.9 хувь буюу 123.9 тэрбум төгрөг, орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 60.6 хувь буюу 1,032.5 тэрбум төгрөг, орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 83.5 хувь буюу 630.4 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Өмнөх онуудад олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодоос авах авлагыг барагдуулах ажил удаашралтай, тодорхой үр дүнд хүрээгүй байна.

3.2.27 Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 443.7 тэрбум төгрөг буюу 403.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөснөөс 333.8 тэрбум төгрөг буюу 303.7 хувиар давж биелсэн байна.

3.2.28 Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх дотоод цэвэр зээлийг 350.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 15.1 тэрбум төгрөг буюу 4.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 15. Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл, /тэрбум төгрөг/

ТЕЗ	Төсөл хөтөлбөрийн нэр	2024 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Олгосон зээл, үүнээс		429.8	345.4	84.4	80.4
БС	Боловсролын зээлийн сан	31.0	16.3	14.7	52.6
ХББОСС	Түрээсийн орон сууц хөтөлбөр	5.0	5.0	-	100.0
ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	50.0	39.5 ⁸	10.5	79.0
	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл	27.7	17.0	10.7	61.4
	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж	29.3	14.5 ⁹	14.8	49.5
Сангийн сайд	"Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн дүрмийн сан	83.7	83.7	-	100.0
	Засгийн газрын зээл ба бонд	44.1	44.1	-	100.0
Орон нутаг	19 аймгийн ТЕЗ	159.0	125.3	33.7	78.8
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс		(779.9)	(360.5)	(419.4)	46.2
БС	Боловсролын зээлийн сан	(30.0)	(14.6)	(15.4)	48.7
ХЗДХС	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(20.6)	-	(20.6)	-
ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	(0.2)	-	(0.2)	-
	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл	(27.2)	(6.3)	(20.9)	23.2
	Хөдөө аж ахуйг дэмжих сан	(10.3)	(1.2)	(9.1)	11.7
	Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгж	(29.3)	(14.3)	(15.0)	48.8
ГБХНХС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	(22.8)	(3.5)	(19.3)	15.4
Сангийн сайд	ААНБ, орон сууцны хөтөлбөр, Анод банк, Зоос банк	(487.3)	(313.7)	(173.6)	64.4
НДС	Капитал банкнаас авах авлага	(67.2)	(2.5)	(64.7)	3.7
ЭМДС	Банкнаас авах авлага	(85.0)	(4.4)	(80.6)	5.2
Эргэж төлөгдөх зээлийн дүн		(350.1)	(15.1)	(335.0)	4.3
Гадаад эх үүсвэрийн зээлийн дүн		460.0	458.8	(1.2)	99.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		109.9	443.7	(333.8)	403.7

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.2.29 Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд дотоод эх үүсвэрээс 429.8 тэрбум төгрөг, гадаад эх үүсвэрээс 460.0 тэрбум төгрөг олгохоор, өмнөх онуудад олгосон зээлээс 779.9 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр баталсан байна.

3.2.30 Дотоод эх үүсвэрээс улсын төсвийн 4, орон нутгийн 19 ерөнхийлөн захирагчаар дамжуулан 345.4 тэрбум төгрөгийн зээл олгож, зарим иргэн, ААНБ баримт бичгийн бүрдэл дутуу, зээлийн шалгуур хангаагүй зэргээс шалтгаалан батлагдсан төсвөөс 84.4 тэрбум төгрөгийг дутуу олгосон байна.

3.2.31 Гадаад эх үүсвэрээс 13 төслийн нэгжээр дамжуулан 134 арга хэмжээг санхүүжүүлэхээр 458.8 тэрбум төгрөгийн зээл олгож, 99.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.2.32 Иргэн, ААНБ-уудад олгосон зээлээс 779.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр баталснаас 360.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, зээлийн хугацаа хэтэрсэн, муу зээлийн ангилалд шилжсэн, зээлдэгчдийн төлбөрийн чадвар буурсан зэргээс шалтгаалан 419.4 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

3.2.33 Жил бүрийн төсөвт дампуурсан Анод, Зоос банкны эрх хүлээн авагчаас авах авлага, татан буугдсан хадгаламж зээлийн хоршоодын эргэн төлөлтийг баталдаг боловч эргэн төлөлт хийгдэхгүй, авлагыг барагдуулах ажил удаашралтай, тодорхой үр дүнд хүрээгүй байна.

3.2.34 Татан буугдсан, төлбөрийн чадваргүй болсон банкнаас авах НДС-ийн авлага 67.2 тэрбум төгрөг, ЭМДС-ийн авлага 85.0 тэрбум төгрөг, нийт 152.2 тэрбум төгрөгийн авлагыг төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр НДС 2.5 тэрбум төгрөгийн, ЭМДС 4.4 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж, 145.3 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

⁸ Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл 38.6 тэрбум төгрөг, дамжуулан зээлийн эргэн төлөлт, гурван талт гэрээний хүүгийн төлбөр 0.9 тэрбум төгрөг

⁹ Дамжуулан зээлийн эргэн төлөлт 14.8 тэрбум төгрөг

3.3 Тухайн төсвийн жилийн бодлогын хүрээнд улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшний үзүүлэлттэй уялдуулахгүйгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг өөрчилж, хэрэгжүүлэх арга хэмжээний урсгал шинжтэй зардлын хязгаарыг хуулиар нэмэгдүүлэн тогтоож байгаа нь дараагийн жилүүдийн суурь зарлага, төсөвт үзүүлэх ачааллыг нэмэгдүүлэх үр дагавартай байна

Улсын төсвийн 2024 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 21,372.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан нь ДНБ-ий 26.7 хувьтай тэнцэж, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх урсгал зардал жил бүр тэлж байгаад анхаарч, төсвийн зарлагын өсөлтийг зохистой түвшинд барих шаардлагатай байна

3.3.1 Улсын төсвийн 2024 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 21,372.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй тайлагнасан нь ДНБ-ий 26.7 хувьтай тэнцэж байна.

3.3.2 Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг 22,677.8 тэрбум төгрөгөөр баталж өмнөх оны гүйцэтгэлээс 32.9 хувиар буюу 5,292.7 тэрбум төгрөгөөр өссөн нь урсгал зарлагыг 4,004.5 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлыг 1,130.2 тэрбум төгрөг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 158.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 16. Улсын төсвийн нийт зарлага ба цэвэр зээл, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 оны				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Нийт зарлага ба цэвэр зээл	16,079.7	22,677.8	21,372.4	1,305.4	94.2	5,292.7
Урсгал зарлага	11,960.5	16,475.0	15,965.0	510.0	96.9	4,004.5
Бараа, үйлчилгээний зардал	3,614.4	8,057.7	7,781.6	276.1	96.6	4,167.2
Цалин, хөлс	1,875.6	4,839.7	4,739.4	100.3	97.9	2,863.8
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	145.1	481.1	468.6	12.5	97.4	323.5
Бараа, үйлчилгээний бусад зардал	1,593.7	2,736.9	2,573.6	163.3	94.0	979.9
Хүү	1,092.6	1,173.6	1,165.9	7.7	99.3	73.3
Татаас ба урсгал шилжүүлэг	7,253.5	7,243.7	7,017.5	226.2	96.9	(236.0)
Татаас	1,033.1	1,841.1	1,776.1	65.0	96.5	743.0
Урсгал шилжүүлэг	6,220.4	5,402.6	5,241.4	161.2	97.0	(979.0)
Хөрөнгийн зардал	3,951.9	6,099.7	5,082.1	1,017.6	83.3	1,130.2
Барилга байгууламж	3,263.3	5,015.6	4,101.3	914.3	81.8	838.0
Их засвар	104.8	84.5	77.6	6.9	91.8	(27.2)
Хөрөнгийн бусад зардал	583.8	999.6	903.2	96.4	90.4	319.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	167.3	103.1	325.3	(222.2)	315.5	158.0
Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(115.1)	(356.9)	(133.5)	(223.4)	37.4	(18.4)
Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	282.4	460.0	458.8	1.2	99.7	176.4

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/*цэвэр дүнгээр /

3.3.3 Урсгал зарлага 15,965.0 тэрбум төгрөгт хүрч, 96.9 хувийн гүйцэтгэлтэй, өмнөх оноос 4,004.5 тэрбум төгрөгөөр өссөн нь бараа, үйлчилгээний зардал 115.3 хувиар, хүүгийн зардал 6.7 хувиар нэмэгдсэнээс тус тус шалтгаалжээ.

3.3.4 Урсгал зарлагын 44.0 хувийг татаас ба урсгал шилжүүлэг, 48.7 хувийг бараа үйлчилгээний зардал, 7.3 хувийг хүүгийн зардал тус тус эзэлж байна.

3.3.5 Зардлын эдийн засгийн ангилал хооронд бараа, үйлчилгээний зардлыг 48.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, татаас, урсгал шилжүүлгийг 41.1 тэрбум төгрөг, Засгийн газрын 2024 оны 15 дугаар тэмдэглэлээр Монгол Улсад өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан Азийн хөгжлийн банкнаас олгох буцалтгүй тусламжийн санхүүжилтийг “малчдад хүндрэлтэй үеийг давах зорилгоор нөөцийн бараа худалдан авч, хүргүүлэх”-д зориулж хөрөнгийн зардлыг 7.4 тэрбум төгрөгөөр бууруулж, тус тус төсөвт зохицуулалт хийсэн байна.

3.3.6 Мөн Улсын Их Хурлаас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталсан байна.

3.3.7 Дээрх хуулийн¹⁰ хэрэгжилтийг хангах зорилгоор Засгийн газраас 2024 онд “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” 166 дугаар тогтоолыг баталж, ХХААХҮС-ын багцаас 11.0 тэрбум төгрөгийг бууруулж, ЗГХЭГ-ын даргын багцад шилжүүлэн төсөвт зохицуулалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7-тай нийцэхгүй байна.

3.3.8 Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т “Энэ хуулийн 6.1.7-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай болон бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуулийг дагаж мөрдөнө” гэж заасан нь Төсвийн тухай хуультай зөрчилдөж, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сулруулах эрсдэлтэй байна.

3.3.9 Тайлант онд УТЕЗ нарын 108 хөтөлбөрийн 265 арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсвийн санхүү төсвийн харилцаанд 19.8 хувийг, боловсрол, шинжлэх ухааны салбарт 18.9 хувийг, нийгмийн хамгааллын салбарт 17.6 хувийг, нийгмийн хэв журам, аюулгүй байдалд 12.9 хувийг эрүүл мэндийн хөтөлбөрт 7.3 хувийг, бусад салбарын хөтөлбөрт 23.4 хувийг зарцуулсан байна.

3.3.10 Өмнөх онд хэрэгжиж байсан хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж дэмжлэг хөтөлбөр хасагдаж, бүсчилсэн хөгжлийн бодлого, удирдлага хөтөлбөрт 63.0 тэрбум төгрөг, шинэ хоршоо хөдөлгөөнд 55.0 тэрбум төгрөгийг тус тус төлөвлөсөн байна.


Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, зарим тэтгэмжийг нэмэгдүүлсэн нь бараа, үйлчилгээний зардал өмнөх оноос 4,167.2 тэрбум төгрөгөөр өсөхөд голлон нөлөөлсөн бөгөөд цалингийн зардлын өсөлт нь иргэдийн орлого хамгаалах эерэг нөлөөтэй боловч инфляцыг өдөөх сөрөг үр дагавартай байна.

3.3.11 Улсын төсвийн бараа, үйлчилгээний зардал 7,781.6 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 4,167.2 тэрбум төгрөгөөр өссөн нь 66.9 хувийг цалин хөлс, НДШ, 33.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

3.3.12 Дээрх зардлын гол өсөлт нь зарим төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт болон төрийн албан хаагчдын цалин хөлсний тогтолцооны шинэчлэлтэй холбогдуулан цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг 157.7 хувиар нэмэгдүүлснээс голлон шалтгаалсан байна.

3.3.13 Иргэдийн орлогыг инфляцтай уялдуулж нэмэгдүүлэх төсвийн бодлогын хүрээнд Засгийн газрын 2024 оны 82, 128 дугаар тогтоол болон 2024 оны төсвийн жилээс эхлэн Засгийн газрын 2022 оны 91, 2024 оны 39, 53 дугаар тогтоолоор хувьсах зардлын нийт дүнд эзлэх цалин хөлсний зардлын жишиг нормыг баримтлан боловсролын салбарын санхүүжилтийг цалин хөлс болон бараа үйлчилгээний бусад зардалд хуваарилдаг болсноос шалтгаалж улсын төсвийн нийт цалингийн зардал 3,187.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дүрслэл 8. Шинэчлэн баталсан цалингийн доод хэмжээ



Эх сурвалж: Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол

3.3.14 Төсвийн баримтлах бодлогод тусгагдсан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх бодлого бүрэн хэрэгжсэн боловч төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 20.0 хувь, бусад төрийн албан хаагчдын үндсэн цалинг 10.0 хувиар нэмэгдүүлсэн нь өрхийн хэрэглээний өсөлтийг үүсгэж эрэлтийн шалтгаантай инфляцыг өдөөх сөрөг нөлөөтэй байна.

3.3.15 Төрийн албан хаагчийн цалингийн өсөлт инфляцад нөлөөтэй талаарх судалгааны үр дүнгээр урт хугацаанд төрийн албан хаагчийн цалин 10.0 хувиар өсөх нь 4.4 хувийн инфляцыг

¹⁰Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

бий болгодог бол инфляц 1.0 хувиар өсөх нь урт хугацаанд төрийн албан хаагчийн цалинг 2.3 хувиар өсгөдөг байна. /Эх сурвалж: Монгол банк/

3.3.16 Төрийн албаны зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлангаар нийт 4276 төрийн байгууллага, 226895 төрийн албан хаагч бүртгэлтэй байна. Тайлант онд шинээр улсын төсвийн 22 байгууллагын 594 албан хаагч нэмэгдсэн байна.

3.3.17 Төсвийн сахилга бат, хариуцлага сул, эрх бүхий байгууллагын буруутай шийдвэр, үйл ажиллагаанаас шалтгаалан цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал үр ашиггүй төлөвлөгдөн зарцуулагдаж байна.

3.3.18 Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зарим УТҮГ, ТӨААТҮГ-ууд нь бусад төсөвт байгууллагуудтай ижил түвшний чиг үүргийг хэрэгжүүлдэг, төсвөөс санхүүждэг, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэггүй, орлого олдоггүй боловч тус ангилалд багтан цалингийн шатлалыг мөрдөхгүй байх, улмаар өндөр цалин тогтоож, цалингийн нийт зардлыг өсгөхөд нөлөөлж байна.

3.3.19 “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” болон “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-д улсын төсвөөс санхүүждэг улсын төсөвт үйлдвэрийн газруудын үндсэн цалинг цалингийн бус сүлжээний ангилалд бүртгэж, төсвийн 10 ерөнхийлөн захирагчийн харьяа 13 улсын төсөвт үйлдвэрийн газар өссөн дүнгээр 4,570 албан хаагчдад 18.5 тэрбум төгрөгийн цалин хөлсийг олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

Үндэсний хөгжлийн хүрээлэн УТҮГ-ын захирлын 2024 оны А/01 тоот тушаалаар албан хаагчдын цалингийн хэмжээг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сан, төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг баримтлаагүй;

3.3.20 Засгийн газрын 2022 оны 487, 2023 оны 240 дүгээр тогтоолуудаар төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоож өгсөн. Гэвч Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо”-ны цахим системд Засгийн газрын тогтоосон цалингийн хэмжээг мөрдөөгүй, үндсэн цалинг цалингийн сүлжээний бус ангилалд бүртгэснээс шалтгаалан “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-ээр тайлант онд төсвийн 21 ерөнхийлөн захирагчийн харьяа 430 байгууллага өссөн дүнгээр 27744 албан хаагчдад 53.0 тэрбум төгрөгийн цалин хөлсийг цалингийн сүлжээний бус ангиллаар олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

- Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо ЗГ-ын тогтоолыг баримтлалгүй ХББОСС-ын тушаалаар тогтоосон;
- Хилийн боомтын захиргааны ажилчдын үндсэн цалин, шатлалыг тооцох хууль эрх зүй тодорхойгүйгээс төсвийн төсөлд АА-шатлалаар санал хүргүүлж, ТҮ-шатлалаар цалин хөлсийг тооцож олгосон;
- Байгууллагын бүтэц орон тоонд батлагдаагүй ажилчдын цалин хөлсийг олгосон болон албан хаагчдаар албан тушаалын жагсаалтад батлагдаагүй чиг үүргийг хавсран гүйцэтгүүлж цалин олгосон 0.4 тэрбум төгрөг /ГБХНХС 0.4 тэрбум төгрөг/.

3.3.21 Зарим сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын цалингийн санг ЗГХЭГ-ын төсөвт баталж байгаа нь ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн орлого, зарлагыг зүй зохистой удирдах, үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлд тавих хяналт сулрах эрсдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Тайлант онд ЗГХЭГ-ын орон тоо бүтцэд ордоггүй, бусад ТЕЗ-ийн бүрэлдэхүүнд хамаарах шинээр 1 ажлын алба, 5 үндэсний хороог нэмж байгуулсан, 2 үндэсний хорооны орон тоог 14-өөр нэмэгдүүлснээс шалтгаалан, гүйцэтгэлээр өмнөх оноос орон тоо 83-аар, үйл ажиллагааны зардал 9.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн;
- Бусад ТЕЗ-ын бүрэлдэхүүнд хамаарах, чиг үүрэг бүхий Хяналт, үнэлгээний үндэсний хороо, Алсын хараа 2050 салбар дундын уялдааг хангах үндэсний хороо, Үндэсний баялгийн сан, орон сууцжуулалтын үндэсний хороо, Шинэ хоршоо хөдөлгөөн салбар дундын уялдааг хангах үндэсний хороо, Эрчим хүчний реформыг удирдан зохион байгуулах үндэсний хороо, Боомтын сэргэлтийн

үндэсний хороо, 20 минутын хот үндэсний хороо зэрэг 7 хороог ЗГХЭГ-ын даргад харьяалуулан төсвийг баталж, тайлагнаж байгаа нь ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагыг зүй зохистой, үр ашигтай удирдах, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцах чиг үүрэгтэй нийцэхгүй байна.

3.3.22 Тайлант онд 89 эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээр ажлаас үндэслэлгүй чөлөөлөгдсөн ажилтнуудад шүүхийн шийдвэрийн дагуу 1.5 тэрбум төгрөгийн нөхөн олговрыг Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д заасны дагуу буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэлгүй төрөөс олгосон байна.

3.3.23 Төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хяналт тавих чиг үүргийн дагуу тайлант онд Төрийн албаны зөвлөлийн мэдэгдэл, шүүхэд гаргасан нэхэмжлэлээр 0.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт

Улсын төсвөөс эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрийн улмаас ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн нөхөн олговрыг буруутай этгээдээс гаргалгүй байгууллагаас олгосон, буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй нийт 6.0 тэрбум төгрөг /ХЗДХС 2.6 тэрбум төгрөг, ШЕЗ 2.4 тэрбум төгрөг, ХББОСС 0.4 тэрбум төгрөг, ГБХНХС 0.4 тэрбум төгрөг, ЭМС 0.2 тэрбум төгрөг, ЭХС 0.1 тэрбум төгрөг/

Үндсэн үйл ажиллагаанаас бусад хөтөлбөр, арга хэмжээний зардлыг эдийн засгийн ангиллаар хянах боломжтой боловч хөтөлбөр, арга хэмжээг бөөн дүнгээр багцлан төлөвлөж, тайлагнаж байгаа нь төсвийн ил тод, үр ашигтай байдлыг алдагдуулж, байна

3.3.24 Цалин, НДШ-ээс бусад бараа, үйлчилгээний бусад зардал өмнөх оны гүйцэтгэлээс 979.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2,573.6 тэрбум төгрөгт хүрсэн нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардал 306.1 тэрбум төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 446.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

3.3.25 Бараа үйлчилгээний зардлын 71.2 хувь буюу 1,832.8 тэрбум төгрөгийг бараа, үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 28.8 хувь буюу 740.8 тэрбум төгрөгийн тогтмол зардлууд эзэлж байна.

Хүснэгт 17. Улсын төсвийн цалин, НДШ-ээс бараа, үйлчилгээний бусад зардал, /тэрбум төгрөг/


Бараа, үйлчилгээний зардал	2023 оны гүйц	2024 оны					Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	Дүнд эзлэх хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6	7=3-1
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	107.8	141.0	126.8	14.2	89.9	4.9	19.0
Хангамж, бараа материалын зардал	61.9	100.0	95.8	4.2	95.8	3.7	33.9
Нормативт зардал	219.7	316.0	313.5	2.5	99.2	12.2	93.8
Эд хогшил, урсгал засварын зардал	87.8	150.6	144.4	6.2	95.9	5.6	56.6
Томилолт зочны зардал	36.7	73.3	60.3	13.0	82.3	2.3	23.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	704.4	1,088.8	1,010.5	78.3	92.8	39.3	306.1
Үүнээс: 210801 БГБАҮТХЗ	653.8	999.9	931.6	68.3	93.2	36.2	277.8
Бараа үйлчилгээний бусад зардал	375.4	867.2	822.3	44.9	94.8	32.0	446.9
Үүнээс: 210901 БҮБЗ	345.0	832.5	792.7	39.8	95.2	30.8	447.7
Нийт дүн	1,593.7	2,736.9	2,573.6	163.3	94.0	100.0	979.9

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/*цэвэр дүнгээр /

3.3.26 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж болон бараа, үйлчилгээний бусад зардлын ангилалд үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад хөтөлбөр, арга хэмжээний зардлыг багцлан тухайн төсвийн ангилалд баталж, гүйцэтгэлээр Сангийн сайдын 190 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангиллуудад зарцуулагдсан боловч нэг эдийн засгийн ангилалд нэгтгэгдэн тайлагнаж байгаа нь гүйцэтгэлийг нарийвчлан хянах, үнэлэх боломжгүй байдалд хүргэж, төсвийн ил тод байдлыг алдагдуулж байна.

Дүрслэл 9. Улсын төсвийн 210801, 210901 зардлууд арга хэмжээний хуваарилалт



3.3.27 Цалин хөлс, НДШ-ээс бусад бараа, үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл 2,573.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 979.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тус зардлын 39.3 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, 32.0 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

3.3.28 Цалин хөлс, НДШ-ээс бусад бараа үйлчилгээний бусад зардлын 71.3 хувийг эзэлж байгаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж болон бараа үйлчилгээний бусад зардалд 210801, 210901 эдийн засгийн ангилал дах зардал 67.0 хувийг эзэлж байна.

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.3.29 Бараа, үйлчилгээний зардлаас УИХ-ын ээлжит сонгуулийн төрөөс 100.0 хувь хариуцах иргэний шимтгэлийн зардалд 39.2 тэрбум төгрөг, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын нөлөөлөлд өртсөн иргэдэд олгох нөхөн олговорт 13.1 тэрбум төгрөг, цахим бодлогын арга хэмжээнд 14.9 тэрбум төгрөг, Парис-2024 олимпын наадамд оролцох Монгол Улсын шигшээ багийн үйл ажиллагааны зардалд 27.0 тэрбум төгрөг, агаарын геофизикийн судалгааны ажилд 40.0 тэрбум төгрөг, нийт 134.2 тэрбум төгрөгийн нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд төлөвлөж, гүйцэтгэлээр 127.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Илрүүлэлт:

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн нийт 0.6 тэрбум төгрөг. /ГБХНХС 0.5 тэрбум төгрөг, МУШС 0.1 тэрбум төгрөг/;
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан нийт 0.7 тэрбум төгрөг. /ХХААХҮС 0.3 тэрбум төгрөг, ГБХНХС 0.2 тэрбум төгрөг, СС 0.1 тэрбум төгрөг, Бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн нийт 0.1 тэрбум төгрөг /СС 0.1 тэрбум төгрөг, ЭМС, ХЗДХС/;
- Бараа үйлчилгээний бусад зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн нийт 0.4 тэрбум төгрөг. /МУШС 0.2 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.1 тэрбум төгрөг, Бусад ТЕЗ 0.1 тэрбум төгрөг/;
- Бараа үйлчилгээний бусад зардлаас эдийн засгийн ангилал зөрчсөн, төсөвт төлөвлөөгүй зардал гаргасан нийт 1.1 тэрбум төгрөг. /ЦХИХХС 0.3 тэрбум төгрөг, ССАЖЗС 0.2 тэрбум төгрөг, ГБХНХС 0.2 тэрбум төгрөг, ЭМС 0.1 тэрбум төгрөг, БС 0.1 тэрбум төгрөг, Бусад ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/

Улсын төсвийн хүүгийн нийт зардлын 99.4 хувийг Засгийн газрын гадаад зээлийн үйлчилгээний төлбөр эзэлж байгаа нь ашиглаагүй зээлийн хүүгийн төлбөрөөс үүссэн валютын ханшны нөлөөгөөр урсгал зардал нэмэгдэх эрсдэлтэй байна

3.3.30 Улсын төсвийн хүүгийн зардлыг 1,173.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,165.9 тэрбум төгрөгийг зарцуулж, 99.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 18. Улсын төсвийн хүүгийн зардлын эдийн засгийн ангилал, /тэрбум төгрөг/


Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 оны				Өмнөх оны зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Хүүгийн зардал	1,092.6	1,173.6	1,165.9	7.7	99.3	73.3
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,012.9	1,166.1	1,158.4	7.7	99.3	145.5
Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	79.7	7.5	7.5	-	100.0	(72.2)

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.3.31 Нийт хүүгийн зардлын 99.4 хувь буюу 1,158.4 тэрбум төгрөгийг гадаад зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөр, 0.6 хувь буюу 7.5 тэрбум төгрөгийг дотоод зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөр эзэлж байна.

3.3.32 Улсын төсвөөс Сенчари - 2, 3, 27, 31 үнэт цаасны хүүгийн төлбөрт 433.8 тэрбум төгрөг, Номад бондын хүүгийн төлбөрт 100.2 тэрбум төгрөг, Хуралдай бондын хүүгийн төлбөрт 25.1 тэрбум төгрөг, нийт 559.1 тэрбум төгрөгийг гадаад үнэт цаасны хүүгийн үйлчилгээний төлбөрт, 599.3 тэрбум төгрөгийг Засгийн газрын зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөрт, 7.5 тэрбум төгрөгийг дотоод үнэт цаасны хүүгийн үйлчилгээний төлбөрт, нийт 1,165.9 тэрбум төгрөгийг төлжээ.

Дүрслэл 10. Хүүгийн зардал /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Улсын төсвөөс олгож байгаа татаасны үр дүн, хэрэгжилтийг хянаж, үнэлэхгүй байгаагаас шалтгаалан үр ашиггүй зарцуулалт болох эрсдэлтэй байгаа тул татаас олгож байгаа салбаруудын бодит хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, түүний үр нөлөөг үнэлэх, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн бодлогын зохицуулалт дутмаг байна

3.3.34 Улсын төсвийн татаас ба урсгал шилжүүлгийн зардлыг 7,243.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 7,017.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 96.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 19 Улсын төсвийн татаас ба урсгал шилжүүлэг, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 оны				Өмнөх оны зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Татаас ба урсгал шилжүүлэг	7,253.5	7,243.7	7,017.5	226.2	96.9	(236.0)
Татаас	1,033.1	1,841.1	1,776.1	65.0	96.5	743.0
Урсгал шилжүүлэг	6,220.4	5,402.6	5,241.4	161.2	97.0	(979.0)

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.3.35 Улсын төсвийн татаас ба урсгал шилжүүлгийн зардал өмнөх оноос 3.3 хувиар буюу 236.0 тэрбум төгрөгөөр буурсан нь боловсролын салбарын хувьсах зардлын цалин, урамшууллыг цалингийн зардлаар төлөвлөж зарцуулсан, төрөөс алдагдлыг нөхөх зорилгоор олгосон татаас өссөнөөс шалтгаалсан байна.

3.3.36 Улсын төсвөөс НДС-д 1,175.7 тэрбум төгрөг, цахилгаан, дулаан, эрчим хүчний алдагдлыг нөхөх, шөнийн тарифын хөнгөлөлтөд 221.6 тэрбум төгрөг, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урамшуулал, хүүгийн хөнгөлөлтөд 316.1 тэрбум төгрөг, бусад салбарын татаас санхүүжилтэд 62.7 тэрбум төгрөг, нийт 1,776.1 тэрбум төгрөгийн татаас олгосон байна.

3.3.37 Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн урамшуулал, хүүгийн хөнгөлөлтөд олгосон 316.1 тэрбум төгрөгийн татаасны хэрэгжилтийг хянаж, үр дүнг үнэлээгүйгээс, тухайн дэмжлэг жижиг фермер, малчин өрхүүд зэрэг зорилтот бүлэгт бодитоор хүрч буй эсэх талаарх нарийвчилсан дүгнэлт байхгүй байна.

3.3.38 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого удирдлага” хөтөлбөрийн “Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулал” арга хэмжээнд 206.4 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийн татаасыг буруу төлөвлөн, олгосон байна.

3.3.39 Дэлхийн банк болон ОУВС-ын тайланд “Татаас нь зорилтот бүлгийг хамгаалах ч, зохистой бодлого, засаглалын орчин дутмаг нөхцөлд үр ашиггүй, алдагдалтай төрийн өмчит

аж ахуйн нэгжүүдийг дэмжих, бүтцийн шинэчлэлийг удаашруулах, шинэ хөрөнгө оруулалтаас зайлсхийх сэдэл болдог”, “Эрчим хүчний татаас нь үр ашиг, хариуцлагыг бууруулж, санхүүгийн сахилга батыг сулруулан, засаглалыг доройтуулах хандлагатай байдаг” гэж дүгнэсэн байна. (Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС).

3.3.40 Эрчим хүчний үнэ тарифын реформыг эхлүүлж, зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж либералчлах, хувийн хэвшил тус салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх шилжилтийн үеийн зардлыг санхүүжүүлэх бодлогын хүрээнд Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2024 оны 632-643 дугаар тогтоолуудаар цахилгааны үнийн тарифыг шинэчлэн тогтоож, 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс хэрэгжиж эхлэхээр баталсан байна.

3.3.41 Эрчим хүчний хэрэглээ 2020 оноос хойш жилд дунджаар 5.9-7.6 хувийн тогтмол өсөлттэй байгаа боловч тус салбарын 5 жилийн дундаж алдагдлын өсөлт 27.3 хувьтай байгаа нь зах зээлийн үнээс доогуур тогтоосон тариф салбарын алдагдалд дангаараа нөлөөлөхгүйг харуулж байна. Улсын төсвөөс олгож буй татаас жил бүр нэмэгдэж байгаа боловч салбарын алдагдлыг бүрэн нөхөх боломжгүй байна.

3.3.42 Улсын төсвөөс нийгмийн хамгааллын болон эрчим хүчний салбарт олгосон татаас сүүлийн 5 жилд 31.0-73.4 хувиар нэмэгдсэн ч алдагдал буурахгүй байгаад анхаарал хандуулан тус салбаруудын тогтолцоог сайжруулах, удирдлагын хариуцлага, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлага үүссэн байна.

Улсын төсвийн нийт урсгал шилжүүлгийн 43.9 хувь буюу 2,299.0 тэрбум төгрөгийг Нийгмийн халамжийн тухай хуулиар олгосон байна

3.3.43 Улсын төсвийн нийт урсгал шилжүүлгийн 43.9 хувь буюу 2,299.0 тэрбум төгрөг нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал, 41.4 хувь буюу 2,172.0 тэрбум төгрөг засгийн газрын дотоод шилжүүлэг, 14.7 хувь буюу 770.4 тэрбум төгрөг нь бусад шилжүүлэг байна.

3.3.44 Засгийн газрын дотоод шилжүүлгийн 60.3 хувь буюу 1,310.8 тэрбум төгрөгийг гүйцэтгэлээр санхүүждэг боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын шилжүүлэгт, 39.2 хувь буюу 852.0 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд олгох дэмжлэгт голлон хуваарилсан байна.

3.3.45 Улсын төсвийн нийт урсгал шилжүүлгийн 43.9 хувь буюу 2,299.0 тэрбум төгрөгийг Нийгмийн халамжийн тухай хуулийн хүрээнд зарцуулсан байна. Үүний 67.0 хувь буюу 1,540.0 тэрбум төгрөг нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардал байна.

3.3.46 Тайлант онд цалингийн зардал 3,187.3 тэрбум төгрөг, халамжийн зардалд 185.6 тэрбум төгрөг, татааст 743.0 тэрбум төгрөгөөр тус тус өмнөх оноос өссөн нь нийт урсгал зардалд 25.8 хувийг эзэлж, урсгал зардал тэлсэн нь цаашид төсвийн зардлын ачааллыг урт хугацаанд нэмэгдүүлэх эрсдэлтэй байгаад анхаарч хуульчилсан байдлаар зардал нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэхгүй байх нь зохилтой байна.

Улсын төсвийн хөрөнгийн зардал сүүлийн 5 жил 2.3-43.0 хувиар тогтмол өссөн боловч нийт зарлага ба цэвэр зээлд эзлэх хөрөнгийн зардал бага байгаа нь хөрөнгө оруулалтын төсвийг шахах хандлагатай болж, урт хугацааны өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэж байна

3.3.47 Хөрөнгийн нийт зардлыг 6,099.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5,082.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 83.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс 6.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 20. Улсын төсвийн 2024 төсвийн хөрөнгө оруулалтын зардал, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 оны				Өмнөх оноос зөрүү
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь	
А	1	2	3	4=2-3	5=3/2	6=3-1
Хөрөнгийн зардал	3,951.9	6,099.7	5,082.1	1,017.6	83.3	1,130.2
Барилга байгууламж	3,263.3	5,015.6	4,101.3	914.3	81.8	838.0
Их засвар	104.8	84.5	77.6	6.9	91.8	(27.2)
Хөрөнгийн бусад зардал	583.8	999.6	903.2	96.4	90.4	319.4

Үүнээс:	Гадаад зээл, тусламж	2,529.3	2,058.6	1,807.4	251.2	87.8	(721.9)
	Концесс	251.6	25.0	-	25.0	-	(251.6)
	УТХО	1,171.0	3,828.6	3,093.5	735.1	80.8	1,922.5
	Бусад	-	187.5	181.2	6.3	96.6	181.2


Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.3.48 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд 3,828.6 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 80.8 хувь буюу 3,093.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнээс Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор 691.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан нь тайлант онд хөрөнгийн зардлыг илүү илэрхийлж төсвийн гүйцэтгэлийн тайланг буруу тайлагнах эрсдэлд хүргэсэн байна.

3.3.49 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 10 ба түүнээс дээш жил үргэлжилсэн 322.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 60.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэл гараагүй 5.8 тэрбум төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг санхүүжүүлээгүй, гэрээ байгуулаагүй 2.7 тэрбум төгрөгийн 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

3.3.50 Улсын төсвийн хөрөнгийн зардал сүүлийн 5 жилд 2.3-43.0 хүртэл хувиар тогтмол өссөн боловч нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 21.0-24.6 хувийг эзэлж байна.

Дүрслэл 11. Улсын төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүн ба хөрөнгийн зардал, /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.3.51 “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан бодлогын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 14 мега төслөөс 2 төслийг 2024 онд гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр тусгасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Хэрэгжилт хангалтгүй төслийн зээлийн үйлчилгээний болон хүүгийн төлбөрт 5.3 тэрбум төгрөгийг зарцуулсан байна

3.3.52 Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр 2,767.0 тэрбум төгрөгийн 136 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 103 төсөл, арга хэмжээнд нийт 2,506.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 21. Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Баталсан		Гүйцэтгэл		Зөрүү		Ашиглалт
	Тоо	Төсөв	Тоо	Олгосон	Тоо	Олгоогүй	
Зээл	100	2,209.0	77	2,068.6	23	105.7	2,050.0
Тусламж	36	558.0	26	437.9	10	12.8	436.7
Нийт дүн	136	2,767.0	103	2,506.5	33	118.5	2,486.7

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

3.3.53 Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй 33 төсөл байна. Тухайлбал: гэрээ байгуулаагүй 9 төслөөс 7 төслийг УИХ-аас соёрхон батлаагүй, газар чөлөөлөлт бүрэн хийгээгүй “Улаанбаатар хотын орлогод нийцсэн

ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл (Өндөр технологийн сан)"-д санхүүжилт олгоогүй байна.

3.3.54 Гадаад зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч гүйцэтгэл гараагүй 9 төслийн хүүгийн төлбөрт 4.1 тэрбум төгрөг, зээлийн шимтгэлийн болон нөхөн дүүргэлтэд 6.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Гадаад зээлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн 21.0 хувийг эдийн засгийн үр ашиггүй, эргэн төлөлт хийх чадамжгүй, бодит эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй зэрэг нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээнд олгосон байна

3.3.55 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд бүрэн тусгаагүй 100 төслийг гадаадын зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр дэд бүтцийн 55 төсөлд нийт санхүүжилтийн 68.0 хувийг, нийгмийн 34 төсөлд 21.0 хувийг, бусад салбарын 11 төсөлд 11.0 хувийг олгосон байна.

3.3.56 Нийгмийн салбарын төслүүдээс үр дүнг үнэлэх боломжгүй 27.1 тэрбум төгрөгийн 3 төсөл, бодит эдийн засгийн өсөлтийг дэмжихгүй 143.4 тэрбум төгрөгийн 10 төсөл, эргэн төлөлт хийх чадамжгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх боломжтой 263.3 тэрбум төгрөгийн 21 төслийг тус тус санхүүжүүлж гадаад зээлийг нэмэгдүүлсэн байна.

Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төслүүдэд тавих хяналт хангалтгүй, хэрэгжих хугацаа удааширснаас төслийн үр өгөөж буурах эрсдэлтэй байна

3.3.57 Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж буй нийт 136 төслийн 47.1 хувь буюу 64 төслийн гэрээний хугацааг сунгасан нь төслийн үр өгөөжийг бууруулах, зардлыг үр ашиггүй зарцуулах үр дагаврыг бий болгож байна. Тухайлбал тайлант онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжиж эхлээгүй 2 төсөлд 1.1 тэрбум төгрөгийн цалингийн зардал гаргасан байна.

3.3.58 Гадаад, зээл тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төслийн гэрээ, хэлэлцээрт төсөл хэрэгжүүлэх нэгжтэй байхаар зааснаас бусад төслүүдэд төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулахгүй байх, төслийн хэрэгжилтэд тавих захиалагч, ТЭЗ нарын дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.3.59 Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төслийн хяналт хангалтгүй, төслийн дүнд бий болсон 45.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй байна.

Илрүүлэлт:

- Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төсөл: Сэргээн босголт, Зээлийн Банкнаас хийсэн үнэлгээний багийн хяналтаар хуваарилалтын дагуу олгоогүй 0.3 тэрбум төгрөгийн 45 ширхэг зөөврийн компьютер байгааг Төсөл хэрэгжүүлэх нэгжээс харьяалах яаманд асуудал шийдвэрлүүлэх тухай албан бичгээр холбогдох бичиг баримтын хамт хүргүүлсэн ч шийдвэрлэгдээгүй;
- Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох БМ201667054 төсөл: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд үнэ төлбөргүй шилжүүлсэн 1.1 тэрбум төгрөгийн 16 машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэн хүлээн авсан боловч хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр-2 төсөл: Төслийн санхүүжилтээр худалдан авсан техник хэрэгсэл, хүнд механизм, замын үзлэгийн тоног төхөөрөмж зэргийг ашиглагч байгууллагуудад актаар хүлээлгэн өгсөн боловч ТӨБЗГ-аас хөрөнгө шилжүүлэх тогтоол шийдвэр гараагүй;
- Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн нэмэлт санхүүжилтийн төсөл: ТӨБЗГ-ын тогтоол шийдвэргүй, тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийг шилжүүлэггүйгээр Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдаа төсөлд балансаас баланст шилжүүлсэн;
- Гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах төсөл: Төслийн хүрээнд барьж байгуулсан автобусны буудлууд, замын камержуулалт, хяналтын тоног төхөөрөмжүүд зэрэг нийт 6.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг хүлээн авах байгууллагуудад нь хүлээлгэн өгөөгүй;
- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлсэн "Хилийн боомтын дэд бүтэц" төслийн 38.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр бий болсон Гашуунсухайт боомтын хөрөнгийг улсын комисс хүлээн авсан боловч эзэмшигчийн асуудлыг эцэслээгүй, тус хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;
- Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл: Төслийн нэгжийн үйл ажиллагаанд Ниссан патрол Y62 5552сс маркийн авто машин худалдан авахаар шийдвэрлэж, 0.3 тэрбум төгрөг

буюу 94,500 ам.долларыг Азийн хөгжлийн банкны зээлийн данснаас шууд төлбөр хийсэн боловч хөрөнгө төслийн нэгжийн эзэмшилд биетээр байхгүй;

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах үйлчилгээг сайжруулах төсөл: Төслийн хүрээнд бий болсон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн болон 4 аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилгыг ашиглагч байгууллагуудад акт үйлдэн хүлээлгэн өгсөн боловч ТӨБЗГ-ын тогтоол шийдвэр гараагүй байна.

3.3.60 Төсвийн тухай хуулиар 2019 оноос гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих төслүүдийг Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлснээр төсвийн гүйцэтгэлийн санхүүжилт сайжирсан хэдий ч олон жил үргэлжилж буй төслүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллаагүй, захиалагчийн зүгээс төслийн хэрэгжилтэд тавих хяналт суларсан байна.

Илрүүлэлт:

- Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III шатны төсөл: Төслөөр 27.5 сая еврогийн буцалтгүй тусламжийн хөрөнгө зарцуулахаас 2024 оны эцсийн байдлаар 10.7 сая еврог зөвлөх багийн зардал, сургалт, зөвлөх үйлчилгээ, судалгаанд зарцуулж 38.9 хувийн гүйцэтгэлтэй, төслийн бодит үр дүн хангалтгүй, удаашралтай;
- Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл: Төсөл 2025 оны 6 дугаар сард дуусах гэрээтэй боловч төслийн зарцуулалт 78.2 хувийн биелэлттэй өссөн дүнгээр 70.6 тэрбум төгрөг /23.5 мянган ам.доллар/ байна. Нийт зарцуулалтын 42.4 хувь буюу 29.9 тэрбум төгрөгийг бараа, ажил үйлчилгээ, бүтээмжит түншлэлийг хөгжүүлэхэд, 35.1 хувь буюу 24.7 тэрбум төгрөгийг зөвлөх болон үйл ажиллагааны зардалд, 25.5 хувь буюу 18.0 тэрбум төгрөгийг гамшгийн үед хариу арга хэмжээ авах зориулалтаар малчин өрхүүдэд олгохоор зарцуулсан байгаагаас харахад төслийн бодит үр дүн хангалтгүй;
- Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл: Зээлийн гэрээг 2020 онд анх баталснаас хойш төслийн захиалагч болон төслийн удирдлагын багийг 3 удаа өөрчилсөн, 2021 онд байгуулсан барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээнүүдийн хэрэгжилт хангалтгүй, зогсонги байдалтай, ажил хийгдээгүй, зээлийн гэрээний хугацаа 81.8 хувь, ашиглалт 5.4 хувьтай байгаагаас 2025 онд төсөв батлагдаагүй, цаашид үргэлжлэх эсэх нь тодорхойгүй байна;
- Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай газар тариаланг дэмжих төсөл: Төсөл хэрэгжүүлэгч төслийн анхны зорилтыг удаа дараа өөрчилсөн, төслийн зээлийг ашиглах төлөвлөгөөг батлаагүй, ашиглалт хангалтгүй 36.1 хувийн зарцуулалттай, тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд туссан 16.6 тэрбум төгрөгийн өртөгтэй 16 худалдан авалтаас 4.4 тэрбум төгрөгийн 5 худалдан авалтыг гүйцэтгэж хэрэгжилт 26.9 хувьтай, төсөл хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэлтэй.

3.3.61 УИХ-ын 2024 оны 54, 81 дүгээр тогтоолоор Засгийн газарт “Гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслүүдтэй холбоотой гадаад зээлийн гэрээ байгуулахдаа үр ашгийн шинжилгээ хийх, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан байх шалгуурыг баримтлах, зээлийн хөрөнгөөр урсгал зарлагыг санхүүжүүлэхгүй байх, хэрэгжилт удаашралтай төслүүдийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар санал боловсруулж танилцуулах”-ыг даалгасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

3.3.62 “Барих-шилжүүлэх” концессын төслөөр хэрэгжүүлсэн “Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 120.85 км /Дархан, Сэлэнгэ/” ажлыг улсын комисс хүлээн авсан боловч ажлын гүйцэтгэлийг эцэслэн баталгаажуулаагүйгээс санхүүжилт олгоогүй байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын хохирлыг барагдуулахаар битүүмжилсэн хөрөнгийн чанар байдал алдагдаж, үнэ цэнэ буурснаас хөрөнгө борлуулагдахгүй, хохирогчдын хохирол барагдахгүй байх эрсдэлтэй байна.

3.3.63 Улсын төсвийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 325.3 тэрбум төгрөг буюу 315.5 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 222.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

3.3.64 Улсын төсвийн эргэж төлөгдөх дотоод цэвэр зээлийг 356.9 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 133.5 тэрбум төгрөг буюу 37.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.3.65 Дотоод эх үүсвэрээс улсын 4 ТЕЗ-аар дамжуулан 220.1 тэрбум төгрөгийн зээл олгож, зарим иргэн, ААНБ-д батлагдсан төсвөөс 50.7 тэрбум төгрөгийг дутуу олгосон байна.

3.3.66 Иргэн, ААНБ-уудад олгосон зээлээс 627.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр баталснаас 353.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 274.1 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдээгүй байна. /Тухайлбал, Боловсролын зээлийн сан 15.4 тэрбум төгрөг, Хөдөө аж ахуйг дэмжих сан 9.1 тэрбум төгрөг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 19.3 тэрбум төгрөг, ААНБ-уудад олгосон дамжуулан зээлийн эргэн төлөлт 92.6 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн/.

3.3.67 Дампуурсан Анод банкнаас 22.5 тэрбум төгрөг, Зоос банкнаас 58.5 тэрбум төгрөг, татан буугдсан хадгаламж зээлийн хоршооноос 20.6 тэрбум төгрөг, ЖДҮДС-аас 0.2 тэрбум төгрөгийн авлагыг тус тус барагдуулахаар төлөвлөсөн боловч эргэн төлөлт хийгдээгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн зорилтот түвшнийг хангахуйц төсөв батлагдсан боловч зарим хөтөлбөр, арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй байна

3.3.68 УИХ-ын 2023 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд 8 тэргүүлэх чиглэл, 24 ТЕЗ, 53 хөтөлбөр, 194 ТАХ-ний үр дүнд нийт 306 шалгуур үзүүлэлтээр 2024 оны зорилтот түвшнийг тусгаж, нийт 185 ТАХ-нд 13,994.7 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай гэж тусгасан байна.

3.3.69 “Монгол Улсын Хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжих 132 төсөл, арга хэмжээнд 3,611.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс 34 арга хэмжээний 1,067.6 тэрбум төгрөгийг Монгол улсын 2024 оны улсын төсөвт баталсан нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд улсын төсөв нь “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”¹¹ гэсэн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

3.3.70 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-д улсын төсвийн 39 ерөнхийлөн захирагчийн 95 хөтөлбөрийн хүрээнд 408 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 22,677.8 тэрбум төгрөг баталсан байна

3.3.71 “Монгол Улсын Хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-д туссан 34 арга хэмжээнээс Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хавсралтаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-д 7 арга хэмжээг тусгаж, зарим арга хэмжээний тоо хэмжээг зөрүүтэй төлөвлөн баталсан байна.

3.3.72 “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт”-д тусгасан нийт хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 79.0 хувь, төсвийн гүйцэтгэл 94.2 хувьтай байгаа нь төсвийн зарцуулалт нь хүрэх зорилтод түвшний үр дүн, хэрэгжилттэй уялдахгүй байна.

3.3.73 Улсын төсвийн 10 ерөнхийлөн захирагчийн 19 арга хэмжээ хэрэгжээгүй, суурь болон зорилтот түвшнийг үндэслэлтэй тодорхойлоогүйгээс төсвийн 5 ерөнхийлөн захирагчийн 8 арга хэмжээг үнэлэх боломжгүй байна.

3.3.74 ЗГХЭГ-аас ТЕЗ нарын хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн зорилтод түвшний хэрэгжилтэд хяналт тавьж, дүгнэж, үнэлээгүй нь Засгийн газрын¹² 2021 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

¹¹ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3

¹² “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 4.2 -Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлж дүгнэх ажлыг улсын хэмжээнд нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүргийг хариуцна”

БҮЛЭГ 4. УУЛ УУРХАЙН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ БУУРСАН БОЛОВЧ ЭКСПОРТЫН БИЕТ ХЭМЖЭЭ ӨССӨН НЬ ТӨСВИЙН ОРЛОГОД НӨЛӨӨ ҮЗҮҮЛЖ, ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ ТӨЛӨВЛӨСНӨӨС 2,450.9 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР САЙЖИРЧ, 920.3 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЛДАГДАЛТАЙ ГАРСАН БАЙНА

4.1 Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцэл төлөвлөснөөс 2,450.9 тэрбум төгрөгөөр сайжирч, 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна

4.1.1 Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 3,371.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна¹³.

Хүснэгт 22. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүдийн ДНБ-д эзлэх хувь болон өсөлтийн хувь

№	Үзүүлэлт	2000-2023	2024 он	Зөрүү
1	Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	Өсөлтийн хувь	21.5%	27.4%
		ДНБ-д эзлэх хувь	30.0%	37.1%
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	Өсөлтийн хувьд	20.0%	35.9%
		ДНБ-д эзлэх хувь	33.6%	38.3%
3	Тэнцвэржүүлсэн тэнцэл	ДНБ-д эзлэх хувь	(3.6%)	(1.2%)
4	Нэрлэсэн ДНБ-ийн өсөлт		19.9%	13.5%
5	Бодит ДНБ-ны өсөлт		6.2%	4.9%

4.1.2 Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 27.4 хувиар өссөн нь өмнөх жилүүдийн дунджаас 5.9 нэгжээр давсан нь төсвийн орлогын суурь өргөжиж, эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнтэй, мөн орлогын ДНБ-д эзлэх хэмжээ 37.1 хувь болж, 7.1 нэгжээр өссөн нь татварын болон татварын бус орлогын өсөлттэй холбоотой байна.

4.1.3 Төсвийн нийт зардал өмнөх онуудын дунджаас 15.9 нэгжээр нэмэгдэж 35.9 хувьд хүрсэн нь төсвийн зарлагын бодлого тэлэлттэй хэвээр байгааг харуулж байна.

4.1.4 ДНБ-д эзлэх зардлын хэмжээ 4.7 нэгжээр өсөж 38.3 хувьд хүрсэн ч орлогын өсөлт өндөр байсантай холбоотойгоор төсвийн алдагдал өмнөх жилүүдээс тодорхой хэмжээгээр сайжирч ДНБ-ий 1.2 хувь болж буурсан байна.

4.1.5 Нэгдсэн төсвийн 2024 оны тэнцвэржүүлсэн тэнцэл өмнөх оноос 1,706.2 тэрбум төгрөгөөр буурч, төлөвлөснөөс 2,450.9 тэрбум төгрөгөөр сайжирсан байна.

4.1.6 Тэнцвэржүүлсэн тэнцлийг төсвийн бүрэлдэхүүнээр авч үзвэл улсын төсөв 1,283.3 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 136.8 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сан 5.2 тэрбум төгрөгийн алдагдалтай, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл 505.0 тэрбум төгрөгийн ашигтай байна.

4.1.7 Тайлант онд Засгийн газрын үнэт цаасны борлуулалтаас 1,307.6 тэрбум төгрөг, Засгийн газрын гадаад зээлээс 1,319.1 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлогоос 2.0 тэрбум төгрөг, төсөвт хамаарах харилцах болон хадгаламжийн данснуудын цэвэр өөрчлөлтөөс 742.5 тэрбум төгрөг, нийт 3,371.2 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 23. Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, /тэрбум төгрөг/

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2023 оны Гүйц	2024 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5=3/2
Харилцах болон хадгаламжийн дансны өөрчлөлт	(1,028.5)	742.5	(10.9)	753.4	(1.5)
Засгийн газрын бонд	(704.1)	1,307.6	(226.6)	1,534.2	(17.3)
Засгийн газрын зээл	944.2	1,319.1	1,156.7	162.4	87.7
Өмч хувьчлал	2.5	2.0	1.1	0.9	55.0
Нийт дүн	(785.9)	3,371.2	920.3	2,450.9	27.3

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

¹³ Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хоорондын давхардсан 5,071.5 тэрбум төгрөгийн орлого, зарлагын шилжүүлгийг цэвэрлэн тайлагнасан байна

4.1.8 Гүйцэтгэлээр Засгийн газрын дотоод үнэт цаасны борлуулалтаас 809.8 тэрбум төгрөг, гадаад зээлээс 2,389.6 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлогоос 1.1 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, өмнөх онуудад авч ашигласан Засгийн газрын дотоод, гадаад үнэт цаасны төлбөрт 1,036.4 тэрбум төгрөг, гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 1,232.9 тэрбум төгрөгийг тус тус төлж, харилцах болон хадгаламжийн данснуудын цэвэр өсөлт 10.9 тэрбум төгрөгт хүрснээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн тэнцлийг 920.3 тэрбум төгрөгийн алдагдалтай илэрхийлсэн байна.

4.2 Улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 2,504.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 1,283.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 1,288.6 тэрбум төгрөгөөр буурсан байна

4.2.1 Монгол Улсын 2024 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 20,173.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 22,677.8 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн нийт тэнцлийг 2,504.1 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөжээ.

4.2.2 Гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн орлого 20,089.1 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээл 21,372.4 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1,283.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 24. Улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, /тэрбум төгрөг/

Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2023 оны Гүйц	2024 оны				Өмнөх оноос
		Төлөв	Гүйц	Хувь	Зөрүү	
А	1	2	3	4=3/2	5=3-2	6=3-1
Харилцах болон хадгаламжийн дансны өөрчлөлт	(246.3)	387.2	862.8	222.8	475.6	1,109.1
Засгийн газрын бонд	(704.1)	797.8	(736.4)	(92.3)	(1,534.2)	(32.3)
Засгийн газрын зээл	944.2	1,319.1	1,156.7	87.7	(162.4)	212.5
Өмч хувьчлал	0.9	-	0.2	-	0.2	(0.7)
Нийт дүн	(5.3)	2,504.1	1,283.3	51.2	(1,220.8)	1,288.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.2.3 Улсын төсвийн алдагдлыг нөхөн зорилгоор 2,047.6 тэрбум төгрөгийн төслийн зээлийн ашиглалт, 342.0 тэрбум төгрөгийн хөтөлбөрийн зээл авч, улсын төсвийн улирлын чанартай орлогын дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор шинээр 300.0 тэрбум төгрөгийн дотоод бонд гаргаж, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдлээс 862.8 тэрбум, өмч хувьчлалын орлогоос 0.2 тэрбум, нийт 3,552.6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

4.2.4 Дээрх эх үүсвэрүүдээс Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 898.9 тэрбум төгрөг, гадаад зээлийн үндсэн төлбөрт 1,232.9 тэрбум, дотоод үнэт цаасны үндсэн төлбөрт 137.5 тэрбум төгрөг, нийт 2,269.3 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

БҮЛЭГ 5. ОРОН НУТГИЙН ЗАРЛАГА ӨМНӨХ ОНООС 67.4 ХУВИАР, ОРЛОГЫН ӨСӨЛТӨӨС 21.8 ПУНКТААР НЭМЭГДСЭН, ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТЭЛЭЛТИЙГ БУУРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

5.1 Орон нутгийн нийт орлого ба тусламжийн дүн 7,121.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 45.6 хувиар өссөн боловч 95.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 362.1 тэрбум төгрөгөөр тасарсан байна

5.1.1 Орон нутгийн 2024 оны нийт орлого ба тусламжийг 7,483.9 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 7,121.8 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 95.2 хувьтай буюу 362.1 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

5.1.2 Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн 79.4 хувь буюу 5,652.4 тэрбум төгрөгийг татварын орлого, 20.6 хувь буюу 1,469.4 тэрбум төгрөгийг татварын бус орлого эзэлж байна.

5.1.3 Татварын орлогын 46.5 хувь буюу 2,630.4 тэрбум төгрөгийг хувь хүний орлогын албан татварын орлогоос бүрдүүлсэн байна. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 78.9 тэрбум төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 25. Орон нутгийн орлогын гүйцэтгэл эдийн засгийн ангиллаар, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5=3/2
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,891.4	7,483.9	7,121.8	(362.1)	95.2
1. Татварын орлого	3,818.4	5,955.4	5,652.4	(303.0)	94.9
1.1. Орлогын албан татвар	2,985.9	4,839.3	4,663.0	(176.3)	96.4
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	1,884.6	2,550.8	2,630.4	79.6	103.1
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	1,165.8	2,367.7	2,111.5	(256.2)	89.2
1.1.3. Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(64.5)	(79.2)	(78.9)	0.3	99.6
1.2. Хөрөнгийн албан татвар	394.8	455.2	459.4	4.2	100.9
1.3. Бусад татвар (төлбөр, хураамж)	437.7	660.9	530.0	(130.9)	80.2
2. Татварын бус орлого	1,073.0	1,528.5	1,469.4	(59.1)	96.1
2.1. Нийтлэг татварын бус орлого	427.6	621.2	600.0	(21.2)	96.6
2.2. Хөрөнгийн орлого	8.2	16.1	6.3	(9.8)	39.1
2.3. Тусламжийн орлого	17.2	19.7	11.2	(8.5)	56.9
2.4. Төсөв хоорондын шилжүүлэг	620.0	871.5	851.9	(19.6)	97.8

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

Татварын орлого

5.1.4 Орон нутгийн төсвийн орлого ба тусламжийн дүн 362.1 тэрбум төгрөгөөр тасрахад татварын орлого 303.0 тэрбум төгрөгөөр тасарсан нь голлон нөлөөлжээ.

5.1.5 Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварыг 14 аймаг нийт 22.5 тэрбум төгрөгөөр давж биелүүлсэн ч Улаанбаатар хот 30.0 тэрбум төгрөг, 7 аймгийн орлого 248.7 тэрбум төгрөгөөр тасарсан байна. /Баян-Өлгий аймгийн ТЕЗ 0.7 тэрбум төгрөг, Говь-Алтай аймгийн ТЕЗ 8.5 тэрбум төгрөг, Дорноговь аймгийн ТЕЗ 11.9 тэрбум төгрөг, Дорнод аймгийн ТЕЗ 1.3 тэрбум төгрөг, Өмнөговь аймгийн ТЕЗ 215.3 тэрбум төгрөг, Сүхбаатар аймгийн ТЕЗ 7.4 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгийн ТЕЗ 3.6 тэрбум төгрөг/.

5.1.6 Бусад татвар төлбөр, хураамжийн орлого 13 аймагт нийт 29.1 тэрбум төгрөгөөр давсан ч Улаанбаатар хот 125.4 тэрбум төгрөг, 8 аймгийн орлого 34.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна. /Баян-Өлгий аймгийн ТЕЗ 0.4 тэрбум төгрөг, Говь-Алтай аймгийн ТЕЗ 0.7 тэрбум төгрөг, Дорноговь аймгийн ТЕЗ 29.3 тэрбум төгрөг, Дундговь аймгийн ТЕЗ 0.3 тэрбум төгрөг, Сүхбаатар аймгийн ТЕЗ 1.1 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгийн ТЕЗ 0.9 тэрбум төгрөг, Төв аймгийн ТЕЗ 1.7 тэрбум төгрөг, Ховд аймгийн ТЕЗ 0.2 тэрбум төгрөг/.

Татварын бус орлого

5.1.7 Татварын бус орлогын 40.8 хувь буюу 600.0 тэрбум төгрөгийг нийтлэг татварын бус орлого, 1.3 хувь буюу 17.5 тэрбум төгрөгийг хөрөнгийн болон тусламжийн орлого, 32.9 хувь

буюу 483.9 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлэг, 25.0 хувь буюу 368.0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг бүрдүүлсэн байна.

5.1.8 Нийтлэг татварын бус орлого 16 аймагт 40.7 тэрбум төгрөгөөр давж 600.0 тэрбум төгрөгийг бүрдүүлсэн ч Улаанбаатар 24.1 тэрбум төгрөг, 5 аймаг 37.8 тэрбум төгрөгөөр тасарсан байна. /Баян-Өлгий аймгийн ТЕЗ 1.2 тэрбум төгрөг, Баянхонгор аймгийн ТЕЗ 0.4 тэрбум төгрөг, Орхон аймгийн ТЕЗ 31.7 тэрбум төгрөг, Сүхбаатар аймгийн ТЕЗ 4.2 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгийн ТЕЗ 0.3 тэрбум төгрөг/

5.1.9 Хөрөнгийн орлогыг 15 аймагт 16.1 тэрбум төгрөг баталснаас 6.3 тэрбум төгрөгийг бүрдүүлж, 8 аймагт 1.5 тэрбум төгрөгөөр давсан, 7 аймаг 11.3 тэрбум төгрөгөөр тасарсан байна. /Баянхонгор аймгийн ТЕЗ 0.1 тэрбум төгрөг, Орхон аймгийн ТЕЗ 10.4 тэрбум төгрөг, Өмнөговь аймгийн ТЕЗ 0.7 тэрбум төгрөг, Увс аймгийн ТЕЗ 0.1 тэрбум төгрөг, Дорнод, Сүхбаатар, Хэнтий 0.01-0.02 тэрбум төгрөг/

5.1.10 Тусламжийн орлогыг 5 аймагт 19.7 тэрбум төгрөгөөр баталснаас 11.2 тэрбум төгрөг буюу 56.9 хувийн орлого бүрдүүлж, 8.5 тэрбум төгрөгөөр тасарсан байна. /Баянхонгор аймгийн ТЕЗ 3.3 тэрбум төгрөг, Дорнод аймгийн ТЕЗ 1.3 тэрбум төгрөг, Өмнөговь аймгийн ТЕЗ 3.1 тэрбум төгрөг, Төв аймгийн ТЕЗ 0.8 тэрбум төгрөг/

5.1.11 Улсын төсвөөс орон нутагт олгох санхүүгийн дэмжлэгийг¹⁴ 368.0 тэрбум төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг¹⁵ 503.5 тэрбум төгрөг, нийт 871.5 тэрбум төгрөгөөр баталснаас 851.9 тэрбум төгрөгийг шилжүүлж 97.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 26. Орон нутгийн орлогын гүйцэтгэл төсөв захирагчаар, /тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Орлого				Аймаг, нийслэл	Орлого			
	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Архангай	74.7	81.3	6.6	108.8	Орхон	350.6	311.5	(39.1)	88.8
Баян-Өлгий	75.6	71.2	(4.4)	94.2	Өвөрхангай	86.5	94.4	7.9	109.1
Баянхонгор	99.1	100.4	1.3	101.3	Өмнөговь	2,081.4	1,879.1	(202.3)	90.3
Булган	85.9	91.7	5.8	106.8	Сүхбаатар	87.6	77.8	(9.8)	88.8
Говь-Алтай	85.0	79.4	(5.6)	93.4	Сэлэнгэ	120.6	119.4	(1.2)	99.0
Говьсүмбэр	28.3	31.7	3.4	112.0	Төв	133.2	140.9	7.7	105.8
Дархан-Уул	86.2	100.3	14.1	116.4	Увс	75.3	81.2	5.9	107.8
Дорноговь	193.0	158.6	(34.4)	82.2	Улаанбаатар	3,281.5	3,090.5	(191.0)	94.2
Дорнод	93.7	97.3	3.6	103.8	Ховд	102.2	110.2	8.0	107.8
Дундговь	78.6	95.5	16.9	121.5	Хөвсгөл	94.3	116.9	22.6	124.0
Завхан	76.9	85.2	8.3	110.8	Хэнтий	93.7	107.3	13.6	114.5
Нийт дүн						7,483.9	7,121.8	(362.1)	95.2

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

5.1.12 Орон нутгийн төсвийн нийт орлого, тусламжийн орлогын 43.4 хувийг Улаанбаатар хот, 26.4 хувийг Өмнөговь аймаг, 4.4 хувийг Орхон аймаг, 2.2 хувийг Дорноговь аймаг, 2.0 хувийг Төв аймаг, 21.6 хувийг бусад аймгууд бүрдүүлсэн байна.

5.2 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 7,258.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч батлагдсан төлөвлөгөөнөөс 1,981.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх оноос 67.4 хувь буюу 2,922.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна

5.2.1 Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2024 онд 9,239.7 тэрбум төгрөгөөр баталж, 7,258.6 тэрбум төгрөг буюу 78.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

5.2.2 Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 1,981.1 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулахад эргэж төлөгдөх цэвэр зээл 33.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 1,390.9 тэрбум төгрөг, урсгал зардал 556.5 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь нөлөөсөн байна.

¹⁴ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 16 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд орон нутгийн төсвөт доор дурдсан хэмжээтэй санхүүгийн дэмжлэг олгоно: .../сая төгрөгөөр/ нийт дүн 368,039.7

¹⁵ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 18 дугаар зүйл. 2024 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг доор дурдсан хэмжээтэй байна: .../сая төгрөгөөр/ нийт дүн 503,483.6

Хүснэгт 27. Орон нутгийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн эдийн засгийн ангиллаар, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=2-3	5=3/2
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,336.3	9,239.7	7,258.6	1,981.1	78.6
А. УРСГАЛ ЗАРЛАГА	3,031.8	4,801.1	4,244.6	556.5	88.4
1. Бараа, үйлчилгээний зардал	1,580.1	2,569.8	2,251.2	318.6	87.6
2. Хүү	57.4	72.5	70.0	2.5	96.6
3. Татаас ба урсгал шилжүүлэг	1,394.3	2,158.8	1,923.4	235.4	89.1
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,236.3	4,279.6	2,888.7	1,390.9	67.5
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	68.2	159.0	125.3	33.7	78.8

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

5.2.3 Бусад урсгал шилжүүлэгт 62.5 тэрбум төгрөг зарцуулснаас 29.4 хувь буюу 18.4 тэрбум төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал, 28.8 хувь буюу 18.0 тэрбум төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг, 14.5 хувь буюу 9.1 тэрбум төгрөгийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 10.4 хувь буюу 6.5 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, 8.9 хувь буюу 5.5 тэрбум төгрөгийг ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал, 8.0 хувь буюу 5.0 тэрбум төгрөгийг төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал тус тус эзэлж байна.

5.2.4 Өмнөх оны гүйцэтгэлээс урсгал зардал 1,212.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. /Өмнөговь аймгийн ТЕЗ 808.9 тэрбум төгрөг, Улаанбаатар хотын ТЕЗ 87.5 тэрбум төгрөг, Дархан-Уул аймгийн ТЕЗ 23.2 тэрбум төгрөг, Дорноговь аймгийн ТЕЗ 22.8 тэрбум төгрөг, Хэнтий аймгийн ТЕЗ 21.7 тэрбум төгрөг, Төв аймгийн ТЕЗ 21.6 тэрбум төгрөг, Баян-өлгий аймгийн ТЕЗ 21.0 тэрбум төгрөг, Өвөрхангай аймгийн ТЕЗ 20.3 тэрбум төгрөг, Ховд аймгийн ТЕЗ 20.0 тэрбум төгрөг, бусад аймгууд 1.5-19.8 тэрбум төгрөг/

5.2.5 Орон нутгийн төсвөөс 1,595.3 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 88.8 хувь буюу 1,415.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 179.4 тэрбум төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь орон нутгийн орлогын төлөвлөгөө тасарснаас шалтгаалжээ. /Өмнөговь аймгийн ТЕЗ 170.3 тэрбум төгрөг, Дорноговь аймгийн ТЕЗ 8.7 тэрбум төгрөг, Сэлэнгэ аймгийн ТЕЗ 0.4 тэрбум төгрөг/

Хүснэгт 28. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл төсвийн захирагчаар, /тэрбум төгрөг/

Д/д	Үзүүлэлт	2024 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	Б	1	2	3=1-2	4=2/1
1	Дорноговь аймаг	11.8	3.1	8.7	26.3
2	Дорнод аймаг	2.6	2.6	-	100.0
3	Өмнөговь аймаг	1,420.0	1,249.7	170.3	88.0
4	Сэлэнгэ аймаг	2.3	1.9	0.4	81.4
5	Дархан-Уул аймаг	1.4	1.4	-	100.0
6	Улаанбаатар	19.5	19.5	-	100.0
7	Орхон аймаг	137.7	137.7	-	100.0
Нийт дүн		1,595.3	1,415.9	179.4	88.8

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

5.2.6 Хөрөнгийн зардалд 4,279.6 тэрбум төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 2,888.7 тэрбум төгрөг зарцуулснаас 48.4 хувь буюу 1,397.5 тэрбум төгрөгийг тоног төхөөрөмж, бусад хөрөнгө, 43.4 хувь буюу 1,254.1 тэрбум төгрөгийг барилга байгууламж, 8.2 хувь буюу 237.1 тэрбум төгрөгийг их засвар тус тус эзэлж байна.

5.2.7 Хөрөнгийн зардал өмнөх оноос 1,652.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Дорноговь аймгийн ТЕЗ 2.5 тэрбум төгрөгөөр буурсан бол Улаанбаатар хотын ТЕЗ 1,289.2 тэрбум төгрөг, 20 аймагт 365.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. /Өмнөговь аймгийн ТЕЗ 209.2 тэрбум төгрөг, Орхон аймгийн ТЕЗ 42.1 тэрбум төгрөг, Ховд аймгийн ТЕЗ 22.6 тэрбум төгрөг, Хөвсгөл аймгийн ТЕЗ 18.7 тэрбум төгрөг, бусад аймгууд 1.3-8.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна/

5.2.8 Орон нутгийн ТЕЗ нарын 534 хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж аймаг нийслэлийн ИТХ-аар 9,239.7 тэрбум төгрөгийн төсөв баталснаас, 7,258.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 78.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 29. Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн төсвийн захирагчаар, /тэрбум төгрөг/

Аймаг, нийслэл	Нийт зарлага				Аймаг, нийслэл	Нийт зарлага			
	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Архангай	85.7	73.2	12.5	85.4	Орхон	392.7	316.7	76.0	80.6
Баян-Өлгий	80.7	70.7	10.0	87.6	Өвөрхангай	103.1	86.4	16.7	83.8
Баянхонгор	108.7	91.8	16.9	84.5	Өмнөговь	2,296.9	1,904.4	392.5	82.9
Булган	99.3	86.4	12.9	87.0	Сүхбаатар	104.0	72.9	31.1	70.1
Говь-Алтай	95.8	76.4	19.4	79.7	Сэлэнгэ	135.5	109.7	25.8	81.0
Говьсүмбэр	34.2	28.7	5.5	83.9	Төв	159.9	125.7	34.2	78.6
Дархан-Уул	109.8	81.5	28.3	74.2	Увс	83.7	74.5	9.2	89.0
Дорноговь	196.2	153.4	42.8	78.2	Улаанбаатар	4,514.0	3,362.4	1,151.6	74.5
Дорнод	106.8	92.4	14.4	86.5	Ховд	132.4	110.6	21.8	83.5
Дундговь	93.2	63.5	29.7	68.1	Хөвсгөл	107.5	98.4	9.1	91.5
Завхан	93.1	85.0	8.1	91.3	Хэнтий	106.5	93.9	12.6	88.2
Нийт дүн						9,239.7	7,258.6	1,981.1	78.6

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

5.2.9 Орон нутгийн 22 ТЕЗ жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 534¹⁶ хөтөлбөр баталснаас давхардаагүй тоогоор 77 хөтөлбөрт 579 хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийт 710 чанарын болон тоон шалгуур үзүүлэлтийг тухайн аймаг, нийслэлийн ИТХ-ын тогтоолоор баталсан байна.

5.2.10 Орон нутгийн ТЕЗ нарын жилийн эцсийн үр дүнгийн үнэлгээгээр 87 хөтөлбөрийн 99 үр дүн 85.0 хувь хүртэл гүйцэтгэлтэй, 363 хөтөлбөрийн 378 үр дүн 85.0-100.0 хувийн гүйцэтгэлтэй, 84 хөтөлбөрийн 102 үр дүн 100.0 хувиас дээш гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

5.2.11 Орон нутгийн 2024 оны жилийн эцсийн тайланд зөвхөн нэг аймагт 45 хөтөлбөр бүртгэгдсэн нь нийт хөтөлбөрийн 50 гаруй хувийг эзэлж байна. Энэ нь хөтөлбөрийн нэршлийг өөрчлөх, товчлох, хуульд заасан нэр томъёо болон бичиг баримтын стандарт мөрдөхгүй байх зэрэгтэй холбоотойгоор боловсруулалт, хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитын илрүүлэлт:

- **Архангай аймаг:** Сангийн яамнаас Засгийн газрын дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлттэй холбоотой тооцоо, судалгааг аймгийн Засаг даргад ирүүлдэггүйгээс Засгийн газрын дамжуулан зээлийн гэрээний эргэн төлөлтийн орлогыг орон нутгийн суурь орлогод 0.5 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг нэмж төлөвлөснийг хянах боломжгүй;
- **Баянхонгор аймаг:** Тайлант онд тус сангаас 1.6 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 0.5 тэрбум төгрөгийн зээл олгосон бөгөөд 13 сум хөнгөлөлттэй зээлийг олгоогүй нь Шинэ хөдөө төсөл хэрэгжсэнтэй холбоотой байна.
- **Говьсүмбэр аймаг:** Сумын орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлж буй төслүүдийг жижиглэн үр дүн багатай урсгал зардлын шинжтэй арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулах эрсдэл үүссэн байна.
- **Дундговь аймаг:** Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлд 2.3 тэрбум төгрөг батлагдсанаас, гүйцэтгэлээр 0,09.0 тэрбум төгрөг буюу 4.0 хувийн зээл олгосон.
- **Ангилагдаагүй, ерөнхий данс, хөтөлбөр арга хэмжээний зардлын данстай холбоотой:**
- **Архангай аймаг:** Тайлант онд аймгийн Засаг даргын ерөнхий дансанд хотын нийтийн хүн тээврийн үйлчилгээнд 0.4 тэрбум төгрөгийг төлөвлөж, шаардлага хангасан хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлсэн иргэдийн тоо холбогдох урсгал зардлын нарийвчилсан тооцоог нотлох санхүүгийн анхан шатны баримтыг ирүүлээгүй, үйлчлүүлсэн иргэдийн тоо, гарсан зардлыг хянах боломжгүй байхад санхүүжилтийг тооцон олгосон байна.
- **Баян-Өлгий аймаг:** Орон нутгийн ерөнхий дансны зардлын 38.8 хувийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын төрийн албан хаагч нарт орон нутгийн 30.0 хувийн нэмэгдэлд олгож үр ашиггүй зарцуулсан.
- **Говь-Алтай аймаг:** Засаг дарга ерөнхий дансны санхүүжилт 2020-2023 онд 0.4-2.7 тэрбум төгрөгт хүрсэн, 2024 онд 3.5 дахин нэмэгдэж 9.2 тэрбум төгрөг болж өссөн. Засаг дарга ерөнхий данснаас 2024 онд 3.4 тэрбум төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт, сумдын ой тэмдэглэхэд 1.4 тэрбум

¹⁶ Давхардсан тоогоор

төгрөг, бусад хөтөлбөр арга хэмжээнд 1.9 тэрбум төгрөгийг урсгал зардал, Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлсэн.

- **Хэнтий аймаг:** Ангилдаагүй зардал дансанд Засаг даргын үйл ажиллагааны зардлыг төлөвлөж, зарцуулах хууль, журам, заавар байхгүй байна.

5.3 Орон нутгийн нийт орлого өмнөх оноос 45.6 хувиар өссөн боловч нийт зарлага 67.4 хувиар өссөнөөс шалтгаалж, төсвийн тэнцэл 136.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

5.3.1 Аймаг, нийслэлийн ИТХ-аар нийт орлого ба тусламжийн дүнг 7,483.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийг 9,239.7 тэрбум төгрөгөөр төлөвлөж, орон нутгийн төсвийг 1,755.8¹⁷ тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар баталсан байна.

5.3.2 Орон нутгийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 509.8 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасаар, 2.0 тэрбум төгрөгийг өмч хувьчлалын орлогоос, 1,244.0 тэрбум төгрөгийг харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

5.3.3 Тайлант онд орон нутгийн нийт орлого ба тусламжийн дүн 7,121.8 тэрбум төгрөг нийт зарлага ба цэвэр зээл 7,258.6 тэрбум төгрөгт хүрч, орон нутгийн төсвийн тэнцэл 136.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөсөн алдагдлыг 1,619.0 тэрбум төгрөгөөр бууруулсан байна.

5.3.4 Орон нутгийн ТЕЗ нарын ирүүлсэн төсвийн төслөөс Сангийн яам хянаж орон нутгийн төсвийн суурь зарлагыг 91.3 хувиар нэмэгдүүлсэн ба аймаг, нийслэлийн ИТХ, Сангийн яамны хянасан суурь зарлагыг 42.2 хувиар нэмж төлөвлөгөөг баталж төсвийн төслийг оновчтой хийгээгүй нь төсвийн алдагдалд нөлөөлсөн байна.

¹⁷ Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хоорондын давхардсан 3,540.0 тэрбум төгрөгийн орлого, зарлагын шилжүүлгийг цэвэрлэн тайлагнасан байна.

БҮЛЭГ 6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН МӨНГӨН ХӨРӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВЧ АЖИЛЛАСАН БОЛОВЧ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НАРИЙВЧИЛСАН ЗОХИЦУУЛАЛТГҮЙ БАЙНА**6.1 Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэхээр салбарын хуульд тусгасан боловч хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалтгүй байна**

6.1.1 Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөхөөр шийдвэрлэсэн байна.

6.1.2 Хуулийн шинэчлэлээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг санхүүгийн эргэлтэд оруулах, ахмадын орлогыг хамгаалах зорилгоор тэтгэврийг дундаж цалингийн өөрчлөлт, инфляцын түвшинтэй уялдуулан жил бүр тогтмол нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүү арилгах итгэлцүүр хэрэглэх, даатгуулагчдад үзүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн хүртээмжийг сайжруулах, залуу малчдыг дэмжиж нийгмийн даатгалын сангийн өгөөжийг нэмэгдүүлэх, тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих бодлогыг тодорхойлсон байна.

6.1.3 Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг үндэслэн Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 300.0 тэрбум төгрөгийн 8.5-9.5 хувийн хүүтэй, 1-3 жилийн хугацаатай, нийт 55.0 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөж хүртэхээр тооцоолж Засгийн газрын үнэт цаас худалдан авсан байна.

6.1.4 Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж хэлбэрээр санхүүгийн хэрэгсэлд¹⁸ хөрөнгө оруулж болно гэж заасан боловч салбарын хууль, тогтоомжид эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал байна.

6.1.5 Нийгмийн даатгалын ерөнхий хуульд Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор тэтгэврийн нөөц сантай¹⁹ байна гэж заасны дагуу тайлант онд 1.0 сая даатгуулагчийн 336.6 тэрбум төгрөгийг мөнгөжүүлэх орлого болгохоор тооцож 212.6 тэрбум төгрөгийг байршуулсан байна. Тэтгэврийн сангийн тайлант оны орлого 367.0 тэрбум төгрөгөөр тасарснаас шалтгаалж, нэрийн дансанд 124.0 тэрбум төгрөгийг дутуу байршуулсан байна.

6.1.6 Цар тахал буюу Коронавируст халдвар тархсан онцгой нөхцөл байдлын үед аж ахуйн нэгж, байгууллага, даатгуулагчийг дэмжих зорилгоор²⁰ ҮОМШӨ-ний даатгалын сангаас нийт 706.6 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн зарцуулснаас шалтгаалан цаашид тус сангийн эх үүсвэр дутагдах эрсдэл үүсэж болзошгүй, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр эрх бүхий байгууллагад хандсан боловч тодорхой шийдвэр гараагүй байна.

Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогыг 716.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна

6.1.7 Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуульд Нийгмийн даатгалын сангийн нийт орлогыг 5,893.3 тэрбум төгрөг, үүнээс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаас 1,175.0 тэрбум төгрөг байхаар баталжээ.

¹⁸ 13.1. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно: 13.1.1. Засгийн газрын үнэт цаас; 13.1.2. Монголбанкны үнэт цаас; 13.1.3. Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж; 13.1.4. Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банк /цаашид "арилжааны банк" гэх/-нд байршуулах мөнгөн хадгаламж.

¹⁹ 29.1 Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоо руу үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна", 29.3.1. энэ хуулийн 18.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгоогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого;

²⁰ УИХ-ын 2020 оны 04 дүгээр сарын 09-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд "2020.02.01-2021.07.01-ний өдрийг хүртэлх хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн /тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан/ 9 дүгээр зүйлийн 1,2,3,4,5 дахь хэсэгт заасан сан хооронд хөрөнгө шилжүүлэн зарцуулж болно."

6.1.8 Нийгмийн даатгалын багц хуулиудын хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын хамрах хүрээ, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэх, төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх, ажиллагсдын дундаж цалин хөлс нэмэгдэх, чөлөөт үлдэгдлийг хадгалуулсны хүүгийн орлого, хуримтлагдсан өр, авлагыг бууруулах зэрэг хүчин зүйлсийг үндэслэн шимтгэлийн орлогыг 716.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн, төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийн татаасыг 539.4 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан байна.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны нийт орлогыг 5,893.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 5,609.7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 95.2 хувийн гүйцэтгэлтэй байна

6.1.9 Нийгмийн даатгалын сангийн нийт орлого 5,893.3 тэрбум төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 95.2 хувь буюу 5,609.7 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 283.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 30. Нийгмийн даатгалын сангийн орлого, /тэрбум төгрөг/

Орлогын төрөл	2023 оны гүйц	2024 оны			
		Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5=3/2
Тэтгэврийн даатгал	2,862.3	3,940.1	3,573.1	(367.0)	90.7
Тэтгэмж даатгал	305.0	373.9	382.4	8.5	102.3
ҮОМШӨ-ний даатгал	277.3	265.4	339.8	74.4	128.0
Ажилгүйдлийн даатгал	62.7	138.9	139.4	0.5	100.4
Дүн	3,507.3	4,718.3	4,434.7	(283.6)	94.0
Улсын төсвийн дэмжлэг	764.3	1,175.0	1,175.0	-	100.0
Нийт дүн	4,271.6	5,893.3	5,609.7	(283.6)	95.2

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

6.1.10 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг өмнөх оноос 34.5 хувь буюу 1,211.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 4,718.3 тэрбум төгрөгөөр баталсан байна.

6.1.11 Тайлант онд тэтгэврийн даатгалын сангийн орлогыг 367.0 тэрбум төгрөгөөр дутуу, бусад сангийн орлого бүрдүүлэлт 83.4 тэрбум төгрөгөөр давснаас шалтгаалан Нийгмийн даатгалын сангийн орлого 283.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

6.1.12 Аж ахуйн нэгж, байгууллагаас авах НДШ-ийн авлага өмнөх оноос 39.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт 36.0 мянган аж ахуй нэгж, байгууллагаас 439.5 тэрбум төгрөгийн авлагатай байгаа нь орлого дутуу бүрдэхэд нөлөөлжээ.

6.2 Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоолыг салбарын шинэчилсэн хуультай нийцүүлж шинэчлэн батлаагүй байна

6.2.1 Чингис хаан банканд байршиж буй 93.4 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө эрсдэлтэй, Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 65.7 тэрбум төгрөгийн авлага барагдуулах ажил удаашралтай байна.

6.2.2 Чингис хаан банканд байршиж буй Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 94.9 тэрбум төгрөгийн үлдэгдлээс тайлант онд 1.5 тэрбум төгрөгийг барагдуулж, 93.4 тэрбум төгрөгийг дансны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулсан байна.

6.2.3 Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 08 дугаар тогтоолоор Чингис хаан банкны өр төлбөрт 5.1 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 3 ширхэг үл хөдлөх хөрөнгийг өр төлбөрт тооцон авахаар шийдвэрлэсэн байна.

6.2.4 Капитал банкны эрх хүлээн авагчаас авах 68.2 тэрбум төгрөгийн авлагаас тайлант онд 2.5 тэрбум төгрөг барагдуулж, үлдэгдэл 65.7 тэрбум төгрөгийн авлага барагдуулах ажил удаашралтай хэвээр байна.

6.2.5 Капитал банк эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн нийгмийн даатгалын сангийн өр, төлбөрт тооцон авсан хөрөнгийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам”-ын дагуу өмнөх оны

үлдэгдэл 15.9 тэрбум төгрөгийн 41 үндсэн хөрөнгөөс 12.6 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийн 10 хөрөнгийг борлуулж, 13.5 тэрбум төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

6.2.6 Дээрх хөрөнгийн түрээсийн орлогоор 0.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлснээс хөрөнгийн ашиглалт, үл хөдлөх хөрөнгийн зуучийн төлбөрт нийт 0.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

6.2.7 Нийгмийн даатгалын ерөнхий хуульд Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухайн жилийн хүүгийн хэмжээг Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл тогтооно гэж заасан боловч тайлант онд тооцох хүүгийн²¹ хэмжээг батлаагүйгээс шалтгаалан даатгуулагчийн нэрийн дансны хуримтлалын үлдэгдлийг дутуу тооцоолох, тэтгэврийг дутуу тогтоох эрсдэлтэй, мөн нэрийн дансны үлдэгдэл нь бодитоор мөнгөн орлого болон хуримтлагдаагүй бүртгэл хэлбэрээр байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 5,107.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 26.5 хувиар өсөхөд тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ

6.2.8 Нийгмийн даатгалын санд нийт 5,609.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлснээс шимтгэлийн орлого 4,434.7 тэрбум төгрөг, улсын төсвөөс 1,175.0 тэрбум төгрөгийн татаас олгож, гүйцэтгэлээр 5,107.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгалын санд 3,573.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 4,666.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 1,093.4 тэрбум төгрөгийн алдагдлыг улсын төсвийн татаас 1,169.8 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж, 76.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй;
- Тэтгэмжийн даатгалын санд 382.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 256.3 тэрбум төгрөгийг зарцуулж, 126.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 339.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрч, улсын төсвөөс татаас 5.2 тэрбум төгрөг, нийт 48.1 тэрбум төгрөгийг зарцуулж, 296.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй;
- Ажилгүйдлийн даатгалын санд 139.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрч, 136.3 тэрбум төгрөгийг зарцуулж, 3.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй.
- Капитал банкны эрх хүлээн авагчаас 2.5 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.

6.2.9 Нийгмийн даатгалын сангийн нийт зардал өмнөх оноос 26.5 хувь буюу 1,071.0 тэрбум төгрөгөөр өссөн нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд сайн дураар даатгуулагч-малчин, туслах малчны 5 хүртэлх жилийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувь, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс бүрэн хариуцан төлөхөөр болсон, Засгийн газрын 2024 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 100,000 төгрөгөөр нэмэгдүүлсэн, мөн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо өмнөх оноос 39370 иргэнээр нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

Хүснэгт 31. Нийгмийн даатгалын сангийн зарлага, /тэрбум төгрөг/

Д/д	Сангийн төрөл	2023 оны гүйц	2024 оны			
			Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
	А	1	2	3	4=2-3	5=3/2
1	Тэтгэврийн даатгал	3,653.5	4,741.1	4,666.5	74.6	98.4
2	Тэтгэмжийн даатгал	217.5	262.4	256.3	6.1	97.7
3	ҮОМШӨ-ний даатгал	54.1	61.9	48.1	13.8	77.8
4	Ажилгүйдлийн даатгал	111.1	123.0	136.3	(13.3)	110.8
	Нийт зарлага	4,036.2	5,188.4	5,107.2	81.2	98.4

Эх сурвалж: Нийгмийн даатгалын сангийн 2024 оны мэдээлэл

6.2.10 Тэтгэврийн даатгалын сангийн зардал 98.4 хувь, тэтгэмжийн даатгалын сан 97.7 хувь, ҮОМШӨ-ний даатгалын сан 77.8 хувийн гүйцэтгэлтэй, ажилгүйдлийн даатгалын сан 110.8 хувь

²¹ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.7-д “Энэ хуулийн 27.6-д заасан тухайн жилийн хүүгийн хэмжээг дараах үзүүлэлтийг харгалзан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн дараа оны нэгдүгээр улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тогтооно.”

буюу 13.3 тэрбум төгрөгөөр илүү зарцуулалттай байгаа нь ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо 31489 болж, өмнөх оноос 1401 иргэн нэмэгдсэнтэй холбоотой байна.

6.2.11 Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан төр хариуцан төлдөг шимтгэлийн 55.5 хувь буюу 24.4 тэрбум төгрөгийг малчин, туслах малчны тэтгэврийн даатгалын шимтгэл²², 23.6 хувь буюу 10.4 тэрбум төгрөгийг байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцгийн нийгмийн даатгалын шимтгэл²³, 20.9 хувь буюу 9.2 тэрбум төгрөгийг бусад төрлийн шимтгэл эзэлж байна.

6.2.12 Нийгмийн даатгалын сангийн тайлант оны тэнцлийн ашгийн хэмжээ өмнөх оноос 268.4 тэрбум төгрөг, улсын төсвөөс олгосон татаас 410.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

6.2.13 Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тэнцлийг 772.1 тэрбум төгрөгийн ашигтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 267.1 тэрбум төгрөгөөр давж, 505.0 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

²² Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.23.Малчин, туслах малчин энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна.

²³ Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.22.Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг энэ хуулийн 7.7-д заасны дагуу даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.

**БҮЛЭГ 7. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТЭНЦВЭР
АЛДАГДАЖ, ӨРИЙН ДАРАМТАД ОРСНООС ҮЙЛ АЖИЛЛАГАА ДОГОЛДОХ ЭРСДЭЛТЭЙ
БАЙНА**

7.1 ЭМДС-ийн орлого 1,921.7 тэрбум төгрөгт хүрч 97.8 хувийн гүйцэтгэлтэй байгаагийн 55.7 хувь буюу 1,070.9 тэрбум төгрөгийг төр хариуцах иргэдийн шимтгэл болон тусламж үйлчилгээний орлогоос бүрдүүлсэн байна

7.1.1 ЭМДС-ийн орлого 1,921.7 тэрбум төгрөгт хүрч 97.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

7.1.2 Даатгалын орлого өмнөх оноос 313.0 тэрбум төгрөгөөр өсөхөд 2024 онд цалин нэмэгдсэн, улсын төсвөөс олгох санхүүжилт 131.4 тэрбум төгрөгөөр өссөн зэрэг нь нөлөөлжээ.

7.1.3 Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчдын 23.4 хувийг ажил олгогч хариуцан төлөх 770916 иргэн, 6.5 хувийг өөрөө хариуцан төлөх 212717 иргэн, 70.1 хувийг төр хариуцах 2311810 иргэн /малчин 51104 иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч 117811 иргэн, Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн суралцагч 42501 иргэн, Гадаадын иргэн, харьяалалгүй 1301 иргэн/ эзэлж байна.

7.1.4 Даатгуулагчийн тоо өмнөх оноос 55224 иргэнээр нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байгаа хэдий ч даатгуулагчийн төрлөөр авч үзвэл улсын төсвөөс шимтгэлийг нь хариуцах иргэдийн тоо 83043 хүнээр өссөн, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн даатгуулагч өөрөө хариуцах иргэдийн тоо 27819 хүнээр буурсан байна.


7.2 ЭМДС-ийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар бодлогын арга хэмжээ аваагүйгээс эх үүсвэр дутагдаж 316.8 тэрбум төгрөгийн өр үүссэн, ЭМДЕГ-аас эмийн сан, эрүүл мэндийн байгууллагаас ирүүлсэн нэхэмжлэлд тавих хяналт хангалтгүй байна

7.2.1 Төсвийн гүйцэтгэлээр эрүүл мэндийн байгууллагуудад олгох тусламж үйлчилгээний санхүүжилтэд 1,725.4 тэрбум төгрөг, эмийн үнийн хөнгөлөлтөд 137.3 тэрбум төгрөг, үйл ажиллагааны урсгал зардалд 15.0 тэрбум төгрөг, эрсдэлийн санд 53.6 тэрбум төгрөг, нийт 1,931.3 тэрбум төгрөгийг зарцуулж, 99.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оноос 328.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

7.2.2 Тайлант онд эмийн үнийн хөнгөлөлт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлбөрт эрүүл мэндийн даатгалын сангаас 2,344.1 тэрбум төгрөгийн төлбөрийн нэхэмжлэл ирүүлсэн байна. Үүнээс дотоод хяналтаар 261.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хасаж 1,984.4 тэрбум төгрөгийг олгож, жилийн эцэст 316.8 тэрбум төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

7.2.3 Засгийн газар, АХБ-тай хамтран хэрэгжүүлсэн Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтын арга хэмжээ төслийн санхүүжилт 69.1 тэрбум төгрөг, эрсдэлийн санд байршуулсан 53.6 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын өр барагдуулахад нэмж зарцуулсан нь өрийн үлдэгдлийг 27.9 хувиар бууруулсан байна.

Дүрслэл 12. ЭМДС-ийн 2020-2025 оны орлого, зарлага, өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/



7.2.4 ЭМДС-ийн эх үүсвэрийн дутагдал, зарлагын өсөлттэй уялдан эмийн үнийн хөнгөлөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний өглөг өсжээ. Тухайлбал 2024 онд өмнөх оноос орлого 19.3 хувиар өсөхөд, зарлага 20.5 хувиар, өглөг 45.1 хувиар нэмэгдсэн байна.

7.2.5 ЭМДС-ийн ашиглаж байгаа health.gov.mn цахим программаар хэрэгжүүлж байгаа нэхэмжлэлийн хяналт хангалтгүйгээс тайлант онд ашиглангийн шинжтэй код ахиулах, завших оролдлого хийх, хуурамч нэхэмжлэл илгээсэн, тусламж үйлчилгээний зардлыг баталсан төлбөрийн хэмжээний дагуу нэхэмжлээгүй, гэрээнд хатуу хязгаарласан тоо хэмжээнээс илүү нэхэмжилсэн зэрэг нийт 338.7 сая төгрөгийн зөрчлийг ЭМЯ-ны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Эрүүгийн цагдаагийн газартай хамтарсан шалгалтаар илрүүлж, санд хохирол учруулсан байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт хүргүүлсэн байна.

7.2.6 Сангийн орлогын 55.8 хувь буюу 1,070.9 тэрбум төгрөгийг төр хариуцах иргэдийн шимтгэл, тусламж үйлчилгээний санхүүжилт бүрдүүлсэн ч эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлын 84.7 хувь буюу 1,623.6 тэрбум төгрөгийг төр хариуцах иргэдэд олгосон байна.

7.2.7 Даатгуулагч өөрөө хариуцах иргэдийн тоо буурсан, зарлагын өсөлт орлогын өсөлтөөс давсан, эрүүл мэндийн байгууллагуудад эмийн үнийн хөнгөлөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлбөрийг бүрэн барагдуулж чадахгүй өрийн дарамтад орсон, үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байгаа тул эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцоонд бодлогын шинэчлэл шаардлагатай

7.2.8 ЭМДС-ийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 1,921.7 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 1,926.9 тэрбум төгрөгт хүрч, нийт тэнцэл 5.2 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.

БҮЛЭГ 8. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧДЫН НЭМЭЛТ ТӨСВӨӨР 1,160.1 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЖ, ГҮЙЦЭТГЭЛЭЭР 1,160.5 ТЭРБУМ ТӨГРӨГ ЗАРЦУУЛЖ, 81.2 ТЭРБУМ ТӨГРӨГИЙГ АВЛАГА ҮҮСГЭН ТАЙЛАГНАСАН БАЙНА

8.1. Зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын давсан орлогын зарцуулалт жил бүр нэмэгдэж байгаад анхаарал хандуулах шаардлагатай байна

8.1.1. Төсвийн ерөнхийлөн захирагчдын нэмэлт төсөв өмнөх оноос 37.6 хувь буюу 317.3 тэрбум төгрөгөөр өсөж 1,160.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 66.2 хувь буюу 768.5 тэрбум төгрөгийг улсын төсвийн, 33.8 хувь буюу 391.6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвийн байгууллагууд бүрдүүлжээ.

Хүснэгт.32. Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр, /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 оны гүйц	2024 оны гүйц	Үүнээс		Өсөлт	
			УТ	ОНТ	Зөрүү	Хувь
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	842.8	1,160.1	768.5	391.6	317.3	37.6
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	43.4	56.5	42.1	14.4	13.1	30.2
ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	182.8	354.5	240.2	114.3	171.7	93.9
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	358.6	482.9	268.9	214.0	124.3	34.7
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	252.0	259.1	210.2	48.9	7.1	2.8
Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	6.0	7.1	7.1	-	1.1	18.3

Эх сурвалж: МУНТГ-ын 2023, 2024 оны нэмэлт төсвийн тайлан

8.1.2. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн 41.6 хувь буюу 482.9 тэрбум төгрөгийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан төсөв эзэлж, өмнөх оноос 34.7 хувиар буюу 124.3 тэрбум төгрөгөөр өсөж байгаагаас үзэхэд Төсвийн ерөнхийлөн захирагчид өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилж, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

8.1.3. Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 259.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 2.8 хувиар буюу 7.1 тэрбум төгрөгөөр өссөн, тайлант онд Сангийн сайдын 2024 оны “Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох тухай” 224 дүгээр тушаалаар 30.9 тэрбум төгрөгийн зарцуулах эрхийг олгосон байна.

8.1.4. Төсвийн байгууллагуудын тайлант онд бүрдүүлсэн үйл ажиллагааны орлогын давалтаас зарцуулах эрх олгож, төсвийн гүйцэтгэлийн тайланд бууруулж тайлагнаж байгаа нь үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөхгүй байхад хүргэж, жил бүр давсан орлогыг нэмэлт дансанд төвлөрүүлэн төсвөөс гадуурх зарцуулалтыг нэмэгдүүлж байна

8.1.5. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын нэмэлт санхүүжилтийн нэмэлт орлогын эх үүсвэрийг Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан ангиллын дагуу үнэн зөв тайлагнаагүй байна.

8.2. Нэмэлт санхүүжилтийн төсвөөс 1,160.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 81.2 тэрбум төгрөгийг дараа ондоо авч зарцуулахаар авлагаар бүртгэж, тайлагнасан байна

8.2.1. Нэмэлт төсвийн зарлага 1,160.5 тэрбум төгрөг болж өмнөх оноос 37.4 хувиар буюу 315.8 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт зарлага, цэвэр зээлийн дүнд 66.3 хувь буюу 768.9 тэрбум төгрөг нь улсын төсвийн, 33.7 хувь буюу 391.6 тэрбум төгрөг нь орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал эзэлж байна.

8.2.2. Нэмэлт төсвийг дараах зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулсан байна. Тухайлбал: 812.4 тэрбум төгрөгийг бараа, ажил үйлчилгээний зардалд, 2.4 тэрбум төгрөгийг хүүгийн зардалд, 1.2 тэрбум төгрөгийг татаас, 277.0 тэрбум төгрөгийг урсгал шилжүүлгийн зардалд, 67.5 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

8.2.3. Тайлант онд нэмэлт төсвийн данснаас зарцуулаагүй үлдэгдэл 97.5 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлснээс 81.2 тэрбум төгрөг буюу 83.3 хувийг авлагаар бүртгэж, он дамжуулан зарцуулахаар байна.

8.2.4. Тайлант онд төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс 16.9 тэрбум төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, төсвөөс гадуур зарцуулсан байна. /Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас Булган аймагт 2.0 тэрбум төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХК-аас БХС-ын багцад 1.7 тэрбум төгрөг, ХЗДХС-ын багцад 12.7 тэрбум төгрөг, Өмнөговь аймагт 0.5 тэрбум төгрөг/

8.2.5. Өмнөх оны аудитаар Сангийн сайдын 2022 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-д давсан орлогын зарцуулах эрхийг дараагийн төсвийн жилд олгодог байхаар зохицуулалт хийх талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, журмын төслийг боловсруулах шатандаа байна.

БҮЛЭГ 9. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЦИЙН 95.9 ХУВИЙГ ГАДААД ӨР ЭЗЭЛЖ БАЙГААГ ХЯНАЖ, ҮР ӨГӨӨЖИЙГ САЙЖРУУЛАХАД ӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГЫГ ЧИГЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**9.1 Өрийн бүтцийн 95.9 хувийг гадаад өр эзэлж байгаа нь санхүүгийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлөхүйц гадаад хамаарал өндөр байгааг харуулж байна**

9.1.1 Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн Засгийн газрын 2024 оны 71 дүгээр тогтоолоор “Засгийн газрын 2024 оны зээллэгийн төлөвлөгөө”-г баталж, 133 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

9.1.2 Засгийн газрын өрийн багцын үзүүлэлтүүдийн харьцаа 2024 оны гүйцэтгэлээр зохистой түвшинд байгаа хэдий ч Засгийн газрын нийт өрийн үлдэгдэлд гадаад валютаар илэрхийлсэн өр 95.9 хувийг эзэлж, зорилтот түвшин 80.0 хувиас хэтэрсэн нь төгрөгийн ханш суларсан үед ханшийн зөрүүнээс алдагдал хүлээх эрсдэлтэй байна.

Хүснэгт 33. Засгийн газрын өрийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл		2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	Зөрүү	Эзлэх хувь
А		1	2	3	4	5	6=5-4	
I. Засгийн газрын дотоод өр		1,136.6	657.3	1,035.5	234.1	1,200.4	966.3	3.6
1.1	Засгийн газрын үнэт цаас	1,136.6	657.3	1,035.5	234.1	400.5	166.4	1.2
1.2	Орон нутгийн үнэт цаас					799.9	799.9	2.4
II. Засгийн газрын гадаад өр		24,851.4	24,693.3	29,641.6	30,274.6	32,021.5	1,746.9	95.9
2.1	Засгийн газрын үнэт цаас	8,354.0	8,175.6	9,359.8	9,371.7	8,655.0	(716.7)	25.9
2.2	Орон нутгийн үнэт цаас					1,724.9	1,724.9	5.2
2.3	Зээл	16,497.4	16,517.7	20,281.8	20,902.9	21,641.6	738.7	64.8
III. Засгийн газрын өрийн баталгаа		1,060.4	876.5	812.9	29.5	178.0	148.5	0.5
IV. Концесс (“барих-шилжүүлэх”)*		850.2	673.9	463.5	230.9	-	(230.9)	-
V. Орон нутгийн зээллэг		-	17.2	12.3	4.5	-	(4.5)	-
5.1	Дотоод өр		17.2	12.3	4.5	-	(4.5)	-
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III+IV+V)		27,898.6	26,918.2	31,965.8	30,773.6	33,399.9	2,626.3	
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		23,024.3	21,837.3	27,691.6	26,582.9			
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон өрийн хязгаар**		70.0%	70.0%	70.0%	65.0%	60.0%		
		(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(ӨҮЦ)	(НҮ)		
Засгийн газрын өр / ДНБ		74.5%	61.8%	59.4%	43.7%	41.8%		
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		61.5%	50.1%	51.4%	37.7%	-		
ДНБ (оны үнээр)		37,453.3	43,555.0	53,851.0	70,442.0	79,956.3		
Ам.долларын эцсийн ханш		2,849.50	2,848.80	3,444.60	3,410.69	3,420.25		


Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.1.3 УИХ-ын 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулиар Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлдэг байсныг 2024 оноос эхлэн нэрлэсэн дүнгээр илэрхийлдэг болсон байна.

9.1.4 Засгийн газрын өрийн үлдэгдлийн 95.9 хувийг гадаад өр, 3.6 хувийг дотоод өр, 0.5 хувийг Засгийн газрын өрийн баталгаа тус тус эзэлж байна.

9.1.5 Өрийн бүтцийн 95.9 хувийг гадаад өр эзэлж байгаа нь төсвийн бодлого алдагдах, валютын ханшийн эрсдэлийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлж, гадаад хамаарал өндөр байгааг харуулж байна.

Дүрслэл 13. Тогтвортой байдлын хязгаар



9.1.6 Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр²⁴ илэрхийлсэн үлдэгдэл ДНБ-ий 41.8 хувьтай тэнцэж байгаа нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэлд²⁵ заасан Засгийн газрын өрийн нийт хэмжээнээс 14,129.5 тэрбум төгрөгөөр бага, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиас 18.2 хувиар бага байгаа нь Төсвийн

тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон төсвийн тусгай шаардлагыг²⁶ хангасан байна.

9.1.7 Тайлант хугацаанд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт 3,114.0 тэрбум төгрөг төсөвлөснөөс, гүйцэтгэлээр үндсэн төлбөрт 1,548.9 тэрбум төгрөг, хүү болон шимтгэлийн төлбөрт 1,166.0 тэрбум төгрөг, нийт 2,714.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулсан байна.

Хүснэгт 34. Засгийн газрын 2024 оны өрийн үйлчилгээний үзүүлэлт, /тэрбум төгрөг/

д/д	Засгийн газрын өрийн үйлчилгээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Зөрүү	Хувь
			Улсын төсвөөс	Өрийн зохицуулалт		
А	Б	1	2	3	4=1-2	5=2/1
1	Үндсэн төлбөр	1,940.4	1,548.9	731.4	391.5	79.8
1.1	Дотоод үнэт цаас	137.5	137.5		-	100.0
1.2	Гадаад үнэт цаас	573.0	178.5	731.4	394.5	31.2
1.3	Гадаад зээл	1,229.9	1,232.9		(3.0)	100.2
2	Хүүгийн төлбөр	1,173.6	1,166.0	-	7.6	99.4
2.1	Гадаад зээл	607.0	599.4		7.6	98.7
2.2	Гадаад үнэт цаас	559.1	559.1		-	100.0
2.3	Дотоод үнэт цаас	7.5	7.5		-	100.0
3	Нийт төлбөр	3,114.0	2,714.9	731.4	399.1	87.2

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.1.8 Өрийн зохицуулалтын хүрээнд “Номад” бондоос нийт 12.0 сая ам.доллар буюу 40.8 тэрбум төгрөг, “Сенчири-1” бондоос 86.9 сая ам.доллар буюу 296.1 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс буцаан худалдан авч 2024 оны 03 дугаар сард төлсөн, Хуралдай бондын төлбөрийн 116.9 сая ам.доллар буюу 394.5 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний төлбөрийг “Сенчири-3” бондын үлдэгдлээс төлсөн байна.

9.1.9 Засгийн газрын өрийн үндсэн төлбөрт улсын төсвөөс 1,548.9 тэрбум төгрөг төлсөн нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд²⁷ заасан хязгаарт багтаж байна.

²⁴ Монгол Улсын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “өнөөгийн үнэ цэнээр” гэснийг “нэрлэсэн дүнгээр” гэж, мөн зүйлийн 6.5 дахь хэсгийн “нэмэгдүүлэх, 6.4-т заасан хугацааг сунгахыг” гэснийг “нэмэгдүүлэхийг” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “2025” гэснийг “2024” гэж, мөн зүйлийн 19.9 дэх хэсгийн “Энэ хуулийн 6.1.2-т” гэснийг “Энэ хуульд” гэж тус тус өөрчилсүгэй”;

²⁵ Монгол Улсын хуулийн 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөр Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийн 1 дүгээр зүйлийн 8-д “Засгийн газрын өрийн нийт хэмжээ 47,529.4 тэрбум төгрөг, Дотоодын нийт бүтээгдэхүүний эзлэх хувь 60.0 хувь”;

²⁶ Монгол Улсын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулийн өөрчлөлтөөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх”;

²⁷ Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 13 дугаар зүйл “Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2024 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ 1,940,399.6 сая төгрөг байна”.

9.1.10 Засгийн газрын өрийн үлдэгдэл нэрлэсэн үнээр 33,399.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 8.5 хувь буюу 2,626.3 тэрбум төгрөгөөр өсөхөд НЗДТГ-аас 2,505.8 тэрбум төгрөгийн үнэт цаас шинээр гаргасан нь гол нөлөө үзүүлсэн байна.


Хүснэгт 35. Засгийн газрын 2024 оны өрийн үзүүлэлт, /тэрбум төгрөг/

Д/д	Засгийн газрын өрийн хэрэгсэл	Эхний үлдэгдэл	Ашиглалт болон буцаалт	Эргэн төлөлт	Шилжсэн	Ханшийн зөрүү	Хуримтлагдсан хүү	Нэрлэсэн үнээр эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
I. Засгийн газрын дотоод өр		234.1	1,098.3	137.5		-	5.5	1200.4	40.9
1.1	Үнэт цаас	234.1	1098.3	137.5		-	5.5	1200.4	40.9
II. Засгийн газрын гадаад өр		30,274.6	4,119.8	2,143.0		(581.9)	351.9	32,021.5	1,158.5
2.1	Үнэт цаас	9,371.7	1,707.5	910.0		20.1	190.5	10,379.9	559.1
2.2	Зээл	20,902.9	2,412.3	1,233.0		(602.0)	161.4	21,641.6	599.4
III	Засгийн газрын өрийн баталгаа	29.5	196.6	48.5		(1.2)	1.6	178.0	6.9
IV	Барих шилжүүлэх төрлийн концесс	230.9	-	-	230.9	-	-	-	-
V	Орон нутгийн зээллэг	4.5	-	4.5		-	-	-	-
Нийт		30,773.6	5,414.7	2,333.5	230.9	(583.1)	359.0	33,399.9	1,206.3

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.1.11 Тайлант онд төгрөгийн евротой /EUR/ харьцах ханш 224.7 төгрөг, зээлжих тусгай эрхтэй /SDR/ харьцах ханш 115.6 төгрөгөөр тус тус чангарсан, экспортын орлого өмнөх оноос 3.9 хувиар өсөж, төсвийн орлого нэмэгдсэний үр дүнд 583.1 тэрбум төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний ашигтай гарчээ.

Дүрслэл 14. Ханшийн алдагдлын статистик, /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.2 Өрийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд зөвхөн эдийн засгийн өсөлтөд найдах бус, гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжих төсөл арга хэмжээний мөнгөн урсгалыг бодитой төлөвлөж, үр өгөөжийг сайжруулах, хүүгийн дарамтыг бууруулах зорилгоор дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлого шаардлагатай байна

Засгийн газрын дотоод үнэт цаас

9.2.1 Засгийн газрын нийт өрийн дүнд дотоод үнэт цаасны үлдэгдлийн эзлэх хувь 2020-2023 он хүртэл тогтмол буурсан боловч 2024 онд өмнөх оноос 166.4 тэрбум төгрөгөөр өсөж, 400.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн багцын 1.2 хувийг эзэлж байна.

Дүрслэл 15. Засгийн газрын дотоод үнэт цаасны статистик, /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.2.2 Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, хөрөнгийн зах зээл дэх жишиг хүүгийн түвшнийг тогтоох зорилгоор жил бүр шинээр гаргах Засгийн газрын дотоод үнэт цаасны 10.0-20.0 хүртэлх хувийг урьдчилан зарласан хугацаа, нөхцөл бүхий хуваарийн дагуу арилжаа зохион байгуулахаас 3 сарын өмнө олон нийтэд нээлттэй зарлаж, үнэт цаасны арилжааг зохион байгуулах замаар тогтмолжуулахаар заасан ч Засгийн газраас дотоод үнэт цаас гаргах нөхцөл үүсээгүй шалтгаанаар 2024 онд дотоод үнэт цаас гаргаагүй байна.

9.2.3 Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 75.8 хувь буюу 303.4 тэрбум төгрөгийг Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор Нийгмийн даатгалын санд арилжаалсан үнэт цаас, 24.2 хувь буюу 97.1 тэрбум төгрөгийг Монгол Улсын Хөгжлийн банкны эзэмшиж байгаа Сайн хувьцаа хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор арилжаалсан үнэт цаас эзэлж байна.

Хүснэгт 36. Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/

Д/д	Үнэт цаасны зориулалт	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Шинээр гарсан	Эргэн төлөлт	Хуримтлагдсан хүү	Нэрлэсэн үнээр эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
1	Сайн хувьцаа хөтөлбөр	96.6				0.5	97.1	1.0
2	Төсвийн алдагдал санхүүжүүлэх үнэт цаас	137.5			137.5		-	6.5
3	Нийгмийн даатгалын сан	-		300.0	-	3.4	303.4	-
	Нийт	234.1	-	300.0	137.5	3.9	400.5	7.5

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.2.4 Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Сангийн сайдын 2024 оны “Засгийн газрын үнэт цаас хаалттай гаргах тухай” 202 дугаар тушаалаар Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор НДЕГ-т 300.0 тэрбум төгрөгийн 1-3 жилийн хугацаатай, 8.5-9.5 хувийн хүүтэй дотоод үнэт цаасыг хаалттай арилжаалсан байна.

9.2.5 Хадгаламжийн даатгалын корпорац ХХК-ийн эзэмшиж байгаа 130.5 тэрбум төгрөг, Хаан банкны эзэмшиж байгаа 6.0 тэрбум төгрөг, Капитрон банкны эзэмшиж байгаа 1.0 тэрбум төгрөг, нийт 137.5 тэрбум төгрөгийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны үлдэгдлийг хуваарийн дагуу 2024 онд төлж дуусгасан байна.

9.2.6 Монголын хөрөнгийн бирж ХК-аар 2024 онд компанийн хувьцаа болон бондын арилжаа өмнөх оноос 592.1 тэрбум төгрөгөөр, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас 83.1 тэрбум

төгрөгөөр, арилжааны банканд байрших иргэд, аж ахуй нэгжийн хадгаламжийн үзүүлэлт 21.7 хувь буюу 4,792.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

9.2.7 Монголын хөрөнгийн бирж ХК-ийн үнэт цаасны арилжаа болон арилжааны банканд байрших иргэд, аж ахуй нэгжийн хадгаламж жил бүр өсөж байгаа нь дотоод санхүүжилтийн эх үүсвэрийг ашиглах, гадаад өрийн дарамтыг багасгах боломжийг бүрдүүлнэ. Гэхдээ хадгаламжийн хүү өндөр байгаа нь дотоод үнэт цаасны өгөөжийг бууруулах тул боломжит эрсдэлийн түвшинд дотоод үнэт цаас гаргалтыг тогтмолжуулах, дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх бодлогын арга хэмжээ авах шаардлагатай байна.

Орон нутгийн дотоод үнэт цаас

9.2.8 Тайлант онд 798.3 тэрбум төгрөгийн орон нутгийн дотоод үнэт цаас шинээр гаргаж, 33.4 тэрбум төгрөгийн хүү төлж, хуримтлагдсан хүү 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 799.9 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын өрийн багцын 2.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 37. Орон нутгийн дотоод үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/

Үнэт цаасны төрөл	Зориулалт	Гаргасан огноо	Хүү	Эргэн төлөх огноо	Шинээр гарсан	Хуримтлагдсан хүү	Нэрлэсэн үнээр эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
Засгийн газрын 2024 оны 201 дүгээр тогтоол /нээлттэй арилжаалсан/								
Транч 1	Бөөрөлжүүт цахилгаан станц	2024.06.25	14.0%	2027.06.25	300.0	0.8	300.8	20.9
Транч 2	Зам засвар арчилгаа	2024.06.25	13.0%	2026.06.25	100.0	0.3	100.3	6.5
Транч 3	Зам засвар арчилгаа	2024.06.25	12.0%	2025.06.25	100.0	0.2	100.2	6.0
Засгийн газрын 2024 оны 264 дүгээр тогтоол /хаалттай арилжаалсан/								
Транч 1	Батарей хуримтлуурын төсөл	2024.12.26	7.404%	2029.12.26	212.8	0.2	213.0	
Транч 2	Батарей хуримтлуурын төсөл	2024.12.26	5.674%	2029.12.26	85.5	0.1	85.6	
Нийт дүн					798.3	1.6	799.9	33.4

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.2.9 НЗДТГ нь дотоод үнэт цаас гаргаж 798.3 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээс 56.8 хувь буюу 453.6 тэрбум төгрөгийг 65 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд ашигласан, 43.2 хувь буюу 344.7 тэрбум төгрөг ашиглалтгүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

9.2.10 Дотоодын зах зээлээс 1-5 жилийн богино хугацааны арилжааны нөхцөлтэй, 5.7-13.0 хувийн хүүтэй үнэт цаас гаргаж зам засвар, арчилгаа, батарей хуримтлуурын станц барих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3²⁸, 6.4.4²⁹ дэх заалтуудтай нийцээгүй, өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зарчмыг алдагдуулсан байна.

Засгийн газрын гадаад үнэт цаас

9.2.11 Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл 8,655.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 716.7 тэрбум төгрөгөөр буурч, нэрлэсэн үнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн багцын 25.9 хувийг эзэлж байна.

²⁸ 6.4.3-д "тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа нь түүнийг санхүүжүүлэх зээллэгийн эргэн төлөх хугацаанаас илүүгүй байх чиглэл баримтлах"

²⁹ 6.4.4 -д "гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэл баримтлах"

Хүснэгт 38. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/

Гадаад үнэт цаас	Гаргасан огноо	Хүүгийн хувь	Эргэн төлөх огноо	Эхний үлдэгдэл		Шинэ эргэрсэн	Ханшийн өөрчлөлт	Эргэн төлөлт /Тэрбум төгрөг/	Нэрлэсэн үнээр Эцсийн үлдэгдэл		Хүүгийн төлбөр	
				Сая ам.доллар	Тэрбум төгрөг				Сая ам.доллар	Тэрбум төгрөг	Сая ам.доллар	Тэрбум төгрөг
Сенчир и-2	2023.01.19	8.65	2028	650.0	2,216.9		6.2	-	675.1	2,309.2	56.2	190.9
Сенчир и-2027	2021.07.07	3.5	2027	500.0	1,705.4		3.8	296.1	420.1	1,436.8	18.6	63.1
Сенчир и-2031	2021.07.07	4.45	2031	500.0	1,705.4		4.8	-	510.7	1,746.7	22.2	75.6
Сенчир и-3	2023.12.05	7.875	2029	350.0	1,193.7		3.3	-	351.9	1,203.6	30.7	104.2
Хуралдай	2017.03.09	8.75	2031	169.8	578.9		(5.9)	573.0	-	-	7.4	25.1
Номад	2020.10.07	5.125	2026	578.0	1,971.4		5.3	40.9	572.7	1,958.7	29.7	100.2
Дүн				2,747.8	9,371.7	-	17.5	910.0	2,530.5	8,655.0	164.8	559.1

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.2.12 Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл үндсэн төлбөрийн 910.0 тэрбум төгрөгөөр хасагдаж, ханшийн тэгшитгэлийн зөрүү 17.5 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүү 175.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 8,655.0 тэрбум төгрөг байна.

9.2.13 Номад бондын 2024 онд эргэн төлөх 12.0 сая ам.доллар буюу 40.8 тэрбум төгрөгийн үнэт цаас, “Сенчири-2027” бондын 86.8 сая ам.доллар буюу 296.1 тэрбум төгрөгийн үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаг үеийг ашиглан эргэн төлөх үнээс хямд өртгөөр нээлттэй зах зээлээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авсны үр дүнд, Номад бондоос 0.3 тэрбум төгрөг, Сенчири-27 бондоос 10.8 тэрбум төгрөг, нийт 11.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөрийг хэмнэжээ.

Орон нутгийн гадаад үнэт цаас

9.2.14 Тайлант онд 1,707.5 тэрбум төгрөгийн орон нутгийн гадаад үнэт цаас шинээр гаргаж, ханшийн тэгшитгэлийн зөрүүгээр 2.6 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүү 14.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 1,724.9 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын өрийн багцын 5.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 39. Орон нутгийн гадаад үнэт цаасны үлдэгдэл, /тэрбум төгрөг/

Үнэт цаасны төрөл	Зориулалт	Гаргасан огноо	Хүүгийн хувь	Эргэн төлөх огноо	Шинээр гарсан	Ханшийн өөрчлөлт	Хуримтлагдсан хүү	Нэрлэсэн үнээр эцсийн үлдэгдэл
Транч 1	Сэлбэ дэд төв төсөл	2024.11.21	7.75%	2027.08.21	1,707.5	2.6	14.7	1,724.9
Нийт дүн					1,707.5	2.6	14.7	1,724.9

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.2.15 Засгийн газрын 2024 оны “Нийслэлийн гадаад үнэт цаас гаргах, Засгийн газрын өрийн баталгаа гаргах” тухай 265 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих “Сэлбэ дэд төв”-д түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар жилийн 7.75 хувийн хүүтэй 33 сарын хугацаатай 500.0 сая ам.долларыг олон улсын зах зээлд арилжаалж, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Монголбанканд төвлөрүүлсэн байна.

9.2.16 Сэлбэ дэд төвийн төслийн ажил эхлээгүй шалтгаанаар тус үнэт цаасны 500.0 сая ам.доллараас 400.0 сая ам.долларыг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн /1 ам.долларын ханш 3,416.71 төгрөг/ ханшаар хөрвүүлж 1,329.1 тэрбум төгрөгийг арилжааны 7 банканд 6-24 сарын хугацаатай жилийн 12.5-16.1 хувийн хүүтэй төгрөгийн, үлдэгдэл 100.0 сая

ам.долларыг Худалдаа хөгжлийн банканд 24 сарын хугацаатай, жилийн 8.05 хувийн хүүтэй валютын хадгаламжид тус тус байршуулсан байна.

9.2.17 Жилийн эцэст арилжааны банкнуудад байршуулсан хадгаламжийн хүүгээс 11.6 тэрбум төгрөгийн хүүгийн авлага бүртгэсэн боловч тус үнэт цаасны хуримтлагдсан хүү 14.7 тэрбум төгрөг, ханшийн зөрүүгээр 2.6 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж, тус бондын эх үүсвэрийг ашиглаагүй, нийт 5.7 тэрбум төгрөгийн алдагдалд орсон байна.

9.2.18 УАГ-аас 2024 онд хийсэн Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах төслийн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтэд уг төлөвлөгөө нь санхүүжилтийн тогтвортой байдалд эрсдэл учруулж болзошгүйг онцолсон байхад 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаас гаргаж, арилжааны банканд байршуулсан нь Монгол Улсын гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлсэн боловч өрийн дарамтыг үүсгэсэн байна.

9.2.19 Орон нутгаас гаргасан гадаад үнэт цаас нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зээллэгийн төлөвлөгөөнд тусгаагүй, Стратегийн баримт бичигт дахин санхүүжилтээс бусад зориулалтаар Засгийн газрын гадаад үнэт цаасыг арилжаалахгүй байх Өрийн удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2³⁰ дахь заалттай нийцэхгүй байна.

9.2.20 Иймд төсвийн сахилга батыг хангахын тулд өрийн хэрэглээг хатуу хяналттай байлгаж, алдагдалтай төсвийн бүтэцтэй зэрэгцэн өр нэмэх явдлыг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Засгийн газрын гадаад зээл

9.2.21 Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл ашиглалтын 2,412.3 тэрбум төгрөгөөр, хуримтлагдсан хүүгийн 161.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, үндсэн төлбөр 1,233.0 тэрбум төгрөг, ханшийн тэгшитгэлийн зөрүү 602.0 тэрбум төгрөгөөр хасагдаж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн үлдэгдэл 21,641.6 тэрбум төгрөгт хүрч, Засгийн газрын өрийн багцын 64.8 хувийг эзэлж байна.

Хүснэгт 40. Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл, /тэрбум төгрөг/

Зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт болон буцаалт	Үндсэн төлбөр	Ханшийн зөрүү	Хуримтлагдсан хүү	Нэрлэсэн үнээр эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
Төслийн зээл	14,690.5	2,070.5	717.8	(435.5)	103.7	15,711.4	369.8
Хөтөлбөрийн зээл	6,212.4	341.8	515.2	(166.5)	57.7	5,930.2	229.6
Дүн	20,902.9	2,412.3	1,233.0	(602.0)	161.4	21,641.6	599.4

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

9.2.22 Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтын 239.4 тэрбум төгрөг буюу 9.9 хувийг эдийн засагт үр өгөөж багатай салбарт ашигласан байна. Үүнд 2.3 нэгж хувийг нийгмийн халамж, 3.4 нэгж хувийг онцгой байдлын салбарт, 3.5 нэгж хувийг засаглалын салбарт, 0.8 нэгж хувийг байгаль орчин аялал жуулчлалын салбарт ашигласан байна. Иймд өрийн менежментийн үр ашгийг сайжруулахын тулд өрийг дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд, ХАА зэрэг ирээдүйд татварын орлого болон өсөлтийн суурь болох нийгмийн болон эдийн засгийн үр өгөөж ихтэй салбарууд дахь бүтээмж нэмэгдүүлэх төслүүдэд чиглүүлэх хэрэгтэй байна.

9.2.23 Тайлант онд ашиглалт гараагүй 2014-2023 онуудад гэрээ байгуулсан 2024-2028 онуудад үндсэн төлбөрөө төлж эхлэх 184.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй 6 гадаад зээлийн төслийн үлдэгдэлд 10.2 тэрбум төгрөгийн хүүгийн зардал төлсөн байна.

Гадаад төслийн зээлийн ашиглалтыг сайжруулахгүй бол цаашид эдийн засагт хүүгийн дарамт учрах эрсдэлтэй байна. Тухайлбал:

- АХБ-ны санхүүжилтээр 2014 оноос хэрэгжиж эхэлсэн Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих 27.5 сая ам.долларын хөтөлбөр 64.9 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 4.0 тэрбум төгрөг;

³⁰ 6.4.2-д "энэ хуульд өөрөөр заагаагүй бол арилжааны нөхцөлтэй гадаад зээллэгийн эх үүсвэрээр эргэн төлөгдөх чадвартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх"

- АХБ-ны санхүүжилтээр 2014 оноос хэрэгжиж эхэлсэн Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих /тусгай үйл ажиллагаа/ 14.5 сая зээлжих тусгай эрхтэй /SDR/ хөтөлбөр 68.6 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 0.9 тэрбум төгрөг;
- АХБ-ны санхүүжилтээр 2019 оноос хэрэгжиж эхэлсэн “Эрүүл мэндийн IV нэмэлт” 16.0 сая ам.долларын төсөл 87.0 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 3.1 тэрбум төгрөг;
- Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр 2023 оноос хэрэгжиж эхэлсэн “Ногоон - Улаанбаатар орон сууц”-ны 20.0 сая ам.долларын төсөл гүйцэтгэл гараагүй, хүүгийн зардалд 1.1 тэрбум төгрөг;
- Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр 2022 оноос хэрэгжиж эхэлсэн Чойр - Сайншандын 220 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих 62.8 сая ам.долларын төсөл 0.9 хувийн гүйцэтгэлтэй, хүүгийн зардалд 1.1 тэрбум төгрөг;
- Польш Улсын Засгийн газрын санхүүжилтээр 2019 оноос хойш хэрэгжиж эхэлсэн Эрдэнэт хотын хатуу хог боловсруулах үйлдвэр байгуулах, хог хаягдлыг татан зайлуулах менежментийг сайжруулах 9.0 сая еврогийн төсөл 90.0 хувийн гүйцэтгэлтэй, тайлант онд хүүгийн зардалд 0.05 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Засгийн газрын өрийн баталгаа

9.2.24 Засгийн газрын өрийн баталгаа 196.6 тэрбум төгрөг, хуримтлагдсан хүү 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, эргэн төлөлтийн 48.5 тэрбум төгрөг, ханшийн тэгшитгэлийн зөрүүгээр 1.2 тэрбум төгрөгөөр хасагдаж, нэрлэсэн үнээр илэрхийлсэн эцсийн үлдэгдэл 178.0 тэрбум төгрөг болж, нийт гадаад өрийн 0.5 хувийг эзэлж байна.

9.2.25 Эрдэнэс монгол ХХК-ийн үндсэн төлбөрт 27.9 тэрбум төгрөг, ханшийн зөрүү 1.6 тэрбум төгрөг, нийт 29.5 тэрбум төгрөгийг бүрэн төлж барагдуулсан байна.

9.2.26 Тайлант онд дараах өрийн баталгааг гаргасан байна. Үүнд:

- Монгол Улсын Их хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолоор олгосон зөвшөөрлийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 133 дугаар тогтоолоор БНХАУ-ын хөгжлийн банкны 420.0 сая юанийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Чойбалсан ДЦС-ыг 50 мвт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд 12 жилийн хугацаатай жилийн 5.1 хувийн хүүтэй 196.6 тэрбум төгрөгийн өр;
- УИХ-ын 2024 оны 17 дугаар тогтоолоор олгосон зөвшөөрлийн дагуу Засгийн газрын 2024 оны 265 дугаар тогтоолоор “Сэлбэ дэд төвийг орон сууцжуулах төсөл”-ийг санхүүжүүлэх зорилгоор жилийн 7.75 хувийн хүүтэй 33 сарын хугацаатай 500.0 сая ам.долларын гадаад үнэт цаас.

Орон нутгийн зээллэг

9.2.27 Орон нутгийн зээллэгийн үлдэгдэлд бүртгэлтэй Зорчигч тээвэр ОНӨААТҮГ, Цахилгаан автобусаар парк шинэчлэлийн Монгол Улсын Хөгжлийн банкттай 2020 онд байгуулсан жилийн 11.8 хувийн хүүтэй 3 жил 8 сарын хугацаатай 21.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэл 4.5 тэрбум төгрөгийг бүрэн төлж барагдуулсан байна.

БҮЛЭГ 10. ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН ЦАХИМ ХУУДСЫГ БУСАД САНХҮҮГИЙН СИСТЕМД ХОЛБОЖ ХӨГЖҮҮЛСЭН БОЛОВЧ ХЭРЭГЛЭГЧ, ИРГЭН ОЛОН НИЙТЭД ЭНГИЙН ОЙЛГОМЖТОЙ, ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР БУС, МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ БАЙДАЛ ХАНГАЛТГҮЙ НЬ ХУУЛИЙН ЗОРИЛТ, ҮР ДҮНГ БУУРУУЛЖ БАЙНА

10.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон Шилэн дансны тухай хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагын төрөл, нэршлийн хувьд уялдуулах шаардлагатай байна

9.1.1 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны нээлттэй өгөгдлийн санд бүртгэлтэй 6403 байгууллагыг Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.6-д заасан нэр төрлөөр ангилах боломжгүй байна.

Хүснэгт 41. Шилэн дансны тухай хуульд заасан байгууллагын төрөл

№	Шилэн дансны тухай хуульд заасан байгууллагын төрөл
1	3.1.1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд
2	3.1.2. Төрийн өмчит үйлдвэрийн газар
3	3.1.3. Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани
4	3.1.4. Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж байгууллага
5	3.1.5. Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч
6	3.1.6. Төрийн санхүүжилт авч байгаа нам, эвсэл

Хүснэгт 42. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь байгууллагын төрөл

№	Шилэн дансны нэгдсэн цахим хуудас дахь байгууллагын төрөл	Тоо
1	Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэн	809
2	Бусад улсын бүртгэлд бүртгэлгүй мэдээлэл оруулах нэгж /Төрийн сан дээр данстай/	6
3	Засгийн газрын тусгай сан	174
4	Олон улсын санхүүжилттэй төсөл хөтөлбөр	71
5	Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	370
6	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компани	278
7	Төсвийн байгууллага	4,695
	Бүгд	6,403

9.1.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны байгууллагын төрөл, хуулийн үйлчлэлд хамаарах төрөлтэй нэр томъёоны хувьд зөрүүтэй байгаа нь төрийн өмчийн оролцоотой компаниуд санхүүгийн мэдээллээ ялгаатай байдлаар олон нийтэд хүргэх эрсдэл үүсэж байна.


9.1.3 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3³¹-д заасан хяналтын багц дахь 17 байгууллагын шилэн дансны хөтлөлтөд хийсэн тулгалтаар журамд заасны дагуу мэдээлсэн 7 төрлийн 1,186 мэдээлэл, журамд тусгагдаагүй мэдээлсэн 4 төрлийн 224 мэдээлэл нийт 17 байгууллагын 1,410 мэдээлэл байна.

9.1.4 Хяналтын багц дахь 12 байгууллага нь цэсгүй тул мэдээлээгүй, 5 байгууллага нь 11 мэдээллийг мэдээлж байгаа нь мэдээллийн ялгамжтай байдал үүсэж байна. /Хавсралт 4/

9.1.5 Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-аар хяналтын багцын байгууллагын мэдээлэх мэдээллийн төрлийг тодорхой заасан боловч эдгээр байгууллагууд харилцан адилгүй, мэдээлсэн төлөвтэй боловч “оруулах мэдээлэл байхгүй” гэсэн тайлбартай мэдээлсэн нь 66.0 хувийг эзэлж байна.

³¹ “хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани”

Дүрслэл 16. Хяналтын багц дахь 17 байгууллага 2024 онд мэдээлсэн мэдээллийн тоо



9.1.6 Журмын дагуу тухай бүр оруулахаар зохицуулсан зарим мэдээллийг үйл ажиллагааны онцлогтоо тохируулж, мэдээлэл оруулах давтамжийг нарийвчлан журмаар зохицуулах шаардлагатай байна. Тухайлбал тухайн онд концессын мэдээлэл /тухай бүр/ байхгүй бол мэдээлэл оруулахгүйгээр мэдээлсэн төлөвтэй байхаар бус энэ талаар мэдээлэхгүй байх зохицуулалтыг хийх нь зүйтэй байна.

9.1.7 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон хууль, журмын нэр томъёоны зөрүүтэй байдлыг арилгаж, төрийн өмчийн оролцоотой компаниуд санхүүгийн мэдээллээ ялгаатай байдлаар мэдээлэх асуудлыг хууль тогтоомж, системтэйгээ уялдуулж, мэдээллийг үнэн зөв байхад анхаарах, журмыг шинэчилж боловсронгуй болгох шаардлагатай байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны системд хөгжүүлэлт хийсэн боловч хэрэглэгч, иргэдэд энгийн ойлгомжтой, хэрэглэхэд хялбар бус, мэдээллийн үнэн зөв байдал хангалтгүй байгаа нь хуулийн зорилт, үр дүнг бууруулж байна

9.1.8 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг төсөв санхүүгийн 7 цахим систем /Засгийн газрын санхүү, удирдлагын мэдээллийн, И-Хуулга, Орон нутгийн хөгжлийн сангийн, Төсвийн хөрөнгө оруулалтын, Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн, Төрийн худалдан авах ажиллагааны, Татварын удирдлагын нэгдсэн/-ийн мэдээллийн сантай шууд холбож мэдээлэл солилцох боломжтойгоор шинэчилж, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

9.1.9 Шилэн дансны системийн шинэчилсэн хувилбарт хэрэглэгчдэд ямар нэгэн бүртгэл, баримт бичиг шаардахгүйгээр чөлөөтэй ашиглах боломжтой нээлттэй лицензтэй цахим өгөгдлийг нэвтрүүлсэн боловч төсөв, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад, Сангийн яамны мэдээлэл, статистик тайлан цэсийн зарим мэдээлэлд нэвтрэхэд өгөгдөл байхгүй, ТЕЗ болон түүний харьяа байгууллагуудын мэдээллийг нэгтгэх, харьцуулах, дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлээгүй нь систем хэрэглэгчдийн зорилгыг хангаж чадахгүй байна.

9.1.10 Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийн зөрчил, дутагдал болон албан шаардлагын талаар 49 байгууллагаас ирүүлсэн 72 санал гомдлоос Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 22 байгууллагын 33 санал гомдол байна.

9.1.11 Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2.13³², 7.5.1³³ дэх заалтын дагуу санал, гомдлыг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, арга хэмжээний биелэлтийг хянасан эсэх нь тодорхойгүй байна.

9.1.12 “Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны шилэн данс хөтлөлтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан”-д 62 ТЕЗ болон түүний харьяа 6,424 байгууллагын шилэн дансны хөтлөлт дунджаар 95.7 хувьтай, Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн иргэн, хувийн сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгж, нөхөрлөл, хоршоо, төрийн бус байгууллагуудын шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийн хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэсэн байна.


9.1.13 Тайланд тусгасан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээлэлтэй тулгахад ТЕЗ болон түүний харьяа байгууллагын тоо 21, нийт мэдээлэх мэдээлэл 11,

³² 7.2.13 “Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны талаар бусад хэрэглэгчдээс ирүүлсэн санал, хүсэлтийг хянан шийдвэрлэх”

³³ 7.5.1 “Ирсэн захиаг тухай бүр шалган шийдвэрлэх”

мэдээлсэн 3,171, хугацаандаа мэдээлсэн 2,498, хугацаа хоцорсон мэдээлэл 673 тоон үзүүлэлтээр зөрүүтэй, мэдээлсэн мэдээллийг нийт мэдээлэх мэдээлэлтэй харьцуулан хөтлөлийн үнэлгээ, хуулийн хэрэгжилтийг дүгнэж байгаа нь үнэлэх аргачлал зохисгүй, мэдээллийн үнэн зөв байдал бүрэн хангагдаагүй байна.

Дүрслэл 17. Шилэн дансны нэгдсэн цахим систем болон Үнэлгээний тайлангийн харьцуулалт



10.2 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийн 97.1 хувийг бүрэн байршуулж, 2.9 хувийг байршуулаагүй, нийт мэдээллийн 89.5 хувийг хуулийн хугацаанд, 10.5 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн байна

10.2.1 Аудитад 61 төсвийн ерөнхийлөн захирагч, 369 төвлөрүүлэн захирагч, 4731 шууд захирагч, 178 төрийн өмчит үйлдвэрийн газар, 410 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 76 Засгийн газрын тусгай сан, 636 орон нутгийн тусгай сан, 126 төсөл хөтөлбөрийн нэгж, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа 12 компани, нийт 6599 байгууллагыг хамрууллаа.

10.2.2 Аудитад хамруулсан байгууллагууд мэдээлбэл зохих мэдээллийн 97.1 хувийг бүрэн мэдээлж, өмнөх оноос 2.4 хувиар өссөн бол хугацаандаа оруулсан мэдээлэл 2.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй байна

10.2.3 Тайлант онд шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг олон нийтэд мэдээлэх үүргийг 2860 байгууллага зөрчсөн байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газруудад хамаарах 86 байгууллага нийт 131.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 490 удаагийн тендер шалгаруулалт, худалдан авалт зохион байгуулсан мэдээллийг ил тод мэдээлээгүй, 106 байгууллага 4,777.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 514 удаагийн худалдан авалтын үйл ажиллагааны мэдээллийг хугацаа хоцроосон;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,262.4 тэрбум төгрөгийн 7938 зарлагын мөнгөн гүйлгээг 397 байгууллага мэдээлээгүй, 1,407.1 тэрбум төгрөгийн 8230 зарлагын мөнгөн гүйлгээг 561 байгууллага хугацаа хоцроосон;
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,845.1 тэрбум төгрөгийн 7009 орлогын мөнгөн гүйлгээг 376 байгууллага мэдээлээгүй, 2,147.9 тэрбум төгрөгийн 6666 орлогын мөнгөн гүйлгээг 562 байгууллага хугацаа хоцроосон;
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 87.6 тэрбум төгрөгийн 3785 шийдвэрийг 290 байгууллага мэдээлээгүй, 111.8 тэрбум төгрөгийн 5987 шийдвэрийг 482 байгууллага хугацаа хоцроож мэдээлсэн.

10.2.4 Давхардсан тоогоор шилэн дансны цахим хуудсанд 1149 байгууллага 19222 мэдээллийг мэдээлээгүй, 1711 байгууллага 21397 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчлийг таслан зогсоох, мэдээллийг үнэн зөв, бодитой, иж бүрэн байршуулах 2,676.1 тэрбум төгрөгийн албан шаардлага, 383.9 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар 882.7 тэрбум төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниуд хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.

10.2.5 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т хамаарах хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа 17 компаниас 12 компанид төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит хийж 2.6 тэрбум төгрөгийн зөрчил илэрч, зөрчил арилгах 2 албан шаардлага өгсөн байна.

БҮЛЭГ 11. ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ 54.3 ХУВЬТАЙ БАЙНА

10.1.1 Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 5, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад 3, Сангийн сайдад 11, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад 1, бусад Төсвийн ерөнхийлөн захирагчд нарт 1, нийт 24 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

10.1.2 Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг Сангийн сайдын 2025 оны 01/2408, Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-ын 2025 оны 01/142, Боловсролын яамны ТНБД-ын 2024 оны 2/2319, ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2024 оны 01/3257 дугаар албан бичгээр тус бүр УАГ-т ирүүлсэн байна.

10.1.3 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудаас 76.3 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасныг, аудитаар хянахад 54.3 хувийн хэрэгжилттэй байна.


10.1.4 Монгол улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 14 зөвлөмж 71.6 хувийн хэрэгжилттэй, Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Дүрслэл 18. Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн тоо, хувиар




10.1.5 Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар өгсөн 10 зөвлөмж 30.0 хувийн хэрэгжилттэй байна.

Дүрслэл 19. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудитаар өгсөн зөвлөмжийн тоо, хувиар



10.1.6 Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн 1, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд ЭЗХС-д өгсөн 2, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад өгсөн 2, Боловсролын сайдад өгсөн 1, Бусад Төсвийн ерөнхийлөн захирагчдад өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.



ХАВСРАЛТ ТАЙЛАН 1: “УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН

**ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭХ, НЭН ТЭРГҮҮНИЙ
ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛАН ЭРЭМБЭЛЖ ТӨЛӨВЛӨХ ТОГТОЛЦООГ
ОРХИГДУУЛСАН НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛСӨН
БАЙНА**

АГУУЛГА

ХАВСРАЛТ ТАЙЛАН 1: “УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН.....	74
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	77
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	79
БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨЛТ ХИЙГДЭХГҮЙ БАЙГААГААС БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨХ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БЭЛТГЭЛ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА	80
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 74.4 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна	80
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний цар хүрээ, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна	82
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТЭЗҮ, тоног төхөөрөмж, их засварын ажлыг эрэмбэлэх, сонгох шалгуур тодорхойгүй байна	83
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан барилга байгууламжийн 52.8 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна	86
Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлээгүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй тоног төхөөрөмжийг бэлтгэхээр төлөвлөсөн байна	88
БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА	91
Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталж байгаа нь худалдан авах ажиллагаа удаашрах, хугацаандаа хэрэгжихгүй байхад нөлөөлж байна	91
Тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний үнэ, өртгийн урьдчилсан судалгаа хийх, техникийн тодорхойлолтод зайлшгүй тусгах шалгуур, шаардлага тодорхойгүй байна	93
Худалдан авах ажиллагаанд гаргасан гомдлын 80.0 хувь үндэслэлтэй байхад захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрт тавих хяналт, хариуцлага сул байна	94
БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН 37.3 ХУВИЙГ ЗАРЦУУЛААГҮЙ, 2024 ОНД ДУУСГАХААР ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ 31.0 ХУВЬ НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.....	97
Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилд төлөвлөсөн санхүүжилт 63.7 хувийн гүйцэтгэлтэй байна	97
Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгох зөрчил давтагдсаар байна	99
Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 1664 төсөл, арга хэмжээнээс 31.0 хувь нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна	101
Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан байна	104
Хэрэгцээ шаардлагыг харгалзахгүйгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлснээс хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн зарим тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна	106

Товчилсон үгийн тайлбар

1	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
2	УИХ	Улсын Их Хурал
3	ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
4	ЗГХЭГД	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
5	ҮАГ	Үндэсний аудитын газар
6	ШС	Шадар сайд
7	ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
8	СаС	Сангийн сайд
9	БОУАӨС	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд
10	БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
11	ХББОСС	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд
12	БС	Боловсролын сайд
13	ЗТС	Зам, тээврийн сайд
14	ЦХИХХ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд
15	ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
16	ГБХНХС	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
17	ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
18	ГХЯ	Гадаад харилцааны яам
19	ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
20	ЭМС	Эрүүл мэндийн сайд
21	ЭМЯ	Эрүүл мэндийн яам
22	ЭХС	Эрчим хүчний сайд
23	ЭХЯ	Эрчим хүчний яам
24	ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
25	БСҮХД	Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга
26	ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
27	ШТА	Шууд тайлагнах аудит
28	НА	Нийцлийн аудит
29	ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
30	ХБТХ	Хот байгуулалтын тухай хууль
31	ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
32	БХТ	Барилгын хөгжлийн төв
33	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
34	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
35	ХАА	Худалдан авах ажиллагаа
36	ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
37	ААН	Аж ахуйн нэгж
38	ТАХ	Төсөл, арга хэмжээ
39	ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд үндэслэн Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго, зорилт

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагч нар, тэдгээрийн харьяа байгууллагууд болон Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төв, Зам, тээврийн хөгжлийн төв зэрэг холбогдох бусад байгууллагыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй

Аудитад АДБОУС 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн хянах зэрэг судалгааны арга зүйг ашигласан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Эрчим хүчний тухай хууль,
- Авто замын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,

- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр,
- Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”,
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2023 оны А/261 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”,
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”,
- Барилга байгууламжийн үнэ бүрдэл, төсөв зохиох норм, дүрэм, стандарт,
- Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудитад учирсан хүндрэл, бэрхшээл

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн бодит байдалд аудит хийхэд хүний нөөц хүрэлцэхгүйн улмаас эрсдэлд суурилан түүвэрлэн хянав.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд 27 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад тухайн оноос эхлэн хэрэгжих 712, өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 607, нийт 11,579.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1319 төсөл, арга хэмжээг 3,828.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ.

Хүснэгт 1. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, /тэрбум төгрөг/


Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга, байгууламж	464	5,113.4	1,489.1	556	5,031.4	1,407.5	1020	10,144.8	2,896.6
Их засвар	21	50.7	46.0	27	94.5	35.9	48	145.2	81.9
Тоног төхөөрөмж	213	486.9	456.2	22	483.5	77.0	235	970.5	533.1
ТЭЗҮ	14	318.5	316.6	2	0.7	0.4	16	319.2	317.0
Нийт	712	5,969.5	2,307.9	607	5,610.1	1,520.7	1319	11,579.7	3,828.6

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 1319 төсөл, арга хэмжээнээс 56.1 хувь буюу 740 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар, 43.9 хувь буюу 579 төсөл, арга хэмжээг дараагийн онуудад үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 2020-2022 онд 1,330.9-1,418.9 тэрбум төгрөг төлөвлөж байсан бол 2023 онд өмнөх оноос 92.7 хувиар өсөж 2,686.0 тэрбум, 2024 онд 42.5 хувиар өсөж 3,828.6 тэрбум төгрөгт хүрчээ.

Дүрслэл 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг /2020-2024 он/



БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНХҮҮЖИЛТИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГААГААС БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТЭЙ УЯЛДУУЛАХ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БЭЛТГЭЛ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖИХГҮЙ БАЙНА

1.1. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар ТЕЗ нараас санал болгосон 1794 төсөл, арга хэмжээнээс 1049 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусган Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж, төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад УИХ-аас 17 төсөл, арга хэмжээг хасаж, 267 төсөл, арга хэмжээг нэмж тусгаснаар 1299 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр анх баталжээ.

1.2. Төсвийн жилийн дундуур буюу 2024 оны 8 дугаар сард төсөвт тодотгол хийх үед хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 9 төсөл, арга хэмжээг нэмж тусгахаар Засгийн газраас өргөн мэдүүлж, УИХ-ын хэлэлцүүлгийн явцад 2 төсөл, арга хэмжээг хасаж, 22 төсөл, арга хэмжээг нэмж баталснаар нийтдээ улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1319 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.3. Төлөвлөсөн 1319 төсөл, арга хэмжээний 54.0 хувь буюу 712 төсөл, арга хэмжээ нь 2024 оноос эхлэн шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээ байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 74.4 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна

1.4. УИХ-ын 2023 оны 39 дүгээр тогтоолоор “Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-г баталж 205 арга хэмжээг хэрэгжүүлэхээр, үүнээс 127 арга хэмжээний эх үүсвэрийг “улсын төсөв” нэршил орсноор төлөвлөжээ.

1.5. Улсын хөгжлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсвийн урсгал зардлаас эсвэл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нь тодорхойгүйгээр “улсын төсөв” гэсэн ерөнхий нэрээр эсвэл “улсын төсөв, гадаадын зээл”, “улсын төсөв, гадаад тусламж”, “улсын төсөв, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт” зэргээр эх үүсвэрийг нэгтгэн томъёолж тусгасан нь санхүүжилтийн эх үүсвэр бүрээр төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан шинжлэх, хэрэгжилтийг үнэлэх боломжийг хязгаарлаж байна.

1.6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх 712 төсөл, арга хэмжээнээс 182 төсөл, арга хэмжээг буюу 25.6 хувийг Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдуулж төлөвлөсөн, 74.4 хувь нь тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
/Хавсралт 1/

Хүснэгт 2. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний уялдаа

УТХО-ын төлөвлөгөөнд тусгагдсан шинэ ТАХ-ний тоо	Үүнээс улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй			
	Уялдсан ТАХ-ний тоо	Эзлэх хувь	Уялдаагүй ТАХ-ний тоо	Эзлэх хувь
Шинэ 712	182	25.6%	530	74.4%

1.7. Богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдахгүй байгаа нь төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчимд нийцэхгүй байна.

1.8. Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8³⁴, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.17³⁵, 6 дугаар зүйлийн 6.10.3³⁶ -т заасан шаардлагад нийцэхгүй байна.

1.9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн шинээр эхлүүлэх 712 төсөл, арга хэмжээний 74.4 хувь буюу 530 нь тухайн жилийн хөгжлийн бодлогын зорилтыг хангахад чиглэхгүй, дунд болон урт хугацааны ерөнхий зорилтод чиглэсэн байгаа нь хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх үйл ажиллагаа нь нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчмын шаардлагыг хангахгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа

УХЖТ-тэй уялдуулаагүй ТАХ-ний тоо	Засгийн газрын 2020- 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр		Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлого		Аймаг, нийслэлийн ЗД- ын ҮАХ болон бусад	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
530 ТАХ	193	36.4%	122	23.0%	215	40.6%

1.10. Эдгээр нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.3³⁷, 9.4.3³⁸-д заасан чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

1.11. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-д “Улсын төсөв нь **улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэх**”-ээр тусгасан боловч Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29¹.2.5. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, **хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх**” буюу хөгжлийн жилийн төлөвлөгөөнөөс гадна урт, дунд хугацааны бодлогод уялдсан байж болохоор өргөн хүрээгээр тусгасан байх тул эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

1.12. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй 65 багц төсөл, арга хэмжээ тусгагдсан ба үүнээс 18.5 хувь буюу 12 багц төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулж төлөвлөсөн, үлдэх 53 багц төсөл, арга хэмжээ буюу 81.5 хувь нь уялдаагүй байна.

1.13. Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1³⁹ дэх заалтад улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулахаар тусгажээ.

1.14. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 30.0 тэрбум төгрөгөөс бага өртөг бүхий төсөл, арга хэмжээг дунд хугацаанд хэрхэн төлөвлөх, богино хугацааны тухайн жилийн төлөвлөгөөтэй хэрхэн уялдуулах, өмнөх онд нь бэлтгэл ажлыг хэрхэн хангуулах талаар эрх зүйн тодорхой зохицуулалтгүй байна.

1.15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулах, газрын болон техникийн зөвшөөрөл авах зэрэг төсөвлөлтийн шаардлагыг өмнөх онд хангуулах, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд чиглүүлэх шаардлагатай байна.

³⁴ 27.1.8. “Төсвийн төслийг боловсруулахад ... улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”

³⁵ 5.2.17. “Төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын .. төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын ... хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг”

³⁶ 6.10.3. “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”

³⁷ 9.5.3. “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний төсөв, хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах”

³⁸ 9.4.3. “Макро эдийн засгийн бодлого болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг салбар хооронд шууд удирдан зохион байгуулах бөгөөд улсын төсвийн төсөл Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх”

³⁹ 28.1. “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна”


1.16. Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.15⁴⁰ дах заалтад Засгийн газар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах журмыг батлахаар тусгасан боловч хэрэгжээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний цар хүрээ, шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна

1.17. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх 1319 төсөл, арга хэмжээг ТЕЗ-дын шийдвэрээр багцад задалж 2385 багц арга хэмжээг төлөвлөжээ.

1.18. Эдгээр багц төсөл, арга хэмжээг төсөвт өртгөөр нь ангилбал хамгийн бага нь 2.2 сая, хамгийн их нь 676.3 тэрбум төгрөг байх ба нийт төсөл, арга хэмжээний 35.4 хувийг 500.0 сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ эзэлж байна.

Дүрслэл 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн ангилал



1.19. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хамрах цар хүрээгээр нь авч үзвэл аймаг, нийслэл, бүсийн түвшний томоохон төсөл, арга хэмжээнээс гадна сумын нийтийн халуун усны барилга, худаг, тоглоомын талбай, ногоон байгууламж, тохижилт, сумын төвийн авто зам, шугам сүлжээ зэрэг сум, дүүргийн түвшний асуудлыг хамрахын зэрэгцээгээр хичээлийн хэрэгсэл, анхны тусламжийн багц, ухаалаг тоолуур, гэрийн зуух, гэр хорооллын хашаа, хаалга зэрэг айл өрхийн түвшний асуудлыг ТЕЗ нар багцад хуваарилан төлөвлөжээ.

1.20. Энэ нь улсын төсвийн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төрөл, төсөвт өртгийн ялгаа зааг, эрэмбэ, ач холбогдол тодорхойгүй байгаагаас шалтгаалж байна.

1.21. Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан “Урсгал зардлын ангиллын тайлбар”-т тавилга⁴¹, хангамжийн материал, сургалт семинар, хичээл үйлдвэрлэлийн дадлагын ажлын зардал, нормын хувцас⁴² зэрэг нь урсгал зардалд хамаарахаар заасан байхад улсын төсвийн хөрөнгө оруулалтын тоног төхөөрөмж ангиллаас тэдгээрийг төлөвлөж, санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- ССАЖЗС-ын багцын Соёлын салбарын тоног төхөөрөмж /Хөвд/ TAX-ний хүрээнд 0.01 тэрбум төгрөгийн 30 ширхэг дээл, хувцас;
- Хүүхэд залуучуудын театрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ TAX-ний хүрээнд 0.5 тэрбум төгрөгөөр тайзны хөшиг;
- ХХААХҮС-ын багцын Мал аж ахуй, хөдөө аж ахуйн салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ TAX-ний хүрээнд 10-40 литрийн 360 ширхэг бидоныг 0.1 тэрбум, Мал аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашиг, хөдөлмөрийн бүтээмж төслийн тоног төхөөрөмж /Баянхонгор/ TAX-ний хүрээнд 120 ширхэг малын байршил тогтоогчийг 0.02 тэрбум төгрөгөөр бэлтгэсэн байна.

⁴⁰ 10.1.15. “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний саналыг хүлээн авч үнэлэх, сонгон шалгаруулах журмыг батлах”

⁴¹ “Тавилга: Байгууллагын үйл ажиллагаанд зориулж авсан ширээ, сандал, шүүгээ гэх мэт тавилга бэлтгэх зардал”

⁴² “Нормын хувцасны зардал: Хуульд заасны дагуу ... ажлын тусгай зориулалтын нормын хувцас худалдан авах зардал ”

1.22. Мөн Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлэх боломжтой:

- Ногоон байгууламж бүхий эко дүүрэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ төсөвт өртөг 2.5 тэрбум;
- Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/ төсөвт өртөг 3.0 тэрбум;
- Ногоон байгууламж бүхий эко хороо /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 6, 8, 15, 16, 18, 25, 30, 39, 40, 41 дүгээр хороо/ төсөвт өртөг 3.0 тэрбум;
- Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Завхан/ төсөвт өртөг 1.0 тэрбум;

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сангаас санхүүжүүлэх боломжтой:

- Орон нутгийн музейн соёлын өвийн тоног төхөөрөмж /Говь-Алтай, Есөнбулаг сум/ ТАХ-ний хүрээнд Гэрэл зургийн мэргэжлийн студийн гэрлийн багц тоног төхөөрөмж, “Жангар тууль” уйгаржин монгол бичгээр бичиж бүтээх хайрцаг хүндэтгэлийн ширээний хамт, Адууны иж бүрэн тоног хэрэгсэл, Асар майхан /нийт 0.09 тэрбум/;
- Цахим орчны хүүхэд хамгааллын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ ТАХ-ний хүрээнд 0.09 тэрбум төгрөгийн контент;

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зорилготой давхацсан жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай 13.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг ХХААХҮС-ын багцад төлөвлөж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Шинэ хөдөө-үйлдвэрлэгч өрх төслийн тоног төхөөрөмж /Орхон, Жаргалант сум/;
- Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/;
- Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тоног төхөөрөмж /Дархан-Уул/;
- Жижиг дунд үйлдвэрлэгчийг дэмжих төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй/;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол/;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж-2 /Улаанбаатар, Баянгол/;
- Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тоног төхөөрөмж /Дархан-Уул, Сэлэнгэ, Төв/;

1.23. Монгол Улсын богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдаа холбоонд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтэд тулгарч буй асуудлын шалтгаан нөхцөлийг тодорхойлон сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТЭЗҮ, тоног төхөөрөмж, их засварын ажлыг эрэмбэлэх, сонгох шалгуур тодорхойгүй байна

1.24. Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.1}. “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна” гэж зааснаар зөвхөн төлөвлөж буй “барилга байгууламж”-ийн төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлж байна.

1.25. Харин их засварын ажил, тоног төхөөрөмжийн худалдан авалт, ТЭЗҮ боловсруулах ажлыг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол зэрэг шалгуураар үнэлж, эрэмбэлж төлөвлөх асуудлыг холбогдох хууль, журмаар зохицуулаагүй бөгөөд норм норматив, ашиглалтын хугацааг харгалзан үзэх, хэрэгцээ, шаардлагаар үнэлж, хуваарилах шаардлага тодорхойгүй байгаа нь тухайн чиглэлийн хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөхөд хүндрэл учруулж байна. Тухайлбал:


- ЗГХЭГД-ын багцын Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ ТАХ-ний хүрээнд Баян-Өлгий аймагт нийт 0.8 тэрбум төгрөгөөр 300 ширхэг, Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж /Өвөрхангай/ Багийн Засаг дарга нарыг унаажуулах Багц-1 ТАХ-ний хүрээнд 95 мотоцикл тус тус нийлүүлсэн;
- Шадар сайдын багцын 0.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Онцгой байдлын автомашин /Хөвсгөл, Их-Уул сум/ ТАХ-ний техникийн тодорхойлолтод 1985 оноос хойш үйлдвэрлэгдсэн Зил-131 автомашиныг худалдан авахаар тусгаж 1990 онд үйлдвэрлэгдсэн буюу 35 жил ашиглагдсан тээврийн хэрэгсэл худалдан авсан;

- ЭХС-ын багцын 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эрчим хүчний тусгай зориулалтын сэлбэг материал, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл /Улсын хэмжээнд/ ТАХ-ний хүрээнд 1.1 тэрбум төгрөгөөр 2 аймагт 5360 ширхэг ухаалаг тоолуур нийлүүлсэн;
- ГБХНХС-ын багцын Хүүхэд зөөвөрлөх том оврын автобус /Хүүхдийн Найрамдал зуслан/ ТАХ-ний хүрээнд 0.4 тэрбум төгрөгөөр 2014, 2015 онд үйлдвэрлэгдсэн буюу 9-10 жил ашигласан 2ш автобус худалдан авсан нь 2-3 жилийн дараа нийтийн тээврийн үйлчилгээний стандартад заасан 12 жилийн ашиглалтын хугацаа нь дуусахаар байна.

1.26. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний үнэлгээ, эрэмбэтэй холбоотой мэдээлэл буюу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-ээс гаргаж ирүүлсэн судалгаагаар ТЕЗ нараас улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд тусгуулахаар шинээр эхлүүлэх 1784 барилга байгууламжийг санал болгосноос 1209 төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэн 464 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр сонгон төсвийн төсөлд тусган өргөн мэдүүлжээ.

1.27. Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг ТЕЗ нар болон Сангийн яамнаас тус бүр 2 үе шатаар үнэлж, хоёр үе шат бүрийн дөрвөн үнэлгээний нийлбэр онооны хамгийн өндрөөр эрэмбэлж сонгохоор журамд тусгасан боловч 2024 оны төсвийн төлөвлөлтөд тухайн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Дүрслэл 3. Үнэлгээний онооны нийлбэр дүнгээр эрэмбэлэх заалтыг мөрдөөгүй



1.28. Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоогүй 662 төсөл, арга хэмжээг үнэлсэн нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 4.2.4⁴³, 4.3⁴⁴, 4.5⁴⁵ дахь заалтуудтай нийцээгүй байна.

1.29. Зураг төсөв нь магадлалаар баталгаажаагүй 230 төсөл, арга хэмжээг төслийг эрэмбэлэх, сонгох 2 дугаар үе шатанд үнэлж эрэмбэлсэн нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ын 5.5⁴⁶ дахь заалт, "Улсын төсвийн

⁴³ 4.2.4 "тухайн төслийн төрлөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа болон Аргачлал 2-т заасны дагуу төслийн шинжилгээг хийсэн байх"

⁴⁴ 4.3 "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн шинэ төслийн тухайд Аргачлал 2-ын дагуу төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох шинжилгээг хийсний үндсэн дээр Аргачлал 3-ын дагуу үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ"

⁴⁵ 4.5 "Төсөл нь холбогдох аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна"

⁴⁶ 5.5 "Энэ журмын 5.4-т заасны дагуу ирүүлэх төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, газар нь чөлөөлөгдсөн, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийгдэж, дүгнэлт гаргуулсан байх шаардлагатай бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөлд сонгох үнэлгээг хийхгүй"

хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал"-ын 2.4⁴⁷ дэх заалттай тус тус нийцээгүй байна.

1.30. Мөн төсөл, арга хэмжээг үнэлж эрэмбэлэх 1 дүгээр үе шатанд ТЕЗ болон Сангийн яамнаас өндөр үнэлгээ өгсөн боловч 2 дугаар үе шатанд оноо өгөөгүй, үнэлгээ хийгээгүйгээс 44 төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгагдаагүй байна. Тухайлбал:

ХХААХҮС-ын эрхлэх асуудлын хүрээнд:

- 12.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Бэлчээрийн усан хангамж /Хөвсгөл” ТАХ нь 1-р шатанд 96.5 оноо, 2-р шатанд 93 оноо, нийлбэр оноо 189.5 оноогоор төлөвлөгөөнд тусгасан бол
- 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Голын эхийн услалтын систем байгуулах /Говь-Алтай, Цогт сум” ТАХ нь 1-р шатанд 107 оноотой боловч 2-р шатанд үнэлгээ хийгдээгүйгээс төлөвлөгөөнд тусгаагүй байна.

ЭХС-ын эрхлэх асуудлын хүрээнд:

- 1.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Цахилгаан хангамж /Ховд, Булган сум”, 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Цахилгаан хангамж /Баян-Өлгий, Алтанцөгц сум, Хаш баг”, 2.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум”, 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Цахилгаан хангамж /Баян-Өлгий, Алтай сум, 3, 5 дугаар баг, Баяннуур сум, 3 дугаар баг” ТАХ-үүд нь 1-р шатанд 88.5-107 оноо, 2-р шатанд 56.5-80.5 оноо, нийлбэр 145-181.5 оноогоор төлөвлөгөөнд тусгасан бол
- 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаанбаатар - Дарханы хоорондох 110 кВ-ын транзит ЦДАШ-д /113-118/ шилэн кабельтай аянгын тросс татах /Улаанбаатар, Дархан-Уул” ТАХ-нд 2-р шатанд үнэлгээ хийгээгүйгээс төлөвлөгөөнд тусгаагүй байна.

1.31. Төсөл, арга хэмжээг эрэмбэлэхдээ шалгуур, аргачлалд нийцүүлэх, бодит үнэлгээ өгөх нь тэргүүлэх ач холбогдолтой, хэрэгцээ шаардлагатай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхээр байна.

1.32. “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ыг Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталж, 2023 оны 12 дугаар сард А/264 дүгээр тушаалаар өөрчлөлт оруулжээ.

1.33. Одоо мөрдөгдөж байгаа журмын 4.8 дахь хэсэгт “Бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтуудтай уялдсан эсэх” гэсэн шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд оруулж улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаагүй төсөл, арга хэмжээг 1-4 оноогоор, “Магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй эсэх” гэсэн шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд оруулж магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг 1-4 оноогоор үнэлэхээр зохицуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29^{1.2.2}⁴⁸, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3⁴⁹ дахь заалттай тус тус нийцээгүй байна.

1.34. Төсвийн тухай хуульд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгаж төлөвлөхгүй байхаар заасан байхад Сангийн сайдын тушаалаар баталсан журамд төлөвлөж буй жагсаалтаас хасахгүйгээр тодорхой оноо, үнэлгээ өгч эрэмбэлэхээр зохицуулсан байгаа нь “сүүлийн 2 жилийн дотор магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх” шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгагдах нэг шалтгаан болж байна.

1.35. Иймд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудад нийцүүлэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх журмыг өөрчлөн сайжруулах, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ ангилалд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх, сонгох эрх зүйн зохицуулалтыг холбогдох хууль, журамд тусгаж мөрдүүлэх шаардлагатай байна.

⁴⁷ 2.4 “Төслийг эрэмбэлэх, сонгох 2-р үе шатанд зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, тухайн газар нь чөлөөлөгдсөн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулсан төслүүдийг оруулж үнэлнэ”

⁴⁸ 29^{1.2.2}.барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

⁴⁹ 6.10.3.улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэхээр тусгасан барилга байгууламжийн 52.8 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна

1.36. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оноос шинээр хэрэгжүүлэх 712 төсөл, арга хэмжээнээс барилга байгууламж, их засварын ангилалд 485 ажлыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

1.37. Барилга байгууламж, их засвар ангиллын 485 төсөл арга хэмжээний 52.8 хувь буюу 256 төсөл, арга хэмжээ нь сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагыг хангаагүй байна. /Хавсралт 2/ Үүнд:

- **903.6 тэрбум төгрөгийн 106 төсөл, арга хэмжээ зураг төсөвгүй;**
- **657.9 тэрбум төгрөгийн 134 төсөл, арга хэмжээ нэг маягийн зураг төсөвтэй, холболтын ажлын өртөг тодорхойгүй;**
- **176.0 тэрбум төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ 2 жилээс өмнө хийгдсэн магадлалын дүгнэлттэй буюу магадлалын хугацаа дууссан байна.**

1.38. Дээр дурдсан магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй 256 төсөл, арга хэмжээний 163 нь ТЕЗ, болон 37 нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн, 56 нь төсвийн төслийг хэлэлцэх явцад УИХ-аар нэмж баталсан төсөл, арга хэмжээ байна.

Дүрслэл 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санал хүргүүлсэн, өргөн барьсан болон төсвийн тухай хуульд батлагдсан байдал



1.39. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁵⁰, 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.2}⁵¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3⁵², 16 дугаар зүйлийн 16.1.4⁵³ дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

1.40. Зураг төсөвгүй эсвэл зураг төсөл нь сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажгаагүй, өөр байршил дахь барилга байгууламжийн өртгийг жишиг болгон төсөвт өртгийг ойролцоогоор тооцох зэргээр хуульд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг бүх шатанд төлөвлөж баталж байна.

1.41. Хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж байгаа нь худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаанд зохион байгуулж амжихгүй, батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглаж чадахгүй байх, гэрээний хугацаанд хэрэгжихгүй

⁵⁰ 29.4. "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана";

⁵¹ 29^{1.2.2}. "Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх"

⁵² 13.3.3. "Улсын болон орон нутгийн төсөв, .. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад ... техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ ... тусгахыг хориглоно"

⁵³ 16.1.4. "Монгол Улсын Их Хурал төсвийн хэмнэлтийн талаар ... техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлахгүй байх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ"

удаашрах зэрэг үр дагаврыг бий болгож олон жил үргэлжлэх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

1.42. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд газрын зөвшөөрөлгүй төсөл, арга хэмжээг тусгахыг хориглосон байхад 79.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталжээ. /Хавсралт 3/ Тухайлбал:

- ЦХИХХС-ын багцын 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Үүрэн холбооны сүлжээ” /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/;
- ЗГХЭГ-ын даргын болон Боловсролын сайдын багцад Архангай аймагт шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 7 төсөл, арга хэмжээ газрын зөвшөөрөлгүй байхад төсөвт тусгаан баталсан бөгөөд 2024 оны 1-5 дугаар сард газрын зөвшөөрөл олгосон;
- Боловсролын сайдын багцад 79.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нийслэлийн Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд баригдах сургууль, цэцэрлэгийн 7, аймаг, орон нутагт төлөвлөсөн 9 нийт 16 барилга барих газрын зөвшөөрөл олгогдоогүй байхад төсөвт тусгаан баталжээ.

1.43. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 заалт, 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалттай нийцээгүй байна.

1.44. Тухайн жилийн санхүүжих дүнг авч үзэхэд 2024 оноос шинээр хэрэгжүүлэхээр баталсан нийт 712 төсөл, арга хэмжээнээс 9.0 хувь буюу 64 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаанд тэгш хуваарилаагүй байна. /Хавсралт 4/ Тухайлбал:

- ЗТС-ын багцад 2024-2026 онд хэрэгжих Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 40.7 км /Ховд, Дөргөн сум/ ТАХ-ний 49.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухай жилд ногдох 16.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3 дахин бага буюу 5.5 тэрбум төгрөгөөр;
- Улсын чанартай авто замыг Шарга сумтай холбох хатуу хучилттай авто зам, 23.0 км /Говь-Алтай, Шарга сум/ ТАХ-ний 34.5 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 11.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3.8 дахин бага буюу 3.0 тэрбум төгрөгөөр;
- Боловсролын сайдын багцад 2024-2026 онд хэрэгжих Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/ ТАХ-ний 9.6 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөс тухайн жилд ногдох 3.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 6.4 дахин багаар буюу 0.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

1.45. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5⁵⁴, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 16.1.6⁵⁵, 17.1.5⁵⁶ дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

1.46. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөл, арга хэмжээний байршлыг “улсын хэмжээнд”, “салбарын тоног төхөөрөмж” зэрэг нэрээр нэгдсэн байдлаар тусгасан боловч тэдгээртэй зэрэгцүүлэн ижил нэр агуулга бүхий аймаг, нийслэл, сум дүүргээр хэрэгжих байршлыг заасан, өртөг санхүүжих дүн нь салбарын дүнтэй дүйцэхүйц төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна. Үүнд:

- Боловсролын сайдын багцад Боловсролын салбарын тоног төхөөрөмж нэртэй “Улсын хэмжээнд” гэсэн 25.0 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн ч түүнтэй дүйцэхүйц 23.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Боловсролын салбарын тоног төхөөрөмж гэсэн ижил нэртэй Баянхонгор, Дархан-Уул, Нийслэлийн Багануур, Налайх, Багахангай дүүрэг, Баян-Өлгий аймгийн Баяннуур, Сагсай, Дэлүүн сум зэргээр тодорхой байршлыг тусгайлан заасан 17 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн;
- ЭМС-ын багцад Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж нэртэй “Улсын хэмжээнд” гэсэн 13.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн ч түүнтэй дүйцэхүйц 12.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж гэсэн ижил нэртэй Баян-Өлгий, Улаанбаатар, Баянгол дүүрэг, Төмөр замын төв эмнэлэг зэргээр тусгайлан заасан 13 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн;

⁵⁴ 29.3.5. “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”

⁵⁵ 16.1.6. “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваасан хэмжээнээс багагүй байхаар батлах”

⁵⁶ 17.1.5. “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх”

- ССАЖС-ын багцад Соёлын салбарын тоног төхөөрөмж нэртэй “Улсын хэмжээнд” гэсэн 10.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн ч 6.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын салбарын тоног төхөөрөмж гэсэн ижил нэртэй Булган, Дундговь, Говьсүмбэр зэрэг байршил заасан 6 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн;
- ССАЖС-ын багцад Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж нэртэй “Улсын хэмжээнд” гэсэн 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн ч түүнтэй дүйцэхүйц Соёлын салбарын тоног төхөөрөмж гэсэн ижил нэртэй Дархан-Уул, Сэлэнгэ, Баянхонгор, Төв, Зуунмод сум зэрэг байршил заасан 2.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг төлөвлөжээ.

1.47. Энэ нь салбарын хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийг нэгдсэн бодлогоор төлөвлөх, хуваарилах, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлох боломжийг хязгаарлаж байна.

1.48. Түүнчлэн тоног төхөөрөмжийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг судалж тооцох, тодорхойлох, төлөвлөх, хянах тогтолцоо бүрдээгүйгээс ЭМС-ын багцын 14.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/ болон “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж” /Баян-Өлгий/ ТАХ-ний хүрээнд 4.0 тэрбум төгрөгөөр эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашин худалдан авах багцаас **“Туулах чадвар сайтай, алсын түргэн тусламжийн автомашин”** нэрээр 2.2 тэрбум төгрөгөөр 9 ширхэг жийп машин буюу “Toyota Land Cruiser 300GXR, Land Cruiser 250, Land Cruiser Prado 150, Hilux, Grand cherokee” маркийн автомашин худалдан авч Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Улсын нэг, хоёрдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Эх хүүхэд эрүүл мэндийн үндэсний төв, Баян-Өлгий, Архангай, Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газарт тус тус олгосон байна.

Зураг. Grand cherokee, Toyota Land Cruiser 300GXR, Land Cruiser 250 маркийн автомашин



Эх сурвалж: PIMIS систем

1.49. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁵⁷, 6.3⁵⁸ дахь заалттай нийцээгүй байна.

Хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлээгүй, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй тоног төхөөрөмжийг бэлтгэхээр төлөвлөсөн байна

1.50. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, соёл амралтын хүрээлэн, тохижилтын ажил, орон нутгийн зам засвар болон хог хаягдлын асуудал, багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай тоног төхөөрөмж худалдан авах, хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй зэрэг нийт 63.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээг төлөвлөжээ. /Дэлгэрэнгүйг хавсралт 5/ Тухайлбал:

Хувийн өмчид шилжих хөрөнгө, материал:

⁵⁷ 6.1. “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно”

⁵⁸ 6.3. “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно”

- БОУАӨС-ын багцад 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ТАХ-ний хүрээнд гэр хорооллын айл өрхүүдэд 2200 ширхэг зуух нийлүүлсэн;
- Боловсролын сайдын багцад 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж /Баянхонгор/ ТАХ-ний хүрээнд угсардаг тоглоом, хичээлийн хэрэгсэл, цүнх нийлүүлсэн;
- ЭМС-ын багцад 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хөдөөгийн айл өрхүүдэд анхан шатны эмнэлгийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж /Баянхонгор/ ТАХ-ний хүрээнд даралтын аппарат, халуун хэмжигч, сахар хэмжигч, гар массажны аппарат бүхий 1242 ширхэг эмнэлгийн анхны тусламжийн багц нийлүүлсэн;

Орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт:

- ХББОСС-ын багцад 41.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 ТАХ, ЗТС-ын багцад 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 ТАХ, БОУАӨС-ын багцад 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, Боловсролын сайдын багцад 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, нийт 48.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ногоон байгууламж, орчны тохижилт, явган болон дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, хүүхэд, залуучуудын хүрээлэнгийн тоног төхөөрөмж, цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж, сагсан бөмбөгийн талбай зэрэг 19 ажлыг төлөвлөж санхүүжүүлсэн;

Орон нутгийн хог хаягдлын асуудал:

- ХББОСС-ын багцад 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хот тохижилт, нийтийн аж ахуйн үйлчилгээний автомашин /Төв/ ТАХ-ний хүрээнд хог тээвэрлэх 8 ширхэг машин нийлүүлэх ажлыг төлөвлөж хэрэгжүүлжээ.

1.51. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2⁵⁹, 13.4.1⁶⁰, 13.4.2⁶¹, 13.4.3⁶², 13.4.4⁶³ заалттай нийцээгүй байна.

1.52. Дээрх төсөл, арга хэмжээний заримыг УИХ-ын хэлэлцүүлгийн явцад нэмж баталсан ба Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5. "Энэ хуулийн 13.3, 13.4-т заасан төсөл, арга хэмжээг тухайн жилийн төсөвт тусган батлахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

1.53. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1.1 тэрбум төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг тухайн чиг үүргийг хариуцсан сайдын төсөвт тусгаагүй, мөн төлөвлөсөн санхүүжилтээс тухайн шатны төсөвт хамаарахгүй өөр салбарын эрхлэх асуудлын хүрээний төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Баян-Өлгий аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газарт нийлүүлэх 0.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг ГБХНХС-ын төсвийн багцад бус Боловсролын сайдын төсвийн багцын Боловсрол, хүүхэд хамгааллын салбарын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ ТАХ-ний хүрээнд төлөвлөж санхүүжүүлсэн;
- 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/ ТАХ-г БОУАӨС-ын төсвийн багцад бус ХББОСС-ын төсвийн багцад төлөвлөж хэрэгжүүлсэн байна.

1.54. Мөн "Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах хөрөнгө оруулалт" нэрээр төлөвлөсөн хөрөнгө нь дараа онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг хангах буюу зураг төсөв боловсруулахад бус Сангийн сайдын төсвийн багцад Төсөл, арга хэмжээний бэлтгэл

⁵⁹ 13.3.2. "Улсын ... төсөв, ... хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад ... хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ ... тусгахыг хориглоно"

⁶⁰ 13.4.1. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад ... орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт ... тусгахыг хориглоно"

⁶¹ 13.4.2. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад ... орон нутгийн хог хаягдлын асуудал ... тусгахыг хориглоно"

⁶² 13.4.3. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад ... орон нутгийн авто замын засвар хийх ажил тусгахыг хориглоно"

⁶³ 13.4.4. "Багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах"

хангах хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/ нэрээр “тоног төхөөрөмж” ангилалд 10.0 тэрбум, “барилга байгууламж” ангилалд 5.3 тэрбум, нийт 15.3 тэрбум төгрөг төлөвлөсөн байна.

1.55. Төлөвлөсөн дээрх хөрөнгийг Сангийн сайдын багцад хамаарах бус бусад ТЕЗ нарын төсвийн багцад хамаарах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулжээ. Тухайлбал:

Бэлтгэл хангах хөрөнгө оруулалт “барилга байгууламж” ангиллаас:

- ГБХНХС-ын төсвийн багцад хамаарах Ахмад настны үндэсний төвийн барилгын их засварын ажил /Төв, Батсүмбэр сум/;
- ЭМС-ын төсвийн багцад хамаарах Улсын хоёрдугаар төв эмнэлгийн барилгын засвар /Улаанбаатар/;
- ЗГХЭГД-ын төсвийн багцад хамаарах Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын тоног төхөөрөмж;
- ЭХС-ын төсвийн багцад хамаарах Цахилгаан хангамжийн их засвар /Төв, Батсүмбэр сум/;
- ХББОСС-ын төсвийн багцад хамаарах Орон сууцны инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсөл /Сэлэнгэ, Мандал сум/;
- ХЗДХС -ын төсвийн багцад хамаарах Шүүх шинжилгээний төвийн барилгын их засвар /Дархан-Уул, Дархан сум/;

Бэлтгэл хангах хөрөнгө оруулалт “тоног төхөөрөмж” ангиллаас:

- БСҮХД-ын төсвийн багцад хамаарах Нүүрс тээвэрлэх зориулалттай ачааны автомашин /Увс, Боршоо, Тэс боомт/ болон Боомтын талбай цэвэрлэх, уурын зуухны үнс, нүүрс түрэх зэрэг аж ахуйн зориулалттай универсал трактор /Сэлэнгэ, Алтанбулаг/;
- Боловсролын сайдын төсвийн багцад хамаарах Цахим анги байгуулах /Дархан-Уул, Шарын гол сум, Сэлэнгэ, Мандал, Жавхлант сум/;
- Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Ерөнхий боловсролын 6 дугаар сургуульд "Цахим анги" байгуулах /Дархан-Уул, Шарын гол сум/;
- ЭМС-ын төсвийн багцад хамаарах Улсын хоёрдугаар төв эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар/ ТАХ-г санхүүжүүлжээ.

1.56. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2⁶⁴, 42 дугаар зүйлийн 42.7⁶⁵, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 4.8.32⁶⁶, дахь заалттай нийцээгүй байна.

1.57. Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх урт, дунд, богино хугацааны бодлогыг уялдуулах, улсын төсөв, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний нэр төрөл, цар хүрээ, төсөвт өртгийн хэмжээ, зориулалт зэргийг тодорхой болгох, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.

⁶⁴ 6.6.2. “Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг ... төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх ... байдлаар хэрэгжүүлнэ”

⁶⁵ 42.7. “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно”

⁶⁶ 4.8.32. “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ангиллын төслийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх”

**БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТЫГ
САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталж байгаа нь худалдан авах ажиллагаа удаашрах, хугацаандаа хэрэгжихгүй байхад нөлөөлж байна

2.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 2024 оноос эхлэн хэрэгжих 5,969.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 712 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны 46.9 хувийг орон нутагт, 26.3 хувийг ТХААГ-т эрх шилжүүлж, 26.8 хувийг ТЕЗ түүний харьяа байгууллага зохион байгуулжээ.

2.2. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний багцын задаргааг батлах, мөн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх шилжүүлэх шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргаагүй байна. Тухайлбал:

- ЗТС-ын багцад 2024 оноос эхлэн шинээр хэрэгжих 2.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Туул голын хойд болон дунд салаан дээрх төмөр бетон гүүрний зураг төсөв, барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх” /Төв, Алтанбулаг сум/ ТАХ-ний эрх шилжүүлэх шийдвэрийг хугацаа алдаж 2024 оны 9 сард гаргаснаас тухайн онд төлөвлөсөн санхүүжилтийг ашиглаж чадахгүйд хүрсэн;
- Шадар сайдын багцад 2024 онд хэрэгжих 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Гамшгаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж” /Дундговь, Говьсүмбэр, Дорноговь/ ТАХ-ний эрх шилжүүлэх шийдвэрийг 2024 оны 10 дугаар сард гаргасан байна.

2.3. Дээрх байдлаар багцын задаргааг батлах, худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэх шийдвэрийг хугацаа алдаж гаргасан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.7⁶⁷, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.3.3⁶⁸, 4.1.1⁶⁹ заалтад тус тус нийцээгүй байна.

2.4. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 272.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 45 барилга байгууламжийн ажлын тендерийг 2024 оны 10, 11, 12 дугаар сард зарласнаар гэрээ байгуулах ажиллагаа хойшлогдож тухайн онд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулах боломжгүй болжээ. /Хавсралт 6/ Тухайлбал:

- ЭХС-ын багцад төлөвлөсөн 0.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Ганга нуурын аялал жуулчлалын цогцолборын цахилгаан хангамж” /Сүхбаатар/ ТАХ-ний худалдан авах ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 27-нд;
- ЗТС-ын багцад төлөвлөсөн 6.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төвийн 4.26 км авто зам” /Хэнтий, Биндэр сум/ ТАХ-ний худалдан авах ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 13-нд;
- ХЗДХС-ын багцад төлөвлөсөн 5.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Улсын бүртгэлийн хэлтэс, архивын тасгийн байр /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/ ТАХ-ний худалдан авах ажиллагааг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр тус тус зохион байгуулсан байна.

2.5. Энэ нь барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг улирал, цаг уураас хамааран гүйцэтгэх ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

2.6. Дээрх асуудлын суурь шалтгаан нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталснаас шалтгаалж байгаа бөгөөд зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулж, магадлалаар баталгаажуулахад тодорхой хугацаа зарцуулж улмаар тендер шалгаруулалт зарлах хугацаа хойшлоход хүргэж байна.

2.7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 712 төсөл, арга хэмжээний 1592 багц төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны 81.1 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 9.6 хувийг харьцуулалтын аргаар, 4.3 хувийг ерөнхий гэрээний

⁶⁷ 45.7. “Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ”

⁶⁸ 2.3.3. “Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний задаргааг эрх шилжүүлсэн шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан цахим системд бүртгэж, баталгаажуулах”

⁶⁹ 4.1.1. “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна”

аргаар, 0.5 хувийг гэрээ шууд байгуулах аргаар зохион байгуулсан бол 3.7 хувьд тендер шалгаруулалтыг зарлаагүй байна.

2.8. Зохион байгуулсан 9.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын аргыг хууль зөрчин сонгосон байна. Үүнд:

- ХББОСС-ын багцад 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Ногоон байгууламж бүхий эко хороо /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 6, 8, 15, 16, 18, 25, 30, 39, 40, 41 дүгээр хороо/ ТАХ-ний худалдан авах ажиллагааг тохижилтын ажлын төлөвлөлтийн даалгаварт үндэслэн зохион байгуулж, гүйцэтгэгч нь зураг төслийг боловсруулах туслан гүйцэтгэгчийн гэрээ байгуулсан;
- ГБХНХС-ын багцын 1.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл, Улаан-Уул, Мөрөн, Эрдэнэбулган сум/ ТАХ-ний худалдан авах ажиллагааг батлагдсан зураг төсөвөгүүгээр зохион байгуулсан;
- ЗТС-ын багцын 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/ ТАХ-ний багц Дулааны шугам сүлжээний засварын ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 1 удаа зарлаж амжилтгүй болоход дахин тендер шалгаруулалт зарлахгүйгээр гэрээ шууд байгуулсан;
- ХББОСС-ын багцаас орон нутагт эрх шилжин хэрэгжсэн 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл” /Ховд/ ТАХ-ний зураг төсөл боловсруулах 0.07 тэрбум төгрөгийн ажлыг 4 хуваан шууд худалдан авалт хийсэн;
- ХХААХҮС-ын багцын “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/ ТАХ-ээс 0.5 тэрбум төгрөгийг удирдах ажилтны тавилга багц 0.08 тэрбум, хурлын заалны ширээ багц 0.09 тэрбум, албан хаагчдын ширээ багц 0.1 тэрбум, сандал багц 0.04 тэрбум, ширээний шүүгээ багц 0.04 тэрбум, албан хэрэгцээний тавилга багц 0.05 тэрбум, тоног төхөөрөмж багц 0.04 тэрбум, камержуулалтын тоног төхөөрөмж 0.02 тэрбум, хамгаалалтын дижитал аппарат 0.04 тэрбум төгрөг зэргээр батлагдсан төсөвт өртгийг хувааж тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зарласан;

2.9. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 31 дүгээр зүйлд заасан “Тендер шалгаруулалтын арга”, 35 дугаар зүйлд заасан “Гэрээ шууд байгуулах арга” болон 10 дугаар зүйлийн 10.3⁷⁰, 12 дугаар зүйл 12.1⁷¹ дахь заалттай нийцээгүй байна.

2.10. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан шинээр эхлүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах, багцын задаргааг батлахдаа хуулиар баталсан ангиллыг зөрчин 37.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

- ХХААХҮС-ын багцын 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих Бяслэг төсөл” /Архангай/ ТАХ нь “тоног төхөөрөмж” ангиллаар батлагдсан байхад орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэхдээ хууль зөрчин сэндвич барилга барихаар ажлын даалгавар боловсруулж, тендер зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан;
- ХХААХҮС-ын багцын 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Загас үржүүлгийн баазын тоног төхөөрөмж /Хөвсгөл, Цагааннуур сум/” ТАХ-ний техникийн тодорхойлолтод “Байгаль орчноо хамгаалах, загас үржүүлэх, төслийн угсралт, зүгшрүүлэлт, мониторинг хийх” ажлыг 0.2 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “зөвлөх үйлчилгээ”-ний ажлыг оруулан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан;
- ЭМС-ын багцын 140.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендер шалгаруулалтыг зарлахдаа төсөвт өртөгт 33 нэр төрлийн 36.4 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажилтай хамааралгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийг хамт нийлүүлэхээр ажлын даалгаварт тусгасан байна.

⁷⁰ 10.3. “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”

⁷¹ 12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журмын 4.8.32⁷², 4.8.38.2⁷³ дахь заалттай тус тус нийцээгүй байна.

Тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээний үнэ, өртгийн урьдчилсан судалгаа хийх, техникийн тодорхойлолтод зайлшгүй тусгах шалгуур, шаардлага тодорхойгүй байна

2.11. Тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан заалт оруулсан, зарим шаардлагатай үзүүлэлтийг орхигдуулсан зэрэг зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ГХС-ын багцын 4.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Гадна фасадын их засвар ТАХ-ний тендер шалгаруулалтын баримт бичигт "төрийн тусгай хамгаалалттай газар 2 ба түүнээс дээш ажил хийж байсан туршлагатай байх" шалгуурыг тусгаж өрсөлдөөнийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн;
- БСҮХД-ын багцын 3.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Гаалийн ажилчдын албаны орон сууц худалдаж авах, засварлах /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ-ний тендер шалгаруулалтын баримт бичиг, техникийн тодорхойлолтод худалдан авах орон сууцны насжилт, барилгын хийц, орон сууц бүрийн болон нийт талбайн хэмжээ зэрэг гол тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тусгаагүй;
- ГБХНХС-ын багцад хэрэгжсэн 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Тусгай хэрэгцээт хүүхдийн сувилал, ахмадын төвийн барилга худалдан авах /Сэлэнгэ, Сүхбаатар сум/ ТАХ-ний техникийн тодорхойлолтод ахмад настан, тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан барилгад тавигдах эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг тусгаагүй;
- ССАЖЗС-ын багцын 4.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Отгон сум/ ТАХ-ний оролцогчийн санхүүгийн чадавхыг нотлохдоо "арилжааны банкны зээлийн эрх нээсэн гэрээ" ирүүлэх шаардлагыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгасан, эрх бүхий байгууллагаас "өрсөлдөөнийг хязгаарласан" гэж дүгнэлт гаргасан байхад зөрчлийг залруулахгүйгээр дахин тендер шалгаруулалт зарласан;
- Боловсролын сайдын 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/ болон 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Бүрд сум, 5 дугаар баг/ ТАХ нь зориулалт, хүчин чадлын хувьд дунд төвөгшилтэй барилга байгууламжид хамаарахаар байхад тендер шалгаруулалтын баримт бичигт бага төвөгшилтэй барилга байгууламжийн тусгай зөвшөөрөл шаардахаар тусгасан;
- Боловсролын сайдын 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум, 3 дугаар баг/ ТАХ-ний тендер шалгаруулалтын баримт бичигт барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардагдах машин, механизмын шаардлагыг тусгаагүй байна.

2.12. Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа худалдан авах тоног төхөөрөмжийн үнийн урьдчилсан судалгаа хийгээгүй, техникийн тодорхойлолтод тавигдах шаардлагыг нарийвчлан тодорхойлоогүйгээс нийлүүлсэн бараа чанарын шаардлага хангахгүй байх, өндөр үнээр нийлүүлэх үр дагавар үүсэж байна. Тухайлбал:

- ХББОСС-ын багцын 6.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Алтанбулаг хилийн боомтын будгийн болон химийн лабораторийн тоног төхөөрөмж /Сэлэнгэ, Алтанбулаг сум/ болон 16.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Барилгын материалын сорилт шинжилгээний түргэвчилсэн лабораторийн тоног төхөөрөмж /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ-ны тоног төхөөрөмжийг зах зээлээс өндөр үнээр нийлүүлсэн;
- ЭМС-ын багцын 0.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй "Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Баян-Өлгий/ (Багц-3)-ын хүрээнд УАЗ фургон автомашиныг 0.07 тэрбум төгрөгөөр нийлүүлсэн байхад Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл багц 2-ын хүрээнд ижил үзүүлэлттэй фургон автомашиныг 0.03 тэрбум төгрөгөөр илүү буюу 0.1 тэрбум төгрөгөөр худалдан авсан;
- ССАЖЗС-ын багцын 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ ТАХ-ний хүрээнд худалдан авах волейболын шал, чөлөөт бөхийн дэвжээ, байтын харваа, үндэсний сурын нум сумны иж бүрдэл зэрэг хөрөнгүүдэд тавигдах шаардлагыг нарийвчлан тусгаагүйгээс өндөр үнээр нийлүүлсэн;

⁷² 4.8.32. "Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний ангиллын төслийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх"

⁷³ 4.8.38.2. "Хуулиар батлагдсан төсөл арга хэмжээний төсөвт өртөг, нэр байршил хүчин чадалд өөрчлөлт оруулахгүй зөвхөн тухайн жилд санхүүжих дүнд зохицуулалт хийхийг хориглоно"

- Боловсролын сайдын багцын 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/ ТАХ-ний техникийн тодорхойлолтод зарим тоног төхөөрөмжийн зайлшгүй шаардлагатай үзүүлэлт, хүчин чадал, мөрдөж буй стандарт, норм, дүрмийн шаардлагыг тусгаагүйгээс хэрэгцээ шаардлагад нийцээгүй, технологийн хоцрогдолд орсон, зах зээлийн үнээс өндөр үнэтэй тоног төхөөрөмж нийлүүлэх нөхцөл боломжийг бий болгосон байна.

2.13. ХХААХҮС-ын багцын 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, орон нутагт эрх шилжсэн Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Төв/ төсөл, арга хэмжээний 1 дүгээр багцын тендерт оролцогч 0.2 тэрбум төгрөгийн үнийн санал ирүүлэхдээ 0.02 тэрбум төгрөгийн хөнгөлөлт олгохоор тусгасан байхад хөнгөлөлтийн дүнг хасаж тооцохгүйгээр гэрээ байгуулсан байна.

2.14. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль, журмын заалтыг зөрчсөн, тоног төхөөрөмжийн үнийн урьдчилсан судалгааг хангалттай хэмжээнд хийлгүйгээр зах зээлийн үнээс өндөр үнээр тоног төхөөрөмж худалдан авсан ТЕЗ нарт албан шаардлага хүргүүлэв.

Худалдан авах ажиллагаанд гаргасан гомдлын 80.0 хувь үндэслэлтэй байхад захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрт тавих хяналт, хариуцлага сул байна

2.15. Нийт 5,969.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 712 төсөл, арга хэмжээ буюу 1592 багц төсөл, арга хэмжээнээс 1356 төсөл, арга хэмжээ буюу 85.2 хувьд нь худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулснаар улсын төсөвт 104.4 тэрбум төгрөгийн хэмнэлт үүсжээ.

2.16. Шинээр хэрэгжих 1592 багц төсөл, арга хэмжээнээс тендер зарлаагүй 68, гүйцэтгэгч шалгараагүйгээс тухайн онд гэрээ байгуулагдаагүй 168, нийт 1,652.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 236 төсөл, арга хэмжээ буюу 14.8 хувь нь тухайн онд хэрэгжих боломжгүйд хүрчээ.

2.17. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч шалгараагүй 168 төсөл, арга хэмжээний 63.1 хувь буюу 106 төсөл, арга хэмжээ нь ТЕЗ нараас төсвийн төсөлд хүргүүлсэн саналд тусгагдаагүй, хэлэлцүүлгийн явцад төсөвлөлтийн шаардлага хангаагүй ажлыг УИХ-аар нэмж баталсантай холбоотой байна.

2.18. Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороод төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 7/ Тухайлбал:

- ГБХНХС-ын багцад хэрэгжсэн 8.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон Гэр бүл, хүүхэд залуучуудын газарт барилга худалдаж авах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/ төсөл, арга хэмжээний ажлын даалгаварт заасан “Авто замын явах хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээ стандартын дагуу байх, ногоон байгууламж норм дүрмийн дагуу төлөвлөгдсөн байх, газрын хэмжээ 500-700м² байх” гэсэн шаардлагыг хангаагүй байхад тухайн оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан;
- Боловсролын сайдын багцын 15.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, 7 дугаар хороолол/ ТАХ-ний гүйцэтгэгчийг шалгаруулахдаа тендерийн баримт бичигт заасан шаардлагад борлуулалтын орлого хүрээгүй оролцогчийг шалгаруулсан;
- ЭЗХС-ын багцын 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн баримт бичигт заасан техникийн чадавхыг нотлох баримтыг ирүүлээгүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан;
- ЭЗХС-ын багцын 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний хүрээнд 2 ширхэг суудлын автомашин худалдан авах тендерийн баримт бичигт 2016 оноос хойш үйлдвэрлэсэн байхаар заасан ба нэг бүр нь 58.8 сая төгрөгөөр 2016 оны Соната автомашин санал болгосон оролцогчийг шалгаруулсан, тус автомашины зах зээлийн үнэ 30.0-45.0 сая төгрөг байна;
- ЭХС-ын багцын 0.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхүүдийн цахилгаан хангамж /Архангай, Цэцэрлэг, Хашаат/ ТАХ-ний ХАА-г эрх шилжүүлэн хэрэгжүүлэхдээ тендерийн баримт бичигт тусгасан ижил төстэй ажлын туршлагыг нотлох эрчим хүчний угсралтын ажлын баримт, материалыг ирүүлэх шаардлагыг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан;

- ЭМС-ын багцын 28.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай сум/, ХХААХҮС-ын багцын 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Завхан/ 2 ажлын ХАА-нд гомдол гарч Сангийн яамнаас захиалагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж дүгнэн зөрчлийг арилгах, дахин үнэлгээ хийх зөвлөмж өгч, албан бичиг хүргүүлсэн байхад үнэлгээний хороо тэдгээрийг харгалзахгүйгээр шийдвэрээ хэвээр үлдээсэн;
- ЭМС-ын багцын 7.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Наркологийн төв эмнэлгийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/ ажлын ХАА-нд гомдол гарч Сангийн яамнаас оролцогч 2 компани гомдол гаргасныг үндэслэлтэй гэж үзэн дахин үнэлгээ хийх зөвлөмж хүргүүлсэн байхад шалгаруулсан;
- Сангийн сайдын багцын 0.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, ГЕГ-т эрх шилжин хэрэгжсэн "Боомтын аж ахуйн зориулалттай универсал трактор худалдан авах" ТАХ-ний худалдан авах ажиллагаанд гомдол гарч Сангийн яамнаас захиалагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж дүгнэж, дахин үнэлгээ хийх зөвлөмж хүргүүлсэн байхад үнэлгээний хороо зөрчлийг арилгахгүйгээр өмнөх шийдвэрээ хэвээр үлдээж тухайн оролцогчийг шалгаруулсан;
- ЭХС-ын багцын 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эрчим хүчний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах - Автовышка /Увс, Улаангом сум/ ТАХ-ний худалдан авах ажиллагаанд гомдол гарч Сангийн яамнаас захиалагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж дүгнэж, дахин үнэлгээ хийх зөвлөмж хүргүүлсэн байхад үнэлгээний хороо зөрчлийг арилгахгүйгээр өмнөх шийдвэрээ хэвээр үлдээж тухайн оролцогчийг шалгаруулсан;
- Боловсролын сайдын багцын 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт заалны барилга, 250 суудал /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/ ТАХ-ний тендерийн баримт бичигт тусгасан ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг хангаагүй оролцогчийг шалгаруулсан;
- Боловсролын сайдын багцын 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум, 3 дугаар баг/ болон 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилгын өргөтгөл /Өвөрхангай, Богд сум/ ТАХ-ний тендерийн баримт бичигт тусгасан ажил гүйцэтгэх хүний нөөцийн шаардлагыг хангаагүй оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан;
- Боловсролын сайдын 3.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/, ЭМС-ын багцын 0.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эрүүл мэндийн төвийн барилга /Өвөрхангай, Зүүнбаян-Улаан сум/, ЗТС-ын 2.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй багцын А0302 авто замаас Хайрхандулаан сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.2 км /Өвөрхангай, Хайрхандулаан сум/, 4.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум/ ТАХ-үүдийн тендерт ирүүлсэн материалд хүний нөөцийн чадавхын шаардлагад заасан мэргэжлийн диплом, сертификат, нотлох баримт бичиг ирүүлээгүй оролцогчийг шалгаруулсан;
- ЗТС-ын багцын 3.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/, 9.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/, 9.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний тендер шалгаруулалтын баримт бичигт заасан техникийн чадавхын болон туршлагын шаардлагыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан
- ЗТС-ын багцын 11.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/ ТАХ-ний тендерт ирүүлсэн төсөв нь магадлалаар баталгаажсан төсвөөс зөрүүтэй буюу техникийн тодорхойлолтод нийцээгүй, шаардлага хангаагүй гүйцэтгэлийг сонгон шалгаруулсан байна.

2.19. Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг бүрэн хангаагүй тендер ирүүлсэн оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.4.2⁷⁴, 26.9⁷⁵, 27 дугаар зүйлийн 27.5⁷⁶ дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

2.20. Тендер шалгаруулалтад гаргасан гомдол, түүний шийдвэрлэлтийн талаарх Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн судалгаагаар

⁷⁴ 26.4.2. "Санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх";

⁷⁵ 26.9. "Тендер шалгаруулалтын баримт бичгийн бүх шаардлагыг нэгэн зэрэг хангасан тендерийг шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ"

⁷⁶ 27.5. "Тендерийг энэ хуулийн 11.4.1-д зааснаар үнэлэхэд харьцуулах үнийг, ... тус тус өсөх дарааллаар эрэмбэлж, эхэнд эрэмбэлэгдсэн тендерийг хамгийн сайн тендер гэж үзнэ"

оролцогч нараас 2024 онд худалдан авах ажиллагаанд гаргасан гомдлын 80.6 хувь нь үндэслэлтэй гэж шийдвэрлэгдсэн нь өмнөх оноос 7.0 хувиар өссөн бөгөөд захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэр гаргаж байгаа тохиолдол нэмэгдсэн байна.

2.21. Захиалагчийн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48 дугаар зүйлийн 48.2.3⁷⁷-д заасан үүрэг, мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.4⁷⁸-д заасан ТХААГ-ын хяналт тавих чиг үүрэг хэрэгжихгүй, худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн гаргасан дүгнэлт, шийдвэрийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагаа хийгдэхгүй байна.

⁷⁷ 48.2.3. “Үнэлгээний хорооны зөвлөмж хууль тогтоомжид нийцэх эсэхэд хяналт тавих”

⁷⁸ 49.4.4. “Худалдан авах ажиллагааны нэгжийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавих”

БҮЛЭГ 3. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨЛӨВЛӨСӨН САНХҮҮЖИЛТИЙН 37.3 ХУВИЙГ ЗАРЦУУЛААГҮЙ, 2024 ОНД ДУУСГАХААР ТӨЛӨВЛӨСӨН АРГА ХЭМЖЭЭНИЙ 31.0 ХУВЬ НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилд төлөвлөсөн санхүүжилт 63.7 хувийн гүйцэтгэлтэй байна

3.1. Төсвийн хөрөнгө оруулалтын www.publicinvestment.gov.mn вэб сайт болон гар утасны аппликейшнаар дамжуулан доорх мэдээллийг олон, нийтэд ил тод, нээлттэй болгосон байна. Үүнд:

- Олон эх үүсвэрийн мэдээлэл /Улсын төсөв, нийслэлийн төсөв, концесс, гадаад, зээл тусламж/;
- Батлагдсан төсөл, арга хэмжээний мэдээлэл /Төсвийн ерөнхийлөн захирагчаар, байршлаар, газрын зургаар, төслийн төрлөөр/;
- Төсөл арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээлэл;
- Санхүүжилтийн мэдээлэл /үе шатаар/;
- Мэдээллийн самбарын мэдээлэл /MNS 7023:2023 стандарт/;
- Ашиглалтад орсон төслийн мэдээлэл;
- Төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой хууль, эрх зүйн мэдээлэл зэрэг байна.

3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтэд 2024 онд 3,828.6 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 2,401.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлж 62.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Дүрслэл 5. Төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн санхүүжилт, гүйцэтгэл, хэрэгжилтийн хувь /ангилал бүрээр/

ШИНЭ

ШИЛЖИХ



3.3. Тухайн онд санхүүжүүлэх 3,770.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 691.6 тэрбум төгрөг буюу 18.3 хувийг Засгийн газрын 2024 оны 249 дүгээр тогтоолоор ТЕЗ нарын барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд зарцуулснаар тайлагнажээ.

3.4. ТЕЗ нарын барьцаа хөрөнгийн дансанд жил бүр Засгийн газрын тогтоолоор төсөл, арга хэмжээний санхүүжүүлээгүй үлдэгдлийг байршуулж дараа онуудад зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3⁷⁹, 43.1.5⁸⁰-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

⁷⁹ 43.1.3. "Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээгээр болон олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөв";

⁸⁰ 43.1.5. "Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив";

Хүснэгт 4. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилт /сая төгрөг/


№	ЗГ-ын тогтоолын дугаар	ТЕЗ нарын барьцаа дансанд байршуулсан	Үүнээс санхүүжилт олгосон	Улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн	Зарцуулагдаагүй үлдэгдэл
1	2019 оны 430	160,893.8	141,999.1	17,313.1	1,581.5
2	2020 оны 253	50,258.8	48,256.5	1,514.1	488.3
3	2021 оны 397	378,380.9	323,488.7	48,785.8	6,106.3
4	2022 оны 495	77,681.8	57,058.9	9,976.5	10,646.4
5	2023 оны 456	428,885.3	314,081.6	16,171.6	98,632.1
6	2024 оны 249	691,582.9	82,765.4	130.7	608,686.8
	Нийт	1,787,683.4	967,650.2	93,891.9	726,141.3

3.5. Тухайн жилд төлөвлөсөн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, он дамжуулан санхүүжүүлж байгаа нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилт, зарцуулалтад тавих хяналтыг сулруулж, улмаар олон жил дамжиж, санхүүжилтийн тодорхой эх үүсвэр ашиглалтгүй байршихад хүргэж байна.

3.6. Төсвийн жилийн санхүүжилтийн гүйцэтгэлээр Батлан хамгаалахын сайд, Гадаад харилцааны сайд, Улсын ерөнхий прокурор, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны дарга, Авлигатай тэмцэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн 90-99.5 хувийг зарцуулсан, хэрэгжилт хангалттай байна.


3.7. Харин Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга 20.5 хувь, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга 20.7 хувь, Хорин минутын хот үндэсний хорооны дарга 24.0 хувь, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч 26.7 хувийн гүйцэтгэлтэй буюу хэрэгжилт хангалтгүй байна.

Дүрслэл 6. Тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл, ТЕЗ-аар, хувиар



3.8. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоо хэмжээгээр санхүүжилтийн гүйцэтгэлийг авч үзвэл 1319 төсөл, арга хэмжээний 2385 багц ажлын 25.0 хувь буюу 644 багц ажилд санхүүжилт олгоогүй байна.

Дүрслэл 7. Тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн гүйцэтгэл, ТАХ-ээр, хувиар



Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгох зөрчил давтагдсаар байна

3.9. Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд барилга угсралтын зарим ажлын санхүүжилт хүссэн гүйцэтгэлийг хянахдаа бодит гүйцэтгэлээс 2.4 тэрбум төгрөгөөр илүү дүнгээр хянаж баталгаажуулсан байна. Үүнд:

Төсөл, арга хэмжээний бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгосон:

- БОУАӨС-ын багцын 0.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Ганга нуурыг бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл /Сүхбаатар, Дарьганга/ ТАХ-ний гүйцэтгэгчид 0.1 тэрбум;
- Боловсролын сайдын багцын 4.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Бага сургуулийн барилга, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар баг/ ТАХ-ний ажлын гүйцэтгэл 35.0 хувьтай байхад 61.5 хувийн гүйцэтгэлээр 0.8 тэрбум;
- ХББОСС-ын багцын 1.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Ховд/ ТАХ-ний бодит гүйцэтгэлийг хянаагүйгээс 0.3 тэрбум, зураг төсөв боловсруулах гэрээг байгуулахдаа холболтын зураг төсвийг иж бүрэн зураг төслийн үнээр тооцон 0.06 тэрбум;
- Боловсролын сайдын багцын 3.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/ ТАХ-ний барилгын гадна ханыг зураг төсөвт өнгөлгөөний тоосгоор тусгасныг энгийн тоосгоор өрснийг баталгаажуулж 0.1 тэрбум;
- Боловсролын сайдын багцын 5.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/ ТАХ-ний ажлын гүйцэтгэлийг бодитоор хянаж баталгаажуулаагүйгээс 0.4 тэрбум;
- ЗТС-ын багцын 1.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Чандмань/ ТАХ-ний 5 дугаар багцын ажилд гүйцэтгэлээс 0.06 тэрбум;
- ЭМС-ын багцын 13.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Халдварт өвчин судлалын үндэсний төв-2 /Төв, Сэргэлэн/ ТАХ-ний гадна инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэлийг олгохдоо ашиглаагүй материалын үнэ, тээврийн зардалд 0.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг тус тус илүү баталгаажуулсан байна.
- ЗТС-ын багцын 3.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 5.5 км /Дорнод, Хэрлэн сум/, 9.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/, 9.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний хүрээнд автозамын 10 багц, барилга байгууламжийн 2 багц, нийт 12 багц ажлаас авто замын 7 ажлыг урьдчилан санхүүжүүлж, хийж гүйцэтгээгүй ажилд 0.7 тэрбум;

- ЗТС-ын багцын 11.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/ ТАХ-ны ажилд гүйцэтгэлээс 0.8 тэрбум;
- ХББОСС-ын багцын 9.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Уртын голын ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/ ТАХ-ны хийгдээгүй ажилд буюу 21 багц усалгааны системийн ажилд гүйцэтгэлээс 0.3 тэрбум;
- ХББОСС-ын багцын 9.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Соёлын төвийн барилга /Сүхбаатар, Онгон сум, 5 дугаар баг/ ТАХ-ны хийгдээгүй ажилд олгосон илүү санхүүжилт 0.07 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү олгосон.

3.10. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12⁸¹ дахь заалтыг зөрчсөн байна.

3.11. ЭМС-ын багцын 140.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг ЭМС-ын 2024 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/175 дугаар тушаалаар батлахдаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн үнийн дүнг 36.4 тэрбум төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд 40.1 тэрбумаар нийлүүлэхээр тусгасан байна.

3.12. ХББОСС-ын багцын 9.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж /Өвөрхангай, Бат-Өлзий сум/ ТАХ-г хэрэгжүүлэхдээ усан сан, гүний худгийн гадна цахилгаан хангамжийн 160 кВа-ийн хүчин чадал бүхий КТПН иж бүрдэл дэд өртөөг агаарын станц АТП болгон өөрчилж барьсан, төсөвт гадна дулааны худаг, сувгийн тагийг 452км-ээс тээвэрлэн угсрахаар тооцсон боловч бодитоор газар дээр нь төмөр бетон цутгасан, бодит гүйцэтгэлээр санхүүжүүлээгүй байна.

3.13. Шадар сайдын багцын 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Тусгай чиг үүргийн байгууллагуудын бие бүрэлдэхүүний дадлага, сургалт хийх талбай байгуулах /Улаанбаатар, Багахангай дүүрэг/ төсөл, арга хэмжээг 5 га талбай бүхий хашаа, гүйлтийн зам, индэр, үзэгчийн суудал бүхий дадлага, сургалтын зориулалттай зураг төсөвтэй ажлыг гүйцэтгүүлэхдээ байршлыг өөрчлөн 20 га талбай, сургалтын барилга бүхий байгууламж барихаар шийдвэр гарган зураг төсөлгүйгээр хашаа, газар шорооны ажил гүйцэтгүүлсэн байна.

3.14. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5⁸² дахь заалттай нийцээгүй байна.

3.15. ХХААХҮС-ын багцын Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих "Бяслаг" төсөл /Архангай, Тариат сум/ ТАХ-г орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлэхдээ хуулиар батлагдсан "тоног төхөөрөмж" ангиллыг өөрчилж барилга угсралтын ажил гүйцэтгүүлэхээр тендер зарлаж, гэрээ байгуулсан ба барилгын ажлын гүйцэтгэл 90.0 хувьтай, 0.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг аймгийн Засаг даргын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлжээ.

3.16. Төрийн байгууллагын уялдаа холбоогүй байдал, хариуцсан ажилтнуудын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж гүйцэтгэсэн ажлыг санхүүжүүлэх боломжгүйд хүрч, улсын төсвийн хөрөнгөөр баригдсан барилга байгууламж ашиглалтгүй орхигдох эрсдэл үүсэж болзошгүй тул энэ төрлийн зөрчлийг ХАА зохион байгуулах шатанд зогсоох арга хэмжээ авч байх шаардлагатай байна.

3.17. Дээрх төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн Засаг даргад "эдийн засгийн ангиллыг өөрчилж ажлын даалгаврыг боловсруулсан, худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулах эрх олгосон буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах" албан шаардлагыг хүргүүлсэн байна.

3.18. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний зураг төсвийн үнийг барилга, угсралтын ажлын төсөвт өртөгт тусгахдаа зураг төсөл боловсруулах гэрээний үнийн

⁸¹ 4.8.12. "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох"

⁸² 13.1.5. "Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртгийг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх"

дүнгээс өндрөөр тусган төлөвлөснийг Сангийн яамнаас хянан 0.2 тэрбум төгрөгөөр хасаж санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 5. Төсөл, арга хэмжээний зураг төсвийн ажлын өртгийн зөрүү /сая төгрөг/

№	ТАХ-ний нэр	Зураг төсвийн ажлын		Төсөвт илүү тусгасан
		Гэрээний үнийн дүн	Төсөвт өртөгт тусгасан дүн	
1	МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хичээлийн 3 дугаар байрыг буулгаж барих ажил /Улаанбаатар, Сүхбаатар/	697.8	817.8	120.0
2	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 6.3 км /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	95.0	96.9	1.9
3	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 75 ор /Булган, Рашаант/	54.2	56.1	1.9
4	Дотуур байрны барилга, 150 ор /Булган, Хангал сум, Хялганат тосгон/	15.1	41.6	26.5
5	Дотуур байрны барилга, 150 ор /Булган, Хутаг-Өндөр /	30.2	32.7	2.5
6	Эмнэлгийн барилгын өргөтгөл, 15 ор /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ сум, Хатгал тосгон/	30.2	32.0	1.8
7	Цагдаагийн тасгийн байр /Хэнтий, Батноров, Бэрх тосгон/	25.4	29.9	4.5
8	Цагдаагийн тасгийн байр /Хэнтий, Баян-Овоо сум/	23.9	27.9	3.9

Эх сурвалж: PIMIS систем, зураг төсөл гүйцэтгэх гэрээ

3.19. Боловсролын сайдын багцын 26.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй МУИС-ийн Хууль зүйн сургуулийн хичээлийн 3 дугаар байрыг буулгаж барих ажлын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ ТАХ-ний гүйцэтгэгч, зураг төслийн компанитай 2023 оны 10 дугаар сарын 16-нд зураг төсөв боловсруулах ажлыг 0.78 тэрбум төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан боловч тухайн ажлын төсөвт өртөгт зураг төсвийн үнийг 0.8 тэрбум төгрөгөөр тооцон 0.12 тэрбум төгрөгөөр илүү тусгасан байна.


3.20. Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь зураг төсөл боловсруулах, магадлал хийх, зураг төсөлд өөрчлөлт оруулах үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилт, санхүүжилтийн гүйцэтгэл, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 1664 төсөл, арга хэмжээнээс 31.0 хувь нь төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй байна

3.21. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1319 төсөл, арга хэмжээ буюу 2385 багц төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 3,578.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1664 төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөжээ.

3.22. Хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн нийт 1664 төсөл, арга хэмжээнээс 69.0 хувь буюу 1148 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авсан байна.

Дүрслэл 8. 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн ТАХ, хэрэгжилт



3.23. Эдгээр хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд 12,820 хүүхдийн суудалтай 26 сургууль, 4470 хүүхдийн ортой 32 цэцэрлэг, 1200 ортой 11 дотуур байр буюу боловсролын салбарын 69 барилга байгууламж ашиглалтад оржээ.

3.24. Мөн 4080 хүний суудалтай соёлын төв, музей, номын сангийн 12 барилга, 2000 ортой эмнэлгийн 24 барилга, инженерийн дэд бүтцийн 18, дэд станц болон цахилгаан хангамжийг сайжруулах 23 байгууламж, 202.4 км урт авто зам тус тус ашиглалтад оржээ.

3.25. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн 1664 багц төсөл, арга хэмжээнээс 31.0 хувь буюу 516 багц төсөл, арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусаагүй байна.

3.26. Засгийн газраас улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах 9 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр нэмж тусгах төсвийн төслийг 2024 оны 8 дугаар сард УИХ-д өргөн мэдүүлсэн.

3.27. Эдгээр төсөл, арга хэмжээний урьдчилсан судалгаа, тооцоолол хийгдээгүйгээс хугацаандаа хэрэгжихгүй байх, төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн онд бүрэн ашиглах боломжгүй болох эрсдэлтэй байгаа талаар Төрийн аудитын байгууллагаас санал дүгнэлт хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцэн, нийтдээ 396.9 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 22 төсөл, арга хэмжээг нэмж баталжээ.

3.28. Дээрх 22 төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, 2024 онд төлөвлөсөн 396.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээс 39.8 тэрбум төгрөг зарцуулагдсан, санхүүжилтийн гүйцэтгэл 10.0 хувьтай байгаа бөгөөд үүнд барилга байгууламж, ТЭЗҮ ангилалд төлөвлөсөн ажлууд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Тоног төхөөрөмж худалдан авах 51.3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 10 төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 2, хэрэгжилт дутуу 2, хэрэгжээгүй 6;
- Барилга байгууламжийн 101.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн ч хэрэгжээгүй, санхүүжилт нь зарцуулагдаагүй бөгөөд үүнээс гэрээ байгуулаагүй 3, оны эцэст буюу 12 дугаар сард гэрээ байгуулсан 2 төсөл, арга хэмжээ;
- ТЭЗҮ боловсруулах 243.8 тэрбум төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн ч хэрэгжээгүй, төлөвлөсөн санхүүжилт нь зарцуулагдаагүй бөгөөд гэрээ байгуулсан 1, гэрээ байгуулаагүй 6 төсөл, арга хэмжээ байна.

3.29. ЗТС-ын багцын “Хөшигийн хөндий туннел” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/, “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл/, Улаанбаатар хотын хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ ТАХ-ний төсөвт өртөгт зохицуулалт хийж 12.6 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

3.30. Дээрх зохицуулалтаар “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл/ ТАХ-г “Хөшигийн хөндий туннел” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/ ТАХ-нд хамруулан гүйцэтгэх, “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүрэн байгууламжийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Хүрхрэн ам хүртэл/ ТАХ-ний оронд Улаанбаатар хотын хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ ТАХ-г гүйцэтгэхээр шийдвэрлэжээ.

3.31. Мөн зохицуулалтаар Улаанбаатар хотын хөнгөн төмөр замын тээвэр /LRT/ төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар/ багц-2 ТАХ-ний төсөвт өртөг 7.0 тэрбум байснаас 23.0 тэрбум төгрөг болж нэмэгдсэн нь ТЭЗҮ-г улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөж батлахдаа үнэ өртгийн урьдчилсан судалгаа хийгээгүйг харуулж байна.

3.32. Гүйцэтгэгч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүйгээс шалтгаалан зарим барилгын ажил удааширч, 2024 онд төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулаагүй байна. Үүнд:

- ССАЖЗС-ын багцын 1.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Спорт заалны барилга /Дундговь, Говь-Угтаал/ ТАХ-ний гүйцэтгэгч 2024 онд төлөвлөгдсөн 0.5 тэрбум төгрөгийн санхүүжилтэд ногдох ажлаа хийж гүйцэтгээгүй;
- ЗТС-ын багцын 2.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Сумын төвийн хатуу хучилттай авто зам 2 км /Дундговь, Эрдэнэдалай/ ТАХ-ний үлдэгдэл 0.3 тэрбум төгрөгийг зарцуулаагүй, гүйцэтгэгч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлж учирсан хохирлыг барагдуулах зөвлөмжийг Төрийн аудитын байгууллагаас өмнө онд хүргүүлсэн боловч захиалагч хэрэгжүүлээгүй;
- ЗТС-ын багцын 5.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 6.9 км /Говьсүмбэр, Шивээговь сум/ ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ хэрэгжүүлээгүйгээс тухайн онд төлөвлөсөн 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүй;
- ХХААХҮС-ын багцын 2.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга /Говьсүмбэр, Сүмбэр сум/ ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний хугацаанд ажлаа гүйцэтгээгүйгээс тухайн онд төлөвлөсөн 0.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүй;
- ССАЖЗС-ын багцын 4.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Төв Монголын байгаль, түүх, соёлын цогцолборын барилга /Архангай, Эрдэнэбулган/ ТАХ-ний гүйцэтгэгч ажлаа хийж гүйцэтгээгүйгээс шалтгаалан 3.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүй, барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан;
- ССАЖЗС-ын багцын 4.3 тэрбум төгрөгийн Усан бассейн, спорт фитнесийн барилга /Увс, Улаангом сум/ ТАХ нь гүйцэтгэгчээс шалтгаалан 2022 оноос хойш ажил хийгдээгүй, 2024 онд төлөвлөсөн 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүй;
- ССАЖЗС-ын багцын 1.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Солийн Данзаны нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн /Архангай, Хотонт/ ТАХ-ний гэрээний хугацааг 2024 оны 9 дүгээр сарын 18-н хүртэл сунгасан боловч гүйцэтгэгч гэрээний хугацаанд ажлаа хийж дуусгаагүй;
- Боловсролын сайдын багцын 4.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Бага сургуулийн барилга, 160 суудал /Архангай, Эрдэнэбулган сум, 6 дугаар баг/ ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй;
- ССАЖЗС-ын багцын 4.5 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Дөрвөлжин/ ТАХ-ний гүйцэтгэгчтэй 2024 оны 8 дугаар сарын 05-нд гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч ажлаа эхлүүлээгүйгээс төлөвлөсөн 1.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулаагүй;
- Боловсролын сайдын багцын 7.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/ ТАХ-ний гүйцэтгэгч гэрээний дагуу ажлаа гүйцэтгээгүй, төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулаагүй ажил зогссон байна.

3.33. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу зураг төсөвгүй, магадлалын дүгнэлтгүй, магадлалын дүгнэлт гарснаас хойш 2 жилийн хугацаа өнгөрсөн, нэг маягийн зураг төсөлтэй барилга байгууламжийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг ажлын даалгаварт үндэслэн зарлаж байгаа нь хэрэгжилтийг удаашруулж, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

3.34. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж ангиллаас 13 ТЕЗ нар нийт 41.2 тэрбум төгрөгийн компьютер, техник хэрэгсэл худалдан авчээ. /Хавсралт 8/

Дүрслэл 9 Тоног төхөөрөмжийн задаргаа



3.35. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хүлээн авах, ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлт хангалтгүй, зураг, төсвийн дагуу гүйцэтгээгүй, чанарын шаардлагад нийцээгүй төсөл, арга хэмжээг ашиглалтад хүлээн авах зөрчил давтагдсаар байна. Тухайлбал:

- Боловсролын сайдын багцын 7.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 320 суудал /Архангай аймаг, Цахир сум/ ТАХ-ний гүйцэтгэгчийн дулааны улиралд гүйцэтгэх тухай албан бичигт тулгуурлан бүрэн дуусаагүй барилгыг комисс ашиглалтад хүлээн авсан;
- ХББОСС-ын багцын 0.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Цэнхэр, Мөрөнгийн голын урсац сайжруулах усан сан /Хэнтий/ ТАХ-г ашиглалтад оруулах комисс 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр хүлээн авсан боловч далангийн бетон хагарсан, шороон даланг тэгшилээгүй, усны урсгал өөрчлөх сувгийг бүрэн битүүлээгүй;
- ХББОСС-ын багцын 5.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн шинэчлэл /Хэнтий, Биндэр сум/ ТАХ-ний цэвэрлэх байгууламжийн туршилт тохируулга, биологийн аргаар цэвэрлэх бактерийг хийгээгүй байхад 0.4 тэрбум төгрөгийн эцсийн санхүүжилтийг олгосон;
- ХББОСС-ын багцын 51.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ /Хэнтий, Хэрлэн сум/ ТАХ-ний төсөвт тусгагдсан ухсан шуудуу, нүхийг ургамалт өнгөн хөрсөөр хучих ажлыг гүйцэтгэсэн эсэхийг хянаж хүлээн аваагүй, бохир усны 314 худгийн түвшнийг засварлаагүй;
- ЗТС-ын багцын 6.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ ТАХ-ний хэрэгжих хугацаа 2026 он хүртэл боловч үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авсан, 1000 м явган хүний замын ажлыг гүйцэтгээгүй;
- Боловсролын сайдын багцын 2021-2024 онд хэрэгжсэн 6.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Сургуулийн барилга, 320 суудал /Архангай, Батцэнгэл сум/ ТАХ-г улсын комисс хүлээн авсан боловч ашиглалтын явцад 1 болон 3 дугаар давхрын дөрвөн өрөөний дүүргэлтийн хананд цууралт үүссэн, спорт заалны агааржуулалтыг холбоогүй, 4 ширхэг паар ажиллахгүй, 1, 2, 3 дугаар давхрын ариун цэврийн өрөөний агааржуулалтыг гэрлийн унтраалгаас салгаагүй, ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг суулгаагүй;
- Боловсролын сайдын багцын 3.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/ ТАХ-ний гадна ханыг зураг төсвийн дагуу хийгээгүй байна.

Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан байна

3.36. Хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зарим ажлыг хэрэгжүүлэхдээ зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлээгүй, захиалагчийн хяналт хангалтгүй байна. Үүнд:

- Боловсролын сайдын багцын 2.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Дотуур байрны барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/” ТАХ-ны дотуур байрны барилгын ханын өрлөг, битүүмжлэл, гадна хөөсөн дулаалгыг ажлын норм дүрмийн дагуу гүйцэтгээгүй;

- ХХААХҮС-ын багцын 10.5 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/ ТАХ-ний хүрээнд хийж гүйцэтгэсэн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа доголдсон;
- ХББОСС-ын багцын 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Завхан/ ТАХ-ний хүрээнд 7 суманд хийгдсэн хүүхдийн тоглоомын талбай, сагсны талбай, ногоон байгууламж бүхий тохижилтын 8 ажлын ногоон байгууламжийн ажил нь хийгдээгүй байхад хүлээн авсан;
- ССАЖЗС-ын багцын 5.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Аялал жуулчлалын “Соёмбо” цогцолбор /Хөвсгөл, Мөрөн сум/ ТАХ-ний гадна хашаа хайсны тулгуур шонг зураг төсөлд 2 метрийн урттай 80х80 мм байхаар төлөвлөснийг 1.7 метр урттай 50х50 мм хэмжээтэй хийснийг хүлээн авсан;
- ССАЖЗС-ын багцын 0.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Биеийн тамир, спортын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/ ТАХ-ний хүрээнд нийлүүлэх тоног төхөөрөмжөөс 0.017 тэрбум төгрөгийн волейболын шал, үндэсний шагайн харвааны иж бүрдлийг дутуу нийлүүлсэн;
- ХХААХҮС-ын багцын 0.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Бэлчээрийн усан хангамж ТАХ-ний хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн, Бүрэнтогтох, Их-Уул, Рашаант, Эрдэнэбулган суманд баригдах худгийн 5 барилгыг 3.5х4м, өндөр нь 2.8м гэж төлөвлөснийг 3х3м харьцаатай, 2.3м өндөртэйгөөр гүйцэтгэснийг хүлээн авсан;
- Боловсролын сайдын багцын 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/ ТАХ-ний тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасан сөрөг нөлөө үзүүлэхгүй материалаар хийгдсэн эсэхийг нотолсон баримт бичгийг тулган баталгаажуулаагүй, хөрөнгийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн явцад үүссэн эвдрэл гэмтлийг шалгахгүйгээр хүлээн авсан;
- ЗТС-ын багцын 4.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Сумын төвийн авто замын шинэчлэл, 2.15 км /Дорноговь, Замын-Үүд сум/ ТАХ-ний хүрээнд хийгдэх ажлуудаас явган замын ажлыг хийж гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан;
- ЗТС-ын багцын 1.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Сумын төвийн хатуу хучилттай авто зам” /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт баг/ ТАХ-ний гүйцэтгэгч зураг төсөвт тусгагдсан ус зайлуулах шүүрүүлэх суваг, хоолой, 8 худгийн ажлыг хийж гүйцэтгээгүй;
- ХХААХҮС-ын багцын 0.5 тэрбум төгрөгийг гэрээний үнийн дүнтэй “Түүхий эдийн төвийн барилга /Ховд, Мөст Сум/ ТАХ-ний гадна тохижилтын ажлаас хогны сав, сандал, ногоон байгууламжийн ажлыг хийгээгүй;
- ЗГХЭГД-ын багцын 2.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Ховд, Манхан сум/ ТАХ-ний гадна хашаа, ногоон байгууламжийн ажлыг хийгээгүй;
- Боловсролын сайдын багцын 7.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/ ТАХ-ний бетон цутгалтын ажлыг гүйцэтгэхдээ угсралтын цутгамал бетон, төмөр бетон бүтээцийн норм дүрэм баримтлаагүй, 1-2 давхрын бетон багана, хучилт, шатыг цутгахдаа бетон хольцыг нягтруулаагүй;
- Боловсролын сайдын багцын 1.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 50 ортой /Архангай, Тариат сум/ ТАХ-г байнгын ашиглалтад хүлээн авсан боловч барилгын дээвэрт хэсэгчилсэн байдалтай ус тогтсон, гал тогооны тоног төхөөрөмжийн цахилгаан хангамжийг норм, дүрмийн дагуу угсраагүй, газардуулга хийгээгүй хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөн;
- Боловсролын сайдын багцын 7.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сургуулийн барилга, 320 суудал, /Архангай, Цахир сум/ ТАХ-ний барилгын аянга зайлуулагчийг бүрэн хийгээгүй, газардуулагчийг холбоогүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөн байхад ашиглалтад хүлээн авч ашиглаж байгаа;
- ХХААХҮС-ын багцын 3.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Ховд/ ТАХ-ний 1 дүгээр багцын гүйцэтгэгч ажлын даалгаварт тусгаснаас бага хүчин чадалтай трактор нийлүүлсэн байхад хүлээн авсан;
- ЗТС-ын багцын 9.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэл, 2.8 км /Дорнод, Хэрлэн сум, Лхамжавын гудамж/ ТАХ-ны замын ажлын ПКО+000-ПКО+260 хооронд хучилтын өргөнийг 0.1 м-ээр дутуу гүйцэтгэж 0.004 тэрбум төгрөгийн илүү санхүүжилт олгосон;
- ЗТС-ын багцын 9.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Чойбалсан хот доторх хатуу хучилттай авто замын шинэчлэл, сайжруулалт /Дорнод, Хэрлэн сум/ ТАХ-ний 2 дугаар багц

хатуу хучилттай автозамын ажилд тээврийн зайг буруу тооцсоноос 0.08 тэрбум төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

3.37. Эдгээр нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт гүйцэтгэлд тавих үе шатны хяналт хангалтгүй, ТЭЗҮ, тоног төхөөрөмжийг хүлээн авах комисс ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлт бүрийг тулган хянаж хүлээн авах үүргээ хэрэгжүүлэхгүй байгаатай холбоотой байна.

3.38. ХХБОСС-ын багцын 26.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтэц /Архангай/ төсөл, арга хэмжээний хүрээнд 37 барилгын дээврийн болон фасадын засварын ажил, 5.5 км явган хүний зам, авто замын 207 ширхэг гэрэлтүүлгийн ажил хийж 7.2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон боловч хүлээн аваагүй, улсын комисс ажиллаагүй байна.

3.39. Мөн тухайн төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг 26.9 тэрбум төгрөгөөр байгуулсан боловч төсөвт өртөг нь магадлалын дүгнэлтээр 13.5 тэрбум төгрөгөөр баталгаажсан байх тул хэсэгчлэн ашиглалтад хүлээн авч гэрээг дүгнэх шаардлагатай байна.

Хэрэгцээ шаардлагыг харгалзахгүйгээр төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлснээс хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн зарим тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна

3.40. Хэрэгжиж дууссан 2,164.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 1148 төсөл, арга хэмжээний 93.8 хувийг ашиглагч байгууллагын өмчид бүртгэсэн, 6.2 хувийг буюу 214.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 71 төсөл, арга хэмжээний үр дүнд үүссэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

3.41. Энэ нь төсөл, арга хэмжээ хэрэгжиж дууссан ч өмчид бүртгүүлэх хүсэлт илгээгээгүй, ТӨБЗГ-ын тогтоол, шийдвэргүй, оны эцэст хүлээлгэн өгснөөс өмчид бүртгүүлэх хүсэлтийг холбогдох газруудад уламжлах арга хэмжээ хийгдэж байгаа зэрэг шалтгаанаар өмчид бүртгэгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4⁸³, 14 дүгээр зүйлийн 14.4.2⁸⁴, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.1⁸⁵, 4.1.4⁸⁶, 4.4⁸⁷ дэх заалттай нийцээгүй байна.

3.42. Тухайн ТЭЗ-ийн хөрөнгөд бүртгэх боломжгүй, хувийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж хэрэгжүүлснээс шалтгаалан төрийн болон орон нутгийн өмчид бүртгэсэн ч иргэн, ААН-д эзэмшүүлж ашиглуулж байгаа, үнэ төлбөргүй олгох эзэмшүүлэх, эсвэл түрээсийн гэрээ байгуулах зэргээр төрийн байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд хүрээд байна. Тухайлбал:

- БОУАӨС-ын багцын Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/ ТАХ-ний хүрээнд 1.9 тэрбум төгрөгийн 2200 ш зуух худалдан авч дүүргийн ЗДТГ-ын өмчид бүртгэн ирээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж олгосон;
- ХББОСС-ын багцын 1.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Хороо, дүүргийн орчныг тохижуулах "Шинэ хороо" төсөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 8, 11, 28 дугаар хороо/ ТАХ-ний хүрээнд Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын айл өрхийн хашаа, хаалгыг солих ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн;
- ХХААХҮС-ын багцын 3.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Ховд/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн 0.4 тэрбум төгрөгийн хүнсний

⁸³ 13.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна"

⁸⁴ 14.4.2. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: ...бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"

⁸⁵ 4.1.1. "Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй"

⁸⁶ 4.1.4. "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд улсын төсвийн хөрөнгө оруулалт, зээл, тусламж, хандиваар бий болсон хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд үнэ өртөг, эзэмших хуулийн этгээд нь тодорхойгүй болон маргаантай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт асуудлаа тавьж шийдвэрлүүлнэ"

⁸⁷ 4.4. "Улсын төсвийн тухай хуулийн дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ болон төрийн өмчид хамаарах хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон эд хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан актыг үндэслэн эцсийн гүйцэтгэлийн дүнгээр Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу үнэлж эргэлтийн болон үндсэн хөрөнгийн холбогдох данс бүртгэлд заавал тусгана"

бүтээгдэхүүн боловсруулах тоног төхөөрөмжийг, 0.1 тэрбум төгрөгийн зөөлөн бороожуулах усралтын 28 системийг 166 иргэн, ААН-д олгосон;

- ХХААХҮС-ын багцын Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Төв/ ТАХ-ний хүрээнд 0.3 тэрбум төгрөгийн 100 тонн төмсний элит үр худалдан авч иргэдэд тараасан;
- ССАЖЗС-ын багцын Соёлын салбарын тоног төхөөрөмж /Ховд/ ТАХ-ний хүрээнд аймгийн Хөгжимт драмын театрт нийлүүлсэн 0.5 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжөөс 0.04 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг ашиглалтын болон түрээсийн ямар нэгэн гэрээгүйгээр хувь хүн, хамтлагт олгосон;
- ХХААХҮС-ын багцын Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Ховд/ ТАХ-ний хүрээнд 0.003 тэрбум төгрөгийн 10,000 ширхэг модны суулгац худалдан авсан;
- ГБХНХС-ын багцын 0.2 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Ахмадын хөгжлийн төвийн тоног төхөөрөмж /Ховд/ ТАХ-ний ажлын даалгаврыг хэрэгцээ шаардлагад үндэслэн боловсруулаагүйгээс хүчилтөрөгчийн коктейлийн 17 аппарат, анхны тусламжийн 220 багц зэрэг тухайн байгууллагад хэрэглэхгүй зүйлс нийлүүлсэн;
- Боловсролын сайдын багцын 1.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Малчдын хүүхдийн сургуулийн өмнөх боловсролын тоног төхөөрөмж /Баянхонгор/ ТАХ-г төлөвлөж, угсардаг тоглоом, цүнх, дэвтэр бал, усан будаг, баримлын шавар зэрэг хичээлийн хэрэгсэл худалдан авсан;
- ХХААХҮС-ын багцын 3.1 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Завхан/ ТАХ-ний хүрээнд газар тариалан эрхлэх зориулалттай техник, тоног төхөөрөмж худалдан авч 16 сум, 1 цэргийн ангид хуваарилснаас Баянтэс, Нөмрөг, Түдэвтэй гэсэн 4 суманд сонгон шалгаруулалт явуулахгүйгээр ААН-д гэрээгээр эзэмшүүлсэн, Асгат суманд 2022 онд мөн уг төслөөр тоног төхөөрөмж нийлүүлэгдэж ААН-д гэрээгээр эзэмшүүлсэн байхад 2024 онд дахин тармуур, хаман боогч, хадуур давхардуулж нийлүүлснээр ашиглалтгүй, бусад сумдад мөн ашиглаж эхлээгүй, сонгон шалгаруулалт, гэрээ хийгдээгүй;
- ХХААХҮС-ын багцын 0.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Өмнөговь/ ТАХ-ний хүрээнд нийт 0.2 тэрбум төгрөгийн өртөгтэй зуны 35ш хүлэмжийг иргэдэд үнэ төлбөргүй тараан олгосон;
- ХХААХҮС-ын багцын Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Архангай/ ТАХ-ний хүрээнд монбелиард, сэлэнгэ, алатау үүлдрийн 272 үхрийг 1.0 тэрбум төгрөгөөр худалдан авсан;
- ХХААХҮС-ын багцын Шинэ хөдөө, Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих төслүүдийн хүрээнд 3.6 тэрбум төгрөгийн 1701 ширхэг оёдлын машиныг худалдан авч иргэдэд тараасан;
- ХХААХҮС-ын багцын 2.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилга /Увс/ ТАХ-ний хүрээнд баригдсан барилгын зарим өрөөг тоног төхөөрөмжийн хамт түрээслүүлсэн;
- ЭЗХС-ын багцын Эрдэнэт шинжлэх, ухаан технологийн паркийн тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний хүрээнд 0.2 тэрбум төгрөгийн 4 төрлийн автомашин худалдан авсан боловч ашиглалтгүй байсныг Аймгийн Засаг даргын захирамжаар 3 төрийн байгууллагад эзэмшүүлсэн;
- ХХААХҮС-ын багцын 0.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төсөл /Орхон/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн 0.7 тэрбум төгрөгийн зургийн аппарат, принтер, хулдаасан хэвлэлийн машин зэрэг 40 ширхэг тоног төхөөрөмж нь Аймгийн Засаг даргын захирамжаар эзэмшүүлсэн эзэмшигчид бодитоор байхгүй,
- ХХААХҮС-ын багцын Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2035 ширхэг тоног төхөөрөмжөөс 1081 ширхэг тоног төхөөрөмж нь биетээр байхгүй, ямар нэгэн гэрээгүй, иргэдэд тараагдсан гэх боловч нотлох баримтгүй байна.

3.43. Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁸⁸, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁸⁹ дахь заалттай нийцээгүй байна.

3.44. Дээрх зөрчлүүдэд Орон нутаг дахь Төрийн аудитын газраас Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлсэн байна.

3.45. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан 88.1 тэрбум төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаагүй, зарим тоног төхөөрөмж ашиглалтгүй байна. Үүнд:

⁸⁸ 4.1.24. “Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”

⁸⁹ 6.2. “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”

- Боловсролын сайдын багцын 1.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Цэцэрлэгүүдийн шүдний кабинет, тохижилт /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ арга хэмжээг хэрэгжүүлсэн боловч ажиллуулах мэргэжлийн эмч, ажилтны асуудал тодорхойгүй, шийдвэрлэгдээгүйгээс ашиглалтгүй;
- Боловсролын сайдын багцын Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улаанбаатар/ ТАХ-ний хүрээнд нийт 0.3 тэрбум төгрөгөөр ерөнхий боловсролын 17 сургуульд нэг бүр нь 0.005 тэрбум төгрөгийн үнэ бүхий 72 ширхэг гутал ариутгагч нийлүүлсэн ч усны хоолойтой холбож ажиллуулах зориулалттай тоног төхөөрөмж тул ашиглалтгүй хадгалагдаж байгаа;
- ЭМС-ын багцын “Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, автомашин /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” нийлүүлэх 0.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний хүрээнд дүүрэг, хороодын Эрүүл мэндийн төвд нийлүүлэгдсэн 24 ширхэг Соната маркийн авто машинаас 18 нь эвдэрсэн, засварласан, гаалийн бичиггүй зэргээр ашиглалтгүй;
- Боловсролын сайдын багцын 1.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй “Политехник коллежийн тоног төхөөрөмж /Говьсүмбэр, Сүмбэр сум/” ТАХ-ны 0.3 тэрбум төгрөгийн универсал тракторын үйлдвэрийн чангалгаа хийгээгүй, ажил болон сургалтын үйл ажиллагаанд бэлэн бус учраас ашиглалтгүй;
- ГБХНХС-ын багцын 0.5 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн тусгай хэрэгцээт иргэдийн сургалтын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ ТАХ-ны хүрээнд компьютер, ухаалаг дэлгэц, принтер нийлүүлэгдэж Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв болон хороодын мэргэжилтнүүдэд тарааж төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан тоног төхөөрөмж байхгүй, сургалтын төвийн байр нь агуулахын зориулалтаар ашиглагдсан, тусгай хэрэгцээт иргэд үйлчлүүлэх стандартын шаардлага хангаагүй;
- ХХААХҮС-ын багцын 0.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Жижиг, дунд үйлдвэрлэчийг дэмжих төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/ ТАХ-ны хүрээнд нийлүүлэгдсэн 0.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий арьс, ширэн эдлэлийн оёдлын 27 тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглах ажлын байр байхгүйгээс агуулахад хураалттай ашиглалтгүй;
- ХХААХҮС-ын багцын 1.7 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Хэнтий/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмж, трактор дагалдах техник төхөөрөмжийг хүлээн авснаас хойш ашиглаагүй, хадгалагдаж байгаа;



- ХББОСС-ын багцын 51.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй /Хэнтий/ ТАХ-ний Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын 1, 2 дугаар багцын ажил дууссан боловч шугам сүлжээний туршилт, тохируулгын ажил хийгдээгүй, хэрэглэгч холбогдоогүй шалтгаанаар ашиглалтгүй;
- ХББОСС-ын багцын 25.3 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/ -ажлыг хүлээн авсан боловч бүрэн хүчин чадлаар нь ашиглаж эхлээгүй;
- ХХААХҮС-ын багцын 2.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Шинэ хөдөө төсөл /Баянхонгор/ТАХ-ний хүрээнд нийлүүлж Баянхонгор үйлдвэрлэл хөгжлийн корпорац ОНӨҮГ-т хуваарилсан кителийн 80 ширхэг оёдлын тоног төхөөрөмжөөс 0.4 тэрбум төгрөгийн 52 нь ашиглалтгүй хадгалагдаж байгаа;
- ХХААХҮС-ын багцын Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/ ТАХ-ний хүрээнд байгуулсан 0.4 тэрбум төгрөгийн Ингэний сүүний үйлдвэрийн барилга болон 1000 тонны зоорь, өвлийн хүлэмжүүд ашиглалтгүй;
- ХХААХҮС-ын багцын 2.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Бизнес инкубатор төвийн барилга /Увс, Улаангом сум/-ыг ашиглаж эхлээгүй, Загвар хоршоод, орон нутгийн хөгжлийг дэмжих барилгын тоног төхөөрөмж /Увс/ ТАХ болон Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Увс/ ТАХ-ний хүрээнд худалдан авсан 1.0 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжийг цахилгааны холболт хийгдээгүй, хөргүүрийн зоорины барилгын ажил хийгдээгүй зэрэг шалтгаанаар ашиглалтгүй;
- ССАЖЗС-ын багцын 0.3 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Мичид кино театрын тоног төхөөрөмж /Завхан/ ТАХ-ны хүрээнд хуучин барилгыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан ч их засвар хийх, эсвэл кино театрын барилгыг шинээр барих эсэх нь тодорхойгүй байхад тоног төхөөрөмжийг урьдчилан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэснээс худалдан авсан сандал, лед дэлгэц, чанга яригч, өсгөгч зэрэг нийт 0.3 тэрбум төгрөгийн 367 ширхэг тоног төхөөрөмж ашиглалтгүй хадгалагдаж байгаа;
- Боловсролын сайдын багцын 0.9 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Өмнөговь/ ТАХ-ны багц 2-ын хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс 0.5 тэрбум төгрөгийн угаалгын машин, тоос сорогч ашиглалтгүй хадгалагдаж байгаа;

- ЭМС-ын багцын 0.5 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй Эрүүл мэндийн салбарын автомашин, тоног төхөөрөмж /Өмнөговь/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс зарим зөөврийн болон суурин компьютер, УАЗ фургон маркийн автомашин ашиглалтгүй хадгалагдаж байгаа;
- ХХААХҮС-ын багцын 3.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Ховд/ ТАХ-ний хүрээнд сумдад нийлүүлсэн 0.2 тэрбум төгрөгийн трактор, дагалдах техник хэрэгслийг 6 сум иргэн, ААН-д гэрээгээр ашиглуулж байгаа, бусад 7 суманд ашиглалтгүй хадгалагдаж байгаа;
- ХХААХҮС-ын багцын 3.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Ховд/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн 0.07 тэрбум төгрөгийн ноосны пресс, ноосны пүүг 4 сум иргэн, ААН-д гэрээгээр ашиглуулж, бусад сумдад ашиглалтгүй хадгалагдаж байгаа;
- ХХААХҮС-ын багцад хэрэгжсэн Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө төсөл /Дархан-Уул/ ТАХ-ний нийлүүлэгдсэн хөдөө аж ахуйн зориулалттай 0.3 тэрбум төгрөгийн 10 тракторыг орон нутгийн өмчид хүлээн авсан бүртгэл байхгүй, хөрөнгийн нэгдсэн бүртгэлд бүртгээгүй, Шинэ хөдөө болон Бичил үйлдвэр үйлчилгээг дэмжих тоног төхөөрөмжийг ил задгай хашаанд 6 сарын хугацаанд хадгалж байгаа нь тоногдож үрэгдэх, хариуцах эзэнгүй орхигдох эрсдэлтэй;
- ССАЖЗС-ын багцад хэрэгжсэн Хүүхэд залуучуудын театрын цахилгаан бараа худалдан авах ТАХ-ны хүрээнд нийлүүлэгдсэн 0.04 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод хүрээгүй, зарим тоног төхөөрөмж нь байгууллагад биетээр байхгүй;
- ССАЖЗС-ын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021-2022 онд хэрэгжсэн 0.3 тэрбум төгрөгийн 10 төрлийн тоног төхөөрөмж ашиглагч байгууллагад биетээр байхгүй, 2-4 жилийн хугацаанд ашиглагчид олгоогүй, бэлтгэн нийлүүлэгч 2 компанийн агуулахад хадгалагдаж байна.

3.46. Эдгээр нь тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүй, ашиглагч байгууллагаас санал авахгүйгээр төсөвт тусган төлөвлөж хэрэгжүүлснээс шалтгаалж төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж байна.

3.47. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг гүйцэтгэгчээс хүлээн авах, аймаг, сумдад хүргэх, хуваарилах, бүртгэх асуудал нь орон нутаг дахь харьяалах төрийн байгууллагаар дамжиж хэрэгжээгүйгээс бүртгэлд тусгагдахгүй орхигдох, бүртгэлд тусгасан боловч биетээр тухайн сум, байгууллагад хүлээлгэн өгөхгүй иргэн, ААН-д хуваарилах, үнэ төлбөргүй олгох эзэмшүүлэх, эзэмшигч ашиглагчийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулахгүй байх, хэрэгжилт үр дүнг тооцохгүй, тодорхойгүй орхигдох эрсдэлийг дагуулж байна. Тухайлбал:

- ХХААХҮС-ын багцын Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төсөл /Хэнтий, Биндэр сум/ ТАХ-ний хүрээнд Биндэр суманд хуваарилсан 0.1 тэрбум төгрөгийн 150 морины хүчин чадалтай 1 ширхэг трактор хаана байгаа нь тодорхойгүй нөхцөл байдал үүссэнийг аудитаар тодруулж зөрчлийг арилгуулсан;
- ХХААХҮС-ын багцад хэрэгжсэн Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих тоног төхөөрөмж /Орхон, Баян-Өндөр сум/ ТАХ-ний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс 0.08 тэрбум төгрөгийн 2 нэр төрлийн 3 ширхэг тоног төхөөрөмж бодитоор хүлээн аваагүй боловч хүлээн авснаар акт үйлдэж, санхүүжилтийг бүрэн олгож, ашиглагч байгууллага санхүүгийн бүртгэл тайланд тусгасан;
- ХХААХҮС-ын багцын 0.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Загас үржүүлгийн баазын тоног төхөөрөмж /Хөвсгөл, Цагааннуур сум/ ТАХ-ний хүрээнд бий болсон хөрөнгийг Хөвсгөл аймгийн ОНӨГ-ын даргын 2024 оны А/45 дугаар тушаалаар аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт 10 төрлийн 12 ширхэг нийт 0.6 тэрбум төгрөгийн хөрөнгийг эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн боловч бүртгэлд тусгаагүй;
- ЗГХЭГД-ын багцын 0.09 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй Сумын ЗДТГ-ын дэлгэц /Говь-Алтай, Есөнбулаг/ ТАХ-ний хүрээнд аймгийн ЗДТГ-т нийлүүлсэн 5 нэр төрлийн 154 ширхэг тоног төхөөрөмж түүний дагалдах хэрэгслийг 1 ширхгээр бүртгэсэн нь хөрөнгийн бодит байдлаас зөрүүтэй байна.

3.48. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж эхлүүлсэн боловч бүрэн хэрэгжиж дуусаагүй, ажил нь зогссон, гэрээ, гүйцэтгэл маргаантай, цаашид үргэлжлүүлэх санхүүжилтийн асуудал тодорхойгүй орхигдсон барилга байгууламжууд байгаа боловч улсын хэмжээний нэгдсэн бүртгэл мэдээлэлгүй байна. /Хавсралт 9/ Тухайлбал:

- Завхан аймгийн Асгат сумын дотуур байрны барилга 1.3 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй анх зураг төсөвгүйгээр 2022 онд хэрэгжиж дуусахаар төсөвт тусгагдсан боловч барилгын материалын үнийн өсөлт, Ковид-19 цар тархалтаас шалтгаалан хэрэгжиж дуусаагүй, барилга угсралтын ажил 40 орчим хувьтай зогссон, магадлалын дүгнэлтээр төсөвт өртөг нэмэгдлийг 0.8 тэрбум төгрөг баталгаажуулсан, 2025 оны төсөвт тусгагдаагүй; барилга байгууламжийн ажил гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй, барилга угсралтын ажил зогссон;

- Биеийн тамир, спортын улсын хороо /хуучин нэрээр/-ны багцад 2020-2021 онд хэрэгжих 1.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Спорт заалны барилга 250 суудал /Ховд, Дарви/ ТАХ 2021 онд ашиглалтад оруулах гэрээтэй боловч гүйцэтгэл 40.0 хувьтай, материалын үнийн өсөлтийн улмаас барилгын ажлыг гүйцэтгэх боломжгүй гэх шалтгаанаар ажил нь зогссон;
- ССАЖЗС-ын багцад 2010-2022 онд хэрэгжих Спорт цогцолборын барилга, 1000 суудал /Улаанбаатар, Хан-Уул/ ТАХ 2022 онд дуусахаар төлөвлөгдсөн боловч хэрэгжиж дуусаагүй;
- ЭМС-ын багцад 2011 оноос эхлэн хэрэгжсэн Геронтологийн төвийн барилга, дэд бүтэц, 60 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/ ТАХ-ний ажлын гүйцэтгэл 60.0 хувьтай зогссон байна.

3.49. Дээрх байдлаар барилга байгууламжийн ажлыг улсын төсвөөр эхлүүлсэн ч бүрэн хэрэгжиж дуусаагүй, зогссон төсөл, арга хэмжээнүүд байгаа боловч улсын хэмжээнд төсөвт өртөг, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл, шалтгаан нөхцөл зэрэг шаардлагатай мэдээллийн нэгдсэн судалгаа байхгүй, хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

3.50. Дуусаагүй зогссон барилга байгууламжийн хэрэгжилтэд тулгарсан асуудлуудын шийдэл, санхүүжилт тодорхойгүй, цаашид улсын төсвөөс олгосон хөрөнгийн үр ашиг буурах, олон жил үргэлжилж удах тутам алдагдсан боломжийн өртөг, шаардагдах төсөв, санхүүжилт нэмэгдэх үр дагавар үүсэж байна.

3.51. Иймд дээрх мэдээлэл, судалгааг Сангийн яам нь ТЕЗ нараас төсөл, арга хэмжээ бүрээр гаргуулж, нэгтгэн дүн шинжилгээ хийх, тулгарсан асуудлын шийдэл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/-д бүртгэн хянах шаардлагатай байна.

3.52. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төсөвлөлтийн шаардлага хангаагүй барилга угсралтын ажлыг эхлүүлснээр газар олголт, техникийн нөхцөлөөс шалтгаалан ажил зогсох, зураг төсөл боловсруулах, өөрчлөлт оруулах зэргээс шалтгаалан ажил удаашрах, барилга угсралтын ажил бүрэн дуусаагүй байхад санхүүжилтийг төлөвлөхгүй орхигдуулах зэрэг зөрчлүүд түгээмэл байгаа нь эхлүүлсэн ажил удааширч зогсох, царцах асуудлын шалтгаан болж байгааг анхаарах шаардлагатай байна.

3.53. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах үе шат буюу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцүүлэх, төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэх, багц болгон задлах үйл ажиллагаанд тавих хяналтгүй, тендер зарлах, гэрээ байгуулах, үе шатны хяналт, ашиглалтад хүлээн авах үйл ажиллагааг хянах давтамжийг тодорхой болгох, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Хүснэгт 6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хяналтын тогтолцооны бүдүүвч

	Үе шат	Гүйцэтгэгч	Гүйцэтгэлийн хяналт	Хяналтын хугацааны давтамж /жилд/	Хяналтын шалгуур
1	Хөрөнгө оруулалтыг төлөвлөх	ТЕЗ	Сангийн яам	1 удаа, төсөв өргөн барихад	Төсөвлөлтийн шаардлага
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах	УИХ	--	--	Төсөвлөлтийн шаардлага
3	Багцад задлах, эрх шилжүүлэх	ТЕЗ	--	--	--
3	Тендер зарлах, гэрээ байгуулах	ТЕЗ, ТХААГ	Сангийн яам, ТХААГ	Тодорхойгүй	Холбогдох хууль тогтоомж
4	Явц, үе шатны хяналт хийх	Захиалагчийн, зохиогчийн хяналт	ТЕЗ, ХББОСЯ	Тодорхойгүй	Холбогдох хууль тогтоомж
5	ТЕЗ-ийн дотоод хяналт хийх	ТЕЗ-ын ХШҮ, дотоод аудит	Засгийн газар, Сангийн яам	Тодорхойгүй	Холбогдох хууль тогтоомж
6	Ашиглалтад хүлээн авах	ТЕЗ, комисс	Сангийн яам, ТЕЗ, ХББОСЯ	Тодорхойгүй	Холбогдох хууль тогтоомж, норм дүрэм
7	Санхүүжилт олгох	ТЕЗ,	Сангийн яам	Тухай бүр	Холбогдох хууль тогтоомж

8	Хөндлөнгийн хяналт	Үндэсний аудитын газар	УИХ	1 удаа, төсвийн гүйцэтгэлд	Холбогдох хууль тогтоомж, стандарт
---	--------------------	------------------------	-----	----------------------------	------------------------------------

3.54. Яамдын хөрөнгө оруулалт, төлөвлөлт хариуцсан нэгжийн бүтэц, орон тоог дунджаар авч үзэхэд бодлого, төлөвлөлт хариуцсан нэгжид 14, санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж 11, хяналт, шинжилгээ, үнэлгээний нэгж 8 орон тоотой байхаар батлагдсан бөгөөд бодлого, төлөвлөлт хариуцсан албан хаагчдын 35 хувь, хяналт, шинжилгээ хариуцсан албан хаагчдын 37.5 хувь нь 1 жил хүртэлх хугацаанд ажилласан эсвэл орон тоо нь сул байна.

Чиг үүрэг	Үзүүлэлт	Дундаж
Яамны бодлого, төлөвлөлт хариуцсан нэгж	Батлагдсан орон тоо	14
	Ажиллаж байгаа ажилтны тоо	12
	3-аас дээш жил ажиллаж байгаа ажилтны тоо	8
	1 жил хүртэл ажиллаж байгаа	3
	Сул орон тоо	2
Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан нэгж	Батлагдсан орон тоо	11
	Ажиллаж байгаа ажилтны тоо	10
	3-аас дээш жил ажиллаж байгаа ажилтны тоо	5
	1 жил хүртэл ажиллаж байгаа	2
	Сул орон тоо	1
Хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан нэгж	Батлагдсан орон тоо	8
	Ажиллаж байгаа ажилтны тоо	7
	3-аас дээш жил ажиллаж байгаа ажилтны тоо	4
	1 жил хүртэл ажиллаж байгаа	1
	Сул орон тоо	2

3.55. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналтын үйл ажиллагааны чанарыг сайжруулахын тулд хүний нөөцийн тогтвортой, мэргэшсэн байдалд анхаарах шаардлагатай байна.

3.56. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд дараах зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Үүнд:

- Үе шат бүрийг хянах байгууллага, давтамж, шалгуурыг тодорхой болгож журмаар зохицуулах,
- Шалгуур, стандартыг нарийвчлах, хяналт хийх арга, хариуцлагын механизмыг бий болгох,
- Хяналтын тайлан дүгнэлтийг хүргүүлэх, үр дүнг хариуцах арга хэлбэрийг нарийвчлан зааж баталгаажуулах шаардлагатай байна.

3.57. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх тогтолцооны үе шат бүрд хийх хяналт хангалтгүй, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахгүй байх, хариуцлага тооцохгүй орхигдуулах зөрчил түгээмэл байгаад анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил давтагдсаар байна

3.58. Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд өмнөх онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн дараах зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс алдаа, зөрчил давтан гарсаар байна. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД:

- Барилга байгууламжийн ажлын үе шат бүрийг хянах үйл ажиллагаа, захиалагчийн хяналтын тогтолцооны үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, сайжруулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН САЙДАД:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан боловч гадна шугам сүлжээ, эх үүсвэрийг иж бүрэн төлөвлөөгүйгээс зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийн санхүүгийн болон бусад эх үүсвэрийг шийдвэрлэх замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх;
- Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох жишиг үнийг тогтоож мөрдүүлэх;

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ:

- Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд төсөл, арга хэмжээний төлөвлөлт, багцын задаргаа, хэрэгжилт, санхүүжилтийн мэдээллийг бүрэн байршуулах, бүрэн байршуулсан эсэхэд хагас жил тутам дотоод аудит хийж хэрэгжилтийг хянах;

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД:


- Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгдсэн чиглэл, арга зүйгээр хангах;

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДАД:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон үйлдвэр, агуулах, зоорь, хүлэмж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, үржлийн мал зэргийн ашиглагчийг нээлттэй, ил тод, өрсөлдөөнт зарчмаар сонгон шалгаруулах, оновчтой, үр ашигтай ашиглахад чиглэсэн журам, заавар боловсруулан баталж, нэгдсэн арга зүйгээр хангах, хэрэгжилт үр дүнг бүртгэх, тайлагнах, хянах, хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх;

БОЛОВСРОЛЫН САЙДАД:

- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ширээ, сандалд тавигдах чанар, эдэлгээтэй холбоотой нарийвчилсан шаардлагыг боловсруулан мөрдүүлэх, бүсчилсэн хэлбэрээр орон нутагт үйлдвэрлэх, нийлүүлэх нөөц боломжийг судалж худалдан авах ажиллагааг чанартай, үр ашигтай, хэмнэлттэй байхаар зохион байгуулах зөвлөмж тус тус хэрэгжээгүй байна.



**ХАВСРАЛТ ТАЙЛАН 2: “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР
ДҮН” СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН**

АГУУЛГА

ХАВСРАЛТ ТАЙЛАН 2: “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” СЭДЭВТ АУДИТЫН ТАЙЛАН	113
ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	115
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	117
БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА НЬ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	118
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА ХУУЛЬ ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА.....	122
БҮЛЭГ 3. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ХУДАЛДАН АВАЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦАД ТАВИГДАХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ УДААШРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА	124
БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТЭД 2,183.1 ТЭРБУМ ТӨГРӨГ БУЮУ 65.7 ХУВИЙГ ОЛГОЖ, 1,159.6 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНТЭЙ 2507 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГАСАН БАЙНА	128

Товчилсон үгийн жагсаалт

1	ААН	Аж ахуй нэгж
2	ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
3	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
4	АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
5	ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
6	ЗГ	Засгийн Газар
7	ЗД	Засаг Дарга
8	ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
9	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
10	кВт	Киловатт
11	НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
12	ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
13	ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
14	СС	Сангийн сайд
15	СЯ	Сангийн яам
16	ТАХ	Төсөл, арга хэмжээ
17	ТББ	Тендерийн баримт бичиг
18	ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
19	ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
20	ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль
21	ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
22	УБ	Улаанбаатар
23	ХАА	Худалдан авах ажиллагаа
24	ЧД	Чингэлтэй дүүрэг
25	ЭМТ	Эрүүл мэндийн төв

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108, 2025 оны “Тушаалын хавсралтад нэмэлт оруулах тухай” А/44 дүгээр тушаалуудад үндэслэн Төрийн аудитын байгууллагын хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилго, зорилт

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилтын хүрээнд дараах дэд асуудлуудад аудитыг чиглүүлэн хийж гүйцэтгэлээ.

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлсэн эсэх;
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгж болон төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, гэрээний хэрэгжилт, санхүүжилт зэргийг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Аймаг, нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;
- Аймаг, нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;

- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам бодох аргачлалууд”;
- Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохион норм ба дүрэм, стандарт;
- Өмнөх аудитаар өгсөн өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Батлагдсан төсөвт зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрууд өөрийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, Нийслэл дэх Төрийн аудитын газар нэгтгэсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 8,029.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3827 ТАХ, шилжин хэрэгжих 2,167.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1170 ТАХ, нийт 10,197.1 тэрбум сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4997 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.


Хүснэгт 1 Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалт, тэрбум төгрөгөөр

№	Аймаг, хот	Шинэ ТАХ		Шилжих ТАХ		НИЙТ	
		ТАХ тоо	Төсөвт өртөг	ТАХ тоо	Төсөвт өртөг	ТАХ тоо	Төсөвт өртөг
1	Архангай	53	7.1	-	-	53	7.1
2	Баян-Өлгий	176	9.6	9	0.9	185	10.5
3	Баянхонгор	50	9.5	-	-	50	9.5
4	Булган	39	4.7	5	0.8	44	5.5
5	Говь-Алтай	19	4.8	4	0.4	23	5.2
6	Говь-Сүмбэр	28	2.2	5	0.2	33	2.3
7	Дархан	146	21.0	-	-	146	21.0
8	Дорноговь	172	64.0	107	56.0	279	120.0
9	Дорнод	27	10.3	-	-	27	10.3
10	Дундговь	80	28.9	6	0.4	86	29.4
11	Завхан	90	12.2	2	1.6	92	13.8
12	Орхон	236	54.8	47	66.3	283	121.0
13	Өвөрхангай	37	3.8	4	0.2	41	4.0
14	Өмнөговь	601	970.1	217	253.9	818	1,224.1
15	Сүхбаатар	55	11.6	27	17.0	82	28.7
16	Сэлэнгэ	148	19.5	42	7.3	190	26.8
17	Төв	331	26.6	21	3.3	352	29.9
18	Увс	46	6.6	2	0.5	48	7.1
19	Ховд	192	33.9	30	6.6	222	40.6
20	Хөвсгөл	125	5.8	15	4.8	140	10.6
21	Хэнтий	20	5.4	16	10.7	36	16.1
22	Улаанбаатар	1156	6,716.7	611	1,737.0	1767	8,453.7
НИЙТ		3827	8,029.2	1170	2,167.9	4997	10,197.1

Шинээр хэрэгжих ТАХ-ний төсөвт өртгийн 83.7 хувь нь нийслэлд хэрэгжих бөгөөд үүний 70.0 хувийг “Метро” барих бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тайлант онд 3,702.8 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 5052 ТАХ хэрэгжихээс 66.8 хувь буюу 3375 ТАХ бүрэн хэрэгжсэн, 22.7 хувь буюу 1147 ТАХ хэрэгжих шатанд, 10.5 хувь буюу 530 ТАХ хэрэгжээгүй байна. Гүйцэтгэлээр 4318 ТАХ-нд 2,183.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгожээ.

Дүрслэл 1 Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний ангилал



Шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний 35.2 хувийг их засвар, 26.7 хувийг тоног төхөөрөмж, 18.3 хувийг барилга байгууламж, 13.0 хувийг зураг төсөв, 6.8 хувийг авто замын ангилалд хамаарах ажлууд эзэлж байна.

**БҮЛЭГ 1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ХОЛБОГДОХ ХУУЛЬД
НИЙЦҮҮЛЭН ТӨЛӨВЛӨХГҮЙ БАЙГАА НЬ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

1.1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр”, “Хөгжлийн жилийн төлөвлөгөө” зэрэг бодлогын богино, дунд хугацааны баримт бичгүүдэд 95.4 хувийг нийцүүлэн төлөвлөсөн байна. *Хавсралт 1*

1.2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁹⁰, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянан, тайлагнах” журмын 2.2.4⁹¹-д шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд хууль, журамд заасан үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт, тооцооллыг гаргаж хавсаргахаар тусгасан.

Шинээр хэрэгжүүлэхээр баталсан барилга байгууламжийн ангилалд хамаарах 700 ТАХ-нд зардлын тооцоолол хийхээс 76.2 хувьд нь тооцоолол хийгдэж, 23.8 хувьд нь хийгээгүй, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт байхгүй байна. /Хавсралт 2/

1.3. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4⁹²-д санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах гэж заасныг зөрчин 30 багц ТАХ-г 1,123.3 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр баталж, тайлант онд 873.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр тусгажээ. Дээрх ТАХ-г хэрэгжүүлэх шатанд тухайн шатны Засаг дарга нарын захирамжуудаар төсөл нэг бүрээр батлаагүй байна. *Хавсралт 3*

- *Ерөнхий боловсролын сургуулиудын гал тогооны их засварын 1 багц ажлыг 21 ТАХ;*
- *Эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмжийн 1 багц ажлыг 18 ТАХ;*
- *Шинээр баригдах барилга байгууламж, авто зам, инженерийн шугам сүлжээний зураг төсөв, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ, мастер төлөвлөгөө боловсруулах 1 багц ажлыг 6 ТАХ болгосон байна.*

1.4. ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах” журмын 2.3.2.1⁹³-д орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнахаар тусгасан ч холбогдох шалгуур үзүүлэлт, маягт (*хавсралт 1*)-ын дагуу үнэлж эрэмбэлээгүй байна.

1.5. Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24⁹⁴-т “Төсвийн хөрөнгө оруулалт гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг хэлнэ” гэж тусгасан ч өмчид бүртгэх боломжгүй нийтийн орон сууцны дээвэр фасад засвар, цахилгаан шатны шинэчлэлт, хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 66.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 280 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тухайлбал: *Хавсралт 4*

- *УБ, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо, 61 дүгээр байрны фасадын засвар төсөвт өртөг 1.0 тэрбум төгрөг;*
- *УБ, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, их тойруу 81/1 дүгээр байрны гадна фасад засвар төсөвт өртөг 1.1 тэрбум төгрөг;*
- *УБ, Баянзүрх дүүрэг, Нийтийн зориулалттай цахилгаан шатыг шинэчлэлт, төсөвт өртөг 1.5 тэрбум төгрөг;*
- *УБ, Баянгол дүүрэг, дээврийн засвар багц 1-5, 9.5 тэрбум төгрөг;*

⁹⁰ 29.2.Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

⁹¹ 2.2.4.Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

⁹² 29.3.4.санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

⁹³ 2.3.2.1.орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;

⁹⁴ 4.1.24.“хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

- Баянхонгор аймаг 356.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 ТАХ /6 дугаар багийн 30 айлын байрны засварын ажил, 314,316 дугаар байрны дээврийн засварын ажил, 1 дүгээр багийн 128 дугаар байрны их засварын ажил/;
- Дорноговь аймаг, 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 ТАХ /нийтийн орон сууцуудын гадна фасад засварлах ажил/;
- Дундговь аймаг, Нийтийн орон сууцуудын давхар дундын цахилгаан шатны шинэчлэлт шийт солих.

1.6. Аймгуудад төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, өвсний нөөц бүрдүүлэх, улсын төсвийн байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах, амины орон сууц барих, бараа материал худалдан авах, үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах эрсдэлийг бий болгосон байна.

- Говь-Сүмбэр аймаг, аймгийн аюулгүй нөөцөд өвс тэжээл бэлтгэх, баяр наадамд шаардлагатай тоног төхөөрөмж болон зорилтод бүлгийн иргэдэд гэр худалдан авах зэрэг хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 356.0 сая төгрөгийн 7 ТАХ;
- Баян-Өлгий аймаг, "Монголд зочлох жил" хөтөлбөрт 61.5 сая төгрөг;
- Дорноговь аймаг, барилга байгууламжийг паспортжуулах, хөшөө дурсгалыг сэргээх, уурын зуух буулгах, Замын-үүд сумын нэгдсэн эмнэлэгт ур чадварын хэрэглэгдэхүүн худалдан авах, нийтийн эзэмшлийн зам талбайг, цэцэг, зүлэгжүүлэх зэрэг 1.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 20 ТАХ;
- Дорнод аймаг, төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, ахмадын байгууллагад хэрэгцээтэй компьютер, лабораторийн тоног төхөөрөмж зэрэг 597.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ;
- Орхон аймаг, Эрдэнэт хотын цахим түүх бүтээх, түүх дурсгалын ном гаргах зэрэг 7.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ;
- Дундговь аймаг, Дашгэнпиллэн хийдийн барилгын дотор завсар, нийтийн эзэмшлийн орон сууцуудын давхар дундын цахилгааны шийт солих, гэр төсөл, Мандалговь хотын сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх байр, хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр, сүү хөтөлбөр зэрэг 2.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ;
- Орхон аймаг, эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих, хөв цөөрмийн ажлыг дуусгах, уурхайчин багт чөлөөт бөхийн холбоонд дэвжээ худалдан авах, Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах;
- Өмнөговь аймаг, өвс тэжээлийн аюулгүй нөөц, Баян-Овоо сумын усан хангамжийн нөөц тогтоох, гидрогеологийн эрэл хайгуул хийх, малын халдваргүй өвчний болон ядарч доройтсон малын эм бэлдмэл нөөц бүрдүүлэх зэрэг 4.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 ТАХ;
- Сүхбаатар аймаг, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ гэр худалдан авах, гэр дулаалга төсөл, гэр хорооллын өрхүүдэд халаалт, дулаан, агаар сэлгэлтийн чил багц нийлүүлэх зэрэг;
- Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газарт газар уснаа явагч завь, авто тээврийн төвд зөөврийн пүү худалдан авах, улсын бүртгэлийн хэлтсийн шалны засвар, мөнгөн хараа чуулгад тоног төхөөрөмж зэрэг 946.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ТАХ;
- Төв аймгийн Цагдаагийн газрын техник, тоног төхөөрөмж худалдан авах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын бялдаржуулах танхимын тохижилт 573.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ;
- Хөвсгөл аймгийн Мөрөн сум, бараа материал ажил үйлчилгээний зардалд 140.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ.

1.7. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, магадлалаар баталгаажсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон ТАХ-г тусгана” гэж заасан ч барилга байгууламж, их засварын ангилалд хамаарах 700 ТАХ-ээс 49.7 хувь (348 ТАХ) нь зураг төсөвгүй байна. Хавсралт 5

- Баянхонгор аймгийн Баянбулаг сумын сургуулийн их засвар, Баацагаан сумын сургуулийн дотуур байрны их засвар;
- УБ, Сүхбаатар дүүрэг, 16 хороо Өрхийн эмнэлгийн барилга барих;
- УБ, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барих;

➤ УБ, Хан-Уул дүүрэг, 16 дугаар хороо, 7 дугаар сургуулийн барилгыг буулгаж өргөтгөлийн барилга барих.

1.8. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4⁹⁵-т төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй гэж заасан ч тайлант онд хэрэгжиж дуусах 27.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 ТАХ-ний гэрээг 2024 оны 10 дугаар сараас хойш байгуулсан байна.

➤ Булган аймгийн Баян-Агт сум, “0.4 кВТ цахилгаан дамжуулах шугамын ажил”, Хутаг-Өндөр сум, “Усан шүүлтүүртэй халаалтын тогоо шинэчлэх ажил”;

➤ “Улаанбаатар театр” ОНӨТҮГ-ын барилгын их засварын ажил, Чингэлтэй дүүргийн 32-ын тойргийн үйлчилгээний барилга, тохижилт ногоон байгууламжийн ажил.

1.9. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”-аар заасан ч 5 ТАХ-ний санхүүжилтийг 6-20 хувиар бага тооцсон байна.

➤ Баянгол дүүрэг, 24 дүгээр хороо Сургуулийн барилга, 960 суудал, төсөвт өртөг 18.0 тэрбум төгрөг, тухайн онд санхүүжих дүн 1.0 тэрбум төгрөг, нийт санхүүжих дүнгийн 6 хувь;

➤ Баянгол Нарны хорооллоос Нарны зам руу төмөр зам дээгүүр гарсан гүүрэн гарц 1.5 тэрбум төгрөг, тухайн онд санхүүжих дүн 300.0 сая төгрөг, нийт санхүүжих дүнгийн 20 хувь;

➤ Баянгол дүүрэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга, спорт заал, тохижилтын ажил төсөвт өртөг 2.7 тэрбум төгрөг тухайн онд санхүүжих дүн 200.0 сая төгрөг, нийт төсвийн 7.3 хувь;

➤ Хан-Уул дүүрэг, Хорооны цогцолбор барилга (16 дугаар хороо) төсөвт өртөг 2.0 тэрбум төгрөг, тухайн санхүүжих дүн 198.5 сая төгрөг, нийт төсвийн 9.9 хувь;

➤ Чингэлтэй дүүрэг, 39 дүгээр сургуулийн хос биеийн тамирын заал, усан бассейн бүхий спорт заалны барилгын ажил, төсөвт өртөг 7.4 тэрбум төгрөг, тухайн онд санхүүжих дүн, нийт санхүүжилтийн 14 хувь.

1.10. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.6⁹⁶-д “тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх”-аар заасан ч шинээр хэрэгжүүлэх 229.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний санхүүжих дүнг 0.37-143.5 тэрбум төгрөг, нийт 167.3 тэрбум төгрөгөөр бууруулж баталсан байна.

➤ Баянгол дүүрэг, 16 дугаар хороо Гандантэгчэнлин хийд, Сургуулийн барилга ажлын төсөвт өртгийг 622.4 сая төгрөг;

➤ Дорнод аймаг, төрийн тусгай болон хэрэгцээтэй мэргэжлээр ажиллаж байгаа албан хаагчдад гэрээгээр ашиглуулах 3 орон сууц худалдан авах төсөвт өртгийг 220.0 сая төгрөг;

➤ Дорнод аймаг, төрийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах төсөвт өртгийг 37.4 сая төгрөг;

➤ Дорнод аймаг, цагдаагийн албаны бэлэн байдлыг хангахад шаардлагатай авто машин худалдан авах төсөвт өртгийг 120.0 сая төгрөг;

➤ Дорнод аймаг, нутгийн удирдлагын байрны барилгын дотоод тохижилт, тоног төхөөрөмж худалдан авах төсөвт өртгийг 122.2 сая төгрөг;

➤ Дорноговь аймаг, Замын-Үүд суманд хэрэгжүүлсэн 6 ТАХ-ний санхүүжилт 194.5 сая төгрөг

➤ УБ, их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро”-г барих төслийн зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийг 143.5 тэрбум төгрөг;

➤ УБ, урт цагаан жуулчны гудамжны тохижилтын ажлын төсөвт өртгийг 24.6 тэрбум төгрөг.

1.11. Зураг төсөвгүй төсөл арга хэмжээг магадлалаар баталгаажуулахад 6 ТАХ-ний батлагдсан төсөвт өртөг нь 0.50-7.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

➤ УБ, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга 7.2 тэрбум төгрөг;

⁹⁵ 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

⁹⁶ 29.3.6. тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх.

- УБ, Баянзүрх дүүргийн 15 дугаар хороо, 122 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 2.1 тэрбум төгрөг;
- УБ, Баянзүрх дүүргийн 18 дугаар хороо, 129 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга 1.1 тэрбум төгрөг;
- Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 3-р сургуулийн баруун урд уулзвараас арван мянгатын бетон зам хүртэлх 1 км авто замын ажил 849.0 сая төгрөг;
- Говь-Сүмбэр аймаг, халуун усны барилгын ажил 150.0 сая төгрөг;
- Говь-Сүмбэр аймаг, худалдаачны гудамж тохижуулах ажил 50.0 сая төгрөг.

1.12. Дараах төсөл арга хэмжээний зураг төсөв магадлалаар баталгаажихад 2 ТАХ-ний батлагдсан төсөвт өртөг нь буурсан байна.

- УБ,Төвлөрсөн 3 хогийн цэгийн пүү, программ хангамжийн ажил, 421.2 сая төгрөг;
- УБ, 32-ын тойргийн үйлчилгээний барилга, тохижилт ногоон байгууламжийн ажил, 6.2 тэрбум төгрөг.

Шийдвэрлэлт: Аудитаар илэрсэн нийт 906.3 тэрбум төгрөгийн зөрчилд 20.2 тэрбум төгрөгийн 37 албан шаардлага, 886.1 тэрбум төгрөгийн 48 зөвлөмж хүргүүлсэн байна.

1.13 Тайлант онд нийслэлд үнэт цаас бондын эх үүсвэрээс санхүүжигдэх 325.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 2 багц ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

- Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт, зураг төсвийн ажил (Улаанбаатар хот) 290.6 тэрбум төгрөг;
- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төслийн инженерийн шугам сүлжээний ажил (Улаанбаатар хот) 34.8 тэрбум төгрөг.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХДАА ХУУЛЬ ЖУРМЫГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙГЭЭС ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮР НӨЛӨӨГ БУУРУУЛЖ БАЙНА

2.1. Орон нутгийн хэмжээнд шинэ болон шилжин хэрэгжих 8,539.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4188 ТАХ-ний ХАА-ны эрхийг холбогдох газруудад шилжүүлсэн байна.

2.2. Тайлант онд 3,133.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3708 ТАХ-ний ХАА-г амжилттай зохион байгуулж, 188.5 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

2.3 Харин 4,756.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 212 ТАХ-ний ХАА амжилтгүй болсон.

2.4. Зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй, эрх шилжүүлэх болон төсөвт тодотгол хийгдсэнтэй холбоотой хугацаа алдсан, хөрөнгө татагдсан зэрэг шалтгаанаар 649.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 268 ТАХ-ний ХАА зарлагдаагүй байна.

2.5. Нийт төсөл, арга хэмжээний 53.9 хувь нь нээлттэй тендер шалгаруулалт, 22.3 хувь нь харьцуулалтын аргаар, 23.2 хувь нь шууд худалдан авалт, 0.6 хувь нь бусад аргаар зохион байгуулсан байна.

2.6. Орон нутгийн хэмжээнд 66.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 55 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахдаа шаардлага хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3-т заасан “Тендер нь энэ хуулийн 27.1-д заасан бүх нөхцөлийг нэгэн зэрэг хангасан бол шаардлагад нийцсэн тендер гэж үзнэ” гэж заасантай нийцэхгүй байна. Тухайлбал: Хавсралт 6

- Архангай аймаг, Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн гал тогоо, эмэгтэй дотуур байрны их засварын ажлын гүйцэтгэгч нь санхүүгийн чадавх;
- Баянхонгор аймаг, Жаргалант сумын дотуур байрны засварын ажлын гүйцэтгэгч нь ижил төстэй ажлын шалгуур;
- Завхан аймаг, Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих ажлын гүйцэтгэгч нь ерөнхий шаардлага хангаагүй;
- УБ, “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”, боловсролын салбарын барилгын их засварын багц-6, ажлын гүйцэтгэгчид нь ижил төстэй ажлын шаардлагыг хангаагүй;
- УБ, Баянгол дүүргийн 2 дугаар хороонд 26-34 дүгээр байр, 27 дугаар хорооны 1-9 дүгээр байрны ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын гүйцэтгэгч нь хүний нөөцийн чадавхын шаардлага хангаагүй;
- УБ, Баянгол, Баянзүрх дүүргүүдийн тохижилт бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгчид нь түргэн хөрвөх чадварын шаардлага хангаагүй;
- УБ, Сүхбаатар дүүргийн 68-р цэцэрлэгийн хашаа шинэчлэх ажлын гүйцэтгэгч нь түргэн хөрвөх чадвар, хүний нөөц, санхүүгийн чадавхын хангаагүй;
- УБ, Хан-Уул дүүргийн зам цэвэрлэгээ арчилгаанд шаардлагатай авто машин механизм, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэгч нь ижил төстэй ажил гүйцэтгэх шаардлага хангаагүй.

2.7. Тайлант онд тендер сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбоотой нийт 273.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 226 ТАХ-нд гомдол гарч СЯ-нд хянагдсан байна.

2.8. Тендерийг хянан үзэх, дахин үнэлэхдээ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.3 дахь заалтуудад нийцээгүй шийдвэр гаргах тохиолдол гарч тендерт оролцогчдын эрх ашиг зөрчигдөх, маргаан үүсэх, шударга өрсөлдөөнийг хязгаарлах эрсдэлийг дагуулсан байна.

- Завхан аймаг, Нөмрөг суманд тохижилт үйлчилгээний ковш худалдан авах тендерт гүйцэтгэгчээр шалгарсан компанийг шаардлагад нийцээгүй гэж үзэн бусад оролцогчоос гаргасан гомдлыг СЯ хянан үзээд захиалагчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзсэн боловч дахин шалгаруулсан.

2.9. ТХТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.4⁹⁷ зөрчиж цахим дэлгүүрт байршсан бараа бүтээгдэхүүнийг бусад этгээдээс худалдан авсан байна.

⁹⁷ 14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.

- Баян-Өлгий аймгийн төсвийн 19 байгууллага 231.2 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг бусад ААН-ээс шууд худалдан авсан;
- Булган аймгийн Татварын газрын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, Булган сумын ЗДТГ хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл мэндийн үзлэгийн өрөөний тохижилт, тоног төхөөрөмж, түр хамгаалах байрны тоног төхөөрөмж зэргийг худалдан авсан.

2.10. Үнэлгээний хороо ТББ-г утга агуулгын хувьд оновчтой тодорхойлоогүйгээс хоёрдмол утга санаа үүссэн, баримт бичгийг боловсруулсан хэдий ч захиалагчаар батлуулаагүй, үйлдвэрлэгчийг заасан, ТББ-т шаардлагатай мэдээллийг бүрэн тусгаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1⁹⁸, 12.4⁹⁹-т заасанд нийцээгүй байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймгийн цэргийн штабт автомашин нийлүүлэх ТАХ-ний ХАА-г зарлахдаа автомашины нэр төрөл, үйлдвэрлэгчийг зааж зарласан;
- Дорноговь аймгийн Тагнуулын газарт автомашин худалдаж авах ТАХ-ний ТББ-ийн техникийн тодорхойлолтод машины төрөл, үйлдвэрлэсэн он, гүйлт болон бусад шаардлагатай нэмэлт үзүүлэлтүүдийг тусгаагүй;
- Хөвсгөл аймгийн ХАА-ны газар 35 ТББ-ийг боловсруулсан ч захиалагчаар батлуулаагүй;
- Өвөрхангай аймгийн зарим сумын төрийн байгууллагуудад дуудлагаар үйлчлэх автомашин худалдан авах 520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ТББ-ийн өгөгдлийн хүснэгтэд багц тус бүрийн төсөвт өртгийг бүрэн тусгаагүй байна.

2.11. Сэлэнгэ аймгийн ЗД болон Ерөө, Сүхбаатар, Түшиг, Хүдэр сумдын ЗД нар нь 16 ТАХ-ний ТББ-т гүйцэтгэлийн баталгааны дүн 160.8 сая төгрөгийг тусгаагүй нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 42 дугаар зүйлийн 42.2¹⁰⁰-т заасантай нийцэхгүй байна.

2.12. Дараах аймгуудын ХАА-ны газрууд тендерийн нээлттэй болон харьцуулалтын аргаас зайлсхийх зорилгоор 730.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 ТАХ-ний төсвийг хувааж, ажлын тоо хэмжээг багасгаж шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.5¹⁰¹, 10 дугаар зүйлийн 10.3.3¹⁰²-д заасантай тус тус нийцэхгүй байна. Тухайлбал:

- Говь-Сүмбэр аймаг 87.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тоног төхөөрөмж худалдан авах ТАХ-г 6 хувааж шууд худалдан авсан;
- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын төсөвт 4 байгууллагын хэрэгцээнд 76.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийтийн тээврийн автобус худалдан авах ТАХ-г 4 хувааж шууд худалдан авсан;
- Өвөрхангай аймгийн хөгжимт драмын театр 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй уран бүтээлчдийн хувцас шинэчлэх ТАХ-нд тендер зарлалгүй 7 иргэн, ААНБ-тай шууд гэрээ байгуулсан;
- Ховд аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 47.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийтийн эзэмшлийн орон сууц, гудамж, зам талбайн нөхөөс хийх ажлын гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулсан.

2.13. Завхан аймгийн Тэлмэн сумын ЗДТГ эрх шилжсэн зарим ТАХ-ний тендерийн гүйцэтгэгчийг шалгаруулахдаа үнэлгээний хороо байгуулаагүй, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөөгүй, Аймгийн ЗДТГ болон ХАА-ны газар нь үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр тухайн байгууллага болон түүний харьяа нэгжид ажил үүргийн хамаарал бүхий, шууд болон шууд бусаар харьяалагддаг албан тушаалтнуудыг томилсон нь “ТБОНӨХБАҮХАТ” хуулийн 50 дугаар зүйлийн 50.2.1¹⁰³, заалт, СС-ын 2023 оны А/254 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам”-ын 2.4-т заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэлт: Дээрх илэрсэн зөрчилд АНТАГ-аас 41.1 тэрбум төгрөгийн 8 албан шаардлага, 13.7 тэрбум төгрөгийн 33 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

⁹⁸ 12.1 Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана,

⁹⁹ 12.4 Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно,

¹⁰⁰ 42.2 Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана.

¹⁰¹ 8.5 Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

¹⁰² 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.

¹⁰³ 50.2.1.тендер шалгаруулалтын баримт бичиг, зарлал, урилга боловсруулах, тендер хүлээн авах;

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ, ХУДАЛДАН АВАЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ЯВЦАД ТАВИГДАХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙГАА НЬ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ УДААШРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА

3.1. Орон нутгийн хэмжээнд тайлант онд 3,703.1 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 5052 ТАХ хэрэгжихээс 66.8 хувь буюу 3375 ТАХ бүрэн хэрэгжсэн, 22.7 хувь буюу 1147 ТАХ хэрэгжих шатанд, 10.5 хувь буюу 530 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хүснэгт 2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, тэрбум төгрөг

№	Аймаг, нийслэлийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Хэрэгжиж дууссан ажил		Он дамжин хэрэгжиж байгаа		Хэрэгжээгүй	
					тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Архангай	53	7.1	6.7	47	4.5	3	2.3	3	-
2	Баян-Өлгий	193	10.5	9.6	170	7.8	13	1.8	10	0.0
3	Баянхонгор	53	10.0	7.3	41	5.9	5	1.3	7	0.0
4	Булган	47	5.5	4.7	35	4.2	1	0.3	11	0.2
5	Говь-Алтай	23	5.2	5.2	7	1.1	9	3.9	7	0.2
6	Говь-Сүмбэр	33	2.3	2.5	21	1.6	8	0.9	4	-
7	Дархан-Уул	230	46.4	20.1	144	12.0	16	3.3	70	4.9
8	Дорноговь	285	120.0	105.1	243	71.2	24	34.0	18	-
9	Дорнод	45	10.3	10.0	33	3.4	12	6.6	0	-
10	Дундговь	90	29.4	14.0	54	11.3	8	2.7	28	-
11	Завхан	100	13.8	13.4	92	12.0	6	1.3	2	0.1
12	Орхон	303	127.2	121.8	224	45.2	32	66.3	47	10.3
13	Өвөрхангай	49	4.6	4.0	36	2.6	5	1.4	8	-
14	Өмнөговь	818	1,223.8	621.1	575	347.8	147	273.3	96	0.0
15	Сүхбаатар	82	28.3	23.3	50	11.8	10	11.5	22	-
16	Сэлэнгэ	192	26.8	24.6	131	13.4	41	11.0	20	0.2
17	Төв	377	27.0	34.6	342	26.4	22	8.2	13	0.0
18	Увс	49	7.1	5.9	43	5.1	4	0.8	2	-
19	Ховд	230	40.6	26.3	148	15.3	28	6.9	54	4.2
20	Хөвсгөл	154	10.6	7.3	130	6.4	7	0.7	17	0.2
21	Хэнтий	36	16.1	15.6	32	14.7	3	0.8	1	-
22	Нийслэл	1610	2,757.7	2,619.7	777	616.1	743	1,959.7	90	43.8
НИЙТ		5052	4,530.3	3,703.1	3375	1,239.8	1147	2,399.1	530	64.2

3.2. Зарим ТАХ-ний зураг төсөв болон гүйцэтгэгч сонгон шалгаруулалт удааширсан, технологийн зогсолт хийсэн, захиалагч гэрээг тухай бүр дүгнээгүй зэрэг шалтгаанаар он дамжин хэрэгжихээр байна.

3.3. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй, магадлалын дүгнэлтгүй, худалдан авах ажиллагаанд оролцогчгүй, төсвийн тодотголоор санхүүжилт хасагдсан зэрэг шалтгаанаар зарим ТАХ хэрэгжээгүй байна.

Дүрслэл 2 Төсөл арга хэмжээний ангилал



3.4. TAX-г ангилбал, барилга байгууламжийн 1044 TAX буюу 20.7 хувь, дэд бүтцийг сайжруулах, зам, гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээний 471 TAX буюу 9.3 хувь, орчны тохижилт, ногоон байгууламжийн 1562 TAX буюу 30.9 хувь, техник, тоног төхөөрөмж, машин механизм авах 1219 TAX буюу 24.1 хувь, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах болон бусад 756 TAX буюу 15.0 хувийг эзэлж байна.

3.5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим барилга байгууламжийн зураг төсөвт тусгагдсан ажлыг бүрэн хийгээгүй, ажлыг чанартай гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн

хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

Архангай аймаг:

- Өлзийт сумын “ЕБС-ийн дотуур байр, спорт заалны их засвар”-ын ажил, хана таазнаас усны нэвчилт үүссэн, спорт заалны төв хаалгыг шинэчлээгүй, өлгүүр хувцас солих өрөөний дээврийг засварлаагүй;
- Хашаат сумын “Спорт заал, дотуур байрны их засвар”, дээвэр хэсэгт зай, завсар үүссэн, дусаал дусаж, хана таазанд нэвчилт үүссэн.

Баянхонгор аймаг:

- Баянбулаг сумын хуучин сургуулийн барилгын гадна фасадын ажил, гадна металл фасадын амлагааг завсар зай ихтэй хийсэн;
- Эрдэнэцогт сумын цагдаагийн барилгын засварын ажил, ашиглалтын шаардлага хангаагүй.

Булган аймаг:

- Хишиг-Өндөр сумын сургуулийн барилгын засварын ажлын төсөвт тусгагдсан ажлууд бүрэн хийгдээгүй.

Говь-Алтай аймаг:

- Бугат сумын төвд 0.3 км хатуу хучилттай авто замын ажлын төсөвт туссан явган хүний зам, тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч хийгдээгүй.

Говь-Сүмбэр аймаг:

- Биеийн тамир спортын газарт тоног төхөөрөмжийн хүндрүүлэгчийг нийлүүлээгүй;
- Халуун усны өрөөнүүдийн шалны налууг стандартын дагуу хийгээгүй.

Дархан-Уул аймаг:

- Хонгор сумын ЭМТ-ийн гадна талбайд савлуур саравчийг бүрэн хийгээгүй;
- Дархан сумын 1 дүгээр сургуулийн урлаг заалны засварын ажлыг чанартай гүйцэтгээгүй.

Дорноговь аймаг:

- Хатанбулаг сумын ЭМТ-ийн өргөтгөл болон 8 айлын орон сууц барих ажлыг чанартай гүйцэтгээгүй.
- Сайншанд сумын 1 дүгээр багт тоглоомын талбай барих ажлын төсөвт тусгагдсан резин хавтангаас 17.5м² дутуу хийгдсэн, 4 сандлыг суурилуулаагүй;

Дорнод аймаг:

- Чойбалсан сумын ЕБС-ийн спорт заалны барилгын засварын ажлыг чанартай гүйцэтгээгүй.

Завхан аймаг:

- Арц суурийн хилийн боомтод халуун усны барилга барих ажлын дотор заслын ажил дутуу, цэвэр бохир усны хоолой хийгдээгүй;
- Цагаанхайрхан сумын Агьт багт байрлах хөв цөөрмийг засварлах, машины зогсоол барих, мод тарих ажил бүрэн хийгдээгүй;
- Их-Уул сумын хоёрдугаар цэцэрлэгийн засварын ажлыг чанартай хийгээгүй.

Өвөрхангай аймаг:

- Төгрөг сумын ЕБС-ийн дотуур байрны дээврийн засвар, Гучин-Ус, Есөнзүйл сумдын төрийн албан хаагчдын байрны ажлыг чанартай хийгээгүй;

Өмнөговь аймаг:

- Гурвантэс, Цогтцэций сумдын нийтийн биеийн тамир, урлаг, соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах цэнгэлдэхийн дээврийн засварын ажлыг чанартай гүйцэтгээгүй;
- Даланзадгад сумын 1-р сургуулийн биеийн тамирын заалны барилгын гадна тохижилтын ажлыг бүрэн гүйцэтгээгүй, цэнгэлдэх хүрээлэнгийн их засвар, талбайн тохижилт, гадна зогсоолын ажлын гүйлтийн замыг ажлын зурагт тусгасны дагуу гүйцэтгээгүй;

Сүхбаатар аймаг:

- Онгон сумын ЭМТ-ийн засвар болон Уулбаян сумын биеийн тамирын заалны засварын ажлыг чанартай гүйцэтгээгүй;

Ховд аймаг:

- Жаргалант сумын автобус баазын хашаа будах ажил, эмэгтэйчүүдийн хөгжлийн төвийн засвар, 3*3 сагсан бөмбөг, гар бөмбөг, тоглоомын талбайн цогцолборын ажлуудыг чанартай гүйцэтгээгүй;
- Мөст сумын ЕБС-ийн 1 дүгээр байрны гадна засвар болон урлагийн заалны засвар ажлыг чанартай гүйцэтгээгүй, цэвэр усны шугам сүлжээний шинэчлэл ухаалаг тоолууржуулах ажлыг бүрэн нийлүүлээгүй.

Хөвсгөл аймаг:

- Музей, Номын сангийн байрны сантехникийн засварын ажлыг төсөвт тусгасны дагуу бүрэн хийгээгүй.

Нийслэл:

- Баянгол дүүргийн 24 дүгээр хороо, цэцэрлэгийн барилгын засвар, Баянзүрх дүүргийн 25 дугаар хороо, 34 дүгээр хорооны замын байгууламжийн ажил, Хан-уул дүүргийн спорт хорооны барилгын засвар, Чингэлтэй дүүргийн 149 дүгээр сургуулийн урд хийгдсэн авто зогсоол барих зэрэг ажлууд чанартай хийгдээгүй байна.
- УБ, Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө барих ажил, Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Цэцэрлэгийн барилга худалдаж авах ажил, Баянгол дүүргийн 73 болон Оюуны ундраа сургуулийн гал тогооны их засвар зэрэг ажлуудыг чанартай гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй.

3.6. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссоор өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй байхад хүлээн авсан, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй дараах төсөл, арга хэмжээ байна.

- Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын ЕБС-ын 1-р сургуулийн дотуур байрны засвар;
- Сүхбаатар аймгийн Онгон сумын эрүүл мэндийн төвийн засвар, Асгат сумын сургуулийн их засвар, Түмэнцогт сумын соёлын төвийн дээвэр.
- Ховд аймгийн Жаргалант сумын камерын хяналтын дэд төвийн байрны засвар;
- Хөвсгөл аймгийн Биеийн тамир, спортын газрын заалны их засвар, баяр наадмын талбайн хиймэл ногоон зүлэг, гүйлтийн зам засвар шинэчлэлт, Хатгал тосгоны ЕБС-ийн засвар.
- Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум, ЕБС-ийн их засвар, Биндэр сумын сургуулийн дотуур байрны засвар, Политехник коллежийн оюутны дотуур байрны барилгын хэсэгчилсэн засвар.
- Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 24 дүгээр цэцэрлэгт өргөтгөлийн барилгын засвар
- Дорнод аймгийн Чойбалсан сумын ЭМТ-ийн барилгын засвар.
- УБ, Баянгол дүүргийн 18 дугаар хороо, Түшиц хана засварлах ажил, хөгжлийн бэрхшээлтэй хүний налуу замыг стандарт, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй;
- УБ, Налайх дүүргийн 152 дугаар цэцэрлэгийн дэргэд Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө барих ажил, Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо, Цэцэрлэгийн барилга худалдаж авах ажил, Баянгол дүүргийн 73 болон Оюуны ундраа сургуулийн гал тогооны их засвар зэрэг ажлуудыг чанартай гүйцэтгээгүй, захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй;

3.7. Дээрх зөрчлүүд нь Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5¹⁰⁴, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.11¹⁰⁵, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны А/178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1¹⁰⁶, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 5.1.3¹⁰⁷-т заасан чиг үүргээ хяналт тавих үүрэг бүхий байгууллагууд болон ИТХ, ЗД нар бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэлт: Дээрх илэрсэн нийт 281.9 тэрбум төгрөгийн зөрчилд АНТАГ-аас 79.8 тэрбум төгрөгийн 38 албан шаардлага, 202.1 тэрбум төгрөгийн 19 зөвлөмжийг шалгадагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

¹⁰⁴ Барилгын асуудал эрхэлсэн төрийн болон нутгийн захиргааны байгууллага нь барилгын үйл ажиллагаанд холбогдох норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих замаар хувийн, нийтийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг хүлээнэ

¹⁰⁵ Захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй.

¹⁰⁶ Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай / цаашид захиалагч гэх/ гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина.

¹⁰⁷ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: барилгын ажлыг зураг төсөл, норм, нормативын баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэх;

БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТЭД 2,183.1 ТЭРБУМ ТӨГРӨГ БУЮУ 65.7 ХУВИЙГ ОЛГОЖ, 1,159.6 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНТЭЙ 2507 ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГАСАН БАЙНА

4.1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинэ болон шилжих 4922 ТАХ-нд тайлант онд 3,286.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 4137 ТАХ-нд 2,183.1 тэрбум төгрөг буюу 66.4 хувийн санхүүжилт олгосон.

Хүснэгт 3 ОНТХО-аар хэрэгжүүлсэн ТАХ-нд олгосон санхүүжилт, тэрбум төгрөг

№	Аймаг, нийслэл	2024 онд санхүүжих дүн		Тайлант онд олгосон санхүүжилт					
		Тоо	Мөнгөн дүн	Шинэ ТАХ		Шилжих ТАХ		Нийт	
				Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Архангай	53	5.6	47	4.3	3	0.8	50	5.1
2	Баянхонгор	53	4.8	42	3.5	2	0.1	44	3.6
3	Баян-Өлгий	185	9.4	151	7.7	9	0.4	160	8.1
4	Булган	44	5.0	32	3.4	4	0.3	36	3.7
5	Говь-Алтай	23	4.4	13	1.2	1	0.1	14	1.3
6	Говь-Сүмбэр	33	2.3	23	1.6	2	0.1	25	1.7
7	Дархан-Уул	230	21.2	127	13.5	76	4.4	203	17.9
8	Дорноговь	278	55.4	165	31.1	67	8.9	232	40.0
9	Дорнод	29	6.0	41	4.8	0	-	41	4.8
10	Дундговь	86	22.5	52	8.0	5	0.3	57	8.3
11	Завхан	92	12.7	97	10.5	2	0.5	99	11.1
12	Орхон	293	77.8	203	35.3	34	15.9	237	51.1
13	Өвөрхангай	41	4.1	35	2.5	4	0.1	39	2.6
14	Өмнөговь	780	581.1	493	299.9	199	214.2	692	514.1
15	Сүхбаатар	82	11.2	39	4.7	18	2.9	57	7.6
16	Сэлэнгэ	190	17.5	102	8.9	36	3.6	138	12.5
17	Төв	318	26.3	327	19.7	33	3.3	360	23.1
18	Увс	49	5.9	42	5.0	2	0.2	44	5.3
19	Ховд	170	21.2	148	14.5	26	3.0	174	17.6
20	Хөвсгөл	140	6.3	125	3.9	17	1.6	142	5.5
21	Хэнтий	36	8.7	19	4.1	15	4.1	34	8.2
Аймгийн дүн		3205	909.7	2323	488.2	555	264.9	2878	753.1
22	Нийслэл	1717	2,376.6	823	1,109.9	436	320.0	1259	1,429.9
НИЙТ		4922	3,286.4	3146	1,598.2	991	584.9	4137	2,183.1

4.2. Өмнөх оноос хэрэгжиж буй 1304 ТАХ-нд 785.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоос гүйцэтгэлээр 584.8 тэрбум төгрөг буюу 74.4 хувийг, шинээр хэрэгжих 3618 ТАХ-нд 2,500.6 тэрбум төгрөгийг олгохоос 1,598.2 тэрбум төгрөг буюу 63.9 хувийн санхүүжилтийг тус тус олгожээ.

4.3. Нийт олгосон санхүүжилтээс 25.4 тэрбум төгрөг буюу 1.2 хувийг нь техник хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал эзэлж байна.

4.4. Хэрэгжиж дуусаагүй ТАХ-ний үлдэгдэл, хэрэгжиж дууссан ТАХ-ний барьцаа хөрөнгө 55.8 тэрбум төгрөгийг төрийн сангийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулжээ.

4.5. Захиалагч байгууллагаас гэрээний үүргээ зөрчсөн 138 гүйцэтгэгчид 394.4 сая төгрөгийн алдангийг тооцсон байна. *Хавсралт 7*

4.6. ОНТХО-аар хэрэгжсэн төсөл арга, хэмжээнд дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

Гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй:

- Дорноговь аймаг, Улаанбадрах суманд төрийн албан хаагчийн 6 айлын орон сууцны барилга барих ажлын гүйцэтгэл 70 хувь гэж тайлагнасан байхад гүйцэтгэгчид 80 хувийн санхүүжилт 373.6 сая төгрөг олгосон;
- Сүхбаатар аймаг, “Боловсрол хорооллын хойд хэсгийн авто зам” төсөл арга хэмжээний замын хашлага байрлуулах ажлыг хийгээгүй байхад гүйцэтгэлийг баталгаажуулж, бодит гүйцэтгэлээс 50.7 сая төгрөг илүү олгосон;
- Баянхонгор аймаг, Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн барилгын дээврийн ажлын гүйцэтгэлд 42.4 сая төгрөг илүү олгосон;

- Орхон аймаг, гэр бүлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэлзүйн төв ажиллуулах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах ажлын гүйцэтгэгчид гэрээний үүргээ биелүүлээгүй байхад 40.0 сая төгрөг илүү олгосон;
- Орхон аймаг, Эрдэнэтэд үйлдвэрлэв төвийн барилгын зураг төсөл боловсруулах ТАХ-а хүчин төгөлдөр бус баримтад үндэслэн 0.8 сая төгрөг илүү олгосон;
- Архангай аймаг, 1 дүгээр сургуулийн дотор байрны халаалтын иж бүрэн засварын ажлын гүйцэтгэлд 0.3 сая төгрөгийг илүү олгосон;

Анхан шатны баримтын бүрдэлгүй шилжүүлсэн:

- Орхон аймаг, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөрт 6.4 сая төгрөг;
- Орхон аймаг, “Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүдээ хайртай хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зардалд 4.2 сая төгрөг;
- Орхон аймаг, хувийн хэвшлийн бяцхан одод цэцэрлэгт зуны улиралд чийрэгжүүлэлтийн бүлэг ажиллуулах зардалд 2.3 сая төгрөг;

Зориулалт бусаар зарцуулсан:

- Орхон аймаг, тэгш ой тохиож буй 5 суманд 100.0 сая төгрөг;
- Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 45 жилийн ойн арга хэмжээний зардалд 15.9 сая төгрөг;
- Орхон аймаг, Баян-Өндөр уул болон 7 бурхан одны тахилга хийх арга хэмжээний зардалд 0.2 сая төгрөг;

Техник хяналт, зураг төсвийн үнэ, зохиогчийн хяналтын зардалтай холбоотой:

- Булган аймаг, Булган сумын “Аймгийн нөөцийн тэжээлийн агуулахын засвар, тохижилт” ТАХ-ний захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардалд нийт зардал 2.4 сая төгрөгийг ААНБ-д шилжүүлсэн;
- Завхан аймаг, Тэс, Тэлмэн, Шилүүстэй, Баянтэс сумд, зураг төсөв хийх эрхгүй хувь хүн болон ААН-д 7.5 сая төгрөгийг зураг төсвийн үнэ шилжүүлсэн;

Чанарын баталгааны хугацаа дуусаагүй байхад санхүүжилт олгосон:

- Орхон аймаг, Номын өргөө бүхий цогцолбор барилга ТАХ-нд 150.0 сая төгрөг, Баян-Өндөр суманд хэрэгжих 3 ТАХ-нд 12.3 сая төгрөг;

Зах зээлийн үнэлгээнээс өндөр:

- Чингэлтэй дүүрэг, “ЧД ЗДТГ-ын албан хаагчдад шаардлагатай тоног төхөөрөмж авах ажил” ТАХ-нд 7.1 сая төгрөг;

Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан:

- Сэлэнгэ аймаг, он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан болон гэрээний хугацаанд ашиглалтад хүлээлгэж өгөөгүй ТАХ-ний санхүүжилт нийт 214.9 сая төгрөг;
- Архангай аймаг, 1 дүгээр сургуулийн дотор халаалтын иж бүрэн засвар, 13 дугаар цэцэрлэгийн барилгын их засварын ажлуудын хэмнэлт 8.1 сая төгрөг.

Шийдвэрлэлт: Дээрх илэрсэн нийт 5.5 тэрбум төгрөгийн зөрчилд АНТАГ-аас 323.6 сая төгрөгийн 11 төлбөрийн акт, 925.6 сая төгрөгийн 6 албан шаардлага, 122.6 сая төгрөгийн 4 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

4.7. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд 1,265.8 тэрбум төгрөгийн 3296 ТАХ-г ашиглалтад хүлээн авч 1,159.6 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 2507 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

Хүснэгт 4 Хөрөнгийн бүртгэлийн судалгаа, тэрбум төгрөг

№	Төсөл арга хэмжээний нэр	Ашиглалтад хүлээн авсан ТАХ		НББ-д тусгасан ТАХ		НББ-д тусгаагүй ТАХ	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	Архангай	44	3.3	42	2.9	2	0.4
2	Баянхонгор	40	5.4	25	3.2	15	2.7
3	Баян-Өлгий	168	7.8	163	7.7	5	0.1
4	Булган	32	4.2	20	2.5	12	1.5
5	Говь-Алтай	8	1.0	4	0.7	4	0.3
6	Говь-Сүмбэр	22	1.8	19	1.2	3	0.6
7	Дархан-Уул	73	1.5	41	2.6	13	1.2
8	Дорноговь	178	43.4	47	5.3	53	10.9
9	Дорнод	33	3.4	32	3.2	1	0.1

10	Дундговь	43	3.8	29	2.8	14	1.0
11	Завхан	46	7.3	26	2.8	6	1.4
12	Орхон	224	45.2	212	32.9	12	12.4
13	Өвөрхангай	38	3.0	36	2.9	2	0.1
14	Өмнөговь	573	352.6	536	335.5	37	17.1
15	Сүхбаатар	50	11.8	27	10.2	2	0.0
16	Сэлэнгэ	121	11.9	109	10.9	12	1.0
17	Төв	220	13.9	153	9.2	67	4.7
18	Увс	41	4.6	38	4.2	3	0.4
19	Ховд	81	12.2	70	7.6	11	4.6
20	Хөвсгөл	61	4.2	39	1.7	3	0.4
21	Хэнтий	32	14.6	32	14.6	0	-
Аймгийн дүн		2128	557.0	1700	464.5	277	61.1
22	Нийслэл	1168	708.8	807	695.1	361	13.7
НИЙТ		3296	1,265.8	2507	1,159.6	638	74.8

4.8. Харин 74.7 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 638 төсөл арга хэмжээг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Тухайлбал:

- Ховд аймагт хэрэгжсэн 4.6 тэрбум төгрөгийн 11 ТАХ;
- Завхан аймагт хэрэгжсэн 1.4 тэрбум төгрөгийн 6 ТАХ;
- Сэлэнгэ аймагт хэрэгжсэн 1.0 тэрбум төгрөгийн 12 ТАХ;
- Баянхонгор аймагт хэрэгжсэн 664.6 сая төгрөгийн 15 ТАХ;
- Архангай аймагт хэрэгжсэн 360.5 сая төгрөгийн 2 ТАХ;
- Дорнод аймагт хэрэгжсэн 145.4 сая төгрөгийн 1 ТАХ;
- Увс аймагт хэрэгжсэн 425.5 сая төгрөгийн 3 ТАХ;
- Баян-Өлгий аймаг 129.5 сая төгрөгийн 9 ТАХ;
- Булган аймаг, Хутаг-Өндөр сумын Эрүүл мэндийн төвийн засвар болон Сэлэнгэ сумын Усан сан, цэвэр усны шугамын шинэчлэлийн ажлын үргэлжлэл ТАХ-г бүртгэлд тусгаагүй;

4.9. Хөрөнгөд бүртгэгдээгүй зарим ТАХ-ний баримт бичгийн бүрдүүлбэр хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах, цаг хугацааны хувьд оройтож хэрэгжсэн, ажлын явц удааширсан зэргээс шалтгаалж бүртгэлд тусгаагүй байна.

4.10. Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 56.5 тэрбум төгрөгийн дүнтэй 189 ТАХ-г шууд зардлаар бүртгэсэн байна. Тухайлбал:

- Нийслэл, нийтийн зориулалттай орон сууцны фасадын засварын ажлын 31.3 тэрбум төгрөгийн 72 ТАХ.

Шийдвэрлэлт: Дээрх илэрсэн нийт 8.4 тэрбум төгрөгийн зөрчилд АНТАГ-аас, 4.9 тэрбум төгрөгийн 9 албан шаардлага, 3.5 төгрөгийн 4 зөвлөмжийг шалгагдагч байгууллагуудад хүргүүлсэн байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

- Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 29,670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30,591.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.
- Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан боловч тайлант жилийн төсвийн тухай хуулийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотойгоор төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилснөөс дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үр нөлөөг бууруулж, төсвийн тогтвортой байдлын зарчим алдагдаж байна.
- Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн бодлого, чиглэлийг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглүүлэн төлөвлөсөн боловч бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэн дүгнээгүй, үр нөлөөг тооцож, нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй уялдуулаагүй байна.
- Нэгдсэн төсвийн орлого 31,456.6 тэрбум төгрөг болж өмнөх оноос 29.0 хувиар өссөн боловч төлөвлөгөө 1.7 хувиар тасарч, эрдэс, баялгийн бүтээгдэхүүний экспортоос хамааралтай орлогод суурилсан төсвийн тэлэлт эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.
- Хамгийн өндөр татвар төлдөг 100 аж ахуй нэгжид уул уурхайн салбар давамгайлж, нэгдсэн төсвийн орлогын 35.3 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 75.3 хувь, гадаад худалдааны экспортын 86.6 хувийг эзэлж байгаа тул эдийн засгийн олон тулгуурт бүтэц бүхий, тогтвортой өсөлтийг хадгалах, уул уурхайн бус салбаруудын хөрөнгө оруулалтыг онилсон, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд татварын бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх бодлогыг баримталж, стратегийн болон үүсмэл ордыг хайгуул хийж, нөөц тогтоосон хэлбэрээс хамааран хувь эзэмших эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулан Үндэсний баялгийн сангийн орлогыг нэмэгдүүлээгүй, Ирээдүй өв сангийн хөрөнгийг мандатын дагуу удирдах тогтолцоо бүрдээгүй байна.
- Уул уурхайн биржийн зэсийн баяжмалын арилжааны зарлах суурь үнэ, хайлуулах, цэвэршүүлэх зардлын бенчмаркыг хатуу тогтоосноос худалдан авагчдын арилжаанд оролцох боломжийг хязгаарласан байна.
- Татварын байгууллагаас татварын бүрдүүлэлт, ногдуулалттай холбоотой зөрчил, гэрээ, бараа, ажил, үйлчилгээ, мөнгө угаасан байж болзошгүй нийт 7,319.5 тэрбум төгрөгийн гэмт хэргийн шинжтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн нь татварын нийт орлогын 26.7 хувьтай тэнцэж байна.
- Засгийн газраас баталсан жилийн төсвийн хязгаарыг баримтлахгүй төсвийн жилийн дундуур улс төрийн бодлогоор амлалтын шинжтэй болон хуульчлагдсан зардлыг нэмэгдүүлж, урсгал зардлыг тэлж, төлөвлөгдөөгүй, зориулалт бус арга хэмжээг санхүүжүүлж, төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.
- Бараа, үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардлын ангилалд үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрөөс бусад хөтөлбөр, арга хэмжээг багцлан төлөвлөж, эдийн засгийн ангиллаас гардаг зардлуудад зарцуулж, нийт дүнгээр тайлагнаж байгаа нь төсвийн зарцуулалтын ил тод, хариуцлагатай байдал, төсвийн сахилга батыг алдагдуулж байна.
- Тайлант онд 22 байгууллага, 594 төрийн албан хаагч нэмэгдсэн нь төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгох, үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах бодлоготой нийцэхгүй байна.

- Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа зарим УТҮГ, ТӨААТҮГ-ууд нь бусад төсөвт байгууллагуудтай ижил түвшний чиг үүргийг хэрэгжүүлдэг, төсвөөс санхүүждэг, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэггүй, үйл ажиллагааны орлого бүрдүүлдэггүй, Засгийн газраас баталсан цалингийн ангилал, шатлалыг баримтлахгүйгээр орон тоо, үндсэн цалинг нэмэгдүүлэн тогтоосон нь цалингийн нийт зардлыг өсгөхөд нөлөөлж байна.
- Төрийн албаны тухай хуульд үндэслэн Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон боловч дээд хэмжээний хязгаарыг зааж өгөөгүйгээс төсвийн захирагч нар батлагдсан цалингийн санд багтаан төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг харилцан адилгүй тогтоон олгож байна.
- ЗГХЭГ-ын даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарахгүй ажлын алба, хороо, зөвлөлүүдийн цалингийн сан, үйл ажиллагааны зардлын төсвийг баталсан нь төсвийн орлого, зарлагыг зүй зохистой удирдах, үр ашиггүй зардал гаргах, төсвийн зарцуулалтад тавих хяналт алдагдсан байна.
- Улсын төсвөөс олгож байгаа татаас, хөнгөлөлтийн үр нөлөөг үнэлээгүй, ил тод байдлыг хангаагүйгээс тухайн салбарын нийгэм, эдийн засгийн үр өгөөж тодорхойгүй байна.
- Зээл олгосон байгууллагууд зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлж байгаа эсэхэд хяналт тавиагүй, тодорхой арга хэмжээ авч ажиллаагүйгээс муу зээлдэгчдийн тоо өсөж, зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.
- Дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршоодын хохирогчдоос үүссэн авлага барагдуулах ажил зогсонги байдалтай, шүүхийн шийдвэрийн дагуу битүүмжилсэн хөрөнгийн чанар байдал алдагдаж, үнэ цэнэ буурч хохирогчдын хохирол барагдахгүй байх эрсдэлтэй байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн зорилтот түвшнийг хангахуйц төсөв батлагдсан боловч зарим хөтөлбөр, арга хэмжээ зорилтот түвшинд хүрээгүй, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийж үнэлээгүй байна.
- Орон нутгийн төсвийн төслийн төлөвлөлтийн бүх шат дамжлага хоорондын уялдаа холбоо хангалтгүй, бодитой төлөвлөөгүйгээс орон нутгийн зарлага өмнөх оноос 67.4 хувиар, орлогын өсөлтөөс 21.8 пунктээр нэмэгдсэн, төсвийн зарлагын тэлэлтийг бууруулах шаардлагатай байна.
- Засаг даргын үйл ажиллагааны урсгал зардлыг орон нутгийн зарим сан, хөтөлбөр, арга хэмжээ, ерөнхий данс, ангилагдаагүй дансаар дамжуулан зарцуулж байгаа нь төсвийн сахилга бат алдагдах эрсдэлийг үүсгэсэн байна.
- Нийгмийн даатгалын салбарын хууль, тогтоомжид сангийн чөлөөт үлдэгдлийг Монголбанкны үнэт цаас болон Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал байгаагаас зөвхөн Засгийн газрын 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаас худалдан авч, 3 жилийн хугацаанд нийт 55.0 тэрбум төгрөгийн хүүгийн өгөөж хүртэхээр байна.
- Даатгуулагч өөрөө хариуцах иргэдийн тоо буурсан, зарлагын өсөлт орлогын өсөлтөөс давсан, эрүүл мэндийн байгууллагуудад эмийн үнийн хөнгөлөлт, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлбөрийг бүрэн барагдуулж чадахгүй өрийн дарамтад орсон, үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй байна.
- Эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлд цахимаар тавих хяналт, сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.
- Өрийн бүтцийн 95.9 хувийг гадаад өр эзэлж байгаа нь санхүүгийн бие даасан байдалд сөргөөр нөлөөлөх тул эдийн засгийн өсөлтөд найдах бус, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, шинжилгээ, дата-суурьтай шийдвэр гаргалтаар өрийн стратегийг оновчтой болгох шаардлагатай байна.

- Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтын 239.4 тэрбум төгрөг буюу 9.9 хувийг эдийн засаг нийгмийн үр өгөөж багатай салбарт, 6 гадаад зээлийн төслийн үлдэгдэлд 10.2 тэрбум төгрөгийн хүүгийн зардал төлсөн боловч тайлант онд ашиглалт гараагүй байна.
- Гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжих төсөл арга хэмжээний бэлтгэл ажил хангаагүй, мөнгөн урсгалыг бодитой төлөвлөөгүйгээс НЗДТГ гадаад бонд гаргаж, ашиглалтгүйгээр 5.7 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагч нарын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын давсан орлогын зарцуулалт жил бүр нэмэгдэх хандлагатай байна.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон хуульд заасан байгууллагын төрөл, нэршлийн хувьд зөрүүтэй, төрийн өмчийн оролцоотой компаниуд санхүүгийн мэдээллээ ялгаатай байдлаар мэдээлж байгаа нь иргэд олон нийтийг мэдээллээр хангах, ил тод байх хуулийн зорилт, үр дүнг бууруулж байна.
- Өмнөх онд хийсэн аудитаар нийт 24 зөвлөмж хүргүүлснээс бүрэн хэрэгжүүлсэн 9, хэрэгжих шатандаа 6, зөвлөмж хэрэгжүүлээгүй 9, нийт зөвлөмж 54.3 хувийн хэрэгжилттэй байгаа нь төсвийн сахилга бат хангалтгүй байгааг харуулж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд 12820 хүүхдийн суудалтай 26 сургууль, 4470 хүүхдийн ортой 32 цэцэрлэг, 1200 ортой 11 дотуур байр буюу боловсролын салбарын 69 барилга байгууламж, 4080 хүний суудалтай соёлын төв, музей, номын сангийн 12 барилга, 2,000 ортой 24 эмнэлгийн барилга, инженерийн дэд бүтцийн 18, дэд станц болон цахилгаан хангамжийг сайжруулах 23 байгууламж, 202.4 км урт авто зам ашиглалтад оржээ.
- Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тухайн жилийн санхүүжилтийн гүйцэтгэл 62.7 хувь, тухайн онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт 69.0 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт оновчгүй, 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 74.4 хувь нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй, барилга байгууламжийн 52.8 хувь нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй ба Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй ажлуудыг төлөвлөж баталсан байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг дунд хугацаагаар төлөвлөхгүй байгаагаас шалтгаалан тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэлийг хангах ажил орхигдсон, бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөх тогтолцоо алдагдсан байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, урсгал зардал, Засгийн газрын тусгай сан, хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төрөл, төсөвт өртгийн ялгаа зааг, эрэмбэ, ач холбогдол тодорхойгүй байгаа нь хөрөнгө санхүүгийн нөөцийн оновчгүй хуваарилалт, үр дүнгүй зарцуулалтад хүргэж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийг үнэлэх, эрэмбэлэх аргачлал хуульд заасан шаардлагад нийцээгүй, ТЭЗҮ, тоног төхөөрөмж, их засварын ажлыг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага ач холбогдлоор үнэлж, эрэмбэлэх зохицуулалтгүй, норм норматив, ашиглалтын хугацааг харгалзан хуваарилах шалгуур үзүүлэлт тодорхойгүй байгаа нь хөрөнгө оруулалтын эрэмбэ алдагдах суурь шалтгаан болж байна.
- Худалдан авах ажиллагаанд гаргасан гомдлын шийдвэрийн мөрөөр тавих хяналт хангалтгүй, захиалагчийн хуульд нийцээгүй шийдвэрт тооцох хариуцлага сул байна.
- Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүйгээс барилга байгууламжийн ажилд бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгох, зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлэхгүйгээр хүлээн авах зөрчил давтагдсаар байна.
- Хэрэгжиж дууссан 2,164.2 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 1148 төсөл, арга хэмжээний 93.8 хувийг ашиглагч байгууллагын өмчид бүртгэсэн, 6.2 хувийг буюу 214.0 тэрбум төгрөгийн гэрээний дүнтэй 71 төсөл, арга хэмжээний үр дүнд үүссэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна.

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэх тоног төхөөрөмжийн үнэ, өртгийн урьдчилсан судалгаа хийх, судалгаанд үндэслэн төсөвт өртгийг, нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг харгалзан байршил, тоо хэмжээг төлөвлөх эрх зүйн зохицуулалтгүйгээс хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн зарим тоног төхөөрөмжийн ашиглалт хангалтгүй байна.
- ХХААХҮС, БОУАӨС-ын болон Боловсролын сайдын багцад төсвийн хөрөнгөд бүртгэх боломжгүй, хувийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төлөвлөж хэрэгжүүлснээс шалтгаалан иргэн, ААНБ-д үнэ төлбөргүй олгох, эзэмшүүлэх ашиглуулах эсвэл түрээсийн гэрээ байгуулах зэргээр Төрийн байгууллага аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд хүрсэн байна.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон хөгжлийн төлөвлөгөөтэй төсөл арга хэмжээний 95.4 хувь нь уялдсан байна.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг тусгасан нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа холбогдох хууль, тогтоомжийг бүрэн мөрдөөгүй байна.
- Төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих мэргэжлийн байгууллага, захиалагч, зохиогчийн хяналт хангалтгүйгээс ажлыг чанаргүй, дутуу гүйцэтгэх, чанар байдал нь алдагдах, ашиглалтын шаардлага хангахгүй байх нөхцөлийг үүсгэж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД ТОЛИЛУУЛАХ НЬ:

1. Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 29,670.8 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30,591.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа;
2. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагыг хангасан боловч, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор төсвийн хүрээний мэдэгдэлд дахин өөрчлөлт оруулж байгаа нь төсвийн тогтвортой байдлын зарчим алдагдаж байгаад анхаарал хандуулах;
3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлах зөрчил давтагдан гарч байгаа тул төсвийн төсөлд шаардлага хангаагүй арга хэмжээг санал хүргүүлсэн, өргөн барьсан, баталсан тохиолдолд хариуцлага тооцох эрх зүйн орчныг сайжруулах;
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар өмнө жилүүдэд Улсын Их Хуралд толилуулсан, Засгийн газарт зөвлөсөн асуудалд шинжилгээ хийж, улсын төсвийн хөрөнгө оруулалтыг дунд хугацаанд төлөвлөхгүй орхигдож буй тогтолцооны алдааг залруулах тодорхой шийдвэр гаргахыг толилуулж байна.

ЗӨВЛӨМЖ**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД-д:**

1. Төсвийн бодлого, чиглэлийг урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны явц, үр дүнг нэгдсэн байдлаар үнэлж, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн толилуулга, тодруулгад тусган тайлагнал болон хариуцлагын системийг хөгжүүлж, хяналт-шинжилгээний чанарыг дээшлүүлэх;
2. Үндэсний баялгийн сангийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх бодлогын хүрээнд улсын төсвийн оролцоотой болон оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд, түүний үүсмэл ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмших эсхүл ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр орлуулах боломжийг судалж, ашигтай хувилбарыг сонгон хуулийн этгээдүүдтэй хэлцэл хийж сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
3. Үндэсний баялгийн санд эх үүсвэр төвлөрүүлж, хөрөнгө оруулалт хийж эхэлсэнтэй холбоотойгоор Ирээдүйн өв сангийн хуульд заасан корпорац байгуулах, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх олгосон мандатыг боловсруулах бэлтгэл ажлыг эхлүүлж, хөрөнгө оруулалтын цэвэр орлогыг сангийн хөрөнгө оруулалтын өгөөжид суурилсан эрсдэлийн удирдлагатай уялдуулж, урт хугацаанд төсвийг тогтворжуулах бодлого боловсруулах;
4. Монгол Улсын төсвийн бодлогыг урт хугацааны тогтвортой өсөлт рүү чиглүүлж, сонгуулийн мөчлөгөөс үл хамаарах хариуцлагатай төсөвлөлт хэрэгжүүлж, урсгал зардлыг хязгаарлах бодлого баримталж, цаашид төсвийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээг хийж төсвийн зарлагын хуваарилалтыг оновчтой хийх;
5. Засгийн газрын байгууллагуудын бүтэц, чиг үүрэгт иж бүрэн шинжилгээ хийж, давхардал болон хийдлийг арилгаж, бүтэц зохион байгуулалтыг цомхон, оновчтой болгох, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;
6. Төсөвт байгууллагуудтай ижил түвшний чиг үүргийг хэрэгжүүлдэг, төсвөөс санхүүждэг, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэггүй, үйл ажиллагааны орлого бүрдүүлдэггүй зарим улсын төсөвт үйлдвэрийн газруудын цалингийн хэмжээг бусад төсвийн байгууллагуудын нэгэн адил Засгийн газраас баталсан албан тушаалын цалингийн ангилал, шатлалыг мөрдүүлэх;

7. Төрийн албаны тухай хууль болон Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулан төрийн үйлчилгээний албан тушаалын үндсэн цалингийн дээд хэмжээ хязгаарыг тогтоож, төсвийн сахилга батыг дээшлүүлэх;
8. Улсын төсвөөс олгосон татаас, хөнгөлөлтийн үр нөлөөг үнэлж, тухайн салбарт үзүүлсэн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг тодорхойлж, татаас хөнгөлөлтийг үе шаттайгаар бууруулах бодлогыг баримталж төсвийн ачааллыг багасгах;
9. Олон жил дамнасан эргэн төлөлт хийгдээгүй зээл, дампуурсан банк, хадгаламж зээлийн хоршооны хохирогчдоос үүссэн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлж холбогдох хууль, тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх, хууль, шүүхийн байгууллагаар эцэслэн шийдвэрлэсэн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж, хэлэлцэн баталгаажуулах;
10. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг мөнгөн хадгаламж хэлбэрээр санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад тулгарч байгаа асуудлыг салбарын хууль, тогтоомж, журам заавартай нийцүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;
11. Эрүүл мэндийн даатгалын санд үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Эрүүл мэндийн даатгалын тогтолцоонд бодлогын шинэчлэл хийх;
12. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал зардал, тусгай сан, орон нутгийн төсөв, хөгжлийн сангийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээг төсөвт өртөг, зориулалт, нэр төрөл, хамрах хүрээ зэргээр нарийвчлан тодорхойлж зааглах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж хэрэгжүүлэх;
13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хүлээн авах үе шат бүрд хийх хяналтын давтамж, шалгуурыг тодорхойлж, хяналт хариуцлагын системийн эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
14. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас эрх шилжүүлэн хэрэгжүүлэх, багцад задлах төсөл, арга хэмжээний цар хүрээ, нэр төрөл, зориулалтын шалгуурыг бий болгож эрх зүйн зохицуулалтаар хангах;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД-д:

1. Эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлсэн эрдэс, баялгийн үнэд суурилсан орлогын огцом өсөлтөөс зайлсхийж, төсвийн тогтвортой байдлыг хадгалах, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох үзэл баримтлалыг жил бүрийн төсвийн урт, дунд хугацааны бодлогод тодорхойлж, хэрэгжүүлэх;
2. Тухайн жилийн улсын хөгжлийн төлөвлөгөө, төсөвт баримталсан бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг үнэлж, хэрэгжилтийг тайлагнах;

САНГИЙН САЙД-д:

1. Төсвийн бодлогыг хэрэгжүүлэхдээ хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой, хэмжигдэхүйц байдлаар төлөвлөж, хэрэгжилт болон үр дүнг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан тайлагнах, төсвийн үр ашиг, хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлэх;
2. Төсвийн төлөвлөлтийг төсвийн хязгаарт нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг хянаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулахад төсөв захирагчдын санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулахад анхаарч, оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх;
3. Бараа, үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж зэрэг зардлуудыг хэт ерөнхий багцалсныг нарийвчилж, үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгэн адил баталсан эдийн засгийн ангиллаар хуваарилан төлөвлөж, зарцуулалтын ил тод хариуцлагатай байдлыг сайжруулах;
4. Төсвийн орлогод баримталж буй татварын бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн төвлөрлийг сааруулах, уул уурхайн бус салбаруудын хөрөнгө оруулалтыг татах замаар эрдэс баялгийн экспортын мөчлөг дагасан орлого төлөвлөлт, бүрдүүлэлтийн хамаарлыг бууруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

5. Төсвийн төслийн саналыг боловсруулах, төсвийн суурийг хянах, батлах явцад холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчидтай хамтран ажиллах тогтолцоог сайжруулах;
6. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын төсөвт эрхлэх асуудлын хүрээнд нь хамаарахгүй хороо, зөвлөл, ажлын албаны зардлыг төлөвлөж, санхүүжүүлэхгүй байх;
7. Орон нутгийн зарим сан, ерөнхий данс, ангилагдаагүй данс, хөтөлбөр арга хэмжээний нэр, зориулалт ангиллыг хуульд нийцүүлэн тодорхой болгож, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад мөрдүүлэх, хяналт, удирдлагын нэгдсэн бодлогоор хангах;
8. Өрийн бүтцийг хянаж, гадаад өрийн эзлэх хувийг бууруулж, дотоодын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын арга хэмжээ авах;
9. Гадаад зээлээр санхүүжиж байгаа төсөл хөтөлбөрийн мөнгөн урсгалыг бодитой төлөвлөж, зээлийн ашиглалт, өрийн менежментийг сайжруулах;
10. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг бодитой тооцож, төсөвт тусгуулах;
11. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас болон хуульд заасан байгууллагын төрөл, нэршлийн хувьд зөрүүтэй, мэдээллийг ялгаатай, харилцан адилгүй мэдээлдэг байдлыг арилгаж, шилэн дансны хуульд нийцүүлэн журам болон цахим системийг уялдуулах, иргэд олон нийт хэрэглэхэд ойлгомжтой, ил тод байх боломжийг бүрдүүлэх;
12. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх, зарцуулах зарчмыг баримталж, хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагыг тооцож төлөвлөх, төсөвт өртгийн урьдчилсан судалгаа хийх, тендер шалгаруулалтад үнэ өртгийн судалгааг ашиглах заавар, журмыг боловсруулах, батлуулах;
13. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх журам, холбогдох аргачлалуудад өөрчлөлт оруулах, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ ангиллын төсөл, арга хэмжээг үнэлэх, эрэмбэлэх заавар журам боловсруулж, батлуулах;
14. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд нэгдсэн удирдамжаар дотоод аудит хийж хяналт хариуцлагыг сайжруулах арга хэмжээ авч үр дүнг тайлагнах;
15. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан, хэрэгжиж байгаа, өмнөх онуудад эхлүүлсэн боловч хэрэгжиж дуусаагүй зогссон барилга байгууламжийн дэлгэрэнгүй мэдээлэл, судалгааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд бүртгэн хэрэгжилтийг хангуулах тогтолцоог бүрдүүлэх;

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД-д:

1. Уул уурхайн биржийн зэсийн баяжмалын арилжааны зарлах суурь үнийг олон улсын биржийн зарласан катодын цэвэр зэсийн өдөр тутмын албан ёсны үнээр, хайлуулах, цэвэршүүлэх зардлын дундаж үнийг зах зээлийн зарчмын дагуу тодорхойлох, зохицуулах тогтолцоог бий болгох;

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД-д:

1. Татварын байгууллагаас хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн мөнгө угаасан байж болзошгүй, татварын бүрдүүлэлт ногдуулалттай холбоотой гэмт хэргийн шинжтэй хэргүүдийг шийдвэрлэх ажиллагааны хууль эрх зүйн орчныг сайжруулах;

МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА-д:

1. Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын чиг үүргийн хүрээнд тухайн жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, хэрэгжилтийг нэгтгэн, үр дүнг хянаж, Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрсэн үр дүнг тодорхойлсон чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд жил бүр тогтмол хяналт шинжилгээ хийж, үнэлж, тайлагнах;


ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА-д

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн www.health.gov.mn цахим программын хөгжүүлэлтийг сайжруулж, хяналт хэрэгжүүлж байгаа мэргэжилтний хамаарлыг хязгаарлаж, хяналтыг бүрэн цахимжуулах;

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРТ:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ирэх онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг дунд хугацаагаар төлөвлөж, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төсөвлөлтийн шаардлагыг өмнөх онд хангуулахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
2. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг сайжруулж эрх шилжүүлэн хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний нэгдсэн судалгаа мэдээллийг нэгтгэх, сайдын багцын хүрээнд төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэл, бүртгэл хэлбэрээр төсвийн жилийн эцсийн байдлаар бэлтгэж гүйцэтгэлээр баталгаажуулдаг тогтолцоог бий болгох;
3. Орон нутгийн 2026 оны төсөвт төсөвлөлтийн шаардлага хангаагүй буюу төсөвт өртгийг тойм дүнгээр баталж хэрэгжүүлсэн, зураг төсөл, төсвийг магадлалаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт болон захиалагчийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж, үр дүнг тооцож ажиллах;
4. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авалт, гүйцэтгэл, санхүүжилтийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, заавар, аргачлалыг чанд мөрдөж ажиллах.

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2025 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн
А/157 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТААР ТОГТООСОН ТӨЛБӨРИЙН АКТ, ХҮРГҮҮЛСЭН
АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

Д/д	Хариуцагч байгууллага	Гаргасан шийдэл	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төгрөг/
1	Ховд аймгийн Засаг дарга	Төлбөрийн акт	ССАЖЗС-ын багцаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчин 286.8 сая төгрөгийн 79 ширхэг караокены төхөөрөмж худалдан авсан.	286.8
2	Боловсролын яам	Албан шаардлага	Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй, барилгуудыг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулаагүй, ХАА-ны төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь үнэн зөв тайлагнаагүй.	39,071.3
3	Онцгой байдлын ерөнхий газар	Албан шаардлага	Тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулсан.	618.7
4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Албан шаардлага	ХХААХҮЯ-ын багцын 54 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдуулаагүй.	108,393.5
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Албан шаардлага	Тендер шалгаруулалтын баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулаагүй.	988.9
6	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Албан шаардлага	"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	60,535.4
7	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Албан шаардлага	"Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	-
8	Зам тээврийн яам	Албан шаардлага	Төсөл, арга хэмжээний хооронд төсвийн багц дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийснээр үүссэн 12.6 тэрбум, тендер шалгаруулалтын хэмнэлт 5.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх.	18,030.4
9	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Албан шаардлага	"Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийх нийцлийн аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай нотлох баримтыг хугацаанд нь ирүүлээгүй. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд худалдан авсан 257.6 сая төгрөгийн 10 төрлийн тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөөгүй.	-
10	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Албан шаардлага	ССАЖЗЯ-ын багцын 55 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдуулаагүй, 15 төсөл, арга хэмжээг эрэмбэлэхдээ "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх	183,181.2

			төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал"-д нийцүүлээгүй, батлагдсан зураг төсөвгүй 5, төсөвлөлтийн шаардлага хангаагүй 7 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн.	
11	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам	Албан шаардлага	"Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолтод нийцээгүй"	622.1
12	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Албан шаардлага	"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн үнийн урьдчилсан судалгааг хийгээгүй, үнэлгээний хороо тоног төхөөрөмжийн бодит үнийг харгалзан үзээгүй гэрээ байгуулсан, Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комисс бүрэн дуусаагүй ажлыг хүлээн авч дүгнэлт гаргасан, хийгээгүй ажилд санхүүжилт олгосон."	89,305.9
13	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	Албан шаардлага	ХББОСС-ын багцад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 25 төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөтэй уялдаагүй, 30.0 тэрбумаас дээш төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдуулаагүй	63,177.5
14	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Албан шаардлага	Тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлага хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулсан. Тендер шалгаруулалтын баримт бичгийг хууль, журамд нийцүүлэн боловсруулаагүй.	8,190.9
15	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	Албан шаардлага	Барилга угсралтын ажлын зураг төсөлд орсон өөрчлөлтийг баталгаажуулаагүй, захиалагчийн хяналтыг үр дүнтэй гүйцэтгээгүй.	-
16	Эрүүл мэндийн яам	Албан шаардлага	ЭМС-ын багцын 30 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулаагүй, 4 төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй, 29 төсөл, арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээг 2024 оны 9-12 дугаар сард байгуулсан, 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслээгүй.	12,001.7
17	Эрчим хүчний яам	Албан шаардлага	ЭХС-ын багцын 1 төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй, 4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо бодит гүйцэтгэлд үндэслээгүй.	6,504.1
НИЙТ ДҮН				590,908.4

Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Хавсралт 1.

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн		Улсын		О Нугаг		ЭМДС		НДС		ҮБС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,991.1	31,456.6	20,652.3	20,533.0	7,483.9	7,121.8	1,964.8	1,921.7	5,893.3	5,609.7	1,288.5	1,341.9
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	478.6	443.9	478.6	443.9	-	-	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	789.0	841.3	-	-	-	-	-	-	-	-	789.0	841.3
ХҮРИМТЛАЛЫН САН	499.5	500.6	-	-	-	-	-	-	-	-	499.5	500.6
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30,224.0	29,670.8	20,173.7	20,089.1	7,483.9	7,121.8	1,964.8	1,921.7	5,893.3	5,609.7	-	-
1 Татварын орлого	27,910.6	27,417.3	16,917.9	17,033.1	5,955.4	5,652.4	1,964.8	1,921.7	4,718.3	4,434.7	-	-
1.1. Орлогын албан татвар	8,620.6	8,970.6	3,781.3	4,307.6	4,839.3	4,663.0	-	-	-	-	-	-
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	2,550.8	2,630.4	-	-	2,550.8	2,630.4	-	-	-	-	-	-
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	6,149.0	6,419.1	3,781.3	4,307.6	2,367.7	2,111.5	-	-	-	-	-	-
1.1.3. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татвар	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	(79.2)	(78.9)	-	-	(79.2)	(78.9)	-	-	-	-	-	-
1.3. Хөрөнгийн албан татвар	5,037.3	4,731.8	-	-	-	-	1,964.8	1,921.7	4,718.3	4,434.7	-	-
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	455.2	459.4	-	-	455.2	459.4	-	-	-	-	-	-
1.5. Онцгой албан татвар	6,220.2	5,866.8	6,220.2	5,866.8	-	-	-	-	-	-	-	-
1.6. Тусгай зориулалтын орлого	968.0	1,107.4	968.0	1,107.4	-	-	-	-	-	-	-	-
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	28.0	26.4	28.0	26.4	-	-	-	-	-	-	-	-
1.8. Бусад татвар (гөлбөр, хураамж)	1,932.5	1,792.3	1,932.5	1,792.3	-	-	-	-	-	-	-	-
2 Татварын бус орлого	4,648.8	4,462.6	3,987.9	3,932.6	660.9	530.0	-	-	-	-	-	-
2.1. Нийтлэг татварын бус орлого	2,313.4	2,253.5	3,255.8	3,056.0	1,528.5	1,469.4	-	-	1,175.0	1,175.0	-	-
2.2. Хөрөнгийн орлого	1,719.6	1,778.5	1,098.4	1,178.5	621.2	600.0	-	-	-	-	-	-
2.3. Тусламжийн орлого	16.1	6.3	-	-	16.1	6.3	-	-	-	-	-	-
2.4. Төсөв хоорондын шилжүүлэг	577.7	468.7	562.1	461.6	19.7	11.2	-	-	1,175.0	1,175.0	-	-

Хавсралт 2.

Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС		ҮБС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,595.3	30,591.1	22,677.8	21,372.4	9,239.7	7,258.6	1,848.2	1,926.9	5,121.2	5,104.7	-	-
А. УРСГАЛ ЗАРЛАГА	23,106.1	22,176.6	16,475.0	15,965.0	4,801.1	4,244.6	1,933.2	1,931.3	5,188.4	5,107.2	-	-
1 Бараа, үйлчилгээний зардал	10,132.1	9,556.9	8,057.7	7,781.6	2,569.8	2,251.2	69.6	68.3	1.1	0.8	-	-
1.1. Далйн, хөлс	5,516.8	5,368.5	4,839.7	4,739.4	688.4	620.5	8.7	8.6	-	-	-	-
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	-	-	481.1	468.6	83.9	75.3	1.1	1.1	-	-	-	-
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	4,615.3	4,188.4	2,736.9	2,573.6	1,817.5	1,555.4	59.8	58.6	1.1	0.8	-	-
2 Хүү	1,246.1	1,235.9	1,173.6	1,165.9	72.5	70.0	-	-	-	-	-	-
3 Татаас ба урсгал шилжүүлэг	11,727.9	11,383.8	7,243.7	7,017.5	2,158.8	1,923.4	1,863.6	1,863.0	5,187.3	5,106.4	-	-
3.1. Татаас	1,022.0	954.5	1,841.1	1,776.1	355.9	353.4	-	-	-	-	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	10,705.9	10,429.3	5,402.6	5,241.4	1,802.9	1,570.0	1,863.6	1,863.0	5,187.3	5,106.4	-	-
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,379.3	7,970.8	6,099.7	5,082.1	4,279.6	2,888.7	-	-	-	-	-	-
1 Барилга байгууламж	6,844.3	5,355.4	5,015.6	4,101.3	1,828.7	1,254.1	-	-	-	-	-	-
2 Их засвар	642.3	314.7	84.5	77.6	557.8	237.1	-	-	-	-	-	-
3 Хөрөнгийн бусад зардал	2,892.7	2,300.7	999.6	903.2	1,893.1	1,397.5	-	-	-	-	-	-
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	109.9	443.7	103.1	325.3	159.0	125.3	(85.0)	(4.4)	(67.2)	(2.5)	-	-
1 Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	(350.1)	(15.1)	(356.9)	(133.5)	159.0	125.3	(85.0)	(4.4)	(67.2)	(2.5)	-	-
2 Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	460.0	458.8	460.0	458.8	-	-	-	-	-	-	-	-

Хавсралт 3.

Нэгдсэн төсвийн тэнцэл

Үзүүлэлт	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС		ҮБС	
	Төл		Гүй		Төл		Гүй		Төл		Төл	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31,991.1	31,456.6	20,652.3	20,533.0	7,483.9	7,121.8	1,964.8	1,921.7	5,893.3	5,609.7	1,288.5	1,341.9
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	478.6	443.9	478.6	443.9	-	-	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	789.0	841.3	-	-	-	-	-	-	-	-	789.0	841.3
ХУРИМТЛАЛЫН САН	499.5	500.6	-	-	-	-	-	-	-	-	499.5	500.6
НИЙТ ТЭНЦЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	30,224.0	29,670.8	20,173.7	20,089.1	7,483.9	7,121.8	1,964.8	1,921.7	5,893.3	5,609.7	-	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,595.3	30,591.1	22,677.8	21,372.4	9,239.7	7,258.6	1,848.2	1,926.9	5,121.2	5,104.7	-	-
СУУРЬ ТЭНЦЭЛ	(3,371.3)	(920.3)	(2,504.1)	(1,283.3)	(1,755.8)	(136.8)	116.6	(5.2)	772.1	505.0	-	-
ТЭНЦЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	3,371.3	920.3	2,504.1	1,283.3	1,755.8	136.8	(116.6)	5.2	(772.1)	(505.0)	-	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:	742.5	(10.9)	387.1	862.8	1,244.0	(373.9)	(116.6)	5.2	(772.1)	(505.0)	-	-
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,307.6	(226.6)	797.8	(736.4)	509.8	509.8	-	-	-	-	-	-
3. ЭГ-ын бонд	1,307.6	(226.6)	797.8	(736.4)	509.8	509.8	-	-	-	-	-	-
3.1. Урт хугацаат	1,880.6	672.3	1,370.8	162.5	509.8	509.8	-	-	-	-	-	-
3.1.1. Дотоод	2,018.1	809.8	1,508.3	300.0	509.8	509.8	-	-	-	-	-	-
3.1.1.1. Шинээр гаргах	(137.5)	(137.5)	(137.5)	(137.5)	-	-	-	-	-	-	-	-
3.1.1.2. Үндсэн төлбөр	(573.0)	(898.9)	(573.0)	(898.9)	-	-	-	-	-	-	-	-
3.1.2. Гадаад	(573.0)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.1.2.1. Шинээр гаргах	(573.0)	(898.9)	(573.0)	(898.9)	-	-	-	-	-	-	-	-
3.1.2.2. Үндсэн төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2. Богино хугацаат	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1. Дотоод	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1.1. Шинээр гаргах	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
3.2.1.2. Үндсэн төлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4. ЭГ-ын зээл	1,319.2	1,156.7	1,319.2	1,156.7	-	-	-	-	-	-	-	-
4.1. Дотоод	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.1.2. Авлага	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.1.2.3. Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4.2. Гадаад	1,319.2	1,156.7	1,319.2	1,156.7	-	-	-	-	-	-	-	-
4.2.1. Төслийн зээл	1,518.5	1,307.8	1,518.5	1,307.8	-	-	-	-	-	-	-	-
4.2.1.1. Шинээр авах	2,209.0	2,047.6	2,209.0	2,047.6	-	-	-	-	-	-	-	-
4.2.1.2. Үндсэн төлбөр	(690.5)	(739.8)	(690.5)	(739.8)	-	-	-	-	-	-	-	-
4.2.2. Хөтөлбөр болон төслийн бус зээл	(199.3)	(151.1)	(199.3)	(151.1)	-	-	-	-	-	-	-	-
4.2.2.1. Шинээр авах	340.0	342.0	340.0	342.0	-	-	-	-	-	-	-	-
4.2.2.2. Үндсэн төлбөр	(539.3)	(493.1)	(539.3)	(493.1)	-	-	-	-	-	-	-	-
7. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
9. Өмч хувьчлал	2.0	1.1	-	0.2	2.0	0.9	-	-	-	-	-	-
10. НДС-ийн арилжааны банкнаас авах шилжүүлэг	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

/тэрбум төгрөг/

Хавсралт 4:

Хяналтын багц дахь 17 байгууллагын системийн цэсийн харьцуулалт

Байгууллагын нэр	Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт				Бусад						
	4.2.1 тайл ан	4.2.1 төлөв 108	4.2.2 109	4.2.4 110	4.1.13 111	4.1.14 112	4.1.15 113	4.1.16 114	4.2.3 115	4.2.5 116	4.2.6 117
Тавантолгой ХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
Шинэ мөрөн худалдааны төв	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
Хөтөл энерги дулаан ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
Багануур ХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
МП групп ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
Авто-Импекс	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
Шивээхүрэн ТЗ ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
Монгол Шуудан ХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
МХС ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
МЦХ	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
Гүний-Ус	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
МЗХНН УБТЗ	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
Багануур сувилал ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм
Багануур Илч ХХК	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм
Хөдөөгийн шийдэл	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм
Төрийн банк	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм

*Тайлбар: Хяналтын багц дахь 17 байгууллагын ШДНЦХ-д мэдээлэх цэстэй нь тийм, цэсгүй нь үгүй

¹⁰⁸ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг энэ журмын 21 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, жилийн тайланг мөн журмын 22 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор тус тус цахимаар;

¹⁰⁹ хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар;

¹¹⁰ концессын мэдээллийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 15 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;

¹¹¹ аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар;

¹¹² тухайн байгууллага хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;

¹¹³ худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн гарснаас хойш 7 хоногийн дотор PDF форматаар;

¹¹⁴ байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн сарын тайланг энэ журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу дараа сарын 8-ны дотор цахимаар;

¹¹⁵ зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдөр нь зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн баримтад заасан маягтын дагуу PDF форматаар;

¹¹⁶ их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээллийг батлагдсанаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 18 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар;

¹¹⁷ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг тухай бүр PDF форматаар

Хавсралт 5:

Монгол Улсын 2024 оны макро эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 он	2022 он	2023 он	2024 он
МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ					
Нэрлэсэн ДНБ	тэрбум төгрөг	43,555.0	53,851.0	70,441.5	79,956.3
уул уурхайн	тэрбум төгрөг	10,753.0	12,402.0	19,814.1	21,802.1
уул уурхайн бус	тэрбум төгрөг	32,801.0	41,449.0	50,627.5	58,154.2
Нэрлэсэн ДНБ-ийн өсөлт	хувь	16.3	23.6	30.8	13.5
Бодит ДНБ, (2015 оны үнээр)	тэрбум төгрөг	27,091.0	28,455.0	30,567.1	32,053.9
Эдийн засгийн өсөлт, хувь	хувь	1.6	5.0	7.4	4.9
уул уурхайн	хувь	0.8	(15.3)	23.4	10.8
уул уурхайн бус	хувь	1.8	8.2	5.4	4.0
Дефляторын өөрчлөлт	хувь	14.4	17.7	21.8	8.2
Инфляц /жилийн түвшин/	хувь	13.8	13.2	7.9	9.0
Мөнгөний нийлүүлэлт M2	тэрбум төгрөг	27,863.5	29,664.8	37,624.1	43,334.0
Мөнгөний нийлүүлэлт M2 өсөлт	хувь	13.8	6.5	26.8	15.2
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	тэрбум төгрөг	1,105.6	1,089.2	1,151.7	1,222.2
Бэлэн мөнгөний өсөлт	хувь	11.5	(1.5)	5.7	6.1
Нийт экспорт	сая ам.доллар	9,241.1	12,538.6	15,186.9	15,783.4
өсөлт	хувь	22.0	35.7	21.1	3.9
Нийт импорт	сая ам.доллар	6,845.5	8,704.4	9,250.2	11,614.7
өсөлт	хувь	29.2	27.2	6.3	25.6
Гадаад худалдааны тэнцэл	сая ам.доллар	2,395.6	3,834.2	5,936.7	4,168.7
өсөлт	хувь	5.2	60.1	54.8	(29.8)
Гадаад валютын албан нөөц	сая ам.доллар	4,366.1	3,399.6	4,921.5	5,509.8
өсөлт	хувь	(3.7)	(22.1)	44.8	12.0
Ам.долларын тайлант үеийн эцсийн ханш	төгрөг	2,848.80	3,444.60	3,410.69	3,420.46
Өсөлт	хувь	(0.0)	20.9	(1.0)	0.3
ТӨСВИЙН ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ					
Нийт орлого ба тусламжийн дүн	тэрбум төгрөг	14,306.4	18,521.6	24,387.1	31,456.6
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	тэрбум төгрөг	12,711.4	17,126.9	23,294.9	29,670.8
өсөлт	хувь	34.3	34.7	36.0	27.4
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн ДНБ-д эзлэх хувь	хувь	29.2	31.8	33.1	37.1
Татварын орлого	тэрбум төгрөг	11,299.9	15,459.0	21,484.2	27,417.3
Өсөлт	хувь	32.8	36.8	39.0	27.6
Татварын бус орлого	тэрбум төгрөг	1,411.5	1,668.0	1,810.7	2,253.5
Өсөлт	хувь	48.2	18.2	8.6	24.5
Улсын төсвийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	хувь	69.9	60.2	65.7	59.3
Орон нутгийн төсвийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	хувь	12.2	13.9	17.3	19.7
НДС-ийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	хувь	2.9	2.8	2.7	2.7
ЭМДС-ийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	хувь	14.9	14.4	14.4	14.1
ИӨС-ийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	хувь	-	8.8	-	-
ҮБС-ийн орлогын нийт орлогод эзлэх хувийн жин	хувь	-	-	-	4.3
ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ					
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	тэрбум төгрөг	15,630.4	18,159.7	22,509.0	30,591.1
өсөлт	хувь	12.4	16.2	24.0	35.9
Нийт зарлага ба цэвэр зээлийн ДНБ-д эзлэх хувь	хувь	35.9	33.7	32.0	38.3
Урсгал зарлага	тэрбум төгрөг	12,804.0	14,229.3	17,091.4	22,176.6
өсөлт	хувь	18.2	11.1	20.1	29.8
Хөрөнгийн зардал	тэрбум төгрөг	2,982.2	3,803.4	5,188.2	7,970.8
өсөлт	хувь	(1.7)	27.5	36.4	53.6
Эргэж төлөгдөх цэвэр зээл	тэрбум төгрөг	(155.8)	127.0	229.4	443.7
өсөлт	хувь	(478.9)	(181.5)	80.7	93.4
Урсгал зардлын нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх хувь	хувь	81.9	78.4	75.9	72.5
Бараа, үйлчилгээний зардлын урсгал зарлагад эзлэх хувь	хувь	36.7	26.7	29.8	43.1
Хүүний төлбөрийн урсгал зарлагад эзлэх хувь	хувь	6.5	5.6	6.7	5.6
Татаас ба урсгал шилжүүлгийн урсгал зарлагад эзлэх хувь	хувь	56.8	67.6	63.5	51.3
Хөрөнгийн зардлын нийт зарлага ба цэвэр зээлийн дүнд эзлэх хувь	хувь	19.1	20.9	23.0	26.1
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн нийт зарлагад эзлэх хувь	хувь	(1.0)	0.7	1.0	1.5
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ					
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	тэрбум төгрөг	(2,919.0)	(1,032.7)	785.9	(920.2)
Өсөлт	хувь	(34.3)	(64.6)	(176.1)	(217.1)
Тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	хувь	(6.7)	(1.9)	1.1	(1.2)
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТ					
Засгийн газрын нийт өр	тэрбум төгрөг	26,918.1	31,964.7	30,773.5	33,399.9
Өсөлт	хувь	(3.5)	18.7	(3.7)	8.5
Засгийн газрын дотоод өр	тэрбум төгрөг	1,348.4	1,511.3	469.5	1,200.4
Өсөлт	хувь	(32.1)	12.1	(68.9)	155.7
Засгийн газрын гадаад өр	тэрбум төгрөг	25,569.8	30,453.4	30,304.1	32,199.5
Өсөлт	хувь	(1.3)	19.1	(0.5)	6.3
ӨҮЦ-ээр илэрхийлсэн засгийн газрын өр	тэрбум төгрөг	21,837.3	27,690.6	26,582.9	-
Засгийн газрын өр (ӨҮЦ) / Засгийн газрын нийт өр	хувь	81.1	86.6	86.4	-
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ	хувь	50.1	51.4	37.7	-
Хуулиар тогтоосон өрийн хязгаар (Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ)	хувь	70.0	70.0	65.0	60.0
Засгийн газрын өрийн хүүний төлбөрийн төсвийн орлогод эзлэх хувь	хувь	6.5	4.7	4.7	3.9
Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн төсвийн орлогод эзлэх хувь	хувь	12.5	9.9	9.2	7.7
Засгийн газрын нийт өрийн үйлчилгээний төлбөр	тэрбум төгрөг	2,419.6	2,503.5	3,243.5	3,446.3
Өсөлт	хувь	28.2	3.5	29.6	6.3
Төсвийн орлогод эзлэх хувь	хувь	19.0	14.6	13.9	11.6
ДНБ-д эзлэх хувь	хувь	5.6	4.6	4.6	4.3

Хавсралт 1

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний уялдаа

№	Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хөтөлбөрийн үр дүн	Төсөл арга, хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ-ний уялдсан тоо
1	1.2.1. Олон улсын жишигт нийцсэн боомтын тоог нэмэгдүүлнэ.	Төмөр замын Эрээнцав боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох	24,530.8	18,597.8	6
		Хилийн боомтуудад ухаалаг цахим гарц суурилуулах	13,496.6	13,496.6	1
2	1.3.2.3.Мал эмнэлгийн оношилгооны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	Мал эмнэлгийн оношилгооны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх	4,143.2	4,143.2	3
3	2.1.1. Хөрөнгө оруулалт татах, хамгаалах цогц механизмыг бүрдүүлнэ.	Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд төрөөс зөвшөөрөл авахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэдээ мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг үзүүлэх	40,000.0	40,000.0	1
4	2.3.2.Эрчим хүчний найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	10 аймгийн төвд баригдах дулааны станцын цахилгаан, ус хангамжийн дэд бүтцийг бүрдүүлэх ажлыг үргэлжлүүлэх	51,861.9	22,069.4	10
		Хөвсгөл аймгийн дулааны станцыг 21 МВт-аар өргөтгөх	16,639.9	8,000.0	1
		Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	19,199.6	19,199.6	1
5	3.1.4. Ерөнхий боловсролын сургалтын орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.	Ерөнхий боловсролын сургуулийн барилга барих	519,510.5	145,457.4	52
		Спорт заал барих	18,452.0	7,427.5	8
		Дотуур байр барих	68,372.6	22,804.3	15
		Ерөнхий боловсролын сургуульд байгалийн ухааны лаборатори тохижуулах	133.0	133.0	1
		Үдийн хоол үйлдвэрлэлийн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, чадавхжуулах	324.3	324.3	2
		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуульд тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх	7,166.3	3,583.2	2
6	3.1.5.Сургуулийн өмнөх боловсролын сургалтын орчны стандартын шаардлага хангасан цэцэрлэгийн тоог нэмэгдүүлнэ.	Цэцэрлэгийн барилга барих	178,386.0	62,084.0	51
7	3.3.2.Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	"Хавдар судлалын үндэсний төвийн салбар II"-ын барилга барих	10,000.0	5,000.0	1
		Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилга барих	140,000.0	42,000.0	1
		Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга барих	40,000.0	10,000.0	1
8	4.3.1.Аялал жуулчлалын авто замын сүлжээг нэмэгдүүлнэ.	Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/	11,146.9	5,573.5	1
		Булган-Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын төгсгөл 67.8 км	13,374.1	6,687.1	1
		Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн авто замаас Хорго, Тэрхийн цагаан нуур хүртэлх 13 км хатуу хучилттай авто зам барих	26,000.0	7,100.0	1
		Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох авто зам барих	70,206.3	8,103.2	1

		Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох авто зам барих 32.4 км	32,580.5	5,027.9	1
		4.3.1.10.Олон улс, улс хооронд, орон нутгийн авто замын дагуу 100-200 км тутамд үйлчилгээний цогцолбор, амрах талбай байгуулах /амрах өртөө/.	2,325.0	2,325.0	3
		4.3.1.23.Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол-Сайхан-Овоо-Мандал-Овоо чиглэлийн хатуу хучилттай авто замын төслийн бэлэн байдлыг хангах	1,530.0	1,530.0	1
		4.3.1.24.Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн Төв аймгийн Жаргалант сумын Жаргалантын уулзвараас эхлэлтэй Сэлэнгэ аймгийн Орхон сумын А1001 авто замын Орхон сумын уулзварт төгсөх хатуу хучилттай 100 км авто зам барих	16,139.0	8,069.5	1
		Улаангом-Увс нуур чиглэлийн 25.84 км хатуу хучилттай авто зам барих /Увс аймаг/	46,659.1	6,840.3	1
9	5.1.1.Чанар, стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хангамжийн түвшнийг нэмэгдүүлнэ.	Хүнсний бүтээгдэхүүний чанар, баталгаажуулалтын лабораторийн чадавхыг нэмэгдүүлэх	3,000.0	3,000.0	1
10	6.2.2. Гэр хорооллын инженерийн дэд бүтцийн хангамжийг сайжруулна.	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл хэрэгжүүлэх /Чингэлтэй, Сонгинохайрхан/	18,382.7	8,501.6	4
11	6.2.1. Инженерийн бүрэн хангамжтай сууцанд амьдардаг өрхийн тоог нэмэгдүүлнэ.	"Залуус-1" төслийн эхний ээлжийн барилга байгууламжийн гадна инженерийн 1-р хэлхээний шугам сүлжээний угсралтын ажлыг үргэлжлүүлэх	30,004.5	8,001.4	1
		"Ногоон нуур 1008" төслийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлж, инженерийн шугам сүлжээний ажлыг эхлүүлэх	9,731.0	9,731.0	1
12	7.1.1. Авлигын гэмт хэргийг бууруулна.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх	2,658.2	2,658.2	1
13	7.2.1. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгох	1,200.0	1,200.0	1
14	7.3.1.Иргэний эрхийн тэгш байдлыг хангана	Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын сургуулийн барилга /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг/	6,037.9	1,811.4	1
15	7.4.2. Хил орчмын аюулгүй байдлыг сайжруулна.	Хилийн боомтын аюулгүй байдлыг хангаж, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системд холбох	11,134.5	11,134.5	3
16	7.5.1. Шүүхийн шинжилгээний дүгнэлтэд ирсэн гомдлыг бууруулна.	Шинэ төрлийн шинжилгээ хийхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, программ хангамж авах	4,750.0	4,750.0	1
Нийт			1,459,076.4	526,364.9	182

Хавсралт 2

**Сүүлийн хоёр жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх
шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт**

№	ТЕЗ	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүү жих дүн	Тайлбар
1	БОУАӨС	Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Сүхбаатар/	2024	2025	3,000.0	1,500.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
2	БОУАӨС	Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2024	2026	2,512.5	753.8	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
3	БОУАӨС	Хэрлэн голыг бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төсөл /Хэнтий/	2024	2026	3,000.0	900.0	Магадлалгүй төсөл, арга хэмжээ
4	БОУАӨС	Цаг уурын өртөөний барилга /Хөвсгөл, Шинэ-Идэр, Тариалан, Цагаан-Үүр сум/	2024	2025	640.0	320.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
5	БОУАӨС	Өгийнуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Архангай/	2024	2025	3,000.0	1,500.0	Магадлалгүй төсөл, арга хэмжээ
6	ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын барилга /Дундговь, Сайнцагаан сум/	2024	2025	2,878.3	1,439.2	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
7	БС	Дотуур байрны барилга, 150 ор /Хөвсгөл, Цэцэрлэг сум/	2024	2026	3,000.0	800.0	магадлалын хугацаа дууссан
8	БС	Дотуур байрны барилга, 75 ор /Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл тосгон/	2024	2026	2,278.4	2,278.4	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
9	БС	Сургуулийн барилга, 960 суудал /Орхон, Баян-Өндөр сум, Оюут баг, 2А хороолол/	2024	2026	15,795.2	4,738.6	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
10	БС	Сургуулийн спорт заалны барилга /Сэлэнгэ, Сайхан сум, Номгон тосгон/	2024	2026	1,482.1	500.0	Магадлалгүй төсөл, арга хэмжээ
11	БС	Сургуулийн барилга, 320 суудал /Увс, Бөхмөрөн сум/	2024	2026	9,507.7	2,852.3	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
12	БС	Сургуулийн барилга, 640 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум, 3 дугаар сургууль/	2024	2026	14,915.0	3,000.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
13	БС	Дотуур байрны барилга, 100 ор /Өвөрхангай, Уянга сум, 2 дугаар сургууль/	2024	2026	2,924.8	877.4	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
14	БС	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Завхан, Улиастай сум/	2024	2026	11,748.7	3,000.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
15	БС	Сургуулийн барилгын өргөтгөл, 960 суудал /Дархан-Уул, Дархан сум, 10 дугаар баг, Оюуны ирээдүй цогцолбор сургууль/	2024	2026	19,635.0	5,890.5	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
16	БС	Сургуулийн барилга, 320 суудал /Өвөрхангай, Хархорин сум/	2024	2026	7,571.6	1,871.5	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
17	БС	Сургуулийн барилга, спорт заал, 320 суудал /Өвөрхангай, Баян-Өндөр сум, 5 дугаар баг/	2024	2026	8,500.0	2,550.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
18	БС	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Эрдэнэхайрхан сум/	2024	2026	2,615.5	784.7	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр

							ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
19	БС	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Завхан, Улиастай сум/	2024	2026	3,473.8	1,236.9	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
20	БС	Политехник коллежийн цогцолборын барилга, 800 суудал /Хөвсгөл, Мөрөн сум/	2024	2026	19,220.0	5,548.4	магадлалын хугацаа дууссан
21	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Булган сум/	2024	2025	2,453.9	1,227.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
22	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Цахир сум/	2024	2025	2,453.9	1,227.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
23	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Архангай, Өндөр-Улаан сум/	2024	2025	2,453.9	1,227.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
24	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Баян-Уул сум/	2024	2025	2,453.8	1,226.9	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
25	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Говь-Алтай, Тайшир сум/	2024	2025	2,453.9	1,227.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
26	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Сэлэнгэ, Түшиг сум/	2024	2025	2,453.9	1,227.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
27	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/	2024	2026	3,526.1	1,057.8	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
28	ЗГХЭГ	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга, музейн танхимын хамт /Өвөрхангай, Есөнзүйл сум/	2024	2025	2,453.9	1,227.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
29	ЗТС	Дүүргийн хатуу хучилттай авто зам, замын шинэчлэл, гүүрэн байгууламж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2024	2024	22,950.0	22,950.0	Магадлалгүй төсөл, арга хэмжээ
30	ЗТС	Сумын доторх болон улсын чиглэлийн хатуу хучилттай авто замаас сум хүртэлх хатуу хучилттай авто зам /Төв, Баяндэлгэр сум/	2024	2025	2,110.7	1,000.0	магадлалын хугацаа дууссан
31	ЗТС	Сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр, Хархорин, Хужирт сум/	2024	2026	4,739.0	1,421.7	Магадлалгүй төсөл, арга хэмжээ
32	ЗТС	Сумын төвийн авто зам /Хөвсгөл, Шинэ-Идэр сум/	2024	2025	757.0	267.0	магадлалын хугацаа дууссан
33	ЗТС	Тал нуурын зам засвар /Баян-Өлгий, Толбо сум, 1 дүгээр баг/	2024	2024	50.1	50.1	магадлалын хугацаа дууссан
34	ЗТС	Түйн голын төмөр бетон гүүр, 64.75 у/м /Баянхонгор, Богд сум/	2024	2025	3,250.0	1,625.0	магадлалын хугацаа дууссан
35	ЭХС	Хөлийн гол-2, 3, Хонхор нуур-2 орчмын цахилгаангүй айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 11 дүгээр хороо/	2024	2026	740.6	245.0	Магадлалгүй төсөл, арга хэмжээ
36	ХББОСС	Орон сууцны хорооллын дэд бүтцийн шугам, сүлжээ /Сэлэнгэ, Мандал сум/	2024	2024	500.0	500.0	Магадлалгүй төсөл, арга хэмжээ
37	ХББОСС	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2024	2026	12,570.0	3,570.0	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
38	ХББОСС	Халуун усны барилга /Ховд, Дуут сум/	2024	2024	400.0	400.0	Магадлалгүй төсөл, арга хэмжээ

39	ССАЖЗС	Соёлын төвийн барилга, 250 суудал /Дундговь, Баянжаргалан сум/	2024	2025	2,868.9	1,434.5	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
40	ССАЖЗС	Спорт заалны барилга /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/	2024	2025	2,554.8	1,277.4	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
41	ССАЖЗС	Аялал жуулчлал, соёлын өв /Архангай, Цахир сум, Баянгол баг/	2024	2024	374.1	374.1	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
42	ССАЖЗС	Спорт заалны барилга /Архангай, Эрдэнэбулган сум, Булганхангай хороолол/	2024	2025	1,154.9	577.5	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
43	ССАЖЗС	Соёлын төвийн барилга, 200 суудал /Завхан, Дөрвөлжин сум/	2024	2026	4,512.5	1,065.7	Нэг маягийн зураг төсөлтэй болон өөр ТАХ-ний (жишиг) магадлалтай ТАХ
